



Legum servi esse debemus, ut Liberi esse possimus

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ, ПРАКТИКИЙН СӨТГҮҮЛ

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Банк, санхүүгийн салбарт ИХ ХЭМЖЭЭНИЙ ХОХИРОЛ
гчруулдгаар МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН нийгмийн
хор аюул тодорхойлогддог!!!

*"Мөнгө угаах гэмт хэрэг түүний криминологи шинж" өгүүллэл
73-75 дугаар нүүрт.*

Онолын хувьд зарч болзошгүй ямар ч эрсдлийг
даатгаж болно гэж үздэг . . .

"Даатгалын эрх зүйн тулгуур ойлголт" өгүүллэл 38-43 дугаар нүүрт.

Сэтгүүлийн зөвлөл

Сонин, сэтгүүлийн зөвлөлийн дарга

Академич Ж.Амарсанаа

Гишүүд:

Л.Баасан

Хууль зүйн шинжлэх ухааны доктор,
"Отгонтэнгэр" Их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал

Г.Банзрагч

Хууль зүйн доктор

Ц.Батцэрэн

Нийслэлийн шүүхийн шүүгч

Ж.Бямбаа

Хууль зүйн доктор,
Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч

Л.Бямбаа

Хууль зүйн доктор, Улсын дээд шүүхийн шүүгч

Н.Гантулга

Хууль зүйн доктор, Цагдаагийн академийн дэд захирал

Д.Даваа-Очир

Хууль зүйн доктор,
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Тогтоол гүйцэтгэх газрын дарга, хурандаа

И.Дашням

Хууль зүйн шинжлэх ухааны доктор

Д.Зүмбэрэлхам

Хууль зүйн доктор, Төрийн албаны зөвлөлийн дарга

Т.Мэндсайхан

Хууль зүйн доктор,
Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн эрхлэгч

Ц.Сарантуяа

Хууль зүйн шинжлэх ухаан доктор, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш

С.Сүхбаатар

Хууль зүйн доктор, дэд профессор,
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч

Б.Цэрэнбалтав

Улсын ерөнхий прокурорын орлогч

С.Цэрэндорж

Хууль зүйн доктор, "Хүний эрх, ардчилал" судалгааны төвийн тэргүүн

Б.Чимид

Монгол Улсын Ардын багш, гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор

Ч.Энхбаатар

Хууль зүйн шинжлэх ухааны доктор,
Удирдлагын академийн Ерөнхий эрдмийн тэнхимийн эрхлэгч

Дугаарыг эрхэлсэн:

С.Алтантуяа

Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга

Эрхлэн гаргагч:



Хууль зүйн үндэсний хүрээлэн

Редакцийн хаяг:

Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,
Сүхбаатарын талбай-7

Утас: 315736, 99083007 Факс: 315736

Вэб сайт: www.legalcenter.mn

И-мэйл хаяг: altantuyas_9@yahoo.com

Улсын бүртгэлийн дугаар: 279

ЭНЭ ДУГААРТ:



Хууль зүйн албаны 100 жилийн ойд

**1911 оны Монголын үндэсний хувьсгалын тухай
гадаадын түүх судлалд өгүүлсэн нь**

/ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Түүхийн шинжлэх
ухааны доктор, профессор **О.Батсайхан**/.....3-7



Төрийн байгуулалтын хууль тогтоомж

**Монгол Улсад хууль тогтоомжийг хэвлэн нийтэлж
ирсэн түүхэн тойм**

/МУИС-ийн ХЗС-ийн Монголын төр, эрх зүйн түүхийн
судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан,
докторант **Б.Батбаяр**

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргааны
хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний
ажилтан, магистр **А.Түвшинтулга**/.....8-15

Хууль нийтлэх зарим асуудал

/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн
эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан
Р.Болормаа/.....16-21

Авлига ба нийгэм

/Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн
байцаагч, комиссар, докторант **Д.Золжаргал**/.....22-23



Шүүх эрх мэдэл

**Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, Шүүх
ажиллагаанд орчуулагчийн оролцоог чухалчлах
нь**

/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Олон улсын эрх зүйн
секторын эрдэм шинжилгээний ажилтан **Б.Энх-Амгалан**/
.....24-29

**Хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад
буцаах асуудал**

/МӨХ-ийн гишүүн, өмгөөлөгч, магистр **Б.Ганболд**/.....30-34



Прокурорын хяналт

**Монгол Улсын Прокурорын байгууллагын 80
жилийн ойд***

**Эрүүдэн шүүх гэмт хэрэгт тавих прокурорын
хяналт**

/Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор, Хууль
цаазын ахлах зөвлөх **Е.Сарсай**/.....35-37



Иргэний хууль тогтоомж

Даатгалын эрх зүйн тулгуур ойлголт

/Монгол Даатгал* ХХК-ийн Даатгалын газрын захирал,
МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч **Б.Жавхлант**,
Австралийн Мельбурнийн Их сургуулийн Азийн хуулийн
судалгааны төвийн зочин эрдэмтэн, хууль зүйн доктор
Б.Гүнбилэг/.....38-43

* Монгол Улсад Прокурорын байгууллага байгуулагдсаны түүхт
80 жилийн ойг 2010 онд тэмдэглэнэ.

Зар сурталчилгаа ба гэм хор

/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн
засгийн эрх зүйн секторын судалгааны тайлан/
.....44-59

**Бизнесийн эрх зүй дэх хууль зүйн хариуцлагын
онол практикийн асуудал**

/Шихихутуг хууль зүйн дээд сургуулийн Салбар эрх зүйн
гэнхимийн багш **С.Батбуян**/.....60-62



Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

**Монгол Улсын шүүх эрх мэдлийн хүрээний
хууль тогтоомж, олон улсын гэрээний
зөрчилдөөн**

/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Олон улсын эрх зүйн
секторын судалгааны тайлан/.....63-66

Авлигатай тэмцэх Сингапурын туршлага

/Хууль зүйн доктор **Ж.Батзандан**/.....67-68

**Ашигт малтмалын лиценз эзэмшигчийн эрх зүйн
байдлыг харьцуулсан судалгаа**

/ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, магистр
Ц.Ундрах/.....69-72



Криминологи

**Мөнгө угаах гэмт хэрэг түүний криминологи
шинж**

/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн судалгааны секторын эрдэм
шинжилгээний ажилтан **Г.Оюунболд**/.....73-75

**Интерпол ба шүүх-ДНХ шинжилгээ, түүний
хэрэглээ**

/Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн
пабораторийн тасгийн дарга, биологийн ухааны доктор
С.Ганболд/.....76-78

**Гарын мөрний шинжилгээний өнөөгийн байдал,
тулгамдсан асуудал**

/Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Гарын
хэзэний шинжилгээний хэлтсийн шинжээч, Цагдаагийн
дэслэгч **Б.Номин**/.....79-81



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

**Торгох ялын эрх зүйн зохицуулалтын түүхэн
уламжлал ба торгох ял оногдуулсан шүүхийн
шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт
шалгалтын тасгийн ахлах байцаагч, ахмад, докторант
Б.Байгал/.....82-84

CONTENT:



The 100th anniversary or the Justice sector

Accounts of the 1911 Mongolian National Revolution by Foreign Historians

/O. Batsaikhan, Ph.D, Institute of International Studies, The Mongolian Academy of Sciences/.....3-7



State organization legislation

A Historical Overview of Publishing Legislation in Mongolia

/B. Batbayar, Ph.D candidate, Researcher of Research Center for Mongolian State and Law History, School of Law, National University of Mongolia/
A. Tuvshintulga, LL.M, Researcher of Administrative and Humanitarian Law Sector, National Legal Institute/.....8-15

Some Issues on Publication of Law

/R. Bolormaa, Researcher of Civil and Economic Law Sector, National Legal Institute/.....16-21

Corruption and Society

/D. Zoljargal, Ph.D candidate, Investigator of Independent Authority Against Corruption of Mongolia/.....22-23



Judicial power

Importance of Translator's Participation in Inquiry, Investigation and Court Trial Proceedings

/B. Enkh-Amgalan, Researcher of International Law Sector, National Legal Institute/.....24-29

Issues on Returning a Case Back to Inquiry, Investigation

/B. Ganbold, LL.M, Member of Association of The Advocates/.....30-34



Prosecutors supervision

On The Occasion of the 80th anniversary of Mongolian Prosecutor's Authority*

Prosecutors Supervision of the Crime Torture

/Yo. Sagsai, Supervising Prosecutor of Metropolitan Prosecutor's Office/.....35-37



Civil legislation

Fundamental Concepts in Insurance Law

/B. Javkhlan, Director of Insurance Department in "Mongol Daatgal" LLC, Member of Association of The Advocates, B. Gunbileg, Ph.D, Visiting Scholar of Asian Law Research Center, University of Melbourne, Australia/.....38-43

Advertisement and Tort

/Brief Report of Civil and Economic Law Sector, National Legal Institute/.....44-59

Theoretical and Practical Issue on Legal Liability of Business Law

/S. Batbuyan, Lecturer of Branch Law Department, "Shikhihutug" University/.....60-62



International law and comparative law

Conflicts Between Legislation of Mongolia on the Judiciary and International Treaties

/Brief Report of International Law Sector, National Legal Institute/.....63-65

Singaporean Experience of Combating Corruption

/J. Batzandan, Ph.D/.....67-68

A Comparative Study on the Legal Status of Mineral Liscence Holders

/Ts. Undrakh, LL.M, Lecturer of School of Law, Otgontenger University/.....69-72



Criminology

Criminological Attributes of the Crime of Money Laundering

/G. Oyunbold, Researcher of Criminal law and Criminology Research sector, National Legal Institute/.....73-75

Interpol and Forensic Analysis of DNA

/S. Ganbold, Ph.D, Head of laboratory of National Institute of Forensic Investigation/.....76-78

Current Status and Challenges of Fingerprint Evidence Examination

/B. Nomin, Expert of Fingerprint Evidence Examination Division, National Institute of Forensic Investigation/.....79-81



Enforcement of court decisions

The Historical Tradition of Using Fines as criminal Punishment and the Enforcement of Court Decisions of Imposing Fines

/B. Baigal, Ph.D candidate, Head Office of Enforcement of Court Decisions/.....82-84

* 80th anniversary of Mongolian Prosecutor's Authority will be celebrated in 2010.

1911 ОНЫ МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУВЬСГАЛЫН ТУХАЙ ГАДААДЫН ТҮҮХ СУДАЛД ӨГҮҮЛСЭН НЬ

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор О.Батсайхан



Баруун гар талаас доктор, профессор О.Батсайхан, Академич Ж.Амарсанаа

Монголын 1911 оны үндэсний хувьсгалын түүхэн үйл явдлын талаар гадаадын эх сурвалж, эрдэмтэн судлаачдын бүтээлд юу хэмээн бичсэнийг сонирхгооё.

Хүрээнд сууж байсан Оросын консул Лавдовский 1911 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Гадаад яамандаа илгээсэн 1234 тоот нууц пахилгаандаа: “Өнөөдөр Халхын ноёд олон хүн оролцсон баяр ёслолын цуглаан дээр Гэгээнийг Бүх Халхын хаанаар өргөмжиллөө”¹ хэмээн мэдэгдсэн байна. Оросын консул товч бөгөөд тодорхой ийм мэдээг Засгийн газартаа уламжилсан байна.

Оросын эрдэмтэн И.И.Ломакина бичихдээ²: “Өглөөнөөс бүхнийг хамарсан өргөн цуглаан эхэлж, түүнд бүх л дээд лам нар, цэрэг, хоёр мянга орчим зэвсэглэсэн казакууд оролцож, жагсаалаар Богдын өвлийн ногоон ордоноос Хүрээ рүү хөвлөв. Богд болон түүний

эхнэрийг хүүгийн хамтаар шар өнгөтэй хаалттай сүйхэнд суулган өргөж, баяр ёслолд зориулан алтан болон шар өнгөөр бүрсэн асар том гэр хүрч, тэндээсээ Орлон руу шар өнгийн материалаар зассан замаар явав. Замын хоёр талаар ноёд жагссан байв. Гэрийн хойморт хос сэнтий зассан байв. Ийм байдалтайгаар цогчин дуган орж, товчхон мөргөл үйлдээд буцаад ордондоо заларсан. Баяр ёслолын байдалтай нам гүм байдалд Хаан эзний сууринд залах тухай тунхагийг уншиж, Богд болон түүний эхнэрийн толгой дээр Далам, Сайн ноён хан нар титэмийг өмсгөсөн. Алтан очир нь Чингис хааны үр сад сэргээснийг илэрхийлж байв. Ийнхүү их бууны дуутай зэрэгцэн хаан суудалд засах ёслол болжээ. Үүний дараа бэлэг өргөн баяр хүргэх үйл явц эхлэв. Үүний дотор гол нь сөн цагааны бэлэг орж байв. Энэ өдөр сөн цагааны бэлэг срдийнхөөс 100 дахин илүү өргөж, бүгд цагаан хадаг барьсан байв. 900 цагаан тэмээний хүзүүн дээр булга, хар үнэг болон бусад зэрлэг үнэт амьтдын арьс өлгөөстэй байв. Өргөл бэлэг хошуу бүрээс, томоохон ноён бүрээс, Хүрээний хятадуудаас өгч, заримдаа мөнгөн элдэл, торгон хувцас бэлэглэж байжээ.

Төрийн ёслолоос хоёр цагийн дараа хааны гэр бүл дахин мөргөл хийхээр нээлттэй сүйхэнд суун, Майдар сум рүү явсан байна. Дагалдсан ноёд, лам нар бүхий л хугацаанд асаасан лаа барьж явав. Цуваа их бууны дуун дор янж байв.

Мөргөл үйлдсэний дараа буцаж ордондоо залраад хишиг тарааснаар энэ өдрийн ёслол оройн 5 цагт өндөрлөж, хаан эзэн, улсын эх лагны сууринд суусан Богд, түүний эхнэр тус тусдаа хаалттай сүйхэнд сууж, өөрийн ордондоо залрав”³ хэмээн бичжээ. Хааны ийнхүү янж байхад өнгө онгийн тут дохиур барьсан түшмэлүүд дагалдаж, замын дагуу ард олон өвлөг сөхрөн мөргөж өөрийн хаандаа хүндэлж илэрхийлж байсан. Хааны ногоон орлоны гадаа сүйхээс нь буухад их буу дахин буулгаж байв. Ийнхүү Олноо өргөгдсөний эзэрхлийн үе эхлэв хэмээн мөн тэнд бичжээ.

Хүрээнд сууж байсан Оросын ерөнхий консул В.Ф.Люба Петербургт илгээсэн 1912 оны 1 дүгээр сарын мэдээндээ “Хэзээ нэгэн цагт Монголын сүүлчийн жилүүдийн түүхийг бичих болбол түүхчээ хамгийн аймшиггүй ухаантан ч энэ тухай болохыг зүрхлээгүй тийм зүйлийг хэрэгжүүлэгч VIII Богд гэгээний зоригтой, шийдвэртэй санаачилгыг галархалтайгаар тэмдэглэх болно”⁴ хэмээн онцлон тэмдэглээд нааш өгүүлэхдээ: “Монголыг эдүгээ эрх чөлөөтэй залгуулсан энэ үйл хэргийг манлайлсан хүн нь яах аргагүй Хутагт мөн”⁵ гэсэн байв.

Түүхэн энэ цаг үед Хутагт ард түмнийхээ хүсэл зоригийг соргоогоо мэдэрч, Хятадаас холбоогоо таслахаар шийдэж, Монголын хувьд хэзээ нэгэн цагт байсан шиг нь хүчирхэгээр хамгийн дээд ондорлогтоо зогсож, Их Орос Улсаас тусламж эрсэн” юм хэмээн

¹ Архив Внешней политики Российской империи ф.Китайский стол 143, Описы 491, л.644, с.388.

² И.И.Ломакина. “Монгольская столица, старая и новая, Сфера Евразии, Товарищество научных иланий КМК: 2006”. с.65.

³ Харбинская газета. “Новая жизнь”. 4 Января 1912 года

⁴ РГИА., ф.892, оп.3, ед.хр.127, л.1. Архив Внешней политики России, Фонд Миссии в Пекине. Описы 1. Дело 316

⁵ РГИА., ф.892, оп.3, ед.хр.127, л.1. Архив Внешней политики России, Фонд Миссии в Пекине. Описы 1. Дело 316.

⁶ И.И.Ломакина. “Монгольская столица, старая и новая, Сфера Евразии, Товарищество научных иланий КМК: 2006” с.64.

консул В.Ф.Люба нэмэж тэмдэглэсэн байна.

Оорийн амьдралын гучин жилийн Монголд онгөрүүлж, монголчуудын хэл, ахуй, зан заншилыг сайтар судалж, Монгол орон, ард олны талаар оорийн гэсэн бодит ойлголттой болсон, тухайн үед Монголд, тэгэхдээ Хүрэннээс зайлуу Ховдын орчим амьдарч байсан А.В.Бурдуков оорийн дурсамжаа бичихдээ: "1911 он гарсаар Монголд томоохон үйл явдал болох гэж байна", "Богдын эрдэм чадлын тухай, Богдын даншиг оргөх ёслолын үеэр Богд ууланд ноёдын нууц зовлогөөн болж гэнэ", тэгсэнээ Да лам, Ханг ван хоёр гэнэт алга болж гэнэ, тэгсэн чинь Оросоос тусламж гуйсан юм байх гэх зэргээр ард олны дунд тарж байсан цуу яриа, мэдээ мэдээлэлийн талаар дурдаад Монголд зуунаар оршиж байсан Манжийн дарлалаас монголчууд гарч, эрх чөлөөгөө олж авах хөрс суурийг хэрхэн бүрэлдүүлж байсан тухай тэмдэглэжээ. Тэрбээр 1911 оны 12 дугаар сарын 29-ний үйл явдлыг өөрийн нүдээр харж чадаагүй бөгөөд энэ тухай Монголын тал нутгаар тархсан мэдээлэлд үндэслэн дараах үйлсийг тэмдэглэжээ. Үүнд: "Энд Ховид нам гүм байсан бол Хүрэннд чухал үйл явдал болж байв. 1911 оны 11 дүгээр сарын 18-нд тусгаар тогтносон Монгол Улс тунхаглагджээ. Уламжалд тулгуурлан монголчуудыг барьж байсан Манж, хятадын засаглал энэ үед суларч, эсэргүүцэл үзүүлэх чадвар сул байв. Хүрэнний гудамжинд гарч, лам голдуу монголчууд бөөнөөрөө жагсан, хашгирч, Хятад амбаны замыг гудамжинд хааж, сүйх тэргэнийх нь цонхыг гахалахад тэрбээр ухаангүй айж, засгийн эрхээс огехийг зөвшөөрч, нэргүүдийнхээ зэр

зэвсгийг хураалгаж, Хятад руу тайван замаар явсан" хэмээн бичжээ. Харин түүнийг уг номын тайлбарыг хийсэн Оросын эрдэмтэн Е.Даревская "энэ бол улс горийн чухал үйл явдлыг энгийн болгосон номын алдаатай хэсгүүдийн нэг" хэмээн шүүмжлэн бичсэн бол Ховдын ойр Хангалцигт байнга оршин сууж байсан А.Бурдуков Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ямар цалайцтай байсаныг анзаарахгүй байж, эл үйл явдлыг лутуу үнэлэхгүй байж чадах байсан" хэмээн түүнийг буруутгасан байдаг.

А.Бурдуков: Хүрэнний үйл явдлуудын тухай ард олон хятадуудтай хийсэн Монголчуудын томоохон тэмцэл болсон хэмээн ярьж байв. Олон зууны эзэгнэлд нь ошоогдсон ард олны дунд хятадуудаас ошөө авах сэтгэлгээ сэргэж эхлэв. Улиастай, Ховдоос хятадуудыг хоох үлдээд байв. Гарал үүсэл нэгтэй халхын дөрвөн аймаг хөдөлгөөнийг шууд л дэмжиж байв. Хүрээ, Улиастай, Ховдыг холбож байсан өртөө улаа замхрав. Улиастай дахь жанжин, Ховдын амбанд монголчуудад засгаа өгөх шаардлага тавив" хэмээн бичээд Ховд хотыг хэрхэн чөлөөлсөн тухай маш цэлгэрэнгүй өгүүлсэн нь энэ үеийн түүхийн чухал сурвалж болж байна.

Консул В.Ф.Любагаас 1912 оны 1 дүгээр сарын 8-нд В.Котвичид бичсэн захидалдаа¹¹: Монгол Улсын хаан ширээнд Богд гэгээн суусан тухай өгүүлээд Монголчууд тусгаар тогтнолоо тунхаглан зарлалаа. Хятадуудын сэтгэл самгардсан байдал нь тэдэнд тус боллоо. Цаашид яах бол гэж бодож байна, монголчуудад цэрэг, мөнгө, хүмүүс хүрэлцэхгүй байхад бид түүгээр хараад сууж болохгүй. Тэд танд их найдлага тавьж байна, гэвч гэдэнд бүгдийг өгч чадах билүү гэх

зэргээр өөрийн болол саналаа бичээд Монголын ноёдтой хэлхээ холбоо барих, Засгийн газартай холбоотой байх, нууц кодыг тайлах гэх зэргээр бичиг хэргийн ажил Консулын албанд энэ үед маш их байгаа тухай мон бичжээ.

Консул В.Ф.Люба эл захидалдаа Богдыг хаанд ширээнд залах торийн их ёслолын үеэр зураг авах гэсэн боловч амжилттай болоогүй тухай өгүүлсэн байна. Тэрээр өгүүлэхдээ хамгийн сонирхолтой агшинг зурагт буулгаж чадсангүй учир нь Богдыг ирүүт лам, ноёд, ард олон бүчин авч, нэг ч зурагчин түүхэн агшинг хальсанд буулгаж чадсангүй. Уг нь гурван сайн дурын зурагчин байсан хэмээжээ.

В.Ф.Любагаас В.Котвичид бичсэн 1912 оны 1 дүгээр сарын 22-ний захидалдаа Богдыг хаан ширээнд залсан тухай нэгэн баримт бичиг явуулсан тухай өгүүлжээ. Энэ нь Богд гэгээнийг Монгол Улсын хаанд өргөмжилсөн өргөмжлөл ерөөл байсан болов уу. Учир нь В.Ф.Люба эл баримт бичиг бол онцгой баяр ёслолын шинжтэй, их гоёмсог шинжтэй юм. Танд илүү бус байх болов уу хэмээн найдмой.

Харамсалтай нь Богдыг хаан ширээнд залсан түүхэн агшинг нэг ч зурагчин хальсандаа буулгаж чадсангүй. Лам ноёд Богдыг хүрээлээд зургий нь авахуулахгүй байв. Есөн цагаанд өргөсөн 9 цагаан тэмээ, есөн цагаан адуу ("9 цагаан" -д 1 тэмээ, 8 морь орж байв - 0.5) гэдэг зургийг авч явуулсан тухай өгүүлсэн байна¹². Мөн түүнчлэн Монголын үндэсний цэргүүд казаккийн өмд хувцас болон малгай өмсч, шар погоон зүүхээр байна гээд шинэ цэргүүдийн зураг илгээсэн байна. Өөрөөр хэлбэл Богд гэгээнийг Монгол Улсын хаан ширээнд залах үеэр цэргийн ёслол, жагсаал болсон бололтой байна.

¹ А.В.Бурдуков. "В старой и новой Монголии. Воспоминания, письма". М., 1969. с.30-50.

² А.В.Бурдуков. "В старой и новой Монголии. Воспоминания, письма". М., 1969. с.53.

³ А.В.Бурдуков. "В старой и новой Монголии. Воспоминания, письма". М., 1969. с.377.

⁴ А.В.Бурдуков. "В старой и новой Монголии. Воспоминания, письма". М., 1969. с.53.

⁵ "В.Котвичийн хунийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг". Судлан хэвлүүлсэн академич Б.Ширэнцэв, эрхэлсэн акад.Ш.Нашагдорж. УБ., 1972 он. 114 дэх тал.

⁶ "В.Котвичийн хунийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг". Судлан хэвлүүлсэн академич Б.Ширэнцэв, эрхэлсэн акад.Ш.Нашагдорж. УБ., 1972 он. 121 дэх тал.

. Богдыг хаан ширээнд залсан тэр өдөр салхитай, шороо тоос боссон, хүмүүс олноороо шаваралдсан байх хэмээн бичжээ. Гэвч тэрбээр эл захидалдаа Богдыг хаан ширээнд залсан ёслолын ерөнхий дүрслэлийг харуулсан зураг явуулсан тухайгаа өгүүлжээ. Харамсалтай нь тийм зураг өнөө хэр олж үзээгүй байна.

Хайсан гүнээс В.Котвичид 1912 оны 1 дүгээр сарын 20-нд бичсэн захидалд өгүүлэхдээ “Богд гэгээн 12 дугаар сарын 16 (29. - О.Б.)-нд Монголын эзэн хаанаар өргөмжлөгдлөө” гээд “Цагаан хааны хүчирхэг ивээл болон та бүхний дэмжлэгийн үрээр бидний мөрөөдөл биеллээ, хар, шар бид цөмөөрөө баяр бахдалаар дүүрэн байна”¹³ хэмээжээ.

Харин Оросын зарим эрдэмтэн “1911 онд Монголд тусгаар тогтносон улс байгуулагдсаны үр дүн болж, Орос орон өөрийн хөрш Монголтой шинэ харилцаа үүсгэн байгуулсан нь XX зууны нэг ололт юм” гэсэн буюу “Монголд 1911 онд тусгаар тогтносон улс байгуулагдсан явдал нь тус бүс нутагт олон улсын шинэ нөхцөл байдал тодорхойлох болсон юм”¹⁴ хэмээн дүгнэсэн байна.

Оросын цэргийн офицер, ахмад Тонких 1912 оны ес, аравдугаар сард Монголд тусгай аялал хийгээд бичсэн тайландаа: Хүрээнд болсон 1911 оны үйл явдлыг “хувьсгал бүс төрийн эргэлт”¹⁵ хэмээн нэрлээд энэ үйл явдал нь Оросын худалдаанд сайн нөлөө үзүүлээгүйн дээр ядуу монголчууд Хятадын

баараань хомсдолоос үүдсэн үнийн хөөрөгдөлтөд нэрвэгдэж байна гэж тэмдэглэжээ. Энэхүү цэргийн офицер ахмад Тонких Хүрээнд ирээд өөрийн хийсэн ажиглалт, хүмүүстэй уулзсан уулзалтандаа түшиглэн: “Хүрээнд болсон төрийн эргэлтийг Хутагт болон түүнийг хүрээлэгчид хийсэн байна”¹⁶ гээд үүнд хятадын засаг захиргааныхны балмагдал хийгээд оросын төлөөлөгчдийн зөв зүйтэй зөвлөмж нөлөөлжээ гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Мөн буриад Довдановаас Дээд Үлээс 1911 оны 12 дугаар сарын 30-нд В.Котвичид бичсэн захидалдаа Монголын эзэн хааны суудалд Жавзандамба хутагт суусан тухай товч өгүүлээд “миний хоёр хагас сар Хүрээнд байсан явдал эргэлт гарахад ихээхэн түлхэц болсон хэмээн ямар нэгэн хачиргүйгээр мэдэгдэж байна. Надад даалгасаныг би биелүүлсэн”¹⁷ гэж бичсэн байна. Эндээс үзвэл Монголын үндэсний хувьсгал гарахад Оросын талаас зэвсгийн талаар тусламж үзүүлснээс гадна тодорхой асуудлаар зөвлөгөө өгч дэмжиж байсан нь тодорхой байна. Энэхүү Довдановын захидал “Да лам улс орныхоо дотор улс төрийн гарамгай үүрэг гүйцэтгэж байна”¹⁸ хэмээн дүгнээд “Ханд вангийн тухай өгүүлэхдээ “Ханд ван гадаад хэргийн тэргүүн болсоныхоо хувьд бидний түүнд өгсөн итгэлийг хөсөрдүүлэхгүй байх болно”¹⁹ гэж бичсэн байна. Өөрөөр хэлбэл Оросын талаас Ханд ванд илүү итгэл хүлээлгэж байсан бололтой

байна.

Төв Азийн нутгаар аялагч агуу их Н.Рерихийн хүү Юрий Николаевич Рерих Европ, Америкийн их сургуулиудад уншихаар 1929 онд Урусватид бэлтгэсэн “Монгол: Эзлэн түрэмгийлэгчдийн зам” нэртэй лекц бичиж, түүндээ “1911 оны 11 дүгээр сарын 18-нд Богд гэгээний ордонд Монгол ноёдын хуралдаан дээр улс орныхоо тусгаар тогтнолыг баяр ёслолын байдалтай тунхаглажээ. Энэхүү гэмдэглэлт өдрөөс эхлэн монголын тал нутгаар элч нар тусгаар тогтнолын тухай мэдээ дуулгаж, улс орныхоо төлөө гэмцэхээр цэрэг элсүүлэх болсон тухай зарлигийг хүргэхээр давхилдах болжээ. Ховдын хятад амбангаас бусад хятадын цэрэг болон иргэний эрх баригчид ямар нэгэн эсэргүүцэл үзүүлэлгүйгээр Хятад руу явсан бол эсэргүүцэл үзүүлсэн Ховдын цайзыг монголчууд 1912 оны хавар эзлэн авсан юм. 1911 оны 12 дугаар сарын 15-нд Наймдугаар Жавзандамба хутагт Монгол Улсын Олноо өргөгдсөн хэмээх цол бүхий хаанаар өргөмжлөгдөж, Өргөө хааны нийслэл болж, Богд гэгээний шар туг түүний орлоны дээр намирах болов. Монголын түүхийн энэ цаг мөчид өнгөрсөн цагийн агуу удирдагчдаа санаглан Их Монгол Улсыг байгуулах хүсэл өвөрлөсөн хүмүүс бий болов. Монголын бүхий л тал нутгаар аль хэдийн мартагдсан дайчин хуунууд дахин цуурайтаж эхлэв”²⁰ хэмээн

¹³ “В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг”. Судлан хэвлүүлсэн акад.Б.Ширэндэн, эрхэлсэн академич Ш.Нашагдорж. УБ., 1972 он. 116 даях тал.

¹⁴ Жизнь и научная деятельность С.А.Комаратова (1896-1970): в Монголии и в России, Подготовлено к изданию, предисловие, введение, комментарии и указатели - И.В.Кульганек, В.Ю.Жуков. Санкт-Петербург. 2006. с.10.

¹⁵ Энэхүү Оросын цэргийн ахмад Тонких нь 1909, 1912 онд Монголд хоёр ч удаа ирсэн бөгөөд тайлангаа Эрхүү хотноо хэвлүүлсэн байна. Отчет о поездке в Сибирскую Монголию генерального штаба капитана Тонких в сентябре - октябре 1912 года. - Иркутск. - 1913. с.34 Тонких Материалы по описанию Монголии, часть, прилагающаяся к записному Зибикальы (аймаки Тушеты хана, Сайн ноённа, Засатуй Хана)- Иркутск. 1910. с.1.

¹⁶ Отчет о поездке в Сибирскую Монголию генерального штаба капитана Тонких в сентябре - октябре 1912 года. - Иркутск. - 1913. с.111.

¹⁷ “В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг”. Судлан хэвлүүлсэн акад.Б.Ширэндэн, эрхэлсэн академич Ш.Нашагдорж. УБ., 1972 он. 91 дэх тал.

¹⁸ “В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг”. Судлан хэвлүүлсэн акад.Б.Ширэндэн, эрхэлсэн академич Ш.Нашагдорж. УБ., 1972 он. 91 дэх тал.

¹⁹ “В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг”. Судлан хэвлүүлсэн акад.Б.Ширэндэн, эрхэлсэн академич Ш.Нашагдорж. УБ., 1972 он. 91 дэх тал.

²⁰ Ю.Рерих Тибет и Центральная Азия: Статьи, лекции, переводы, Научный редактор М.И.Вороньина - Деситонская, Самара: Издательский дом “Агни”. 1999. с.306-307.

тэмдэглэсэн байна.

А.Бурдуковын нэгэн ажил 19 дүгээр зууны сүүл 20 дугаар зууны эхээр 20 гаруй жил Монголд амьдарч худалдаа эрхэлсэн Сибирийн худалдаачин А.Д.Васеньев нь Монголчуудын болон Монгол Оросын худалдааны тухай тодорхой мэдлэгтэй нэгэн байжээ. Түүний бичсэн илтгэл, захидлууд 1994 онд Барнаул хотод орос хэлээр хэвлэгдсэн нь энэ үеийн Монголын тухай софироолтой эх сурвалжуудын нэгэнл үй ёсоор орох юм. Тэрбээр 1911 онд Петербургт Оросын Экспортний танхимын Алс Дорнодын хэлтсийн хуралдаан дээр тавьсан "Монгол дахь Оросуудын зорилт"²¹ хэмээх илтгэлдээ тухайн үеийн Монголын худалдаа, эдийн засгийн байдлын талаар дүгнэлттэй хөндөж, Монголын үндэсний хувьсгалын тухай өгүүлэхдээ "Монгол өөрийн тусгаар тогтнолыг тунхагласан явдал нь ноцол байдлыг бидний хувьд таламжтайгаар өөрчилж байна. Ийм ноцол байдал буй болсон явдлыг ашиглаж, Монголыг дэмжих хэрэгтэй байна" гээд тухайн цаг үед Оросуудаа юу хийвэл зохилтой талаар "Орос Хятадын хооронд буфер улс байгуулах хэрэгтэй байна. Бидэнд дайсагнасан үзэлтэй хятадуудтай хөрш байснаас энхээр нүүдэллэн орших оронтой хөрш байсан нь бүх талаар нийцтэй" хэмээн нэмж өгүүлсэн байна.

Японы монголч эрдэмтэн Наками Татсуо "1911 оны 11 дүгээр сард Хүрээнд сууж байсан Манжийн амбан хөөгдөж, 1911 оны 12 дугаар сарын 1-нд Халх Монголын хан ван гүнгүүд тэдний улс төрийн тусгаар

тогтнолоо тунхаглав. Харин шинэ засгийн газар албан ёсоор 1911 оны 12 дугаар сарын 29-нд байгуулагдаж, Жавзандамба хутагтыг эзэн хаан хэмээн оргомжилсон"²² гэж бичжээ.

Оросын дорно дахины томоохон мэргэжилтэн И.Я.Коростовец Монголчуудын тусгаар тогтнолоо тунхаглан зарласнаас арав гаруй хоногийн дараа буюу 1911 оны 12 дугаар сарын 26 (29. -0.5)-ны өдөр Оросын Гадаад хэргийн яамнаас гаргасан мэдээлэлд үндэслэн бичихдээ: Хүрээнд монголчууд өөрийн тусгаар тогтнолоо гунхаглан зарлаж, өөрийн шашиныг гэргүүн Жавзандамба хутагтаа эзэн хаанаар өргөмжлөөд улмаар Орост хандан дэмжлэг хүссэн юм хэмээн тэмдэглээд Оросын эзэн хааны засгийн газар монголчуудад ухаалаг хөдлөх хийгээд хятадуудтай хэлэлцээ хийх арга зам олохыг хичээхийг зөвлөсөн²³ хэмээжээ. И.Я.Коростовец цааш нь бичихдээ Хүрээнд дэх Оросын консул үйл ажиллагаа явуулсаны улмаас хаалган Хиагтын хоорондох цахилгаан утасны холбоог устгах болон Хүрээнд дэх Дайчин банкны салбарыг дээрэмдэхээс сэргийлж, Амбан сайд Сандоог Монголоос эрүүл саруулаар гарахад нь тусалж дэмжлэг үзүүлэн Оросын нутгаар дамжин явуулсан²⁴ хэмээсэн буй.

1912 оны 12 сарын 30-нд Б. Я. В л а д и м и р ц о в о с А.В.Бурдуковт бичсэн захидалдаа: "Ихээхэн бэрхшээлийг даван туулж, Монгол, тухайлбал Ар Монгол тусгаар тогтнолтой болж байна"²⁵ хэмээн бичжээ.

Монголчууд тусгаар тогтнолоо

тунхаглан зарласаны дараахан буюу 1911 оны 12 дугаар сарын 29/1912 оны 1 дүгээр сарын 11-ны өдөр Хаант Оросын Засгийн газраас Монголд болсон үйл явдлын талаар албан ёсны мэдээлэл гаргасан билээ. Энэхүү мэдээлэл Монголын тусгаар тогтносныг шууд дэмжээгүй мэт боловч Монгол дахь үйл явдлын талаар дэлхий нийтэд мэдээлснээрээ ач холбогдол бүхий үйл явц байв. Оросын засгийн газрын энэхүү мэдээлэл нь Японы засгийн газраас Оросуудад 1907 оныхоо гэрээг эелдэгээр хандан сануулж, "Монгол" хэмээх нэрийн дор юуг ойлгож байгаагаар тодорхой тайлбарлахыг хүсэхэд хүргэж байжээ.

Иймээс Оросын Дорно дахины мэргэжилтэн И.Я.Коростовец "Оросын Засгийн газрын мэдэгдэл нь хүмүүсийн анхаарлын гадна үлдэж чадаагүй юм" хэмээн тэмдэглээд үүний дараа Оросын томоохон хэвлэлүүдэд Монголын асуудлаар хэд хэдэн өгүүлэл гарч, тэдгээрт Монголд болж буй үйл явдал Оросууд оролцох учиртайг онцлон зааж байсан байна. Түүгээр ч үл барам энэ үед Оросын дорно дахины томоохон мэргэжилтнүүд Монголын асуудлаар өөрсдийн санал бодлоо илэрхийлж байжээ. Тухайлбал, нэрт нийтлэлч, ноён Ухтомский²⁶ өөрийн Хаандаа албан ёсны захидал илгээж, түүндээ монголчуудыг Оросын Цагаан хаанд татахын тулд Монгол руу хэлэлцээр хийлгэх зорилгоор итгэл даахуйг бүрэн эрхт төлөөлөгч илгээхийг²⁷ санал болгож байжээ. Ноён Ухтомский өөрийн захидалдаа Монголд буй өөрийн консулуудаа энэ ажлыг хийхэд

²¹ Доклад, прочитанный А.Д.Васеньевым на заседании Дальневосточного отдела Российской экспортной палаты в Петербурге "Русские задачи в Монголии". - Сибирский купец А.Д.Васеньев. Документы и письма Часть Вторая. Барнаул. 1994. Составитель А.В.Старцев. с.13-18.

²² Nakami Tatsuo Russian diplomats and Mongol Independence, 1911-1915, - Mongolia in The Twentieth century: Landlocked Cosmopolitan. Ed. By Stephen Kotkin and Bruce Elleman, NY and London: M.E.Sharpe, 1999. p.74.

²³ И.Я.Коростовец От Чингис хана До Советской республики, Ответственный редактор О.Батсайхан, Редакторы Б.В.Базирон, В.Ц.Ганжуров. УБ., 2004 он. с.166.

²⁴ И.Я.Коростовец От Чингис хана До Советской республики, Ответственный редактор О.Батсайхан, Редакторы Б.В.Базирон, В.Ц.Ганжуров. УБ., 2004. с.166.

²⁵ А.В.Бурдуков "В старой и новой Монголии, Воспоминания", письма. М., 1969, с.338.

²⁶ Дурьсан захидлыг хаандаа бичсэн ноён Ухтомский нь 1896 онд Бээжин рүү онцгой бүрэн эрхт төлөөлөгчөөр илж байхдаа хяаныхаа бэлгийг Богд хутагтад өргөн барихар Монголд түр санагч байсан нэгэн ажээ. Гэвч ноён Ухтомский Монголын болон шашины ёс заншилд захирагдахаас татгалзаж, хутагттай биечлэн уулзаагүй одсон ажээ.

²⁷ И.Я.Коростовец От Чингис хана До Советской республики, Ответственный редактор О.Батсайхан, Редакторы Б.В.Базирон.

хангалттай нэр хүндтэй бус хэмээн үзэж байгаагад илэрхийлээд Монгол руу илгээхэд тохирох хүнээр Хятадад албан хаагч буй ноён Грот²⁴-ыг нэрлэсэн буй.²⁵

Энэхүү ноён Ухтомскийн захидал Монголын асуудалд Оросын хааны анхааралыг тодорхой хэмжээнд татахад хүргэв үү, эсвэл Оросын хаан Монголын асуудлаар тодорхой мэдээлэлтэй байв уу, ямар ч байсан Хаан Монголын талаар Засгийн газартаа чиглэл өгсөн байдаг билээ. Оросын Гадаад хэргийн сайдын "Монголд болж буй үйл явдалд амарлингуй хандах" тухай илтгэлийг хүлээн аваад Хаан түүн дээр өөрийн гараар "тиймээ, тайван харах нь зүйтэй, гэвч алмайрч болохгүй"²⁶ хэмээн цохсон байна.

Тэгвэл Бээжинд суугаа Америкийн элчин сайд Кэлхаун Вашингтонд 1912 оны 1 дүгээр сарын 8-ны орой (*Григорианы тооллоор бол 1911 оны 12 дугаар сарын 29*) яаралтай цахилгаан илгээж, түүндээ: Ар Монгол тусгаар тогтносоныг мэдэгдэхийн сацуу Оросын хяналт дор дотоод хэргээ мэдэх Ар Монголын тусгаар тогтнолыг Хятад хүлээн зөвшөөрч, харин гадаад харилцааг нь хянах, Хятадын талаас Хиагт—Хүрээний

хооронд төмөр зам барихыг Орост зөвшөөрөх, Ар Монголыг колоничлохгүй, цэргээ байрлуулахгүй байхыг Оросын тал шаардсан тухай өгүүлжээ.²⁷ Бээжинд сууж байсан Америкийн элчин сайдын яамнаас Монголын тусгаар тогтнолтой холбогдуулан хэд хэдэн цахилгаан утас төвдөө мэдэгдсэний дотор "Монголын засгийн газрыг гунхагласан ёслолыг нүдээр үзэж өвлийг Хүрээнд өнгөрөөсөн америк хүний ярианд үндэслэн"²⁸ бичсэн 1912 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 494 тоот мэдээ тун сонирхолтой байгаа юм. Уг мэдээнд: "Ар Монголын 72 хошууны төлөөлөгч оролцсон хурлаас тусгаар тогтнолыг зарлаж, Хутагтыг Хаан ширээнд залсан, Монголын засгийн газар нь гадаадын бүх үндэстнийг худалдаа, хөрөнгө оруулалтын эрх тэгш нөхцлөөр хангахаа мэдэгдсэн, Хутагт Өвөр Монголын ноёдыг Монголын эзэнт гүрэнд нэгдэхийг санал болгосон боловч одоогоор амжилт олоогүй байна"²⁹ гэх зэргээр өгүүлжээ.

Эл мэдээнд Монгол Хятадаас тусгаарласан нь хятад иргэдийн дээрэнгүй, зүй бус үйл ажиллагаатай үлэмжхэн холбоотой, Оросууд Монголчуудтай зүй ёсоор найрсаг харилцааг хэмээн бичсэн байна.³⁰

Америкийн монголч эрдэмтэн Христопор Атууд "Young Mongols and Vigilantes in Inner Mongolia's Interregnum decades, 1911-1931" бүтээлдээ "Жавзандамба хутагтыг өргөмжилсөн 1911 оноос эхлэн түүнийг нас барах хүртэл 14 жилийн турш Олноо өргөгдсөний он тоололыг Монголын засгийн газрын баримт бичгүүдэд хэрэглэж байв"³¹ гээд 1911 оны үйл явдал нь бүх монголчуудын түүхэнд чухал үйл явдал болсоныг тэмдэглэжээ.

1911 оны Монголын үндэсний хувьсгалын үйл явдлыг өөрийн нүдээр ажигласан Хятад дахь Англи, Америкийн тамхины нүүсийн төлөөлөгч Т.А.Рустад энэ үсэр Хүрээнд ирээд Английн гаймс сонины Бээжин дэх сурвалжлагч Моррисонд 1912 оны 11 дүгээр сарын 5-нд бичсэн захидалдаа: «Энэ нь Манжийн засгийн газрын эсрэг боссон хятадын хувьсгалын үргэлжлэл биш бөгөөд Монголд болсон биес даасан өөр нэг хувьсгал юм» хэмээн дүгнэсэн нь Монголчуудын үндэсний хөдөлгөөн хэр зэрэг их нөлөө бүхий байсаныг илтгэн харуулсан хэрэг юм.³²

В.Ц.Ганжуров. УБ., 2004, с.167

²⁴ Ноён Грот нь тухайн үед Хятадад алба хашиж байсан болонч Монгол дахь Оросын агтаны компанийн захиралын албтай байсан гэдэг. Ноён Грот монголчуудаас өр нэхэхдээ хатуу арга хэмжээ авч байсан тул Монгол руу илгээхэд үл тохирох хүн бичсэн хэмээн Коростонц тэмдэглэсэн байдаг. 1912 оны 1 дүгээр сарын 25-нд бичсэн нууц цахилгаандаа Люба: "Грот хятад түшмэлийн хувьд огцорсон бөгөөд Хүрээнд дэх Монголор-ын хэрэгт цаашил оролцохгүй болсон учир Петербург ялтаа" хэмээн бичсэн буй.

²⁵ И.Я.Коростонц От Чингис хана До Советской республики, Ответственный редактор О. Батсайхан, Редакторы Б.В.Базаров В.Ц.Ганжуров. УБ., 2004г. с.168.

²⁶ И.Я.Коростонц От Чингис хана До Советской республики, Ответственный редактор О. Батсайхан, Редакторы Б.В.Базаров, В.Ц.Ганжуров. УБ., 2004г. с.168.

²⁷ Р.Болд. "Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага, байр суурь, боллого (1910-1973)" сэдэнт докторын диссертаци. 2007 он. 24 дэх тал.

²⁸ Р.Болд. "Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага, байр суурь, боллого (1910-1973)" сэдэнт докторын диссертаци. 2007 он. 28 дэх тал.

²⁹ Р.Болд. "Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага, байр суурь, боллого (1910-1973)" сэдэнт докторын диссертаци, 2007 он. 28 дэх тал.

³⁰ Р.Болд. "Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага, байр суурь, боллого (1910-1973)" сэдэнт докторын диссертаци. 2007 он. 28 дэх тал.

³¹ Christopher P.Aitwood. "Young Mongols and Vigilantes in Inner Mongolia's Interregnum decades, 1911-1931". - Leiden, Boston, Koln, Brill. 2002. Printed in the Netherlands. p.189.

³² Уло Б.Баркманн Монголын түүх судлалд хувь хүний архив сонин баримт бэлдэгийн нэгэн жишээ Ж.Моррисон 1911 оны Монголын үндэсний хувьсгалын 90 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл 2001 оны 12 дугаар сарын 14-ний өдөр.

МОНГОЛ УЛСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭВЛЭН НИЙТЭЛЖ ИРСЭН ТҮҮХЭН ТОЙМ



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн “Монголын тор, эрх зүйн түүхийн судалгааны тов”-ийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант Б.Батбаяр

Монголчууд бид хууль тогтоомжийг иргэдэд түргэн шуурхай хүргэж ирсэн түүхэн уламжлалтай. “Монголын хууль гурав хоногт” гэдэг үг байдаг. Энэ үг оноогийн бид бүхний ойлгоод байгаа шиг явцуу утгаар биш, харин Монголын их эзэнт гүрний үед хууль цааз, мэдээ мэдээллийг түгээх хурдны хэмжүүрийг илтгэсэн үг байсан бололтой. Өөрөөр хэлбэл, Монголын их гүрний харьяанд байгаа улс орнуудад эзэн хааны зарлиг, цааз гурав хоногийн дотор түгэн тарж байжээ гэж хэлж болно.


Мэдээллийг асар хурдан түгээх явдал нь Монголын эзэнт гүрний хүчтэй байх, цаашид он удаан жил оршин тогтнохын баталгаа болж байв. Тэр үед мэдээллийг хурдан шуурхай түгээж байсан гол зүйл нь ортоо, улааны алба байсан бөгөөд их хааны гаргасан хууль, цааз бүхэн ард иргэдэд 3 хоногийн дотор “морин ортоо дамжин” хүрдэг

байсан нь тэр үедээ дэлхийн хүн төрөлхтнөөс хол давсан амжилт байсан тухай судлаачид¹ тэмдэглэсэн байна.

Хууль тогтоомжийг хэрэглэх, сахин биелүүлэх, түүний биелэлтийг хангах, олон нийтэд ганиулан сурталчлах, мэдээллээр хангах гол арга бол хэвлэн нийтлэх ажил юм.

Монголчууд тулгар тор байгуулаад олон зуун жилийг ардаа орхисон бөгөөд эл хугацаанд хааны зарлиг, тушаал, хууль цааз, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан хууль тогтоомжууд хэдэн мянгаар тоологдох хэмжээнд хүрчээ. Гэсэн хэдий ч түүхийн ээдрээтэй зарим үед бусдын эрхшээлд орж, буслаас хараат байсан он жилүүдэд монголын эрх зүйн хөгжил үе үе тасалданги шинжтэй болж байсан үеийн хууль цаазын эх сурвалж харьцангуй цөөн уламжлагдан иржээ.

1911 онд Монголчууд тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, тулгар тогтсон улсаа бэхжүүлэхийн гулд харанхуй хоцрогдмол урьдын байдлыг халж, ард түмнээ гэгээрүүлэх, соёлжуулах нийгмийн шаардлага зүй ёсоор урган гарч байсан бөгөөд энэ үүднээс 1913 оны 3 дугаар сард “Шинэ толь” хэмээх сэтгүүлийг анх үүтгэн санаачилж, үүндээ шинжлэх ухаан, гэгээрэл, түүх, утга зохиол, улс төрийн шинжтэй нийтлэлүүдийг хэвлэн нийтэлж олон нийтэд хүргэж байв. Анхны эл сэтгүүлээс хойш “Нийслэл хүрээний сонин бичиг”, “Монголын үнэн”, “Ардын үндэсний эрх” зэрэг сонин гарч эхэлсэн бөгөөд эдгээрт тухайн үеийн хууль дүрмүүдийг нийтэлж байснаас гадна мөн хууль



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр А.Тувшинтулга

дүрмүүдийг тусгай дэвтэр² болгон товхиж, олон зуун хувь хэвлэн гархааж байсан нь тухайн үеэлээ л дэвшилтэт явдал байв.

Олноо өргөгдсөн Монгол Улсын үеийн гол хууль болох Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичгийг Богд хааны зарлигийн дагуу тусгай комисс эрхлэн 65 дэвтрээр зохион гаргаж, ингэхдээ улсын дээд, доод хурлаар дэвтэр дэвтрээр нь хэлэлцэн баталж, хожим түүнийгээ нууц байдалд хэвлэж эхэлсэн байдаг. Энэ талаар И.М.Майский монголын төрийн хуулийг зөвхөн учир мэдэх тохоогдсон хүмүүс уншиж болох төрийн нууц гэж үздэг. Манай экспедицийг Өргөөд байх хугацаанд зөвхөн эхний наймаан дэвтэр нь хэвлэгдээд байсан, үлдсэн 56 дэвтрийг хэвлэж амжсан эсэхийг би мэдэхгүй байна³ гэжээ.

Үүнээс гадна Ардын Засгийн Шүүх яам “нугалбар бичиг” өөрөөр хэлбэл нугалсан цаасанд гараар хуулан бичиж олон аймаг,

¹ Монголын хууль гурав хоног уу. “Зууны мэдээ” сонин. 2007.7.20 №171 (2619). Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан П.Чултэсүрэнгийн ирилцлага.

² Монгол Улсын хоронгийн захирах газрын дүрэм. 1916г. Русско-Монгольская Типография нь Ургь.

³ И.М.Майский. “Орчин үеийн Монгол”. УБ., 2001 он. 331 дэх тал.

хошуунд хүргүүлдэг, үүний тул 1922 оны байдлаар Шүүх яамны орон тооны тэн хагас нь бичээч нар байсан тухай Ардын багш, гавьяат хуульч Б.Чимид тэмдэглэсэн нь буй⁴.

1921 онд Судар бичгийн хүрээлэн байгуулагдаж, улмаар монголын хууль цаазыг эрэн сурвалжлах, цуглуулах, судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах, архив, номын сангийн сан хөмрөг бүрдүүлэх ажлыг эхлүүлж, үүний хүрээнд Цэвэр Жамсрано тэргүүтэй тухайн үеийн сэхэвтнүүд монголын эртний хууль цаазын эх сурвалжуудыг олж цуглуулах, хуулбарлах, хэвлэх ажлыг эхлүүлж байсан түүхтэй.

Мөн эл үеэс эрх бүхий төрийн байгууллагуудын хурлын шийдвэр, тэрхүү хурлаар батлан тогтоосон дүрэм журмуудыг “Уриа”, “Монголын үнэн” зэрэг сонинд хэвлэхийн зэрэгцээ улсын анхдугаар их хурлаас хоёрдугаар их хурал хүртэл Бага Хурлын тэргүүлэгчид нийт 30 удаа хуралдаж энэ хооронд Сангийн явдлын яамны дүрэм, Аж ахуйн явдлын яамны дүрэм, Шүүн таслах газрын зөвлөлийн дүрэм, Эдийн засгийн зөвлөлийн дүрэм, Ой модны дүрэм, Дотоод явдлын яамны дүрэм зэрэг 20 гаруй дүрэм, тогтоолыг батлан тогтоосон байна.

Тэрчлэн Хоёрдугаар Бага хурлын тогтоолын ёсоор тэргүүлэгчдээс ухуулах бичиг гаргаж нийтээр зарласан ба Үндсэн хуулийг тайлбарлуулахаар тусгай хүнийг томилсон нь энэ завсар хараахан багталцуулан нийтэлж завдаагүй ба бас ард түмнийг удирдан боловсруулж, шинэ боловсролын байдалд урагш дэвшүүлэхийг эрхэмлэж, Үндсэн хуулийн зэрэг олон зүйл дүрэм

заавар сэтгүүл зэргийг Засгийн газраар уламжлан үлэмж тоогоор тус тус хэвлүүлэн тархаан гүйцэтгэсээр⁵ байв.

БНМАУ-ын хоёрдугаар их хурал төлөөлөгч Жадамбаа “олон зүйлийн дүрмийг батласан хэмээх нь эл дүрмийг хэвлэж нийтэлсэн эсээн, мөн олон ардууд эл гаргасан дүрмүүдийн учир утгыг бүрэн ухааж мэдсэн эсээн”⁶ хэмээн асууж байснаас үзвэл тухайн үед хууль тогтоомжийг хэвлэн нийтэлж, ард түмэнд хүргэх, ухуулж таниулах зайлшгүй шаардлага байсныг нотлон харуулж байна. Энэхүү нөхцөл байдлын үүднээс Улсын хоёрдугаар бага хурлын дөрөвдүгээр тогтоолоор батлан тогтоосон хэд хэдэн дүрмийг Үндсэн хуулийн хамт нэг дэвтэрт багтаан бүгд хоёр түмэн хувь хэвлүүлж, нийтэд зарлан, нийтээр журамлан дагаж явуулахаар хэвлэлийн хороонд өгсөн боловч уг хэвлэлийн машин зэргийг хараахан сайжруулан гүйцэтгэж завдаагүй, мөн харилцан туслалцах хоршооноос гадаадаас захисан цаас ирж эс чадсан зэрэг⁷ шалтгаанаас боогдон саатаж хугацаандаа хэвлэгдэж чадалгүй хойшлогдож байсан удаатай ажээ.

Улсын хоёрдугаар их хуралд илтгэсэн Ерөнхий сайд Б.Цэрэндоржийн илтгэлд Засгийн газрын хурлын тогтоол ба аливаа шинэчлэн тогтоосон хууль дүрэм зэргийг тусгай албаны сэтгүүл болгон сар тутам хоёр удаагаас доошгүй үлэмжхэн тоотой хэвлүүлэн нийтээр зарлан явуулж, журамлан дагаж явахад тус болгохоор Засгийн газрын хурлаар хэлэлцэн тогтсон боловч урьдах зүйлд дурдсан учир шалтгаанаас боогдон саатагдсаар хараахан үүсгэн явуулж чадаагүй бөгөөд одоо

16 дугаар он 1 дүгээр сараас эхлэн явуулахаар төлөмөн буй гэжээ⁸.

Ийнхүү албан ёсоор 1926 оноос “БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл”-д тухайн үеийн хууль, дүрмүүдийг ол дараалан хэвлэж эхэлсэн байна. Тус сэтгүүлийн анхны дугаарт Засгийн газрын нэгдүгээр хурлын тогтоолын зургаан зүйл, Улсын цагдан сэргийлэх газрын дүрэм далан гурван зүйл, Түр цагийн шүүх таслах газрын дүрэм хорин зүйл, Шинэчлэн тогтоосон шүүх цаазын бичгийн ерөнхий анги долоон бүлэг, дөчин зүйл, Улс төрийн хэрэгт холбогдох этгээдийг шүүх таслах түр хурлын дагаж явах заавар, Хянан байцаах яамны дүрэм зэрэг тухайн үеийн шинэ тутам батлагдсан дүрэм хэмжээнүүд нийтлэгдсэн байна.

1925-1930 онд Шүүх цаазын бичиг, Монгол Улсын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль, иргэн, гэр бүл, биеийн хүчнээ үнэлэгчдийн зэрэг томоохон хууль, тэдгээрт нийцүүлсэн олон тооны дүрэм зааврыг гаргажээ.

Хууль, дүрмийг олны сонорт хүргэж, түүнийг эрхэмлэн биелүүлэх үзэл дадлыг хөдөлмөрдөд төлөвшүүлэх явдал хувьсгалын ардчилсан шатнаа шинэ хууль ёсыг тогтоон бэхжүүлэх төвөгтэй зорилтын нэг байсан хэдий ч хууль зүйн албаны байгууллагууд ардын засгийн хууль дүрмүүдийг олшруулан аймаг, хошуудад хүргүүлж, орон нутгийн засаг захиргаа, хуулийн байгууллага, хөдөлмөрчдийн хурлаар дамжуулан, хүн амл өргөнөөр мэдэлэх, аймаг, хотын гонд хууль судлах дугуйлан байгуулж хичээллүүлэх зэргээр засаг төрийн бодлогыг олон түмний дотор

⁴ Монгол Улсын хууль. Эмхтгэл. Нэгдүгээр боть. УБ., 2008 он. 5 дэх тал.

⁵ “Улсын хоёрдугаар их хурал, Улсын нэг, хоёр, гуравдугаар бага хурал”. Монгол Улс, Шинжлэх ухааны академи. Түүхийн хүрээлэн. УБ., 2009 он. 21 дэх тал.

⁶ “Улсын хоёрдугаар их хурал, Улсын нэг, хоёр, гуравдугаар бага хурал”. Монгол Улс, Шинжлэх ухааны академи. Түүхийн хүрээлэн. УБ., 2009 он. 22 дэх тал.

⁷ Дэлгэрэнгүйг “БНМАУ-ын хоёрдугаар их хурал. Баримт, судалгаа”. Эрдэм шинжилгээний оршил тайлбар, монгол бичгээс хөрүүлэгч үйлдсэн Ч.Болдбаатар. УБ., 2008 он. 25-26 дахь талд үзнэ үү.

⁸ “БНМАУ-ын хоёрдугаар их хурал”. Баримт, судалгаа. Эрдэм шинжилгээний оршил тайлбар, монгол бичгээс хөрүүлэгч үйлдсэн Ч.Болдбаатар. УБ., 2008 он. 26 дахь тал.

дэлгэрүүлж, тэдний ухамсар, хүмүүшлийг төлөвшүүлэх, олон хэлбэрийн ажил зохиож байв. Эдгээрийн дотор байгууллагын улирдах ажилтла, бусад ажиллагсад, иргэдийн чухал хэрэгцээ болсон хууль зүйн ном хэвлэлийн ажил мэдэгдэхүйц байр эзэлж ирсэн юм. БНМАУ-ын Шүүх яам уг ажлыг төвлөрүүлэн эрхэлж, хөдөлмөрчдөд зориулсан сэдэвчилсэн эмхтгэл, тайлбар ном зохиол, түүнчлэн 1927 оноос "Хувьсгалт хууль ёсны төлөө" сэтгүүл гаргаж, төр, эрх зүйн асуудлыг нийтэлж байсан зэрэг нь хууль зүйн соёлыг түгээж, хөдөлмөрчдийн улс төр, эрх зүйн ухамсрыг дээшлүүлэхэд тус нөлөө үзүүлсэн нь дамжиггүй". Үүний зэрэгцээ "Арлын үндэсний эрх" зэрэг сонинд хууль, дүрмүүдийг цолээлгүй хэмжээгээр хэвлэн нийтэлж байв.

1930 оны 8 дугаар сарын 15-нд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид ба Засгийн газрын эрхлэх товчоо хураллаж "Хууль, дүрмүүдийг нэгэн мөр дагаж гүйцэтгэх тухай"¹⁰ тогтоолыг гаргажээ. Уг тогтоолд "Засгийн газрын албаны сэтгүүлд хэвлүүлэн нийтлэсэн буюу тусгай зарласан Улсын бага хурлын тэргүүлэгчид ба Засгийн газруудаас батлан тогтоосон аливаа хууль, дүрмүүдийг аймаг, хотын ба хошуудын төр, орон нутгийн захиргааны газруудад уул сэтгүүл буюу мөн тусгай зарласан хуулиудыг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсонд тооцож дагаж хэрэглэх, аливаа нийтлэсэн хууль, тогтоол, тусгай зарласан дотор тухай бүр дагаж хэрэглэх хугацааг заасан бол даруй зохих газруудаас уул хугацааг баримтлан дагаж гүйцэтгэх, аливаа нийтлэсэн хууль, тогтоол, тусгай зарласан дотор тухай бүр дагаж хэрэглэх явдлыг

цахилгаан мэдээгээр уламжлан гүйцэтгээгүй хэмээн заасан зүйл байвал орон нутгийн захиргааны газруудад уул мэдээг хүлээн авсан цагаас эхлэн хүчин төгөлдөр болсонд тооцож гүйцэтгэх, нийтлэн зарлахгүйгээр шийтгэн гаргасан аливаа тогтоолуудыг зохих газруудад хүлээн авсан цаг үеэс эхлэн ёсоор дагаж гүйцэтгэх" эрх зүйн зохицуулалтыг зааж өгчээ. Эл тогтоолын дөрөв дэх хэсгийн "нийтлэн зарлахгүйгээр шийтгэн гаргасан аливаа тогтоолуудыг зохих газруудад хүлээн авсан цаг үеэс эхлэн ёсоор дагаж гүйцэтгэвэл зохино" гэсэн нь тухайн үед батлан тогтоосон хуульд хугацаа заагаагүй бол төв ба орон нутгийн захиргааны газрууд Засгийн газрын албаны сэтгүүл болон тусгай дэвтрээр хэвлэсэн хуулиудыг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсонд тооцож, дагаж мөрддөг байсан нь тун сонирхолтой юм.

"БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл" 1926-1930 он хүртэл нийт тавин долоон дугаар гарсан бөгөөд 1931 оноос хойш "Монгол Ард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид ба Засгийн Газрын хуудалд хийгээд тушаалуудыг эмхтгэн хавсруулсан сэтгүүл", 1940-өөд оноос 1970 он хүртэл "БНМАУ-ын Хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл", 1971 оноос 1990 он хүртэл "БНМАУ-ын Хууль, зарлиг, тогтоолын эмхтгэл", 1991 оноос "Төрийн мэдээлэл" эмхтгэл нэрээр тогтмол нийтлэгдэж ирэв.

1939, 1940 оны үед хууль тогтоомжийг чухам ямар сэтгүүлд нийтэлж байсныг бид энэ удаад тодруулж эс амжив. Ямартай ч 1939, 1940 оны үеийн хууль тогтоомжийг тусгай дэвтрээр¹¹ хэвлүүлж байсан бөгөөд чухам юуны учир эл сэтгүүлийн хэвлэлт тасалдахад хүрэв. 1939 оны Халхын голын

дайн, эсвэл тэр үеийн Монголын эдийн засгийн доройтол, банк санхүүгийн хямрал, их хэлмэгдүүлэлт зэрэг үүнд нөлөөлсөн байж тун магадгүй юм. 1941-1946 он хүртэл "Улсын Бага хурлын Тэргүүлэгчид ба Арлын Сайд нарын Зөвлөлөөс гаргасан хууль, дүрэм, тогтоолуудын эмхтгэл", мөн 1941-1943 онд "Улсын бага хурал, Засгийн газраас гаргасан хууль, дүрэм, тогтоолуудын эмхтгэл", 1946 оноос "БНМАУ-ын Засгийн газрын эмхтгэл" болон "БНМАУ-ын хууль дүрэм, тогтоолын эмхтгэл"-үүд нь зэрэгцэн гарч байв. 1967 онд хэвлэгдсэн ном зүйн лавлах¹² дээр дурдсан гурван өөр эмхтгэлүүдийг ялган салгалгүйгээр нийтэд нь "Хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл" хэмээн товчлон нэрлэж, мөн зүйн лавлагаа, бүртгэлийг үйлдэжээ. Угтаа "Улсын Бага хурлын Тэргүүлэгчид ба Арлын Сайд нарын Зөвлөлөөс гаргасан хууль, дүрэм, тогтоолуудын эмхтгэл", "Улсын бага хурал, Засгийн газраас гаргасан хууль, дүрэм, тогтоолуудын эмхтгэл", "БНМАУ-ын хууль дүрэм, тогтоолын эмхтгэл" гэсэн гурван өөр нэртэй сэтгүүл бөгөөд эхний хоёр сэтгүүлийн 1946 оноос хойш гарсан дугаарыг бид хараахан олж үзэж чадсангүй. Эл үеэс хойш уг хоёр сэтгүүл гараагүй бололтой. Ямартай ч 1946 оноос "БНМАУ-ын хууль дүрэм, тогтоолын эмхтгэл" нь "Төрийн мэдээлэл" сэтгүүл гарах хүртэл тасралтгүй үргэлжлэн хэвлэгдсэн байна.

Энэ завсар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1958 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 74 дүгээр тогтоол гарч, энэхүү тогтоолын дагуу БНМАУ-ын яам, тусгай газар, аймаг, хот, сум, хороо, баг, хоринь гүйцэтгэх захиргааны албан хэрэгцээнд зориулан хууль, дүрэм,

¹⁰ Монгол Улсын Хууль зүйн албаны үүсэл хөгжил. Кэму. Архив, албан хэрэг хөтлөлтийн мэдээлэл арга зүйн улирал тутмын сэтгүүл. Монгол Улсад Хууль зүйн алба байгуулагдсаны 85 жилийн ойд зориулсан тусгай дугаар. 6-7 дахь тал.

¹¹ БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл. №57. 1930 он. 58 дахь тал.

¹² Ашиг орлогоос хураах албан татварын ба соёл бэлэнсрэлдэг өргөтгөн хөгжүүлэхийн тулд зориулан хураах татварын хуулиуд нь бид энэхүү татваруудыг биеийн хүнчээ үнэлэгчдээс хэрхэн хурааж журмын тухай заавруудыг хамтатгасан дэнтэр. Хорин сөн он, нэг сард. Улаанбаатар хот. Ард түмнээс юуны урьд чухалчлан танилцаж биелүүлбээс зохих хууль дүрмүүдийг эмхтгэсэн дэнтэр. Шүүх илчдын яамны хэлэл. Хорин сөн он, тинян сард. гэх мэт.

¹³ "БНМАУ-ын Төрийн Дэд байгууллагаас гаргасан хуульчилсан актуудын ном зүйн лавлах" 1926-1966 он. УБ., 1967 он.

тогтоолыг эмхтгэн сэтгүүл болгон улиралд нэг удаа 6000 ширхэгээр, улирал бүрийн эхний сард хэвлэн, дээр нэр дурдсан газруудад тусгай хувинаар тарааж байв.

БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1959 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 52 дугаар зарлигаар БНМАУ-ын Шүүх яамыг татан буулгасны дараа БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн мөн оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 210 дугаар тогтоолоор тус улсын хууль, хуульчилсан баримтуудыг боловсруулах, тэдгээрийг системчлэх, ангилах үүрэгтэй Хууль цаазны хороог байгуулсан байна. Төр засгаас хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шүүн таслах ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хууль зүйн албаны салбарын удирдах байгууллагын системд зарчмын өөрчлөлт оруулж, хууль боловсруулах, системчлэх ажлыг шинэ байгуулсан Сайд нарын Зөвлөлийн Хууль цаазны хороонд эрхлүүлжээ.

Эл үеэс эхлэн хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрдэмтэн судлаачид нийгэм эдийн засаг, төрийн байгуулалтын чиглэлээр төрийн эрх бүхий байгууллагаас баталсан хууль, зарлиг, захиргааны актуудыг тодорхой эрхийн салбаруудаар нь, мөн тухайн цаг үеийн улс төрийн зүтгэлтнүүдэд холбогдох баримт бичгийг системчлэн нэгтгэн эмхтгэж эхэлжээ. Үүний хүрээнд Мал эмнэлгийн дүрэм зааврын эмхтгэл, Байгаль, байгалийн баялгийг хамгаалах талаар гарсан хууль, тогтоомжийн системчилсэн эмхтгэл 1921-1975 он, БНМАУ Захиргааны эрхтэй холбогдох хуульчилсан актуудын системчилсэн эмхтгэл, В.И.Лениний тухай монголын гүүхэн гол баримт бичгүүд. 1917-1970 он, МАХН-аас МХЗЭ,

залчуудын тухайд явуулсан бодлого. (Баримт бичгийн эмхтгэл) 1921-1976 он, Монголын ард түмний 1911 оны Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө гэмцэл. Баримт бичгийн эмхтгэл. (1900-1914 он), Социалист өмчийн талаар гарсан хууль тогтоомжийн эмхтгэл (1967-1975 он), Шинэ бүтээл, оновчтой саналын талаархи хууль тогтоомжийн системчилсэн эмхтгэл 1960-1975, БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох эрхийн актын эмхтгэл (2 боть бүтээл), Аж үйлдвэрийн талаар гаргасан хуульчилсан актуудын системчилсэн эмхтгэл (1950-1960 он), Соёл гэгээргийн байгууллагын ажлын талаар холбогдолтой зарлиг тогтоол, заалтуудын системчилсэн эмхтгэл (1940-1961 он), Эмэгтэйчүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хуульчилсан актуудын эмхтгэл, Санхүүгийн хяналт, шалгалтад холбогдох хуульчилсан актуудын эмхтгэл 1975-1977 он (2 боть) гэх мэт тодорхой эрхийн салбар тус бүрээр нэлээд олон эмхтгэл гарсныг дурдах хэрэгтэй.

Эдгээрээс хамгийн томоохон системчилсэн эмхтгэл нь БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл 1982 онд "Хууль тогтоомжийг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай", "БНМАУ-ын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн системчилсэн бүрэн эмхтгэл бэлтгэн хэвлүүлэх тухай" 1, 2 дугаар тогтоол гаргаж тэр үеийн Шүүх яаманд төвлөрүүлэн, Улсын Комисс эрхлэж гаргасан "БНМАУ-ын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн системчилсэн бүрэн эмхтгэл"¹¹ болно. Эл эмхтгэлд 1940 оноос хойш 1980-аад оны дунд үеийг хүртэл хамарсан хууль тогтоомжуудыг улс төрийн байгуулалт, нийгэм, эдийн засаг, улс ардын аж ахуйн салбараар төрөлжүүлэн нэгтгэж 7 ботиор хэвлүүлсэн нь практикийн төдийгүй

судалгааны үнэ цэнэтэй ажил болсон юм.

1971 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн "Хууль, зарлиг, тогтоолыг хэвлүүлэх ажлыг журамтай болгох тухай"¹² БНМАУ-ын СнЗ-ийн 291 дүгээр тогтоолоор "БНМАУ-ын Хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл"-ийг 1971 оноос эхлэн "БНМАУ-ын хууль, зарлиг, тогтоолын эмхтгэл" болгож, сар тутам гаргаж байхаар заасан бөгөөд "БНМАУ-ын хууль, зарлиг, тогтоолын эмхтгэл"-д БНМАУ-ын хууль, эрхийн хэм хэмжээ тогтоосон Ардын Их Хурлын Тэргүүлэгчийн зарлиг, МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн хавсарсан тогтоол, Сайд нарын Зөвлөлийн тогтоолыг албан хэрэгцээнд зориудан нийтлэх, уг эмхтгэлийг яам, тусгай газар, хоршоолол, олон нийтийн төв байгууллага, аймаг, хотын намын хороо, гүйцэтгэх захиргааны жил бүрийн захиалгыг үндэслэн шаардагдах тоогоор хэвлүүлэх, БНМАУ-ын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын байгууллага, иргэдийн зайлшгүй мэдэж, дагаж мөрдөлд зохих зарим хууль, зарлиг, тогтоолыг орос хэлээр орчуулан дангаар буюу тусгай эмхтгэл болгон хэвлүүлж холбогдох яам газруудад тараах ажлыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хууль цаазны хороо эрхлэн хариуцаж байхаар тогтоожээ. Үүний дагуу БНМАУ-ын хууль, зарлиг, тогтоолын зарим эмхтгэлийг "Сборник законов и постановлений правительства Монгольской народной республики. Министерство юстиции МНР. Улан-Батор 19..." нэрээр орос хэлээр орчуулан хэвлүүлж байв. Энэ талаар хууль, дүрэм, тогтоолыг орос хэлээр тусгай эмхтгэл болгон 1940-оод оноос нэлээд хэдэн дэвтрийг хэвлүүлж байсан гэж түүхийн ухааны доктор З.Лонжид багш хэлж байсан боловч бид энэ удаад тэрхүү орос хэлээрх эмхтгэлийг хэдэн

¹¹ "БНМАУ-ын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн системчилсэн бүрэн эмхтгэл", 8 боть. УБ.,

¹² "БНМАУ-ын захиргааны эрхийн холбогдолтой зарим хууль тогтоомжийн системчилсэн эмхтгэл". №3. УБ., 1979 он. 22-24 дэх тал.

опоос, хэд хэднээн дугаар гаргаж байсныг, мөн эдгээр эмхтгэлүүд нь үе үе гарч байсан уу, эсвэл тогтмол хэвлэгдэж байсан уу гэдгийг тодруулж амжсангүй. Умартай ч хууль, дүрэм, тогтоолыг тухайн үед нийтлэг хэрэглэж байсан гадаад хэлээр орчуулан, гадаадын хүмүүст зориулан хэвлэж байжээ. Мөн үүнээс бүр өмнө, тухайлбал 1925 ойд “Хуучны зүйлийг сахин хамгаалах тухай дүрэм”¹⁵ зэргийг тусгай дэвтрээр монгол, орос, англи хэлээр хэвлүүлж байсан баримт нэг бус бий.

1972 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Ардын Их Хурлын Тэргүүлэгчид БНМАУ-ын хууль, БНМАУ-ын Ардын Их Хурлын тогтоол, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, тогтоолыг нийтлүүлэх, тэдгээрийн хүчин төгөлдөр болох хугацааг журамтай болгох зорилгоор “БНМАУ-ын хууль, Ардын Их Хурлын тогтоол, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, тогтоолыг нийтлүүлэх, хүчин төгөлдөр болсонд тооцох журмын тухай”¹⁶ 208 дугаар зарлигийг баталжээ.

Уг зарлигт дурдсан эрх бүхий субъектээс батлан гаргасан эрх зүйн актыг хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөр болсонд тооцох, төв орон нутгийн байгууллага болон олон нийтэд хүргэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан байна. Түүнчлэн БНМАУ-ын хууль, БНМАУ-ын Ардын Их Хурал, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс гаргасан хууль, бусад эрхийн актыг баталсан өдрөөс хойш 7 хоногийн дотор Намын төв хороо, Засгийн газрын “Үнэн” сонинд нийтлүүлж байхаар заажээ.

Энэхүү зарлигаар хууль тогтоомжийн актыг хүчин төгөлдөр болох хугацааг тухайн актад тусгайлан заагаагүй, эсхүл эрхийн хэм хэмжээ тогтоогоогүй бол хууль, зарлиг, тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болохоор заасан нь одоогийн Үндсэн хуулийн (1992 он) Хоринзургадугаар зүйлийн 3-д “Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно” гэж зааснаас зохицуулалтын хувьд ялгаатай байсныг гэмдэлгэх хэрэгтэй.

Мөн БНМАУ-аас гадаад улстай байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр бусад баримт бичиг, тэдгээрийг баталсан Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигийг БНМАУ-ын Гадаад явдлын яамны улмжилснаар Намын төв хороо, Засгийн газрын “Үнэн” сонин, “Хууль, зарлиг, тогтоолын эмхтгэл” сэтгүүлд нийтлүүлж байсан бөгөөд харин олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцийг тэр бүр бүрэн хэмжээгээр нийтэлж байсангүй.

БНМАУ-аас гадаад улстай байгуулж тогтоосон журмаар батламж бичиг солилцсон гэрээ, хэлэлцээр, конвенц болон тэдгээрийг баталсан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигийг шаардлагатай бол БНМАУ-ын Гадаад явдлын яамны улмжилснаар Намын Төв Хороо, Засгийн газрын “Үнэн” сонин, «БНМАУ-ын хууль, зарлиг, тогтоолын эмхтгэл» сэтгүүлд нийтлүүлж байх тухай зарлиг

гарахаас өмнө өөрөөр хэлбэл, 1964 оноос Гадаад явдлын яамнаас эрхлэн БНМАУ-ын гадаад харилцаанд холбогдох баримт бичгүүд, хоёр талт болон олон талт гэрээ хэлэлцээр, мэдэгдэл, нот, БНМАУ бусад улсыг хүлээн зөвшөөрсөн, дипломат харилцаа тогтоосон тухай баримт бичгүүдийг уншигчдын албан ажил, эрдэм шинжилгээний болон бусад хэрэгцээнд тус болох зорилгоор хэвлэн нийтэлж эхэлсэн бөгөөд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл¹⁷ нь нийт найман дугаар гарчээ.

Энэ завсар ардчилсан хувьсгал өрнөж улс орон ардчилсан дэглэм, зах зээлийн харилцаанд шилжсэнээр Үндсэн ба бусад хууль, тэдгээрийг дагалдсан дэд акт нэлэнхүйдээ шинэчлэгдэн өмнөх эмхтгэлүүд түүх, соёлын өв болон үлдэв. Хөгжлийн шинэ үеийн хууль, зарлигуудын албан ёсны эхийг 1991 оны эхнээс “Төрийн мэдээлэл” албан сэтгүүлд он дараалан нийтлэж ирснээс гадна хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг Улсын Их Хурлын эрх олгосноор Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний төв цуврал маягаар, мөн сэдэвчилсэн байдлаар эмхтгэн хэвлэж олон түмэнд түгээж ирэв¹⁸.

БНМАУ-ын Бага хурлын тухай хууль¹⁹-д “БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэр хүчин төгөлдөр болох, тэдгээрийг нийтлэх журам”-ын талаар заасан бөгөөд үүнд тус хуулийн 24 дүгээр зүйлд БНМАУ-ын хуулийг батламжлагдсанаа нь, Улсын Бага Хурлын бусад шийдвэрийг

¹⁵ Хуучны зүйлийг сахин хамгаалах тухай дүрэм. Закон об охране памятников старины. Law protecting remains of antiquity. Улан-Батор-Хото. Изданице Ученого Комитета Монголии. 1925 год.

¹⁶ “БНМАУ хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл”. 1972. №10. 507-509 дэх тал.

¹⁷ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. I боть. (1921-1961). УБ., 1964 он. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. II боть. (1962-1966). УБ., 1966 он. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. III боть. (1966-1971). УБ., 1972 он. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. IV боть. (1971-1975). УБ., 1980 он. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. V боть. (1976-1978). УБ., 1981 он. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. VI боть. (1979-1981). УБ., 1985 он. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. VII боть. (1982-1983). УБ., 1987 он. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. VIII боть. (1984-1985). УБ., 1988 он. “Монгол Улсын хууль. Эмхтгэл”. Нэгдүгээр боть. УБ., 2008. 5 дахь тал.

¹⁸ “БНМАУ-ын Бага хурлын тухай хууль”. 1991 он. “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны №1-д нийтлэгдсэн.

батлагдсанаас нь хойш Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга зөвшөөрснөөр 3 хоногийн дотор “Ардын эрх” сонинд нийтэлнэ. БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэр нь тэдгээрт тухайлсан хугацаа заагаагүй бол “Ардын эрх” сонинд нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно гэж мөн хуулийн 25 дугаар зүйлд БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэрийг нийтлэх талаар зохицуулсан бөгөөд БНМАУ-ын хууль, Улсын Бага, Хурлын бусад шийдвэрийн эхийг Улсын Бага Хурлын Тамгын газар эрхлэн “Төрийн мэдээлэл” сэтгүүлд болон “Ардын эрх” сонинд нийтлэх, энэхүү сонин болон сэтгүүлд нийтлэгдсэн хууль, бусад шийдвэрийг албан ёсны эх гэж тооцож байх тухай зохицуулсан байна.

1991 оноос өмнө “БНМАУ-ын хууль, зарлиг, тогтоолын эмхтгэл”-ийг зөвхөн албан хэрэгцээнд зориулан гаргаж байв. Энэ нь иргэд хуулийг уншиж судлах, мөрдөж хэрэгжүүлэх өргөн бололцоо олгохгүй байна гэж Улсын Бага Хурал үзээд “Төрийн мэдээлэл” сэтгүүлийг тогтмол гаргах аар шийдвэрлэж улмаар БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэрийн эхийг Улсын Бага Хурлын Тамгын газар эрхлэн, “Төрийн мэдээлэл” сэтгүүл болон “Ардын эрх” сонинд нийтлэхээс гадна тохимол болгон хэвлүүлж болохыг хуульчилсан байна.

Энэ дагуу Улсын Бага Хурлын даргын 1991 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 18 дугаар захирамж²⁰ гарч, уг захирамжаар төрийн хууль, тогтоолыг бүрэн эхээр нь хэвлэн нийтлэх зорилгоор “Төрийн мэдээлэл” сэтгүүлийг Улсын Бага Хурлын Тамгын газраас эрхлэн сар тутам, анхны дугаарыг туршилтын журмаар 10000 ширхэг хэвлүүлж түүнийг мэдээлэх зорилгоор 5000

ширхэгийг Ардын Их Хурлын Депутат, Бага Хурлын гишүүд, улс, нам, олон нийт, хоршооллын төв байгууллагууд, номын сангуудад жасгаалтаар үнэгүй тарааж үлдсэн хэсгийг холбоо номын худалдааны байгууллагуудаар дамжуулан худалдах, түүнчлэн “Төрийн мэдээлэл” сэтгүүлийг 1991 оны 3 дугаар улирлаас нийтийн захиалгад оруулах ажлыг эхлүүлэхээр уг зарлигт заажээ.

1993 оны намрын чуулганаар УИХ-ын тухай хуульд нэмэлт, мэдээллээс бусад хэвлэх ажлыг тусгай зөвшөөрлийн дагуу хийх ёстой билээ. Иймээс аль нэг дурын байгууллага хуулийн эмхтгэлийг хэвлэн нийтэлснээс үүдэн хожим ямар нэгэн сөрөг үр дагавар бий болохыг үгүйсгэхгүй. Өөрөөр хэлбэл хууль бол тодорхой харилцааг зохицуулж байдаг албан ёсны акт учраас тухайн хэвлэгдэн гарсан хууль тогтоомжийн найдвартай байдлын баталгаа зайлшгүй чухал юм. Иймд энэ ажлыг хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийн үндсэн дээр тодорхой шаардлага шалгуурын дагуу эрхэлдэг байх нь чухал.

1998 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоол²¹-оор хууль, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар болон хуулиар олгогдсон эрх бүхий байгууллагын нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг гагцхүү “Төрийн мэдээлэл” эмхтгэлд албан ёсоор хэвлэн нийтэлж байхаар тогтоов.

“Төрийн мэдээлэл” эмхтгэлд хууль, УИХ-ын бусад шийдвэрээс гадна Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаархи Улсын Дээд Шүүхийн албан ёсны тайлбарыг, мөн холбогдох хуулийн дагуу Монгол

Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаархи оны илтгэл, албан тушаалтнуудын хөрөнгө орлогын байдлын талаархи Авлигатай тэмцэх Газрын мэдээллийг нийтэлж байгаа билээ. Гэсэн хэдий ч энэ бүгдийг тэр бүр бүрэн хамруулж байсангүй, тийм боломж ч хязгаарлагдмал юм.

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн тусгай дугаарыг 2004 оноос эхлэн хэвлэн гаргаж буй бөгөөд энэ хугацаанд нийт 8 тусгай дугаарыг ГХЯ, ХЗДХЯ, Хүний эрхийн Үндэсний комисс, Оюуны өмчийн газар зэрэг байгууллагатай хамтран хэвлэн гаргажээ. Тэдгээрт Монгол Улс нэгдэн орсон хүний эрх, олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, оюуны өмчийн эрх зүй, олон улсын худалдааны эрх зүй, олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенци, дипломат консулын харилцаа, олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм, терроризмын эсрэг болон бусад гэмт хэргийн эсрэг конвенц зэргийг тус тус нийтлээд байна.

Сүүлийн үед судлаачид хууль, хууль тогтоомжийг баримт бичиг, эмхтгэл, судалгаа, лавлагаа гэх мэт шинжлэх ухааны янз бүрийн арга, арга зүйгээр судлан нийтлүүлж байна. Тухайлбал, 2004 онд Академич Ж.Амарсанаа, доктор О.Батсайхан нар “Монгол Улсын Үндсэн хууль”²² баримт бичгийн эмхтгэл хэвлүүлсэн бөгөөд энэхүү эмхтгэлд 1924-1992 оны Үндсэн хуулиудыг үндсэн эхээр нь хэвлүүлснээс гадна Үндсэн хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд, уг хуулийг хэлэлцсэн УИХ, УБХ-ын тэмдэглэл, Үндсэн хууль батлахад хэлэлцүүлсэн илтгэлүүдийг архивын материалд гулгуурлан бүрэн эхээр нь хэвлэжээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн түүхийг судлахад чухал ач холбогдол бүхий судалгааны хэрэгслэлүүд болсон билээ. Мөн 2008 онд МУИС-ийн

²⁰ БНМАУ-ын Бага Хурлын даргын захирамж. 1991 оны 3 дугаар сарын 19-ний өдөр. Дугаар 18. Улаанбаатар хот. УИХ-ын Тамгын газрын архив.

²¹ “Төрийн мэдээлэл”. 1998 он. №9.

²² “Монгол Улсын Үндсэн хууль. Баримт бичиг”. Эмхтгэж тайлбар бичсэн Ж.Амарсанаа, О.Батсайхан. УБ., 2004 он.

ХЗС-ийн Монголын төр, эрх зүйн түүхийн судалгааны төвөөс "Монгол Улсын хууль тогтоомжийн хөгжлийн түүхэн товчоон"³¹ бүтээлийг хэвлүүлээ. Эл бүтээлд Монгол Улсын хууль тогтоомжийг 1911-2007 оныг луустал он дарааллаар нэгтгэн, товч лавлагааг гаргасан бөгөөд судлаачдал түүхэн цаг үеийн эрх баригчдын улс төрийн бодлого, эдийн засаг, нийгмийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж байсан арга хэмжээг эрх зүйн хэм хэмжээний тусламжтайгаар цэгцтэйгээр суллах боломж олгож, мөн хууль тогтоомжийг хүчинтэй, хүчингүйг үл харгалзан нэгтгэн эрэмбэлсэн нь судалгааны хөтөч төдийгүй хууль цаазын эх сурвалж, хууль тогтоомжийг судалгааны эргэлтэд оруулж чанаржуулах, онолын дүгнэлтийн үндэслэлийг сайжруулах, хууль зүйн шинжлэх ухааны суурь судалгааг хөгжүүлэхэд ач холбогдолтой болсон. Судалгаанд Монгол Улсын 96 жилийн хууль тогтоомжийг эх сурвалжийн түвшинд, заримыг товч лавлагаа байдлаар оруулахад 1930-1950 оныг хүртэлх хугацааны хууль тогтоомжийг олдсоны хэмжээгээр оруулан нэгтгэхийг эрмэлзсэн болно. Ер нь энэ үеийн хууль тогтоомжийг тухайн үед хэвлэж байсан эмхтгэл байдаг боловч тухайн цаг үеийн нийгэм, улс төрийн нөхцөл байдлаас хамаарч тэр бүр бүрэн хэмжээгээр хэвлэж байгаагүй бололтой. Мөн нөгөө талаар өнөөдрийг хүртэл энэ цаг үеийн хууль тогтоомжийн ангилалд хамаарах эрх зүйн эх сурвалжууд Батлан ​​хамгаалах яамны болон Тагнуулын газрын архивуудад нууцлалын зэрэглэлтэй хадгалагдаж байна. Монголын төр, засгаас батлан ​​дагаж шийтгүүлсэн албан ёсны шийдвэр нь Монгол

төрийн тусгаар тогтнолоо сэргээн гунхагласан тэр үеэс хойшхи зуу орчим жилийн дотор төр засгаас боловсруулан хэрэгжүүлсэн дотоод, гадаад бодлогын өргөн цар хүрээтэй янз бүрийн сэдэв асуудлыг тал бүрээс нь нэхэн шинжилж, бодитой дүгнэлт өгч, оносон алдсанаа ухааран эргэцүүлж, өнөөгийн байдалдаа дүн шинжилгээ хийж ирээдүйн төлөвөө онож тодорхойлоход үнэлж баршгүй ач холбогдолтой болно. Хураангуйлж хэлэхэд сүүлийн нэгэн зууны Монголын түүх, эрх зүй, монгол судлалын аль ч сэдэв асуудлаар судалгаа хийх эрдэмтэд, Монголыг сонирхдог хэн боловч энэ бүтээлд хэвлэсэн баримтуудаас үнэн зөв, тодорхой мэдээлэл авах боломж хангалттай.

Судлаач, эрдэмтдийн эдгээр ажлын зэрэгцээ төр засгийн дэмжлэгээр хууль тогтоомжийг нийтэд хүргэх ажил чамлахааргүй хэмжээнд өрнөж байгааг дурдах хэрэгтэй. Анх Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, системчлэх, хэвлэн нийтлэх, олон нийтэд таниулах зэрэг ажлыг Шүүх яам 1921 оноос, түүний дараа Сайд нарын Зөвлөлийн Хууль цаазны хороо 1958 оноос, Шүүх яам 1972 оноос, Хууль зүй, арбитрын яам 1989 оноос, Хууль зүйн яам 1990 оноос, Хууль зүй, дотоод хэргийн яам 2000 оноос эрхлэн хариуцаж олон нийтэд хүргэж ирсэн бөгөөд эдгээр байгууллагын хийсэн, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь дараа дараагийн шатны үйл хэрэгт хөрс суурь нь болж өгсөн.

Монгол Улсын ХЗДХЯ-ны Хууль зүйн мэдээллийн төвөөс эрхлэн 1992-1996 оны хууль тогтоомжуудыг дангаар болон цувралаар³², мөн Хууль зүйн үндэсний төвөөс Монгол Улсын хуулиуд (цуврал) эмхтгэлийн 16

дугаарыг он дараалсан байдлаар³³, үүнээс гадна тодорхой эрхийн салбараар төрөлжүүлэн нэлээд олон хууль, хууль тогтоомжийн эмхтгэлүүдийг гаргажээ. Иймэрхүү салбар эрх зүйн чиглэлээрх хуулийн эмхтгэлүүдийг Хууль зүйн үндэсний төв³⁴ болон бусад төрийн болон төрийн бус байгууллагууд одоог хүртэл албан бус эмхтгэл хэлбэрээр хэвлэн гаргасар байна.

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "Үндэсний хууль тогтоомжийн системчлэлийг боловсронгуй болгож, эрх зүйн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх ажлыг эхлүүлнэ", мөн "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2006 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолд "Үндэсний хууль тогтоомжийн системчлэлийг боловсронгуй болгох, эрх зүйн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх хүрээнд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудыг 6 ботиор, мөн Монгол Улсын түүхэнд холбогдох (1206-2006 он) хууль тогтоомжийн он дараалсан эмхтгэлийг 16 ботиор хэвлэн гаргах"-аар тус тус заажээ.

Засгийн газрын 2007 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 33 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 86 дугаар тушаалаар тэдгээр эмхтгэлийг бэлтгэж, хэвлэн гаргах ажлыг Хууль зүйн үндэсний төвд хариуцуулсны дагуу тус төвөөс хүчин төгөлдөр хуулийг 4 боть³⁵-д эрэмбэлэн хэвлэн нийтлээд байна. Энэхүү Монгол Улсын хуулийн эмхтгэл 4 ботид Монгол Улсын

³¹ "Монгол Улсын хууль тогтоомжийн хөгжлийн түүхэн товчоон". (1911-2008 он). УБ., 2008 он.

³² "Монгол Улсын хуулиуд (цуврал эмхтгэл)". 1992-1996 он. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам. Хууль зүйн мэдээллийн төв. УБ., 2002 он гэх мэт.

³³ "Монгол Улсын хуулиуд". Эл цуврал эмхтгэл нь 2003-2009 он хүртэл нийт 16 дугаар гарчээ.

³⁴ Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 18 дугаар тогтоолоор тус төвийн бүтэц, зохион байгуулалт, нэрийг өөрчлөн Хууль зүйн үндэсний хүрээлэн болгож өөрчилсөн.

³⁵ Монгол Улсын хууль. Эмхтгэл. Нэгдүгээр боть. УБ., 2008 он, Монгол Улсын хууль. Эмхтгэл. Хоёрдугаар боть. УБ., 2008 он, Монгол Улсын хууль. Эмхтгэл. Гуравдугаар боть. УБ., 2008 он, Монгол Улсын хууль. Эмхтгэл. Дөрөвдүгээр боть. УБ.

хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудыг оруулсан ба эдгээр хуулиудыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 147 дугаар тушаалаар батлагдсан “Эрх зүйн актын антилагч”-ийг үндэслэн 4 боть болгон системчилсэн бөгөөд цаашдаа ботиудад орсон хуулийн нэмэлт, өөрчлөлтийг нэг багц болгон хэвлэж нийтэд түгээх юм. Энэхүү ажил нь эрх зүйн мэдээллийг нийтэд хүргэх, хуулийг албан тушаалтан, иргэд хэн боловч өөр өөрийн хэрэгцээнд ашиглахад зохих хувь нэмрээ оруулж, эрх зүйн мэдээллийг хүртээмжтэй болгоход ихээхэн ач холбогдолтой болсон тул зориуд цохон тэмдэглэв.

Өдгөө 1206-2009 онд үйлчилж байсан Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн бусад актуудыг олж судлан, боловсруулж, он дараалан эмхтгэх нөр их ажил дуусах шатандаа явж байна. Өнгөрсөн зууны эхэн үеэс хойшхи эрх зүйн тогтолцоог нарийвчлан судалж төрийн байгуулал, байгууламжийн онцлог, эрх зүйн эх сурвалжуудыг судалж дүгнэлт өгсөн бүтээл ховор байна. Ялангуяа соц нийгмийн үеийн хууль, хуулийн дэд актууд, тэр үед гарч байсан албан болон албан бус сэтгүүл, сонин, тусгай дэвтрүүдийг Монгол Улсын Засгийн газрын архив, Үндэсний төв архив, Үндэсний номын сан зэрэг цөөн хэдэн байгууллагад хадгалж буй хэдий ч бүрэн хэмжээгээр хадгалан үлдсэнгүй. Энэ нь архив, номын сангийн сан хөмрөгийг даацтайхан бүрдүүлэх шаардлагатай гэдгийг харуулж байна.

Ийнхүү үе үеийн судлаач эрдэмтэд, хууль зүйн албаны байгууллага, төр засгийн бодлогын хүрээнд хууль тогтоомжийг хэрэглэх, сахин биелүүлэх, түүний биелэлтийг хангах, олон нийтэд таниулан сурталчлах, олон нийтийг хууль эрх зүйн мэдээллээр хангах ажлыг албан болон албан

бусаар янз бүрийн арга хэлбэрээр хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ нь иргэд, албан тушаалтан хууль тогтоомж, хуулийн дэд актуудыг судалж, сахин биелүүлэх, хэрэглэх эрх зүйн ухамсар соёлыг түгээх, төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байсныг дурдах нь зүйтэй.

Өдгөө манай улсад хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл (телевиз, радио, FM, сонин сэтгүүл), интернэт, үүрэн телефоны хэрэгсэл, ном эмхтгэл, сонин хэвлэлд нийтлэх зэрэг янз бүрийн арга хэлбэрээр түгээж буй хэдий ч үүнд анхаарууштай нэлээд асуудал байгааг хэлэх хэрэгтэй болов уу. Хууль тогтоомжийг хэвлэн нийтлэх зөвшөөрөл аваагүй төрийн болон төрийн бус байгууллагаас хууль тогтоомжийг эмхтгэн гаргаж буй нь хэр зөв асуудал вэ. Угтаа хууль тогтоомжийг хэвлэн нийтлэх ажил нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль²⁴-ийн 15.5.5 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн эмхтгэл (Төрийн мэдээллээс бусад) хэвлэх ажлыг тусгай зөвшөөрлийн дагуу хийх ёстой билээ. Иймээс аль нэг дурын байгууллага хуулийн эмхтгэлийг хэвлэн нийтэлснээс үүдэн хожим ямар нэгэн сөрөг үр дагавар бий болохыг үгүйсгэхгүй. Өөрөөр хэлбэл хууль бол тодорхой харилцааг зохицуулж байдаг албан ёсны акт учраас тухайн хэвлэгдэн гарсан хууль тогтоомжийн найдвартай байдлын баталгаа зайлшгүй чухал юм. Иймд энэ ажлыг хууль заасны дагуу тусгай зөвшөөрлийн үндсэн дээр тодорхой шаардлага шалгуурын дагуу эрхэлдэг байх нь чухал.

Мөн хуулийг зүгээр нэг эмхтгээд гаргаад байх уу гэдгийг бас бодолцох хэрэгтэй болов уу. “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн статусыг өөрчилсний дагуу 1994 оноос эхлэн уг эмхтгэлийг сар тутам гаргах болсон бөгөөд тус сэтгүүлийн газраас эрхлэн Монгол Улсын хууль тогтоомжуудын тухай

тайлбар, зөвлөмжүүд болон сэтгүүлийн хавсралт болгон “Төр, засгийн ажилтанд тусламж” сэтгүүлийг 1995 оноос гаргаж байсан бөгөөд түүнд УИХ-аас батлан гаргасан хууль тогтоомжуудын агуулгыг хураангуйлан олон түмэнд хүргэх, хэрэгжүүлэх арга хэлбэр сэлтийг аман ухуулгад зориулан тайлбарлах, бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаар Тамгын газрын ажил үйлсийг сурвалжлан бусдад туршлага болгох, санаа авахуулах зорилгоор гаргаж байв. Үүнийг өнөөдөр илүү боловсронгуй болгож хэрэгжүүлж яагаад болохгүй гэж.

“Төрийн мэдээлэл” эмхтгэл Монгол Улсын цорын ганц албан ёсны эмхтгэл болохын хувьд уг эмхтгэлийг хууль хэрэглэгч субъект шүүх болон хууль хяналтын байгууллага, төрийн төв болон орон нутгийн байгууллага, иргэдэд гүргэн шуурхай хүргэх асуудал хамгийн чухал юм. Иймээс “Төрийн мэдээлэл” эмхтгэлд хуулийг хугацаанд нь хэвлэх, мөн хэрэглэгчдэд цаг алдалгүй албан ёсны эхээр нь хүргэх зайлшгүй шаардлагатай. Мөн “Төрийн мэдээлэл” эмхтгэлийг эрхлэн гаргах редакцын багийн чадавх, бүтэц орон тоо, тэрчлэн уг сэтгүүлийн чанарын асуудлыг ч эргэн харж анхаарах зүйл олон байна. Өнөөдөр хууль тогтоомж олон нийтэд хэр зэрэг хүртээмжтэй, нээлттэй хүрч байна, хууль тогтоомжийг сурталчлах, хэвлэн нийтлэх, олон түмэнд хүргэх ажилд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдын оролцоо ямар түвшинд байна, хуулийг олон түмэнд хүргэхэд зугаагүй нэг эмхтгээд гаргаад байх уу, энэ талаархи эрх зүйн зохицуулалт хангалттай бүрдсэн үү, эсвэл ... гэх мэт ар араасаа хариулт нэхсэн асуудлууд бүрэн дүүрэн шийдэгдээгүй хэвээр байна.

²⁴ 2008 он.

²⁵ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль. 2001 оны 2 дугаар сарын 1. Төрийн мэдээлэл. 2001 он. №6

ХУУЛЬ НИЙТЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

"Помиловать нельзя казнить" гэж бичээд таслалын нэг хувилбар нь "помиловать" гэсэн үгийн ард байршуулбал "Оршоо, цагталж болохгүй", ногоо хувилбар нь "нелзя" гэсэн үгийн арард байршуулбал "Оршоож болохгүй, цагтал" гэсэн утгыг илэрхийлдэг. Оросын цагаан хааны үед хаан ийм зарлиг гарган зарлигийг эргэн засварлаж байсан гэдэг.

Энэхүү өгүүлэлээр:

- Хуулийн албан ёсны, албан, албан ёсны бус эх гэж юу болох, иргэд болон төрийн байгууллагын албан тушаалтнууд албан ажил болон амин хувийн үйл хэрэгтээ алийг нь хэрэглэх үүрэгтэй талаар

- Хуулийн хүчин төгөлдөр болох хугацааны талаар

Монгол Улсад албан эмхтгэлийг нийтлэх эрхтэй субъектууд

- Зарим оронд хууль нийтлэх талаар Үндсэн хууль болон бусад хуульдаа хэрхэн зохицуулсныг авч үзэн дүгнэлт хийж, зарим санал боловсруулахыг хичээлээ.

Хэрэглэсэн судалгааны арга:

- Ажилгалтын аргыг шүүгч, прокурор, цагдаагийн болон нийгмийн даатгалын газар гэх мэт байгууллагын ажилтнуудын хэрэглэж буй хууль нь албан ёсны эсэхийг ажиглан, ажиггалтын үр дүнгээр асуулт зохиов.

- Баримт бичгийн шинжилгээ, социологийн тодорхой судалгааны аргаар шүүгч, прокурор, өмгөөлөгч нийт 226 хуульчаас санал асуулгын хуудсаар судалгаа авсан.

- Ярилцлагын аргаар "Төрийн мэдээлэл" албан ёсны эмхтгэлд ажиллаж байгаа болон урьд ажиллаж байсан ажилтан, УИХ-ын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл, хяналт, дүн шинжилгээний газрын ахлах мэргэжилтэн, орон нутгийн шүүгч, прокурор, цагдаагийн байгууллагын албан тушаалтнаас



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Р.Бомормаа

ярилцлага авч дүн шинжилгээ хийв.

- Түүврийн аргыг ном, сонин, тайлан, интернэтийн цахим хуудас дахь мэдээлэл болон гадаад хэл дээрх ном зэргээс сэдэвтэй холбоотой асуудлыг түүвэрлэн судалгаанд ашигласаа.

- Түүвэрлэсэн баримтуудын хүрээнд өөрийн орны зохицуулалттай харьцуулалт хийхийг хичээв.

- Цуглуулсан мэдээллийн хүрээнд нэвтгэн дүгнэх аргыг хэрэглээ.

Хууль нийтлэх ажил нь хууль тогтоох тэр дундаа хууль гаргах ажлын салшгүй хэсэг бөгөөд хариуцлагатай ажил юм. Хуулийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нийтлэхгүй бол хуулийн биелэлтийг зохион

байгуулах, үр дүнг тооцох, хариуцлага хүлээлгэх аргагүй билээ.

"Хэлэлцээр", "хэлэлцээр" гэсэн хоёр үг ганцхан "р" үсгийн зөрүүтэй байна. "Хэлэлцээр" гэдэг нь талуудын тохиролцсон баримт бичиг, "хэлэлцээр" гэдэг нь уг баримтын бичгийн төслийг талууд хэлэлцэх үйл явдлыг илэрхийлдэг. Нэг хуульд үүнийг ийм маягаар бичвэл зарчмын эрс ялгаа гарч, чуулганд дахиж хэлэлцүүлэхээс өөр аргагүйд хүрнэ. Иймээс хуулийн эцсийн хувилбарыг батлахдаа түүнд хичнээн үг, үсэг, цэг тэмдэг орсныг хүртэл тоолж тэмдэглэж байх нь зүйтэй¹. Цэг, таслал, үсгийг алдаатай нийтэлснээс утгын алдаа гарч, хүний эрх зөрчигдөж болзошгүй юм.

Судалж буй сэдвийн талаар тухайлан судлаагүй ч гэсэн манай орны эрдэмтэд зохиол, бүтээлдээ алив нэг талаас нь хөндөж тайлбарласан байдаг.

Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид *"Хууль нийтлэх бол зөвхөн хэллэх гэсэн үг биш. Түүхэнд тогтсон практикаар бол албан ёсоор бүрэн эхээр нийтэд сонордуулахыг хэлдэг"*.² Хуулийг баталсан жагсаалтын дагуу олшруулж тараах, нийтээр танилцах боломжтой газар тавих, радио телевизээр нэвтрүүлэх зэргээр олон нийтэд хүргэнэ. Түүний дотор хэвлэн нийтлэх явдал нэн чухал ач холбогдолтой.

Хэвлэн нийтлэх нь:

1. албан ёсны;
2. албаны (официозный);

3. албан бус гэсэн төрөлтэй байна³ гэжээ. Харин гавьяат хуульч, доктор, профессор

¹ Б.Чимид. "Үндсэн хуулийн мэдлэг". УБ., 2008 он. 192 дахь тал.

² Мөн тэнд. 195 дахь тал.

³ Б.Чимид. "Захиргааны эрх зүй". УБ., 1988 он. 265 дахь тал.

С.Нарангэрэл “Хууль нийтлэх” (англиар-publication of law, оросоор-опубликование закона)-хуулийг тодорхой хэвэлд бэлтгэх замаар түүнийг бүх нийтэд мэдэгдэж, тэдний сонорт хүргэх. Албан ёсны ба албан ёсны бус гэж ангилна” гэжээ.

Хууль нийтлэх асуудлыг ихэнх хүн бичиг баримт эсвэл ном, сонинд нийтлүүлэх төдийгөөр ойлгодог. “Хууль нийтэлнэ” гэдэг нь хууль тогтоох байгууллага, холбогдох этгээдээс нийтэд зарлан тунхаглах ажил бөгөөд бүх төрлийн хэлбэр, арга ажиллагааг хамаарах ойлголт юм.

Монгол Улсын Засгийн газраас Анхны Үндсэн хууль (1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталсан)-ийг нийт түмэндээ тайлбарлан, мэдээлэн таниулах тогтоолыг 1926 онд (16 дугаар оны 6 дугаар сарын 25-ны өдөр 25 дугаартай) гарган гурван түмэн (30,000) хувийг хэвлүүлэн тараасан байдаг талаар ном зохиолд дурдсан байдаг.

Хуульд эцсийн найруулга хийж, Улсын Их Хуралд танилцуулах хугацааг түүний хэмжээ, цар хүрээ, холбогдох байнгын хорооны саналыг харгалзан УИХ-ын дарга тогтооно. Хуулийн эцсийн найруулгыг УИХ-д танилцуулснаас хойш УИХ-ын дарга ажлын 3 өдрийн дотор түүнд гарын үсэг зурж ёсчлоод УИХ-ын Тамгын газар 24 цагийн дотор Ерөнхийлөгчийн Тамгын газарт илгээнэ. Илгээсэн хуулийг Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан Ерөнхийлөгч тухайн хуульд бүхэл нь буюу түүний зарим хэсэгт хориг тавихгүй бол ёсчилно. Жишээ нь, 11 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан хуульд ажлын 5 өдөрт

багтаан хориг тавихгүй бол заасан өдрийн дараа ерөнхийлөгч ёсчлон УИХ-ын Тамгын газарт батлагдсан хуулийг илгээснээр тэд “Төрийн мэдээлэл” эмхтгэлд нийтэлнэ. Тухайн хуульд заасан бол үг хугацаанд, заагаагүй бол тус эмхтгэлд нийтлүүлснээс хойш 10 хоногийн дараа хууль хүчин төгөлдөр болдог.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 53 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхтгэлд хэвлэн нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эх гэж үзнэ” хэмээн хуульчилсан байна. (Мөн УИХ-ын Тамгын газраас эрхлэн тусад нь хэвлүүлсэн хуулийг албан ёсны эх гэж үзэж болно.) Уг эмхтгэлд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаарх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, яам, агентлагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг бүрэн эхээр нь нийтэлнэ.

Оросын Холбооны Улсад хуулийг гарын үсэг зурсны дараа албан ёсоор нийтлүүлэхийн тулд ерөнхийлөгч болон гүйцэтгэх засаглалын тэргүүнд илгээдэг байхад⁵ манай улсад хуулийг батлуулахын тулд (ёсчуулахаар) илгээдэг.

Хууль нийтлэх эрхийг УИХ-аас буюу эсвэл ХЗДХЯ-аас эрх авсан сонинд (мөн ном, эмхтгэлд Р.Б) нийтэлснийг албан хэвлэл гэж тооцож болно.⁶

Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 4-т Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ

“Төрийн мэдээлэл” эмхтгэлд нийтэлснийг албан ёсны эх гэж үзэх ба дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ хэмээн хуульчилсан.

Хуулийг албан ёсны бусаар иргэд, албан байгууллагад сурталчлах зорилгоор интернэтийн сүлжээгээр цахим мэдээллийг сурталчилж байна. Хууль зүй, дотоод хэргийн яам www.legalinfo.mn цахим мэдээллийн сангаар хуулийг иргэдэд түгээж байгаа нь хууль нийтэлж байгаа нэг томоохон хэлбэр юм. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээний зорилго нь байгууллага, иргэдэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актын талаарх мэдээллийг хайх, хүлээн авах, түгээх боломжийг хангах, шүүхийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд таниулах явдал юм. Ингэснээр хүний эрхийг хамгаалах, хуулийн өмнө эрх тэгш байх, байгууллага, иргэдийн хүлээх харуушлага, ил гэд байдал дээшлэх чухал ач холбогдолтой.⁷ 2009 оны 11 дүгээр сарын 1-ний байдлаар тус санд 5399 тооны эрх зүйн баримт бичиг байна. Мөн өдрийн байдлаар эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 2006 оноос хойш 1,088,589 хүн холбогдож мэдээлэл авсан байна.

Одоо Монгол Улсад Хууль албан ёсоор нийтлэх эрх бүхий субъект нь Улсын Их Хурлын Тамгын газар (УИХ-ын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар “Төрийн мэдээлэл” эмхтгэлийг хэвлэн нийтлэх ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцаж долоо хоног тутам гаргах юм. Харин хуулийн албан эмхтгэл нийтлэх эрхтэй нь Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн

⁴ С.Нарангэрэл. “Эрх зүйн эх толь бичиг”. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2008 он. 532 дахь тал.

⁵ Законодательство в Российской Федерации. М., Формула прайо, 2000 г. С. 410.

⁶ Б.Чинид. “Үндсэн хуулийн мэдлэг”. УБ., 2008 он. 195 дахь тал.

⁷ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээг ашиглах хэрэгслэгийн гарын аялга. 2006 он.

сайдын 2007 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн Тусгай зөвшөөрөл олгох тухай 113 дугаар тушаалаар Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн эмхтгэл (Төрийн мэдээлээс бусад) хэвлэх үйл ажиллагаа эрхлэх сонгон шалгаруулалтад ялсан Хууль зүйн үндэсний хүрээлэн, Өвөрхангай аймгийн Хууль зүйн "Онги" товчоо, "Улаанбаатар хэвлэл" ХХК, "Алмон" ХХК, "Соёмбо принтинг" ХХК, "Сод пресс" ХХК, "Хас пресс" ХХК, "Мон жаст консалтинг" ХХК, "Экимто" ХХК, "Эс Пи Си" ХХК-д Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн эмхтгэл хэвлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгожээ. Мөн "Ардын эрх", "Оглооний сонин" -д хуулийг албан ёсоор нийтлэх эрхийг тус тус 3 жилийн хугацаагаар олгосон байна.

Албан ёсоор нийтэлсэн хуулийг засаг захиргааны нэгж төдийгүй хувь хүн ч албан ажилдаа хэрэглэж байх шаардлагатай байдаг. Гэтэл шүүгчид болон бусад хуульчийн дотор албан ёсоор нийтлүүлсэн хуулийг тэр бүр олж хэрэглэдэггүй нь судалгаанаас харагдаж байна. Сум, сум дундын шүүхийн 35 шүүгч, Нийслэлийн дүүргүүдийн 68 шүүгч, Нийслэлийн дүүргүүдийн прокурор 45, хуульч 78, бүгд 226 хуульч судалгаанд хамрагдсан ба тэд санал асуулгын тэр дундаа анкетын асуулгын аргаар судалгаа авахад дараах байдлаар хариулжээ. Үүнд:


1. Та албан ажилдаа хуулийг хаанаас олж хэрэглэдэг вэ? гэсэн асуултад:

А. цахим хуудаснаас хэвлэн авч хэрэглэдэг. (legalinfo.mn); 55 хуульч буюу 30 хувь нь

Б. "Төрийн мэдээлэл" эмхтгэлд нийтлэгдсэн хуулийг хэрэглэдэг; 79 хуульч буюу 42 хувь нь

В. 48 хуульч буюу 27 хувь нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн нийтлүүлсэн хуулийг хэрэглэдэг;

Г. 2 хуульч эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авч, нийтэлсэн хуулийг хэрэглэдэг гэж хариулжээ.



2. Цахим мэдээлэлд оруулсан хууль, эрх зүйн мэдээллийн найдвартай байдалд:

А. Итгэлтэй байдаг гэж 54 буюу 29 хувь;

Б. Итгэлгүй байдаг гэж 46 буюу 25 хувь;

В. Боломжийн гэж үзэж ажилдаа ашигладаг 44 хүн буюу 46 хувь нь хариулжээ.

Цахим мэдээлэлд оруулсан хуулийн найдвартай байдалд



Цахим мэдээллийн санд байршуулсан хуулийг Албан бус эх гэсэн атлаа "боломжийн гэж ажилдаа ашигладаг" гэсэн шүүгч хэд хэд байсныг тэмдэглэх нь зүйтэй. Мөн судалгаа хийх явцад ярилцлагын аргаар хийсэн судалгаанд "Шүүгч нар өөрсдөө аль нь найдвартай гэж бодсон хуулиа барьж хэрэг маргааныг шийдвэрлэдэг байх" хэмээн нэгэн аймгийн ерөнхий шүүгч хэлж байсан.

Үндсэн хуулийн (1992) 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно хэмээн заасан байдаг талаар дээр дурдсан. Харин ОХУ-д хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг Холбооны Улсын хуулиар тогтоодог. Хэрвээ хуульд хүчин төгөлдөр болох хугацааг заагаагүй бол хууль нийтлэгдсэнээс хойш тодорхой хугацааны дараа хүчин төгөлдөр болдог. Харьцуулсан судалгаанаас үзэхэд Холбооны Улсын хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа нь 3-15 хоногийн хооронд байдаг байна. Жишээ нь, Владимирск мужийн төрийн захиргааны байгууллагуудын баталсан хуулиуд албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 3 хоног дуусахад хүчин төгөлдөр болдог бол Мурманск мужийнх 5 хоног, Ханты-Мансийскийн автономийн тойргийнх 7 хоног, Лепчик болон Самар мужийнх 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болдог бол Саратов мужийн хууль болон мужийн Думын тогтоолууд албан ёсоор нийтлэгдсэн өдрөөс 15 хоног өнгөрөхөд хүчин төгөлдөр болдог. Нийтлэгдсэний дараа хуулиудыг иргэд, албан байгууллагууд түүний утга агуулгыг тодруулан өөрийн байдалд тохируулах боломжтой

болдог. Зарим мужид хууль нийтлэгдсэн өдрөөсөө хүчин төгөлдөр болдог байхад Москва мужид албан ёсоор нийтлэгдсэн өдрийнхөө дараа өдрөөс хүчин төгөлдөр болдог байна. Харин Ивановск муж, Коми-Пермяцкий автономит тойрог гэх мэт газарт хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг албан ёсоор хэвлэн нийтлэгдсэн цаг, мөчөөс тооцдог нь эрх зүйн үүднээс тийм ч зөв биш юм.⁸ (Холбооны Улсын зарим тойргийн хуулиар хуулийн акт нь хүчин төгөлдөр болох хугацаандаа хэвлэн нийтлэгдээгүй бол хууль нь хүчин төгөлдөр болох өдөр нь албан ёсоор нийтлэгдсэн өдрөөр тооцогддог байна.)

Манай орны Үндсэн хууль болон зарим гадаадын орны Үндсэн хуульд хууль нийтлэх талаар хэрхэн тусгасныг авч үзвэл:

1924, 1940 оны Үндсэн хуульд хууль нийтлэх талаар тусгаагүй байна. Харин 1960 оны Үндсэн хуулийн 30 дугаар зүйлд: “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн олонхийн саналаар батлагдвал хуулийг хүчин төгөлдөрт тооцно. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас баталсан хууль, тогтоолыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, нарийн бичгийн дарга хоёрын гарын үсэгтэй нийтэлнэ гэжээ. Харин 1992 оны Үндсэн хуульд (26.3) Монгол Улсын хуулийг албан ёсоор нийтлэх ёстой бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.” гэж заасан нь хууль

нийтлэх талаар илүү боловсронгуй болгосон зохицуулалт юм. Хууль нийтлэх асуудлыг одоо УИХ-ын хуралдааны дэг, УИХ-ын тухай хуулиар зохицуулж байна.

Оросын Холбооны Улсын Үндсэн хуульд: Уг хуулийн 84 дүгээр зүйлд ОХУ-ын ерөнхийлөгч Холбооны Улсын хуульд гарын үсэг зурж нийтлүүлнэ. Мөн 107 дугаар зүйлд хуулийг ерөнхийлөгчид илгээснээс хойш 5 өдөрт багтаан гарын үсэг зурж, нийтлүүлдэг байна. Тус улсын албан хэвлэл болох

“Собрание законодательства Российской Федерации”-д хууль нийтэлдэг ба түүнийг “Юридическая литература” хэмээх хэвлэлийн газарт хэвлэдэг аж. Долоо хоног бүхэн хэвлэгддэг тус эмхтгэлд 100-200 орчим эрх зүйн акт гарч байна. Түүнд улсынхаа Үндсэн хууль, бусад хууль (Холбооны хууль), олон улсын гэрээ, Парламентаас баталсан тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг нийтэлдэг. Түүнчлэн Засгийн газрын эзэмшлийн өдөр тутмын сонин болох “Российская газета” сонинг хуулийн албан ёсны хэвлэлд тооцдог. Энэ сонинд өдөрт дунджаар 3-10 эрх зүйн акт нийтлэдэг байна.⁹

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндсэн хуульд 1982 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын 5 дахь удаагийн сонгуулийн 5 дугаар чуулганаар батлагдсан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар бүлгийн 5 дахь дэд бүлгийн 99 дүгээр зүйлд: Орон

нутгийн эл шатны Ардын Төлөөлөгчдийн Их Хурал тус засаг захиргаандаа Үндсэн хууль, хууль цааз, засаг захиргааны хууль тогтоолыг журамлах ба гүйцэтгэх явдлыг батална. Хуульд тогтоосон эрх мэдлийн хэмжээндээ (хүрээнд Р.Б) шийдвэр батлах ба нийтлэх галаар тусгаар байна.¹¹ Мөн 80 дугаар зүйлд: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тэргүүлэгч Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын шийдвэр ба Бүх Улсын Ардын Их Хурлын байнгын хорооны шийдвэрийг үндэслэн хууль цаазыг нийтэлнэ.¹² хэмээн заасан байна. БНХАУ-ын албан ёсны хуулийг Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Хэвлэлийн байнгын хороо хариуцан нийтлүүлдэг.¹³

Франц Улсын Үндсэн хуульд: Тус хуулийн 46 дугаар зүйлд Үндсэн хуулийн Зөвлөл салбарын хуулийг гагцхүү Үндсэн хуульд нийцээж буй эсэхийг зарласны дараа нийтэлнэ. Мөн хуулийн 61 дүгээр зүйлд Салбарын хуулийг нийтлэх болон Улсын Хурлын хоёр танхимын журмыг дагаж мөрдөхөөс нь өмнө Үндсэн хуулийн Зөвлөлд өргөн мэдүүлж Үндсэн хуультай нийцэж байгаа эсэх талаар Зөвлөл саналаа илэрхийлнэ. Энэ зорилгоор Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Үндэсний Хурлын ба Дээд Хурлын дарга, 60 төлөөлөгч ба 60 гишүүн тухайн хуулийг нийтлэхээс нь өмнө Үндсэн хуулийн Зөвлөл хэсэгт шилжүүлнэ. Өмнөх хоёр хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн Зөвлөл 1 сарын дотор шийдвэр гаргана. Хэрэв Засгийн газрын хэсэлтээр тухайн асуудлыг нэн даруй шийдвэрлэх тохиолдолд

⁸ Законотворчество в Российской Федерации, М., Формула права, 2000 г. С. 400-401

⁹ Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, “Төрийн мэдээлэл” эмхтгэл, №1-д нийтлэгдсэн.

¹⁰ www.planetark.com/avantgo/dailynewsstory.cmf.news?id

¹¹ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хуулийн эмхтгэл, цуврал-1, УБ., 2008 он, 41 дэх тал.

¹² Мөн тэнд. 34 дэх тал

¹³ www.planetark.com/avantgo/dailynewsstory.cmf.news?id.

энг хугацааг 8 хүртэл хоноогоор хязгаарлана. Эдгээр шалтгаанаар Үндсэн хуулийн Зөвлөлд хандсан бол хуулийг нийтлэх хугацааг түр хойшлуулна¹⁴ гэж заажээ.

БНХАУ, Франц улсын Үндсэн хуульд хууль нийтлэгдсэнээс хойш хүчин төгөлдөр болох хугацааг заагаагүй байна.

Нийтлэсэн **торөл** (албан ёсны, албан, албан ёсны бус), **хэлбэр** (ном-эмхтгэл, гарын авлага, танилцуулга, эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ, телефон утасны тусгай шугам (1982, 1933, 1960 гэх мэт), номын сан, хууль зүйн зөвлөгөө (толбөртэй болон толбөргүй), эрх зүйн албан бус сургалт, нээлттэй хаалганы өдөрлөг)-ээс үл хамааран хууль нь албан ёсны эхтэйгээ тохирч байх ёстой. Ингээгүйн төлөө түүнийг нийтэлсэн (түгээсэн) мэдээллийн хэрэгслийн ерөнхий редактор хариуцлага хүлээх ба хэрвээ алдаа гарвал тухайн мэдээллийн хэрэгслээрээ 14 хоногийн дотор алдаагаа залруулах ёстой. Ингэхдээ зөвхөн алдаа гаргасан хэсгийг бус үг хуулийг бүхэлд нь нийтлэх шаардлагатай талаар ОХУ-ын эрх зүйн зохицуулалтад¹⁵ дурдсан байна. Манай орны хувьд ингэж нийтэлбэл хуулийг хэрэглэхэд ихээхэн ач холбогдолтой гэж судлаачийн (Р.Б) зүгээс үзсэн хэдий ч энэ нь эдийн засгийн хувьд асар их зардал гарах нь дамжиггүй.

Дүгнэлт:

Хуулийг нийтлэхдээ цэг, таслал, үсэг орхих гэх мэтээр алдаатай нийтлэснээр ямар үр дагаварт хүрч болохыг дээр дурдсан билээ. Иймд хуулийг нийтлэх эрх бүхий субъектууд хариуцлагатай ажиллаж байх шаардлагатай байдаг нь эцэсээс харагдаж байна.

Судалгаагаар хуулийн албан ёсны, албан, албан ёсны бус эх гэж юу болох, алийг нь албан ажилдаа хэрэглэх талаар ойлголтгүй хуульчид багагүй байгаа нь харагдаж байна. (санал асуулгын хуудсаар судалгаа авахад албан ёсны хууль гэж юу вэ гэхэд 39 хувь нь хариулаагүй байсан.) Албан ёсоор нийтлэгдсэн хуулийг үйл ажиллагаандаа хэрэглэхгүй бол хүний эрх ноцтойгоор зөрчигдөх, гэмт этгээдэд ял завшуулах, хүний эрхийг ханган хамгаалж чадахгүйд хүрэх талтай байна. Судлаач орон нутгийн хуулийн байгууллагын ажилтантай уулзаж ярилцахад (прокурор) Эрүүгийн хуулийг цахим хуудаснаас (ЭЗМНС) авч хэрэглээд санхүүгээр буруу бичсэн байснаас гэмт этгээдэд ял завшуулсан талаар ярьж байсан. Энэ үед шүүгч ч бас ийм хууль хэрэглэсэн гэж байсан. Энэ мэтээс гадна өмгөөлөгч, хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг иргэн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд нэмэлт, өөрчлөлт оруулаагүй хуулийг хувиан авч хэрэглээд алдаа гаргаж байсан талаар баримт цөөнгүй байна. Үүгээр хөгжиж буй манай орны эрх зүйн цахим мэдээлэл энэ хүртэл хөгжсөнийг сайшаахын ялдамд албан бус мэдээллийг түгээж буй цахим мэдээллийн санг үгүйсгээгүй билээ. Харин мэдээллийг түргэн шуурхай оруулж байх, найдвартай байдлыг ханган байнга санаа тавин ажиллахгүй бол иргэд, төрийн албан тушаалтнууд үүнийг хэрэглэснээр хүний эрх зөрчигдөх, үл ойлголцол бий болох талтай байж болохыг сануулах гэсэн юм. Мөн хурдацтай хөгжиж буй мэдээллийн эринд нийцсэн мэдээллийн сан, тогтолцоог улам

сайжруулах, түүнийгээ байнга боловсронгуй болгож байх зүй ёсны шаардлага байгааг хэлэхийг хүссэн билээ.

Хуулийг албан ёсоор нийтлэх эрхтэй байгууллага байсаар атал хаана хэвлүүлсэн нь тодорхой бус, алдаатай хуулийг албан ажилдаа хэрэглэсээр байна. Албан бусаар нийтэлсэн хуульд үг, үсэг, цэг, таслал алдаж хэвлэснийг хэрэглэсний хариуцлагыг албан ёсны бус хэвлэл хэрэглэсэн байгууллага, албан тушаалтан хүлээх нь гарцаагүй юм.

Мэдээллийн хэрэгсэл зөвхөн нийгэмд хэрэгцээтэй гэхээсээ илүү тухайн үйл явдлын талаарх тодорхой нэг хуулийг (Татварын өршөөлийн хууль, Өршөөлийн хууль гэх мэт) авч албан ёсны эмхтгэлд нийтлэгдэхээс өмнө нийтэд хүргэн нийтэлбэл үүнийг иргэд хэрэглэх, ашиглах нь буруу юм. Мөн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хуулийг өөрсдөө дур мэдэн алдаа, мадагтай нийтэлж, албан хэрэгцээнд ашиглаж байгаа нь хууль зүйд нийцэхгүй юм.

Энэ бүхнээс үзвэл **албан ёсны эмхтгэл болох "Төрийн мэдээлэл"** эмхтгэлд батлагдсан хууль, бусад шийдвэрийг цаг алдалгүй нийтэлж байх шаардлагатай байна. Энэ эмхтгэлийг эрхлэн гаргаж байсан ажилтны өгүүлсэнчлэн тусгай дугааруудад нийтлүүлсэн олон улсын гэрээнээс нэг мянга гаруй нийтлэгдээгүй үлдсэн байна. Тэдгээрийг албан ёсны эмхтгэлд нийтлүүлснээр хүчин төгөлдөр болдог журамтай тул нийгмийн харилцааг зохицуулахад болон шүүхийн практикт олон улсын гэрээг хэрэглэх асуудал ямар түвшинд байгаа нь харагдаж байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 5 дахь

¹⁴ В Бугд Найрамдах Франц Улсын Үндсэн хууль.

¹⁵ Законоотворчество в Российской Федерации, М., Формула права, 2000 г. С.418.

хэсэгт “Төрийн мэдээлэл” эмхтгэлд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Грөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаархи Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, яам, агентлагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг бүрэн эхээр нь нийтэлнэ хэмээн заасан ч үүнийг Засгийн газрын 2003 оны 8 дугаар тогтоолоор ХЗҮТ-өөс (хуучин нэрээр) эрхлэн гаргадаг “Хууль зүйн мэдээлэл” эмхтгэлд нийтлэж байхаар тогтоожээ. Одоо “Төрийн мэдээлэл” эмхтгэлд нэгэнт нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг нийтлэхгүй байгаа тул дээрх заалтаас “яам, агентлагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг бүрэн эхээр нь нийтэлнэ” гэснийг хасах саналтай байна.

Хэдийгээр манай улсад эдийн засгийн хямрал нүүрлээд байгаа гэж ярих болсон ч албан ёсны хэвлэл болох “Төрийн мэдээлэл” эмхтгэлийг төрийн байгууллагуудад төсвийн хөрөнгөөс зардлыг гаргаж, үнэ

төлбөргүй түгээж байх шаардлагатай байна. Хэмжээний хувьд А4 болговол (2009 оны 11 дүгээр сараас эхлэн А5 хэмжээтэй болгож өөрчилсөн.) хэрэглэхэд болон хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тусгахад хялбар байх юм. Дурдсан санал, асуулгын хуудсаар авсан судалгаанаас үзэхэд хуулийг А4 хэмжээтэй нийтэлбэл хэрэглэхэд дөхөм байдаг гэж хэд хэдэн шүүгч бичсэн байсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Эмхтгэлд Авлигатай тэмцэх газраас авдаг хөрөнгө орлогын мэдүүлэг; Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн адил нэлээд том хуулийг уг эмхтгэлд нийтлэхэд хэвлэлтийн зардал өсөх, үсгийн хэвлэлдээ багасч хэрэглэхэд тохиромжгүй байх болов уу.

Албан ёсны бус эхийн талаар: Одоогоор эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан-д байршуулсан хуулийг албан ёсны бус гэж үзэх нь эргэлзээтэй байна. Цаашид эрх зүйн мэдээллийг баталгаатай албан ёсны эх болгох, улсын нэгдсэн интернэтийн сүлжээтэй болох хэрэгтэй. Эрх зүйн актыг оруулах үүрэгтэй субъектууд

түргэн шуурхай, найдвартай оруулах, системийн аюулгүй ажиллагааг маш найдвартай хангах шаардлагатай гэж үзнэ. Энэ сайтыг албан ёсны эх болгосон ч “Төрийн мэдээлэл” эмхтгэлийг гаргахгүй байна гэсэн үг биш бөгөөд хуулийн албан ёсны эхээр эрх зүйн цахим мэдээллийн нэгдсэн сүлжээ www.legalinfo.mn хуудсыг гооцож болно гэсэн зохицуулалтыг хийж болох юм.

Мөн Хууль зүйн үндэсний төвөөс (хуучин нэрээр) 2008 онд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг 4 боть болгон эмхтгэн гаргасан. Уг эмхтгэлд улирал бүр хуулийн нэмэлт, өөрчлөлтийг нөхөн хэвлэж хүргэх бөгөөд түүнийг албан ёсны эх сурвалжид тооцох зохицуулалт хийх шаардлагатай. Учир нь төрийн албан ёсны эмхтгэл болох “Төрийн мэдээлэл” эмхтгэл төрийн бүх байгууллага түүний дээр нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад бүртгэл, хяналтын нэгдсэн сан болгож бүрэн эхээр нь бүрдүүлэх нь чухал билээ.





ШИНЭ НОМ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг тэдгээртэй холбогдох Улсын дээд шүүхийн тогтоолтой нь хавсаргаж, эмхтгэн гаргалаа.

Худалдах үнэ: 5000 төгрөг

Утас: 319144



АВЛИГА БА НИЙГЭМ

Өнөөгийн нийгэмд хамгийн нарийн товогтэй асуудлын нэг болох авлигатай тэмцэх үйлсэд хувь хүн, байгууллага нь хамтдаа тэмцэх шаардлага тулгарч байна. Хэдийгээр манай улсад Авлигатай тэмцэх газар байгуулагдан ажиллаж байгаа хэдий ч авлига, ашиглал, санхүүгийн холбоотой хэрэг гарсаар байгаа нь нууц хэвээрээ л байгаа юм. Эдгээр үйлдэл нь нэг байгууллагын удирдлагын гарт мөн тухайн байгууллагын ажилтан албан хаагчид нь (санхүүгийн холбогдох албан тушаалтнууд нь) удирдлагын өөрийн танил тал болон төрөл садан, түүний анд нөхдийн холбоотой мөн бизнесийн холбоотой байдлаар нууцлагдаж болохоор санхүүгийн анхан шатны баримтуудыг хуурамчаар бүрдүүлэх, нөхөж хийх, санхүүгийн тайлан балансад хуурамчаар тусгах, түүнд өөрчлөлт оруулах зэрэг байгууллагын санхүүд эрсдэлтэй цаашилд улс орны эдийн засагт хохиролтой байдлаар мөнгө ашигладаг албан тушаалтнууд цөөнгүй байгаа.

Эдгээр тайлбартай холбогдуулан үзэхэд: жишээ нь, олон салбартай удирдах байгууллагын хувьд бусад салбар нэгж байгууллагыг санхүүгийн хараат байдлаар өөрийнхөө хүссэнээр удирдан зохион байгуулдаг, албан тушаалыг өөрчлөх түүнд эрх мэдэл өгөх замаар хээл хахууль болон ашиглалын гэмт хэрэг гарах магадлал өндөр байгаа нь нууц биш юм. Энэ нь зөвхөн санхүүгийн хараат байдал мөн албан тушаалын салшгүй байдлаас уг гэмт хэрэг гарах нөхцөл байдал бий болж байдаг. Энэ нь бусад салбар байгууллагуудын удирдах албан тушаалтан болон санхүүгийн албан тушаалтны дуу хоолойг боомилон чимээгүй болгох аюул байдаг ба энэ нь үнэний хамгийн



*Авлигатай тэмцэх газрын
Мордон шалгах хэлтсийн
мордон байцаагч, комиссар,
докторант Д. Золжаргал*

өчүүхэн хэсгийг нуухад ард нь асар гом худал хуурмаг байдал төрөн гарах нөхцөл бий болдог юм.

Иргэдийн бүх эрх нь Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажсан байдаг хэдий ч чадвар мөхөс буюу хуулийг завхруулдаг удирдагчид түүнийг зөрчиж үйл ажиллагаа явуулсаар байгааг таслан зогсоох шаардлага байгааг харуулж байна. Энэ бүхнээс үзэхэд манай улсын бүх төрийн байгууллагын олон мянган албан хаагчид ил тод байх, үнэнч шударга байх, ёс суртахуунтай байх нь хамгийн эхний тэмцэл гэж бодож байна. Энэ бол хууль бус буюу ёс суртахуунгүй байдлаар ашиг хонжоо олохын тулд төрийн албан хаагчид болон бизнесийн хүмүүсийн хоорондох мөргөлдөөн буюу тэмцэл гарах магадлал байгааг үгүйсгэхгүй юм.

Бидний цаашдын чиглэлд манай улс улс төр, эдийн засгийн удирдагчдаас ил тод байдал, шударга ёс болон ёс суртахууны төлөөх тэмцэл багтана. Гэхдээ авлигал бол зөвхөн улс төрийн эрх мэдлийг хувийн сонирхолд ашиглах төдий зүйл биш гэдгийг сайтар ойлговол зохилтой. Энэ бол

хууль бус буюу ёс суртахуунгүй байдлаар ашиг хонжоо олохын тулд төрийн албан хаагчид болон бизнесийн хүмүүсийн хоорондох мөргөлдөөнөөс хавьгүй том зүйл юм.

Нэг талаар төрийн албан хаагчид болон бусад албан тушаалтнууд нь өөртөө оноглож байгаа үүргийг умаргсанаар авлига үүсэх нөхцөл бий болдог ба энэ нь тухайн хүний боловсролтой шууд салшгүй холбоотой бөгөөд мөн уг хүнтэй хоёрдмол яриаг бий болгон хүмүүс зөвхөн тэдний сонсох хүсэлтэй байгаа зүйлийг нь хэлээд харин шалгаруулалтгүйгээр хууль завхруулах үзэгдэл нь манай нийгэмд зөрчлийн төдий байгааг харуулж байна. Энэ нь хэн нэгэн албан тушаалтан нь бусдад илт давуу байдлыг бий болгосон үйлдэл нь өнөөгийн мөрдөгдөж буй эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнд хамаарахгүй байгаа хуулийн зохицуулалт нь уг авлигын хэргийг бүрэн гүйцэд илрүүлэхэд хүндрэл учруулсаар байгаа нь нууц биш юм.

Иймд бид хувь хүний амжилт ололт болон хэтийн чиг хандлага нь тэдний нийгэмд үзүүлэх нэмэр хандиваар бус, харин улам бүр материаллаг баялгаар хэмжигдэх болжээ. Энэ байдал нь бидний соёл иргэншлийг ёс суртахууны доройтол тийш хөтөлж буй бөгөөд үүнийг зөвхөн боловсролоор дамжуулан урт хугацааны туршид гуйлшралгүйгээр залуулж болох юм. Бид иргэний хариуцлага, нэн ялангуяа залуусын ухамсрыг энэ чиглэлээр дээшлүүлэх хэрэгтэй байна. Анги танхим, сургуулийн байранд иргэний үүрэг хариуцлагын талаар бид хичээл зааж нийгэмд ашигтай байх үйл хэргийг төлөвшүүлэх ёстой гэж бодож байна. Энэ талаар тодорхой сургалт зохион байгуулж холбогдох багш нарт сургалт явуулж эдгээр багш нар нь уг хичээлийн

сургалтын программд оруулан зааснаар ирээдүй хойч үеийн сайн сайхан амьдралын төлөө тэмцэх нь бидний үүрэг болж байгааг бид ухамсарлан цаашдын үйл хэргийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ нийгэмшлийн баялаг нь санхүүгийн баялгаас давуу үнэлэгдэх ёстой бөгөөд зөвхөн материаллаг баялгыг өвлөн эзэмшихэд чиглэсэн соёл нь авлига цэцэглэх хөрс нь болж өгдөг гэдгийг анхаарах хэрэгтэй байна.

Бид авлигын гай гамшгийг таслан зогсоохын тулд цөхрөх ёсгүй гэдгийг бусад төрийн албан хаагчиддаа уриалах нь зүйтэй бөгөөд авлигын даяаршил хэдийчинээ их байх тусам сайн засаг төрийн төлөөх олон нийтийн шаардлагын хүчит давлагааг улам даяаршуулах ёстой.

Мөн бид зөвхөн албаны сонгогдсон хүмүүс л авлигад өртдөг буруутнууд биш гэдгийг мартаж болохгүй. Буруу итгэл үнэмшлээс үүдэлтэй, үг дуугүй даган зөвшөөрсөн, мөн захиргаадсан ажил, албанаас улбаалсан зэрэг авлигын олон хэлбэр байдаг. Бид аливаа нууцыг хадгалах болон итгэл үнэмшлийн буруугаас үүдэлтэй авлигын үр дагавруудын талаар өөрсдөөсөө асуух шаардлагатай.

Бид сонор сэрэмжтэй, хүчирхэг, иргэний нийгэм байгуулахын зэрэгцээ өөрсдийн үр хүүхдэд эрх мэдлийн хүчирхийллийн эсрэг боловсрол олгох замаар авлигатай тэмцэх ёстой юм. Бид улирч өнгөрсөн он жилүүдэд хаяж гээгдсэн хэмээгдэх иргэний сайхан шинж чанарыг эргүүлэн авч сайн үйлсийг бүтээгч иргэд болох замаар авлигатай тэмцэх ёстой. Энэхүү зорилгыг гүйцэлдүүлэхэд хүн бүрийн тусламж дэмжлэг нэн хэрэгтэй бөгөөд ингэж чадсанаар авлигын хорт буглааг эдгээж чадна гэдэгт итгэл төгс байх ёстой.

Авлига нь нөхцөл боломж, хүсэл шунал зэрэг байгаа үед бий болно. Энэ нь тухайн албан

тушаалтанд хахууль санал болгож байгаа тал болон хууль бус төлбөр шаардаж шахааж байгаа талын аль нь үндэстэй байж болно. Хахуулийг санал болгож байгаа тал нь өөрсдийн эрх хэмжээ хүрэлцэхгүй байгаа эсвэл хууль дүрмийг уландаа гишгэж аль эсвэл ямар нэг байдлаар тал тохой татахгүй бол төр албан хаагч хүссэн зүйлийг нь гүйцэлдүүлж өгөхгүй хэмээн бодсоны улмаас ийнхүү хандаж байж болно. Ядуу зүдүү байдал бусдын хүсэл шуналыг гүйцэлдүүлэхэд ашиглагдах талтай ч аливаад бодитой хандах нь авлига үүсэх нөхцөл боломжийг хязгаарлах арга зам болсоор ирсэн ба цаашид ч байх болно. Авлигыг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагаа нь түүнийг бий болгоход оролцдог хоёр талын аль алийг нь хамрах ёстой.

Авлига газар сайгүй байхаас гадна бас ужиг шинжтэй байдаг. Энэ нь төрийн албан хаагчид өөрсдийн албан тушаалаа урвуудан ашиглах төдий зүйл биш, бас хүмүүс мөнгө хялбар олох боломжтой газар бүрт өөрсдийн алба ажлаа урвуудан ашиглах байдлаар илэрдэг. Жишээ нь: Сайн санааныхан нэртэй төрийн бус байгууллага нь хандив тусламжийн мөнгийг өөрөө өөртөө бүгдийг зарцуулдаг ба уг байгууллагын нэрийг ашиглаж ямар нэгэн байдлаар өөрсдөө давуу байдал олж авдаг. (Ямар нэгэн албан тушаал авах, аливаа хэрэг өөрт болон бусдад ашигтай байдлаар байгуулах) мөн төрийн өндөр албан тушаалтнуудын аюулгүй байдлын албаны хүмүүс гэдгээрийн сул тал, хувийн алдаа дутагдлын талаар мэдээллийг худалдах замаар мөнгө хүртэх явдал цөөнгүй байгаа энэ талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байдаг.

Авлигын түгээмэл тархсан хэлбэрүүдийн хувьд авч үзвэл:

- Нууц мэдээллийг зүй бусаар ашиглах;
- Төрийн албан тушаал, өмч

хөрөнгө, зөвшөөрлийг дур мэдэн худалдах, дүрэм журам, худалдан авсан зүйлийн нэр төрөл, үнийн жагсаалт, гэрээ болон зээлийг өв мэх гарган буулиангуулах;

- Төрийн албан хаагчдад нөлөөлөх оролдлого гаргах, тал засч зуучлах, ашиг сонирхлын зөрчилд автах;

- Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбоо тогтоох;

- Зүй зохисгүй бэлэг, мөнгөн төлбөр, үзвэр үйлчилгээ, дайллага цацлагад өртөх;

- Тал тохой татах, бусдыг хаачихах;

- Хууль бус хяналт шалгалт хийх, харилцаа холбоо, шууданг зүй бусаар ашиглах;

- Албаны тамга тэмдэг, бичиг хэрэг, орон байр болон давуу эрхийг урвуудан ашиглах.

Энэ бүхнээс үзэхэд сэтгэл түгшээх зүйл олон байгаа нь тодорхой.

Авлигын эсрэг өөрчлөлтийг гүүний бүхий л үйл явц, дэг журам, сонголт, хувилбаруудын хамт хэрэгжүүлэх явцдаа энэ бол урт хугацааны үйл ажиллагаа байх болно гэдгийг санах нь чухал. Энэ нь олон түмнээс илэрхий дэмжлэг авдаг зүйл бөгөөд түүний хүрээнд үйлчилдэг ёс зүйн хэм хэмжээ, хандлагууд бүхий л шатанд гэтгүүлэн хүчирхэгжиж байдаг байна. Иймд эхний үед өөрчлөлтийг хамгийн үр дүнд хүрэх буюу хамгийн их ач холбогдолтой байж чадах асуудлуудын хүрээнд цаг хугацаа, дэс дарааллыг сайтар тооцон, төрийн ил тод шударга байдалд олон нийтийн итгэх итгэлийг бий болгон төлөвшүүлэх үүднээс хийх нь зүйтэй. Ер нь авлигын эсрэг компанит ажлыг бүх нийтийн үйл хэрэг болговол зохино.

CE CE CE

ШҮҮХ, ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААХ АЖИЛЛАГААНД ОРЧУУЛАГЧИЙН ОРОЛЦООГ ЧУХАЛЧЛАХ НЬ

Чухалчлах үндэслэл

Улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт гадаад харилцаа, хамтын ажиллагаа оргожин хөгжихийн хэрээр манай улсад зорчих, дамжин өнгөрөх болон оршин суугаа гадаадын иргэдийн тоо олширч, тэдний хууль ёсны эрхийг хангах, хамгаалах асуудал чухлаар тавигдаж байна. Тухайлбал, гадаадын иргэн холбогдогчтой хэргийн шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулагч оролцох¹ хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэх хандлагатай боллоо.

Гэхдээ энэ бол зөвхөн гадаадын иргэнд хэл зүйн туслалцаа үзүүлж, эрх ашгийг хамгаалах талын асуудал биш бөгөөд орчуулагчийн ажил үүргийг тухайлж мөн салгажгүйгээр, нийгдээ хуулийн байгууллагын ажилд зайлшгүй хамрагдах харилцаа болохыг тусган цогц байдлаар анхаарах ёстой судлагдахуун юм.

Хүний эрхийг дээдэлж, эрх зүйт төрийг зүй ёсоор төлөвшүүлж буй орнуудад байцаан шийтгэх ажиллагаанд орчуулагч авах, ашиглах эрх (the right to interpretation and translation in criminal proceedings)-ийн стандарт зүй ёсоор мөрдөгддөг. Энэ эрх нь эрүүгийн хэрэгт татагдсан этгээд тухайн орны албан ёсны хэлийг ойлгохгүй тохиолдолд хэргийн үндсэн гол баримт бичгүүд (ноглох баримт, гэрчийн мэдүүлэг гэх мэт)-ийг орчуулах, хэргийн материалтай танилцахад нь туслах болон шүүх хурлын үед орчуулагчийн туслалцаа үзүүлэх байдалаар хэрэгждэг.



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Олон улсын эрх зүйн секторын
эрдэм шинжилгээний ажилтан
Б.Энх-Амгалан

Хүний эрхийн гол зарчмууд болох оорөө оорийнхөө эсрэг мэдүүдэг өгөхгүй байх хийгээд гэм буруу нь гүйцэд нотлогдоогүй үед гэмт хэрэг үйлдсэн тооцоогүй байх зарчмыг хэрэгжүүлэхэд тавигдах зүй ёсны шаардлагыг хангахад орчуулагчийн эрх үүрэг, харилцаагын тогтолцоо зайлшгүй нөлөө үзүүлнэ.

Орчуулагч хэл зүйн талаас туслах үүргийг гүйцэтгэснээр байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч, ажиллагаанд оролцогч, бусад оролцогч нарын хооронд харилцаа үүсч, ажил хэргийн холбоо тогтдог. Иймээс орчуулагчийн оролцоо нь омгоологчөөс омгохи шатанд, эн тэргүүнд хангагдвал зохих чухал хэрэгцээ юм.

Иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд орчуулагчийн оролцоо мөн чухал. Ялангуяа талууд эвлэрэх буюу шүүхийн бус журмаар хэргийг шийдвэрлүүлэх ажиллагаанд харилцааны гүүр болж өгдөг.

Хууль зүйн орчуулга нь хэл шинжлэлийн болоод хууль зүйн гэсэн 2 том шинжлэх ухааны хүрээг хамарч, тэдгээрийн огтлолцол, нийлэмж дээр бүрэлсэн тогтдог. Өөрөөр хэлбэл шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа нь маш нарийн гөвөгтэй үйл явц тул үүнийг дагаад энэ төрлийн орчуулга бас их эгзэгтэй, хариуцлага, хөлс хүч их шаарддаг ажилд зүй ёсоор багтдаг.

Дээр өгүүлсэн олон талын хэрэгцээ шаардлагад үндэслэн шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулагчийн оролцоог чухалчлах зорилгоор орчуулагчийн эрх зүйн байдал, хэрэгжилт, цаашид төгөлдөршүүлэхэд ямар зохицуулалт байвал зохистой талаар асуудалд хандъя.

Эхлээд холбогдох эрх зүйн зарим зохицуулалтыг дараахь хүрээнд судалж үзлээ.

Нэг. Олон улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд

Монгол Улсын нэгдэн орсон Иргэний байцаан шийтгэх ажиллагааны асуудлаархи конвенци, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай, Гадаадын арбитрийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенци зэрэг олон улсын гэрээнд, тухайлбал Хүний эрхийн гүгээмэл тунхаглалын 10 дугаар зүйлд "Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлох аргаараа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шуудагаар шүүгдэх эрхгүй", Иргэний болон улс

¹ Хэргийг шүүх яшир орчуулагч оролцсон талаар эрт үед тэр болгон тэмдэглэн үлдээх боломжгүй байсан гэж үздэг ч хамгийн анх 17-р зуунд Оманд Африкийн колончлолын үед Англид 1682. 1820 онуудад шүүх хурал орчуулагчийн тусалцаатай янгалсан гэж түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн бөгөөд тэдгээр хурлын орчуулга нь зонхон хэл зүйн хувьд орчуулах тогсохгүй оролцогч талуудын зэрэг зиндаа, соёлын ялгааг тайлбарлаж өгснөөрөө өнөрмөц байжээ.

төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн е-д “Шүүн таслах ажиллагаа явуулж байгаа хэлийг ойлгохгүй буюу уг хэлээр ярьдаггүй тохиолдолд орчуулагчийн туслалцааг үнэ төлбөргүй авах”, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 14 дүгээр зүйлийн 3-д “байцаан шийтгэх ажиллагааны хэлийг ойлгохгүй буюу уг хэлээр ярьж чадахгүй бол орчуулагчийн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх” зэрэг заалт байцаан шийтгэх ажиллагаанд хүн бүр тэгш эрхтэй байх зарчмыг хэрэгжүүлж, энэ эрхийг хангахад орчуулагчийн оролцоо ач холбогдолтойг тодорхойлж өгсөн байдаг.

Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн болон хүний эрхийн дээр дурьдагдсан стандартаас дүгнэлт хийвэл гэмт хэрэгт холбогдож буй этгээд тухайн улсын төрийн албан ёсны хэлийг ойлгохгүй тохиолдолд ямарваа нэгэн ялгаварлан гадуурхаас ангид байж, дараахь эрхүүдээр зайлшгүй хангагдах ёстой. Үүнд:

- төрөлх хэлээрээ мэдүүлэг өгөх;
- орчуулагч авах;
- мэдлэг хэлээрээ хэргийн талаар ойлголт авах хангалттай хугацаагаар хангагдах;
- уг туслалцааг үнэ төлбөргүй авах зэрэг болно.

Судлаачид шүүхийн орчуулагчийн талаархи дэлхийн улс орнуудын эрх зүйн зохицуулалтын үндсэн 2 загвар байна гэж үзсэн. Энэ нь:

• **Англи Саксоны эрх зүйн бүлийн улс орнуудын загвар:** Энэ эрх зүйн бүлийн хувьд хамгийн анх Английн давж заалдах шатны шүүх *R. vs. Lee Kun (1916) 1K.B. 337* хэргийн үед орчуулагчийн эрхийг тодорхойлсон.

1978 онд АНУ-ын Хууль зүйн яамнаас “Шүүхийн орчуулагчийн журам” (Court Interpreters Act of 1978)-ийг баталж, орчуулагчийг

оролцуулах нөхцөл байдал болон Холбооны Улсын шүүхийн орчуулагчид зөвшөөрөл олгоход мөрдөх стандартыг тогтоосон байдаг. 1980 оноос “Холбооны Улсын шүүхийн орчуулагчийн эрх олгох сонгон шалгаруулалт “–ын тогтолцоог хэрэгжүүлсэн. Сонгон шалгаруулалтад тэнцсэн орчуулагчдын нэрсийг албан ёсны эрхтэй нийт орчуулагчдын бүртгэлд оруулан шүүхүүдэд тарааж, сонгож хэрэглүүлдэг байна. АНУ-ын шүүхэд орчуулагч оролцуулахтай холбоотой эрх зүйн эдгээр зохицуулалт нь бусад улс орнуудад ялангуяа цагаач иргэд олонтой улс орнууд холбогдох хууль батлан мөрдүүлж, хүн бүр шүүх ажиллагаанд тэгш эрхтэй байх эрхийг хангаж ажиллахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

• **Эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудын загвар:** Энэ загварт Итали Улсыг төлөөлөл болгон авч үздэг. 1988 онд батлагдсан “Италийн эрүүгийн байцаан шийтгэх хууль”-д шүүхэд орчуулагч оролцох журмыг хуульчилж өгсөн бөгөөд жишээлбэл, тус хуулийн 143-147 дугаар зүйлүүдэд шүүгдэгч нь орчуулагчийн туслалцаа авах эрхтэй тухай, орчуулагчаар оролцож болохгүй нөхцөл байдал, орчуулагчаар оролцохоос татгалзах ба нууц хадгалах үүргийн талаар заасан байна.

Нэгтгэж хэлэхэд, улс орнууд шүүхийн орчуулгын талаар түүх, философи зэрэг олон хүрээг хамруулан судалж ирсэн нь эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход нөлөөлсөн төдийгүй, бие даасан, тусгай судлагдахуун болгон хөгжүүлэхэд хүргэсэн гэж дүгнэж байна. Гадаадын зарим улс орон, тухайлбал БНХАУ-ын хүн ам 56 үндэстнээс бүрддэг тул гадаадын иргэд гэхээсээ илүүтэй өөрийн улсын үндэстэн, ястны тухайд орчуулагчийн асуудлыг

шийдвэрлэх хэрэгцээ шаардлага түлхүү байдгаараа онцлог бөгөөд энэ нь үндэсний цөөнхийн асуудалд нэн чухал зохицуулалтад тооцогдох ёстой¹ болдог.

Хоёр. Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуулийн 14.1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, 14.2-д “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгагварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, 53.1-д “Шүүн таслах ажиллагааг монгол хэлээр явуулна”, 53.2-д “Монгол хэл мэдэхгүй хүнд хэргийн баримт сэлтийг хэлмэрчлүүлэн бүрэн ганилцуулах бөгөөд шүүх хуралдаан дээрэх хэлээр нь үг хэлэх эрх олгоно” гэсэн заалтуудын үзэл баримтлалд нийцүүлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Арбитрийн тухай зэрэг хуульд шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулагчийг оролцуулах үндэслэл, орчуулагчийн эрх үүрэг, хүлээх хармуушлагын талаар зохицуулсан юм.

Шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатны орчуулгын ажил нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны хууль зүй, дотоод хэргийн чиглэлд хамаардаг, нарийн мэргэжил шаардах үйл ажиллагаанд тооцогддог орооно онцлогтой. Шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулгын ажил эрхлэх иргэнийг сонгон шалгаруулж тусгай зөвшөөрөл олгох журамд зааснаар

¹ “Хууль зүйн баримт бичиг ба хууль зүйн орчуулга”. Zhang Xin Hong, Li Ke Xing. 2005 он. Бээжин.

гадаад хэлний болон хууль зүйн нэр томъёо, хэллэгийн зохих мэдлэгтэй, орчуулгын ажлын дадлага, туршлагатай иргэн сонгон шалгаруулалтад орж болох бол тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

- шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үүргийг биелүүлэх;

- луудсан цагт ирж орчуулахаар даалгасан үүргийг бүрэн, зөв биелүүлэх;

- тухайн этгээдийн нэхэмжлэлийн шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал буюу оролцогчийн шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал, шүүх шуралдааны болон бусад ажиллагаа, хуулийн шийдвэрийн агуулгыг үнэн зөвөөр орчуулж өгөх, хэргийн материалтай танилцахад нь туслах.

Дээрх заалтуудаас гадна орчуулагчийг татгалзан гаргах тухай болон орчуулагч санаатайгаар худал орчуулсан, хэлмэрчилсэн бол түүнд хуульд заасан хариуцлага хүлээлгэх тухай, түүнчлэн орчуулагчийн алдаатай үйлдэл, эс үйлдэхүйгээс үүдэлтэй байцаан шийтгэх ажиллагаанд үүсэх харилцааны талаар цухас дурдсан заалтуудыг нэмж тоочиход холбогдох хуулиудын зохицуулалтыг бүрэн хамруулж болно.

Нэгтгэж хэлэхэд шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулагч оролцуулахад тавигдах шаардлагын тухайд манай улсын хуульд нарийвчилсан, нэг мөр мөрдөгдөх зохицуулалт байхгүй, байгаа хэдэн заалтад орчуулагчийн хүлээх үүргийн талаар дурдсан боловч тэдгээр нь учир дутагдалтай, ялангуяа ажил үүргээ гүйцэтгэхэд хэрэгцээт эрхийн талаар ойлголт байхгүй зэрэг байдлыг гадаад улсуудын зохицуулалттай

харицуулсны үндсэн дээр, практикт гарч байгаа бэрхшээлийг харгалзан ямар зохицуулалт хийвэл зохистой талаар дараахь саналуудыг дэвшүүлж байна.

1. Албан ёсны орчуулагчийн оролцоог холбогдох хуульд тусгах тухайд

Шүүх хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд оролцох орчуулагчид тавигдах шаардлагын тухай холбогдох хуулиудад өөр өөр заасан, тухайлбал ЭБШХ-ийн 47.1-д "хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь орчуулга хийх, хэлмэрчлэх мэдлэг, чадвартай хүнийг орчуулагч, хэлмэрчээр томилох тухай шийдвэр гаргаж уг этгээдэд танилцуулна", Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 29.3-д "Орчуулагч, хэлмэрч нь иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, 18 насанд хүрсэн, хэлмэрчлэх, орчуулга хийхэд зайлшгүй шаардлагатай хэлний болон тусгай мэдлэг эзэмшсэн хүн байна" гэсэн заалтууд эдгээр ажиллагаанд оролцох орчуулагч нь албан ёсны орчуулагч байх тухай тусгаж өгөөгүй байна. Харин ИХШШШТХ-ийн 49.5-д "Хэргийн оролцогчийн өөрөө сонгосон орчуулагч, хэлмэрчээс бусад шүүхээс томилогдсон орчуулагч, хэлмэрч нь эрх бүхий байгууллагаас орчуулгын ажил эрхлэх зөвшөөрөл авсан байна" гэсэн заалт албан ёсны орчуулагчийн талаар нэг талаар заасан боловч дурын хэн нэг тухайн хэл гадарладаг этгээдийг орчуулагчаар шүүхэд оролцуулж болохоор эрхийг хэргийн оролцогчид олгож байгаа нь албан ёсны орчуулагч оролцох нөхцлийг хязгаарлаж байгаа юм. Практикт, албан ёсны орчуулагчийг орчуулаагүйгээс үүдэлтэй, холбогдогч нь албан ёсны орчуулагчаар хангагдаагүй гэх, цаашилбал энэ шалтгаар мэдүүлгээс буцах зэргээр хэрэг удаахрах, буцаагдах явдал гарах нь олширсон ба энэ нөхцлөөр шинээр

илэрсэн нөхцөл байдал үүсэх тал байдаг.

Үүнээс үндэслэн холбогдох хуульд энэ харилцаанд оролцох орчуулагч нь сонгон шалгаруулалтаар эрх авсан, тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй албан ёсны орчуулагч байх талаар тусгах хэрэгтэй юм.

II. Орчуулагчийн эрх олгох сонгон шалгаруулалтын журмыг боловсронгуй болгох тухайд

ХЗДХЯ-наас Шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулгын ажил эрхлэх иргэнийг сонгон шалгаруулж тусгай зөвшөөрөл олгох журам болон орчуулга хийх хөлсний доод хэмжээний жишгийг батлан мөрдөж байна. Хэдийгээр эдгээр зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлсэн болон орчуулагчийн эрх олгох сонгон шалгаруулалтын хувьд маргаан зөрчил бага гардаг зэрэг дэвшилттэй тал байгаа боловч сонгон шалгаруулалтад оролцоогч төдийгүй тусгай зөвшөөрлийн гэрчилгээ эзэмшигчид тавигдах шаардлагын нарийвчлах талаар судлах хэрэгтэй. Шалгаруулалтад олон хүн хамрагдах нь сайн талтай боловч орчуулагчийн мэдлэг чадварыг харгалзахгүйгээр аль болох олон оролцогчийг тэнцүүлэх тухай асуудал огт байж болохгүй.

Тус журмын дагуу сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргагчийн бүрдүүлэх материалд Монгол Улсын иргэний үнэмлэх, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний хувьд гадаад улсын паспорт болон түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар багтдаг. Эндээс харахад сонгон шалгаруулалтад гадаадын иргэн, харьяалалгүй хүн оролцох эрхтэй учир шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулагчаар оролцох боломжийг мөн бүрдүүлж өгсөн байна. Тэгвэл МУ-д шүүн таслах ажиллагаа монгол хэлээр

явагдах тул гадаад хүн шалгаруулалтад оролцоход тавигдах шаардлага өөр байх хэрэгтэй. Жишээлхэд, тухайн гадаадын иргэний монгол хэл эзэмшсэн болон ашигласан дэдлага туршлагын байдлыг түлхүү анхаарч шалгаруулалт оролцуулах, шалгалт авах арга хэлбэр бас энэ талруу гүнзгийрэх ёстой.

Одоогийн тогтолцоогоор, шалгаруулалтад оролцогч манай улсын иргэн ба гадаад хүн бүгд шалгалтын хувьд монгол хэл дээрх бичгийн ажлыг гадаад хэлнээ орчуулах хэлбэрээр нэгэн ижил даалгаврыг гүйцэтгэж байгаа юм. 2009 оны сонгон шалгаруулалтын хятад болон солонгос хэлний орчуулагчийн шалгаруулалтад гадаадын иргэд, цагаач хүмүүс оролцсон бөгөөд тэдгээр нь нэгэн адил шалгуурт хамрагдсан явдалд манай улсын иргэд шүүмжлэлтэй хандах, эрх тэгш бус байгааг илэрхийлсэн юм. Энэ асуудалд тухайн гадаадын иргэн, цагаач нь шалгалтын монгол хэл дээрх даалгаврыг ойлгосон учраас л эх хэл рүүгээ хөрвүүлэх болно гэж зарим хүн өөр байр суурьтай хандах. Тэгтэл энэ нь хэрэг дээрээ үгүй билээ. Тэдгээр гадаад хүмүүс эх хэлээрээ мэдэж "ус цас" байдаг боловч монгол хэл дээр асуулт тавихаар ойлгохгүй, асуултаа ойлгоогүй учраас хариулж мэдэхгүй байдал гарсан байна. Аливаа хүн гадаадын хэлнээс эх хэл рүүгээ буулган хөрвүүлэх чадвар илүү байдаг нь маргаангүй үнэн. Ийнхүү шалгаруулалтад оролцогчийн иргэний харьяалаас гадна мэргэжил, мэргэшлийн тухай бас анхаарах шаардлагатай.

"Мэргэжилтэй боловч хэлгүй, хэлтэй боловч мэргэжлийн бус" байдлын дутууг гүйцээж, нөхөж чадах тийм хүн л орчуулга хийнэ гэвэл шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны орчуулагч нь хууль, эрх зүйн мэдлэг, хэллэг, нэр томъёог 2 хэлнээ хөрвүүлэн ангилах чадвар энэхүү хариуцаага

өндөртэй ажилд заавал шаардагдана. Энд нэгэн жишээг дурдахад, гэрээг орчуулахдаа "үүссэн маргааныг арбитраар шийдвэрлүүлнэ" гэснийг "үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ" болгож хоёр үгний ялгааг мэдэхгүй орчуулснаар хэргийн харьяалал буруу тогтоогдож шүүхээр шийдвэрлүүлэх шатанд асуудал үүсгэсэн явдал гарсан. Иймээс хууль мэргэжилтэн энэ төрлийн орчуулагчийн сонгон шалгаруулалтад оролцох, тэнцэх нь элбэг, илүү үр дүнтэй ажиллах талтай гэгддэг. Гэхдээ хэлний мэдлэг сайтай этгээд хууль зүйн ерөнхий мэдлэг, нэр томъёоны талаар тусгайлан сургалтад хамрагдсан байх шаардлагыг бий болгож хэрэгжүүлэх, нэгдсэн сургалт зохион байгуулах гарц бас байгаа гэдгийг тэмдэглэн хэлье.

III. Орчуулагчийн эрх, үүргийг тодорхойлох тухайд

1. Орчуулагчийн эрхийн тухайл: Шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд оролцогчид густусын эрхэй байдаг. Тухайлбал, нарийн мэргэжлийн тусалцаа үзүүлдэг, хэрэгцээ, үүрэг роль ялгаагүй чухалд тооцогдох шинжээч нь хуульд зааснаар, хэргийн материалаас шинжилгээ хийх зүйлд холбогдох хэсэгтэй танилцах, дүгнэлт гаргахад хэрэгцээтэй нэмэгдэл баримт сэлт ирүүлэхийг хүсэх зэрэгтэй. Гэтэл орчуулагч хүн ийм ийм үүрэгтэй хэмээн хуульд заасан боловч тэдгээр үүргээ гүйцэтгэхэд шаардагдах эрхийн талаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 60.3-д "Орчуулагч, хэлмэрч нь орчуулгыг тодруулахаар асуулт тавьж болно" хэмээн заасныг эс тооцвол бусад хуульд тухайлсан нэг ч заалт байхгүй байна. Ийм учраас орчуулагчид дараах эрхийг тодорхойлж өгвөл зохистой гэж үзэж байна. Үүнд:

- Хэргийн талаар мэдэх эрх-энэ

нь орчуулгад холбоотой хэргийн талаар мэдэх, ойлгох эрхийг хэлнэ;

- орчуулахад холбоотой бичиг баримтыг хүсэх эрх—энэ нь шүүх, цагдаагийн болон бусад байгууллагаас орчуулгад ашиглагдах бичиг баримтыг гаргуулж авах эрх юм;

- Тэмдэглэлийг уншиж баталгаажуулах эрх—тэмдэглэлд орчуулгын утга хэрхэн тусгагдсаныг уншиж танилцах, хянах, тохирохгүй байгаа гохиолдолд засах, нэмж оруулах талаар шаардах эрхийг хэлж байгаа юм. Энэ нь шүүх шатанд огт хэрэгждэггүй. Орчуулга бүрэн, үнэн зөв байх ёстой, эс бөгөөс хариуцлага хүлээхийг сануулалд гарын үсэг аваад байдаг, гэтэл орчуулга бүрэн, зөв тэмдэглэгдсэн эсэх талаар мэдэх боломж байхгүй. Харин хэргийн мөрдөн байцаах шатанд энэ эрхийг хангасан буюу ЭБШХ-ийн 202 дугаар зүйлд зааснаар, яллагдагчийг байцаасан тэмдэглэлд "Орчуулагч, хэлмэрч гэмдэглэлийн хуудасны нүүр бүрт нь ба тэмдэглэлд бүхэл нь гарын үсэг зурна.", "Байцаалтын тэмдэглэлийг өөр хэл дээр бичгээр орчуулсан бол түүний хуудасны нүүр бүрт ба бүхэл нь орчуулагч болон яллагдагч гарын үсэг зурсан байвал зохино." гэж заасан нь шүүх хурлын тэмдэглэлд мөн ийнхүү анхааралтай хандахад жишиг болно гэж үзэж байна;

- Хамгаалуулах эрх—энэ нь тодорхой нөхцөл, шаардлагатай тохиолдолд хамгаалалтад байж нөлөөнд автахгүй байхыг хангах зорилгыг агуулна.

2. Орчуулагчийн үүргийн тухайл: Хуульд тусгагдсанаар орчуулагч нь шүүх, мөрдөн байцаагчийн оролцогчид холбогдох материалыг бүрэн зөв орчуулж өгөх, хэргийн материалтай танилцахад туслах үүрэгтэй. Элдэрээс гадна дараах үүргийг нэмж тохивол зохилтой. Үүнд:

- Хараат бус, бие даасан, нууцрга

байх үүрэг-орчуулагч нь гадаадын иргэний эсвэл хуулийн байгууллагын ажилтны туслах гэдэг утгаар бус, бие даасан, хараат бус байдалаар биеэ авч явах үүрэг юм. Ингэснээр шударга байх зарчмыг мон хангах төдийгүй бусад үүргийн тухайд ч чухал нөлөөтэй үүргийн төрөлд орно;

- орчуулагчаар оролцохоос татгалзах үүрэг-энэ бас их онцгой үүрэг бөгөөд хэргийг үнэн зөв орчуулахад нөлөөлөх харилцаа, ашиг сонирхол үүсэх нөхцөлд өөрөө татгалзах үүрэг юм;

- мэргэшлийн ёс зүйг баримтлах үүрэг-энэ нь үйлчлүүлэгчтэй зөв боловсон харьцах, цаг барих, зохих төлбөр хөлсөө шударга зөв тооцохоос гадна шан харамж нэхэхгүй зэргээр үйлчлүүлэгчийг хүндэтгэж харилцахыг хэлнэ;

- нууц хадгалах үүрэг- орчуулгын явцад хэргийн талаар олж мэдсэнээ болон хувь хүний нууцыг хадгалах үүрэг юм;

- үг хэллэг, тайлбарыг бодитоор дамжуулах үүрэг- "нэг үг газар гээлгүй" гээр эх материал болон эх утга санаатай тохирч, дүйцэхээр орчуулах явдал бол энэ төрлийн орчуулгын төрөлд зарчмын том зүйл юм. Мөрдөн байцаалт, шүүх хурлын үед тун нухацтай асуусан, хэлсэн үгийг зөөлрүүлж, хүчийг сулруулахад тохиромжгүйн зэрэгцээ уран зохиолын орчуулгын адил уянгын халил, хэтрүүлэг хэрэглэж болохгүй.

IV. Орчуулгыг баталгаажуулах арга хэлбэрийг бий болгох, хэвшүүлэх тухайд

Одоогийн байдлаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээнээс өөр орчуулагч ажил үүргээ албан ёсоор баталгаажуулах арга хэлбэр байхгүй. Тухайлбал, үнэмлэх байхгүй тул том хэмжээтэй гэрчилгээг байнга авч явах шаардлага гардаг. Зарим үед үнэмлэх нэхэгдэх тохиолдол ч байна. Зарим орчуулагч өөрийн нэр бүхий тамга дардас хувиараа

хийлгэж хэрэглэдэг.

Иргэний байцаан шийтгэх ажиллагааны асуудлаархи конвенци, Гадаадыг арбитрийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай зэрэг олон улсын гэрээнд, тухайлбал Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенцид "Шүүхийн даалгаврыг ... хүсэлт хүлээн авагч засаг захиргааны байгууллагын хэлээр буюу сонирхогч хоёр улсын тохиролцсон хэл дээр үйлдсэн, эсхүл дээр дурдсан хоёр хэлний аль нэг дээр үйлдсэн бөгөөд хүсэлт гаргагч улсын дипломат буюу консулын төлөөлөгч, эсхүл хүсэлт хүлээн авагч улсын баталгаат орчуулагчийн гэрчилсэн орчуулгыг түүнд хавсаргасан байна." гэх зэргээр албан ёсны орчуулагчийн орчуулгыг шууд хүлээн зөвшөөрч, тухайн орчуулга хүчинтэй байх үндсийг гаргаж өгсөн байдаг.

Харин манай улсын ИХШХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 4-д "Гадаад хэлээр бичигдсэн нотлох баримтыг албан ёсны зөвшөөрөл бүхий орчуулагч, хэлмэрчээр монгол хэл дээр орчуулуулж ... нотариатчаар гэрчлүүлсэн байна" гэсэн заалт практикт маш зөрчилтэй байдаг. Албан ёсны эрх бүхий орчуулагч орчуулж баталгаажуулсан бичиг баримтыг дахин баталгаажуулах шаардлага байгаа эсэх, баталгаажуулалтыг тухайн хэлийг мэдэхгүй нотариатч хийж буй нь ойлгомжгүй бөгөөд нэг төдий, мөнгө болоод цаг үрсэн асуудал болдог. Цаашилбал маргаан гарах нөхцөл болж байгаа юм. Нотариатын тамга тэмдэгтэй баримтыг үнэлэхгүй байх хэцүү байдал үүсдэг. Сүүлийн үед хуурамч эсвэл хуудуутай орчуулгыг гэрчилснээс үүдэлтэй байцаан шийтгэх ажиллагааг хууль бус болгосон, ажилд саад болж удаашруулсан зэрэг асуудал гарсаар байна. Энэ нь хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянах нөхцөл болж байгаа нь өмнө

үүсч гарах харилцаанд зохицуулалт хийлгүйгээр зөвхөн дараагийн үүссэн харилцааг яаж шийдвэрлэх талаар зааж байгаа буруу тогтолцоо гэж үзэж байна.

Иймээс ИХШХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 4-ийн "Гадаад хэлээр бичигдсэн нотлох баримтыг албан ёсны зөвшөөрөл бүхий орчуулагч, хэлмэрчээр монгол хэл дээр орчуулуулж нотариатчаар гэрчлүүлсэн байна" гэсэн заалтыг "Гадаад хэлээр бичигдсэн нотлох баримтыг албан ёсны зөвшөөрөл бүхий орчуулагч, хэлмэрчээр монгол хэл дээр орчуулуулсан байна" гэж өөрчлөх саналтай байна.

Ер нь бичгийн орчуулгын материалд орчуулагчийн үнэмлэхний хуудбарыг хавсаргаж, тамга тэмдэг даран гарын үсэг зурах үйлдлүүд хамт хийгдсэнээр хүчин төгөлдөр баталгаа болж чадах тул ийм байдлаар тогтож, хэвшүүлэн хэрэглэх хэрэгтэй гэж үзэж байна.

V. Орчуулагчид хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх тухайд

Дээр дэвшүүлсэн бусад саналуудаар орчуулагчийн эрх үүргийг тодорхойлох болон бусад зохицуулалтыг бий болгосны дүнд орчуулагчийн алдаатай үйлдэл, эс үйлдэл болон ёс зүйн зөрчилд хариуцлага тооцох хууль зүйн үндэс аяндаа бий болно гэж үзэж байна. Шаардлагатай тохиолдолд сануулах, эрхийг түдгэлзүүлэх, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, хуулийн байгууллаагаар шийдвэрлүүлэх гэх мэт арга хэмжээ авах хэлбэрээр орчуулагчид хариуцлага тооцоо болох механизмыг бүрдүүлэх нь тохиромжтой юм. Үүний дунд, орчуулагч өөрийн эрх үүргээ мэдэх, ёс зүйгээ ухамсран, хариуцлагатай ажиллах тал дээр том дэвшилийг дагуулна.

ДҮГНЭЛТ

Дүгнэж хэлбэл шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах

ажиллагаанд орчуулагчийн оролцоог чухалчлах хэрэгцээ, шаардлагын үүднээс:

- Албан ёсны орчуулагч оролцуулах шаардлагыг хуульд тусгах;
- Орчуулагчийн эрх олгох сонгон шалгаруулалтын журмыг боловсронгуй болгох;
- Орчуулагчид хууль зүйн мэдлэг олгох тусгай, үргэлжилсэн сургалтыг зохион байгуулах, албан ёсоор хамрагдах эрх зүйн орчин бүрдүүлэх;

• Орчуулагчийн эрх, үүргийг тодорхойлох;

• Орчуулагчийн ажил үүргээ баталгаажуулах арга хэлбэрийг бий болгох;

• Орчуулагчид хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудлыг эрх зүйн хүрээнд зохицуулах шаардлагатай гэсэн саналтай байна.

Орчуулгын ажил эрхлэгчдийн практикт мөрдөн байцаалт, шүүх хурал аль аль нь зарлагдсан хугацаандаа эхэлдэггүй, олон удаа хойшлох, эсвэл орчуулагчид хугацааг тулгаж хэлэх явдал давтагддаг. Мөн орчуулгын хөлс төлбөрийг хувь хүн төлөх үед боломжийн, харин улсын байгууллага, шүүх, цагдаагаас гаргана гэж тохирсон бол чирэгдэл үүсэх, төлбөрөө олж авч чадаагүй тохиолдол ч байдаг. Хувь хүн төлбөрийг шууд гаргасан

тохиолдолд шуурхай, хялбар байгаа сайн тал байдаг боловч орчуулагчид хөдөлмөрийн хөлс өгсөн талын зүгээс ажил олгогчийн байр суурьтай хандах тал ажиглагддаг. Гэм буруутай этгээдээс орчуулгын зардлыг гаргах тал дээр мэдээжийн харилцаа үүсч болох бол хэрэгт ач холбогдол бүхий гэрчийн мэдүүлэг дээр орчуулгын зардлыг тухайн гэрчээс гаргуулах тухай ярихад зохимжгүй бөгөөд зөрчил үүсдэг. Дээр дурдагдсан бэрхшээлүүдээс болоод орчуулгын эрх авсан иргэдийн итгэл алдарч, ажил эрхлэлт буурсан байдал анзаарагддаг.

Иймээс эрх зүйн хүрээний зохицуулалтыг бий болгохын зэрэгцээ дараахь байдлаар:

- орчуулагчийн нэр, нас, мэргэжил, төгссөн сургууль, ёс зүйн болон сахилгын байдал зэрэг товч танилцуулга, орчуулгын ажлын туршлага, түүн дотор хууль зүйн чиглэлийн орчуулгын ажлын туршлагыг эрх авсан оноор нь тооцох зэргээр орчуулагчдын нэгдсэн, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, хувь хүн, албан байгууллагад нээлттэй, хүртээмжтэй байлгах;

- орчуулагчдыг судалж, харгалзсаны үндсэн дээр тухайн хэрэгт орчуулагчийг сонгож, томилоод заншлыг бий болгох;

- тухайн хэрэгт ажиллагааны эхний үе шатнаас

эхлэн заавал албан ёсны орчуулагчийг оролцуулах;

- нэг хэргийн бүх шатны ажиллагаанд нэг орчуулагч дагнаж тууштай ажиллавал үр дүнтэй байдлыг хангаж өгөх;

- орчуулагч оролцуулах ажлын цагийн хуваарийг гаргахдаа орчуулагчтай урьдаас тохирох, мэдэгдэх;

- олон оролцогчтой, эсвэл онц хүнд, дулиант хэргийн шүүх хуралд 2 орчуулагчийг зэрэг оролцуулах байдлаар орчуулгыг хамтрах, харилцан хянах нөхцлийг бүрдүүлэх;

- орчуулагчийн ажлын хөлсийг хөндлөнгийн байгууллагаар дамжуулан шуурхай, чирэгдэлгүй гаргах замаар орчуулагчийн хараат бус байдлыг хангах зэрэг практик асуудлыг оновчтой зохицуулж, хэвшүүлбэл шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулагчийн оролцоог чухалчлах асуудалд мөн ач холбогдолтой юм.

Орчуулагч нь хэргийг сайтар ойлгохын зэрэгцээ тухайн хэрэгт явагдаж байгаа ажиллагааг мэдэрч чадаж байж л сая орчуулга үр дүнтэй болдог билээ. Орчуулагчийн ур чадвар нь мөрдөн байцаалтын арга тактик, шүүхийн мэтгэлцээнд хэрхэн нөлөөтэй, ямар үр дагавартай зэрэг сонирхолтой сэдэв асуудлыг улам чухал болгон илтгэх болно.

ХЭРГИЙГ НЭМЭЛТ ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТАД БУЦААХ ТУХАЙ

Нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа (цаашид ЭБША гэх)-ны явцад гардаг нэгэн шийдвэр юм.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь хэргийг бүх талаас нь бүрэн дүүрэн судалж сэжигтэн, яллагдагчийг яллах ба цагаатгах, хэргийг хүндрүүлэх буюу хонгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох үүрэгтэй. (Эрүүгийн байцаан шийтгэх хууль /цаашид ЭБШХ гэх/-ийн 16 дугаар зүйл.)

Уг шаардлагыг хангахын тулд прокурор хэргийг хянах явцдаа, шүүгч яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай захирамж гаргахдаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа бүрэн хийгдсэн эсэх, дутуу ямар зүйл байна, түүнийг нөхөн гүйцэтгэх боломж буй эсэхийг нягтлан үзэж шалган тодруулдаг журамтай.

Хэргийг буцаах үндэслэл прокурорын хяналт, шүүхийн аль ч шатанд илэрсэн байж болох ба буцаах үндэслэл тодорхой, нэмж хийх ажиллагаа ойлгомжтой, хууль зүйн үндэслэлтэй, хэрэгт ач холбогдол бүхий байна.

Тухайлбал: ЭБШХ-ийн 322.1-д Давж заалдах шатны шүүх хэргийг буцаахдаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны ажиллагааны чухал аль шатанд шилжүүлж байгааг магадлалдаа заана.

Харин анхан болон давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ ЭБШХ-г ноцтойгоор зөрчсөнийг тогтоовол хяналтын шатны шүүх тогтоол, магадлалыг хүчингүй



**МӨХ-ны гишүүн, омгологч,
магистр Б.Ганболд**

болгож, хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаана (ЭБШХ-ийн 352.1).

1.Хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах үндэслэл

Эрүүгийн хууль (цаашид ЭХ гэх)-ийг буруу хэрэглэсэн, ЭБШХ-ийг ноцтой зөрчсөн, хэргийг бүрэн гүйцэт шалгаагүй, хангалттай нотлох баримт бүрдээгүй, мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу хийгдсэн зэрэг шалтгаанаас хамаарч тухайн хэрэгт нэмж хийх ажиллагаа, шалгах зүйл зайлшгүй байгаа бөгөөд тэдгээрийг хийхгүй бол эсхүл түүнийг нөхөн зөвтгөхгүйгээр хэргийг бүрэн гүйцэт гэж үзэж эцэслэн шийдвэрлэх боломжгүй нөхцөлд хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаадаг.

Тухайлбал: шинжилгээ хийлгээгүй, хохирлын хэмжээг зөрүүтэй буюу буруу тооцсон, зарим гэрч, хохирогчийг байцаагаагүй, мэдүүлгийн зөрүүг арилгаагүй, холбогдох баримт материалыг хавсаргаагүй, хэргийн материалтай танилцуулаагүй, зохих ЭБША-г хийлгэх эсхүл ЭБША-ны алдаа, зөрчлийг зөвтгүүлэх г.м.

Жишээ нь: онц хүнд гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох шинжилгээ хийлгээгүй (ЭБШХ-156.1.6), яллах дүгнэлтийн хохирлын хэмжээ нь хэрэгт байгаа бусад хохирлын баримттай зөрж байгаа, гэрч, хохирогчийн мэдүүлэг зөрүүтэй, урьд өмнө ял шийтгүүлсэн этгээдийн шийтгэх тогтоолын хувийг хэрэгт хавсаргаагүй, хохирогч, иргэний нэхэмжлэгч нарт хэргийн материалыг танилцуулах ажиллагаа хийгээгүй, туршилт, үзлэг г.м ажиллагааг нэмж хийлгэх, ял өөрчлөн сонсгохдоо яллагдагчаар татах тогтоол үйлдээгүй зэрэг зөрчил дутагдалыг арилгах зэрэг болно.

2.Хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах журам

Эрүүгийн хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын бүхий л ажиллагааг хийж дууссан, хэргийг шийдвэрлэхэд хангалттай нотлох баримт бүрдсэн гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь хэргийн материалыг яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч тэдний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч нарт танилцуулж, хэргийг прокурорт шилжүүлнэ.

Прокурор нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар хянавал зохих ЭБШХ-ийн 214 дүгээр зүйлд заасан асуудлуудыг хянан үзээд хэргийг шүүхэд шилжүүлэх эсхүл нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах асуудлыг шийдвэрлэнэ.

Эрүүгийн хэргийг хянах явцад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу

хийгдсэн, хэргийг бүрэн гүйцэт шалгаагүй, хэргийг шүүхэд шилжүүлэх хангалттай нотлох баримт бүрдээгүй гэж үзвэл прокурор уг хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаана (ЭБШХ-215.2.3).

Харин хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах шаардлагагүй, яллах бүрэн үндэслэлтэй, хийгдэх бүх ажиллагаа дууссан гэж үзвэл хэргийг шүүхэд шилжүүлнэ.

Шүүх хэргийг хүлээн авч яллагдагчийг шүүхэд шилжүүлэх эсхүл хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокурор буцаах талаар зохих шийдвэр гаргана. (ЭБШХ-225.1.2, 230)¹

Хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах журам нь дараахь 2 тохиолдолд хамаарна. Үүнд:

а). Прокурор хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах;

Прокурор хэрэгт нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр тодорхой чиглэл өгөх, хэргийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид буцаах эрхтэй. (ЭБШХ-193.1.18) Үүнд:

- Хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэрэг бүртгэлтэд буцаахад прокурор энэ тухай тогтоол үйлдэж ЭБШХ-178.2-т зааснаар хэргийн хугацааг 15 хүртэл хоногоор сунгаж, даалгавар бичиж хэргийг хэрэг бүртгэгчид буцаана.

- Хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр мөрдөн байцаалтад буцаахад прокурор энэ тухай тогтоол үйлдэж ЭБШХ-182.6-т зааснаар хэргийн хугацааг 1 сар

хүртэл хугацаагаар тогтоож, даалгавар бичиж хэргийг мөрдөн байцаагчид буцаана.

Ингэхдээ тухайн хэрэгт нэмж хийх ажиллагаа, шалгах зүйлийн талаар бичгээр даалгавар, заалт өгнө, даалгаварыг хэрэгт хавсаргахгүй² боловч мөрдөн байцаагч заавал биелүүлэх үүрэгтэй.

Гэхдээ уг даалгаварыг мөрдөн байцаагч эс зөвшөөрвөл 5 хоногийн дотор дээд шатны прокурорт нь бичгээр санал гаргах эрхтэй. (ЭБШХ-28.2.13)

б). Шүүх хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах

Дараахь үндэслэлээр шүүх эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурор³ буцаана. Үүнд: (ЭБШХ-225.1.2, 230)

1. Хэргийг буруу нэгтгэсэн, тусгаарлагдсан бол (уг ажиллагааг ЭБШХ-124, 125-р зүйлд заасны дагуу зөвтгөн хийлгэхээр буцаах агуулга),

2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн бөгөөд түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй бол;

- бүрэн биш гэдэгт яллагдагч ЭХ-н хэд хэдэн зүйлээр яллагдагчаар татагдсан ямар үйлдэл нь, ямар зүйл, хэсгээр зүйлчлэгдэхийг заагаагүй эсхүл хамтран оролцогч нэг бүрийн үйлдлийг ялгаагүйг хамааруулж,

- шүүх хуралдаанаар нөхөн хийж болохгүй бүрэн биш ажиллагаа гэдэгт нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын тодорхой ажиллагаа явуулж байж нотлох баримт шинээр цуглуулах, гэмт хэрэгт

сэрдэгдсэн бусад этгээдийг олох, эсхүл мөрдөн байцаалтын ажиллагаа өөр газарт буюу нэмэлт олон ажиллагаа явуулах шаардлагатай байхыг ойлгоно.⁴

3. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн (үүнийг ЭБШХ-321-р зүйлд заасан утгаар ойлгож хэрэглэнэ);

4. ЭБШХ-г ноцтой зөрчсөн бол (үүнийг ЭБШХ-320-р зүйлд заасан утгаар ойлгож хэрэглэнэ);

5. Улсын яллагч хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх шаардлагатай гэж үзсэн (яллах дүгнэлт үйлдсэн буюу яллагдагчаар татах тогтоолыг батдаж шүүх хуралдаанд улсын яллагчаар томилогдон оролцсон прокурор ийм санал гаргасан бол ЭБШХ-239.4.2).

Түүнчлэн зүйлчлэл хүндрэх, шинэ баримт гарч ирэх, харъяалал зөрчиж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан, яллах дүгнэлт хуульд харшилан, шинжээч томилож дүгнэлт гаргуулах, шүүх тогтоох боломжгүй байдлыг шалгах шаардлага үүсэх, өмнө нь буцаасан тогтоол, захирамжийн заалтыг бүрэн хангаагүй түүнчлэн хэргийн бодит байдал эрс өөрчлөгдөхөөр бол хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах үндэслэл болно.

Шүүх эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурор буцаахдаа баримтлах журам нь:

- шүүгч захирамж;
- шүүх тогтоол гаргах бөгөөд ямар үндэслэлээр хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт,

¹ Анхын шатны шүүх хуралдаанаас хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцааж болно.

² Эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд прокуророос таних хяналтын ажилд ЭБШХ-н заалтыг дагаж мөрдөх аргачилсан зааврын 39.4.

³ Шүүхээс эрүүгийн хэргийг прокурорт буцаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, шүүгдэгчийг цагаатгах тогтоол гаргасан, улсын яллагч яллахаас татгалзсан шалтгаан, нөхцлийг судлах, дүгнэлт хийх журмыг үзнэ үү (УЕП-ын 309 тоот тушаал. 2006 оны 11 дүгээр сарын 7-ны одор).

⁴ ЭБШХ-н тайлбар (хамтын бүтээл). УБ., 2003 он. 334 дэх тал.

мөрдөн байцаалтад буцааж байгаа талаар тодорхой дурьдаж хэргийг прокурорт буцаах замаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад дахин шилжүүлнэ.

Хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаасан бол прокурор уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт байтгаан эсэргүүцэл бичих эрхтэй.

Хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаахтай холбогдуулж давж заалдах шатны шүүхээс гаргасан магадлал нь нэн даруй заавал биелэгдэх ба энэ магадлалд хяналтын шатны журмаар гомдол, эсэргүүцэл гаргаж болохгүй.⁵

Урьд нь (анхан шатны шүүхээр) гэм буруутайд тооцогдож ял шийтгүүлж уг ялаа эдэлж байсан буюу эдэлж дууссан этгээдийн хэрэг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцсан бол уг хэргийг шүүхээр “заавал” дахин хэлэлцэж эцсийн шийдвэр гаргадаг (ЭБШХ-322.3) байсныг 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болгосон юм.

Иймд ийм хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх бөгөөд шүүх заавал дахин уг хэргийг авч хэлэлцэх шаардлага байхгүй болно.

Дүгнэлт

Одоогийн дагаж мөрдөж буй ЭБШХ дахь хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах тухай асуудлыг авч үзлээ.

Хэргийг прокурор, шүүх нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаадаг нь нэгэн ёсны зайлшгүй шинжтэй гэмээр шийдвэр болж хэвшсэн байна.

Хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах нь прокурорын болон шүүхийн гэсэн үндсэн 2 үе шатанд хэрэгжиж байгаа ба шүүхийн шатнаас хэрэг буцах нь илүү сонирхол татаж байна.

Яагаад гэхлээр “эхлээд хэргийг прокурор нэмэлт ажиллагаанд буцааж болохоос гадна шүүгч яллагдагчийг шүүхэд шилжүүлэх үедээ хэргийг буцаах асуудлыг заавал шийдвэрлэх эрх үүрэгтэй байдаг 2 шатны ажиллагаа байхад энэ 2 шатаар орсон хэрэг дахиад шүүх хуралдаанаас буцаад байдаг нь ямар учиртай болох нь анхаарал татна.

Үүнд прокурорын төдийгүй шүүгчийн ажлын хариуцлаггүй байдал ч нөлөөлж байгаа гэж үзэхэд хүргэнэм.

Уг сэдвийн хүрээнд дүгнэлт хийж үзэхэд дараахь санал сэтгэгдэл төрсөн болохоо та бүхэнтэй хуваалцахыг зорилоо. Үүнд:

Нэг. Хэргийг прокуророос нэмэлт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах нь шүүх хэргийг буцаахаас илүү дээр санагдавч прокурор ямар үндэслэлээр буцаах талаар ЭБШХ-д⁶ тусгайлан заасан зүйл, заалт эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Шүүхийн практикт энэ ажиллагаа эхрэн явагдаж байгаа талаар мэдэгдэх зүйл тун бага агаад прокурор даалгавар бичиж хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах журам үйлчилж буй боловч уг даалгаварыг хэрэгт хавсаргадаггүй учир түүнийг хэргийн оролцогчид, бүр өмгөөлөгч, тэрчлэн шүүх мэдэх арга байхгүй ба нууцлаж байгаа нь нэн сонирхолтой.

Гэхдээ “даалгаварын заалтыг

ханга” гэж тогтоолын үндэслэл дээрээ прокурор бичсэн байх нь гайхалтай агаад уг даалгаварыг зөв ч бай, буруу ч бай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч заавал биелүүлдэг, түүнийг эсэргүүцэх чадвар байхгүй болсон нь практикт хэвшмэл болжээ.

Тухайлбал: хэргийг хэрэгсэхгүй болгосон санал үйлдэж хэргийг прокурорт шилжүүлэх үед прокурор заавал саналыг үндэслэлгүй гэж үзэж хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцааж даалгавар өгөх, уг даалгаварыг биелүүлж дахин ийм санал гаргахад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийг солих, дараагийн мөрдөн байцаагч солигдохгүйн тулд зайлшгүй яллаж таардаг буруу практик байна.

Жишээ: Н-д холбогдох хэргийг 2 удаа хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснийг хэрэгсэхгүй болгох тусам нь дахин сэргээсээр энэ хэрэг УМБГ ба нийслэлийн прокурорын газрыг 2 жил дамнаж “хэсэн сэлгүүцэж”, энэ хугацаанд гадаад улсад хүртэл ажиллагаа хий гэсэн шийдвэр даалгавар хүртэл гарч, ажил цалгардаж, үргүй зардал бий болж, хүний эрх зөрчигдөж сэжигтэн нэр зүүсээр байна.

Энэ нь дан ганц хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хувьд биш дээд шатны прокурор доод шатны прокурорын шийдвэрийг хүчингүй болгож хэрэгсэхгүй болгосон хэргийн нь сэргээж даалгавар өгдөг, тиймд уг хэрэгт ялах дүгнэлт хүссэн хүсээгүй дараагийн хэрэг авсан прокурор үйлдэж улмаар шүүхэд очиж хэрэг нь унадаг сонирхолтой түүх олон хэрэгт давтагдаж байгаагаас тодорхой.

Хоёр. Хэргийг буруу буюу дутуу шалгасан бол буцаахгүй

⁵ ЭБШХ-326-р зүйлийн 326.1, 353-р зүйлийн 353.4 дэх хэсгийг тайлбарлах тухай УДШ-2006-3-20-ний №10 тоот тогтоол.

⁶ Ерөнхий зохицуулалтаас өөр.

⁷ Зохиогчийн өмгөөлөл дор буй хэрэг учир нууцлав.

гээд яах билээ гэсэн хэдий ч яллах тал (прокурор) болно гээд шүүхэд шилжүүлж байхад шүүх шийдвэрлэж байх нь л зүйтэй.

Өөрөөр хэлбэл яллах тал нотлох баримтаа бүрэн цуглуулсан, яллах боломжтой, хийх ажиллагаа байхгүй гэж үзээд шүүхэд яллагдагчийг шилжүүлэх шийдвэрээ гаргаж яллагдагчаар татах тогтоолыг батлаж буюу яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд албан ёсоор хүлээлгэн өгч байхад шүүх төвийг сахисан, яллах ба өмгөөлөх аль ч талд хэлбийлгүй мэтэлцээний үндсэн дээр хэргийг аль нэг талд шийдвэрлэх ёстой атал хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хутгалдан орж, ингэ тэг, ийм байдлаар шалга, үүнийг тогтоо, гэм буруутайг бүрэн нотолж ир гэх маягийн заавар өгч хэргийг буцааж байгаа учир нэг ёсны яллах сонирхол нэвт шингэсэн, гэм буруугийд тооцох чадвараа алдсан гэж дүгнэхэд хүргэж байна.

Жишээ:⁴ Шүүх хуралдаанаар хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй, хэргийн талаар нотолбол зохих асуудлуудыг тогтоогоогүй, хохирогч Ц.Э-н биед учирсан гэмтлийг шүүгдэгч Т.Э учруулсан гэдэг нь бүрэн нотлогдоогүй байна. Иймд дараахь зүйлүүдийг нэмж тодруулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд: ... хохирогч Ц.Э намайг 4 залуу зодсон, 170 см өндөр нуруутай туранхайдуу бистэй урт үстэй, 24-25 орчим настай, залуу байсан. Царайг нь харж чадаагүй. Намайг зодож байхдаа доошоо тонгойход нь үс нь урагшаа нүүрээ халхалсан. Үсээ гараараа хойш нь болгож байсан, гэрч Д-н: үүрээр хүнд зодуулсан байдалтай орж ирээд л

унтсан, Т.Э богино халимагтай, учир нь буржгар үстэй тул үс нь орооцолдож байдаг тул ургуулдаггүй гэсэн мэдүүлэг зэргээс Т.Э-с гадна өөр хүмүүс байсан болох нь нотлогдсон, тэдгээр нь зөвхөн салгасан гэж үзэхэд учир дутагдалтай байх тул тэдгээрийг олж байцаах ... гэж буцаажээ.

Хэрвээ шүүх ингэж л дүгнэж байгаа юм бол ЭБШХ-13.2-т зааснаар шүүгдэгчид ашигтай байдлаар авч үзэж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй, яагаад шийрэгнээд байгаа нь дээд шатны шүүхээс хэргийг буцааж магадгүй гэж үзсэнтэй холбоотой байх.

Манай эрүүгийн процессын хэв маяг⁵ ёсоор төр нэгэнтээ яллах үүргийг хүлээдэг учир бүрэн яллаж чадаагүй бол хариуцлагаа өөрөө үүрэх ёстой ба шүүх ийм шийдвэр гаргаад байгаа нь яллах талтай нэг гэдгийг илтгэж байна гэсэн сэжиг хар төрүүлэнэ.

Мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу хийгдснээс болж хэрэг олон дахин буцах, заримдаа замхарч алга болох, үүнээс болж олон хүмүүсийн ажил цалгардах, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэрч, хохирогч, шинжээч, өмгөөлөгч нар цаг заваас аваад янз бүрийн байдлаар хохироод байж таарахгүй санагдана.

Хэрвэ шүүх буцаахаа болих эсхүл цагаатгаад байвал тэр хэмжээгээр прокурор түүнийг дагаад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үүрэг хариуцлага өсч ажлын ур чадвар дээшлэх бус уу.

Нэгэнтээ яллаж чадахгүй л юм бол ядаж л яллахаас татгалзах чадварт суралцах нь зүйтэй баймаар.

Шүүх тогтоол гаргахаар

зөвлөлдөх тасалгаанд орно (ЭБШХ-282.1), Шүүх МУ-ын нэрийн өмнөөс тогтоол гаргана (ЭБШХ-283.1), Шүүхийн тогтоол нь шийтгэх буюу цагаатгах хэлбэртэй байна (ЭБШХ-290.1), "Цагаатгах тогтоол" гэж шүүгдэгчийн гэм буруугийг нотолсон шүүхийн шийдвэрийг; "Шийтгэх тогтоол" гэж шүүгдэгчийг гэм буруутайг нотолж, түүнд ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг хэлнэ (ЭБШХ-5.1.21, 5.1.22) гэж хуульчлан зааснаас үзвэл Шүүх нэг бол шийтгэх эсхүл цагаатгах тогтоол гаргах ёстой гэж ойлгогдож байна, харин хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах агуулга үүнд байхгүй атал буцаасан энэ шийдвэрийг юу гэх вэ гэдэг нь сонирхолтой.

Тоон мэдээ дурдвал:⁶ анхан шатны шүүхүүд 2009 оны эхний хагас жилд 6558 хүнд холбогдох 4148 эрүүгийн хэрэг хүлээн авч, 547 хүнд холбогдох 311 эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж, 2 хүнд холбогдох 2 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, шүүгдэгч, хохирогч эвлэрснээр 238, цагаатгах тогтоолоор 95 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, 4821 хүнд холбогдох 3264 хэргийг таслан шийдвэрлэж, эхний хагас жилд 855 холбогдогчтой 571 хэргийн үлдэгдэлтэй байна.

Шүүхийн шийдвэрийн мөн чанар нь нэг бол шийтгэх нөгөө бол цагаатгах л ёстой атал "яллах юмыг нь аваад ир" гэж явуулж байгаатай агаар нэгэн адил ийм шийдвэр гаргах нь хэр оновчтой, ялихгүй зүйлээр шалтгааж практикт хэлдэгээр "боос"

⁴ СБД-н шүүх. Шүүхийн тогтоол (хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах тухай). №13.. 2008 оны 1 дүгээр сарын 7-ний өдөр.

⁵ Б.Ганболд. "ЭБШЭЗ (сөрөнхий анги)". УБ., 2008 он. 103 дахь тал.

⁶ МУ-ын Шүүхийн 2009 оны эхний хагас жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүнгийн тухай танилцуулга. 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр. УДШ-н нэб сайт. www.supremecourt.mn.

түүгээр байх шаардлага байна уу?.

Гурав. Яллах тал болох прокурор буцаан гэхлээр буцааж боллог (ЭБШХ-230.1.4) хэрнээ омгоологч буцааа гэхлээр болдоггүй, бас буцаасан хэрэгт прокурор эсэргүүцэл бичиж боллог (ЭБШХ-230.2) хариу хэргийн бусад оролцогч, өмгөөлөгчид ийм эрх байхгүй г.м тэгш бус зохицуулалт ЭБШХ үйлчилсээр байна.

Хэрвээ хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хэргийг буцаасан нь шүүхийн шийдвэр мөн юм бол анхан шатны уг шийдвэрт өмгөөлөгч давж заалдах эрхтэй гэсэн үг. Гэтэл зөвхөн прокурор ажлын 5 хоногт эсэргүүцэл бичдэг. Энэ нь давж заалдах эрхийг хязгаарлаж байгаа юм биш үү. Эсрэгээр бодвол давж заалдах эрхгүй болохоор шүүхийн шийдвэр гэж үзэхэд учир дутагдалтай санагднам.

Үүнийг дараах 2 шалтгаанаар тайлбарла:

1. Анхан шатны шүүх хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаасныг прокурор эс зөвшөөрч эсэргүүцэл бичсэнээр давж заалдах шатны шүүх хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаасан нь буруу гэж үзэж анхан шатны шүүхээр дахин

хэлэлцүүлэхээр буцаахад анхан шатны шүүх нь цагаатгах эсхүл шийтгэх тогтоолын аль нэгийг гаргачихаж байна.¹¹

Жишээ нь:¹² М нь 2006 оны 10 дугаар сарын 5-ны өдрөөс 2006 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн хооронд Б, Я, А, Ш, Э нарын 5 эмэгтэйг ондөр цалинтай ажилд оруулна гэж хуурч мэхлэн Сингапур Улсад аваачиж мөлжих зорилгоор биеийг нь үнэлүүлж, МУ-ын хил давуулан худалдаалсан учир прокурор ЭХ-113.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлжээ.

ЧДШ хэргийг 2008 оны 4 дүгээр сарын 21-нд мөрдөн байцаалтыг бүрэн хийгээгүй, түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй гэж үзэж нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаасныг прокурор эс зөвшөөрч эсэргүүцэл бичсэнээр Нийслэлийн давж заалдах шатны шүүхээр хэлэлцэж хэргийн бүрдэл хангагдсан байна, нэмж шалгах шаардлагагүй тул хэргийг анхан шатны шүүхээр эцэслэн шийдвэрлүүлэхээр буцаажээ.

Анхан шатны шүүх 2008 оны 6 дугаар сарын 27-нд ЭХ-113.3-т зааснаар 10 жил 1 сар хорих ялыг чанга дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид

эллүүлэхээр шийдвэрлэснийг Нийслэлийн давж заалдах шатны шүүх бусдын биеийг үнэлүүлсэн, биеэ үнэлэхэд татан оролцуулсан гэмт хэрэг гэж үзэж зүйлчлэлийг хөнгөрүүлэн өөрчилж 3 жил хорих ял болгон улмаар тэнссэн байна.

Прокурорын эсэргүүцлээр энэ хэргийг 2008 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УДШ хянан үзээд хүн худалдаалах гэмт хэрэг гэж дүгнэж, магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн тогтоолыг өөрчлөлт оруулж хэвээр нь баталжээ.

2. Өөр нэг шалтгаан нь давж заалдах шатны шүүх хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаавал хяналтын шатны шүүхэд гомдол гаргах, эсэргүүцэл бичиж болохгүй энэ нь ЭБШХ-315.1.2 (гарснаараа хүчин төгөлдөр болно) гэсэн эрх зүйн үндэстэй байх ба УДШ шүүгдэгчийн гэм бурууг эцэслэн шийдвэрлээгүй хэргийг хяналтын шатны шүүх авч хэлэлцэхгүй гэж¹³ тайлбарласан байгаагаас ойлгогднам.

Яллах нотлох баримт хангалттай бус бөгөөд өмгөөлөх тал түүнийг няцааж чадаж байвал дахин ажиллагаанд буцааж яллах талыг хэт барилгүй шүүх цагаатгаж байх нь зүйтэй гэснээр төгсгөл өчмүй.

□ □ □

¹¹ Тэгэхээр хэргийг буцаахгүй шийдэх боломж байгаа гэсэн үг.

¹² Хүн худалдаалах гэмт хэргийг шүүхээр шийднэрлэсэн байдал. 2008-11-10. МУ-ын Дээд Шүүхийн мэдээлэл. УБ., 2008. №004/89/. 58 дахь тал.

¹³ ЭБШХ-326 дугаар зүйлийн 326.1, 353 дугаар зүйлийн 353.4 дэх хэсгийг тайлбарлах тухай УДШ-н 2006 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн №10 тоот тогтоол.

Монгол Улсын Прокурорын байгууллагын 80 жилийн ойд*

ЭРҮҮДЭН ШҮҮХ ГЭМТ ХЭРЭГТ ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

Эрүүдэн шүүх гэмт хэрэгт тавих прокурорын хяналтын тухай ярихын өмнө манай улсын эрүүгийн хуулиар эрүүдэн шүүхтэй холбоотой ямар ямар хэргүүдийг гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй гэж тогтоож өгсөнийг авч үзэх нь зүйтэй болов уу.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хууль (ЭХ)-д Эрүүдэн шүүх (ЭХ-ийн 251 дүгээр зүйл) гэмт хэргийг эс тооцвол тусгайлан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бий болгож тогтоож өгсөн зохицуулалт хуульд хараахан байхгүй байна.

Зарим эрдэмтэн, судлаачид илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцох, яллагдагчаар татах, ял шийтгэх (ЭХ-ийн 248 дугаар зүйл) хүүхээс хууль бус шийдвэр гаргах (ЭХ-ийн 250 дугаар зүйл) нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэх (ЭХ-ийн 253 дугаар зүйл) гэмт хэргүүдэд эрүүдэн шүүх гэмт хэргийн элементүүд агуулагдаж байдаг гэж үздэгтэй би санал нэг байна.

Монгол Улсын хууль тогтоомжоор эрүүдэн шүүх гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан материаллаг эрх зохицуулалтаас гадна аливаа хэргийг мөрдөн мөшгих Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа



Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор, Хууль цаазын ахлах зөвлөх Е. Сагсай

(ЭБША)-ны хүрээнд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж хэрэг илрүүлэхийг урьтал болгодог хууль бус ажиллагаа гарсаар байгаатай маргах ёстой.

Эрүүгийн хуулиар эрүүдэн шүүх гэмт хэргийн (ЭХ-ийн 251 дүгээр зүйл) субъектийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч байхаар хуульчлан тогтоосон нь ЭБША-ны мөн чанартай шууд холбоотой гэж үзэж байна. Өнөөдөр ЭБША-г эрхлэн хэрэгжүүлэх чиг үүргийг төр дангаараа (шүүхийн өмнөх шатанд) хэрэгжүүлдэг. Төрийн энэхүү чиг үүргийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага өөрөөр хэлбэл

хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэдэг албан тушаалтнуудаар дамжуулан эрхлэн хэрэгжүүлж байна. Тэд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх эрхийг эдэлж, үүргийг хүлээж хуулиар зөвшөөрөгдсөн албадлагын арга хэмжээ авах эрхтэй зэргээр ЭБША-г бүхэлд нь бие дааж явуулдаг. Ийм учраас энэхүү ажиллагааны хүрээнд хүний эрх эрх чөлөөнд халдах түүнийг үндэслэлгүйгээр хязгаарлах боломж бололцоо зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт байдаг. Энэ утгаар нь Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн субъект нь зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар байхаар хуульчилсан нь зүйтэй юм. Харин Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч болох прокурор, шүүгчид нь эрүүдэн шүүх ажиллагаа явуулах боломж хуулиар байхгүй гэж хэлж болно. Прокурор нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрх үүрэгтэй. Хэрэг мөрдөн байцаах ажиллагаанд хууль хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьдаг субъектийн хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд эрүүдэн шүүх аливаа хэлбэрийн зөрчил гаргуулахгүй байхад хяналт

*Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1930 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 25 дугаар тогтоолоор Улсын Прокурорын газрыг анх Шүвх явдлын яаманд харьяалуулан байгуулж, “Дагаж мөрдөх эрх үүргийн дүрэм”-ийг баталж, прокурорын байгууллагад улсын нэрийн өмнөс хуулийн биелэлтэд хяналт тавих үүргийг хүлээлгэсэнээр прокурорын байгууллага үйл ажиллагаагаа эхэлсэн билээ.

Прокурорын байгууллага ийнхүү үүсч байгуулагдсан цагаасаа эхлэн 80 жилийн хугацаанд эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавих, шүвхэд төрийг төлөөлөн оролцох чиглэлээр төр, ард түмний өмнө хуулиар үүлэсэн үүргээ амжилттай хэрэгжүүлж ирлээ. Монгол Улсад Прокурорын байгууллагыг байгуулсан чиглэлд 80 жилийн ойг 2010 онд тэмдэглэхтэй холбогдуулан авч арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталж, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр төл болон орон нутгийн салбар ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байна. Ой угтсан арга хэмжээний хүрээнд Прокурорын газрууд нь үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлан таниулахын зэрэгцээ хяналтын ажлын чанар, үр дүнг сайжруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг авч эхлээд байна. (<http://www.gpo.mn/modules.php?name=News&file=article&sid=294> сагсай)

хэрэгжүүлж ажилладаг гэдэг утгаараа нөгөө талаараа шүүх хуралдаанд мэтгэлцээний тэгш эрхтэй нэг тал болж оролцдог оороо өөрөө эрүүдэн шүүх үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин байхгүй юм. Шүүгчийн хувьд шүүх хуралдааны мэтгэлцээнд хөндлөнгийн байр суурь баримталж мэтгэлцээний үр дүнг үндэслэн хууль хэрэглэж эцсийн шийдвэр гаргадаг субъектийн хувьд ЭХ-ийн 251 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн субъект болохгүй. Зарим хүний үздэгээр цагдаа, тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажилтнууд, гэрч байтугай хэв журмын албаны ажилтнуудыг ч энэ гэмт хэргийн субъект болох ёстой гэж үздэгтэй санал нийлэхгүй байна. Эдгээр хүмүүс нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль (ЭБШХ)-иар ЭБША-г эрхлэн явуулах эрх хэмжээгүй өөрөөр хэлбэл бусдыг байцаах (мэдүүлэг гаргуулах) боломжгүй учраас энэ зүйлд заасан гэмт хэргийн субъект болж чадахгүй гэж үзэж байна. Хэрвээ тэд өөрсдийн албан үүргийн хүрээнд бусад хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус үйл ажиллагаа явуулсан бол ЭХ-ийн 251 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт биш өөрсдийн үйлдлийн хэр хэмжээ шинж чанараас хамаарч хүний эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн болон иргэдийн, улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн, түүнчлэн шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийн субъект болж болох юм гэсэн бололтой байна. Мэдүүлэг өгөхийг албадах гэмт хэргийн объектив талын гол шинж болсон хүч хэрэглэх буюу, хүч хэрэглэхээр заналхийлэх, тохуурхан даажигнах, тарчилган зовоох, хуурч мэхлэх зэрэг хууль бус үйлдэл нь ЭБША-ны явцад илрэн гардаг үндсэн онцлогтой юм. Өөрөөр хэлбэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь ЭБША-ны оролцогчдоос

(сэжигтэн, яллагдагч, хохирогч, гэрч, шинжээч гэх мэт) мэдүүлэг авахдаа хууль бус арга хэрэглэж албадсан байх шаардлага тавигдана. Ийнхүү албадах нь гэмт хэрэг илрүүлэх, хэрэг хүлээлгэх, хэрэгээ шуурхай шийдвэрлэх, танил тал харах, өш хонзон санах, нэр төр олох гэсэн ямарч сэдэлт зорилготой байж болно, гэхдээ энэ нь гэмт хэргийн бүрэлдэхүүнд нөлөөлөхгүй юм. Иймээс хэрэг бүртгэгч, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг хүлээсэн прокурор нь ЭБША-ны явцад мэдүүлэг өгөхийг албадах, хууль бус ажиллагаа гаргуулахгүй байхад ихээхэн үүрэг хариуцлага хүлээх ёстой.

Прокурор нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаах ажиллагааг хуулийн хүрээнд явуулахад хяналт тавих чиг үүргийн хүрээнд:

1. ЭБША-г зөвхөн Эрүүгийн Байцаан Шийтгэх Хуулинд заасан үндэслэл журмын дагуу явуулахад хяналтаа чиглүүлэх ёстой. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн явуулж байгаа Эрүүгийн Байцаан Шийтгэх Ажиллагаагаа бүр нь гагцхүү хуулийн хүрээнд явагдах шаардлага тавигдах бөгөөд ЭБШХ-ийн 8 дугаар зүйлд зааснаар “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь ЭБША-гаа явуулахдаа Үндсэн хууль, ЭБШХууль бусад хууль чанд сахина. Үүнийг зөрчвөл түүний гаргасан шийдвэрийг хууль заасан үндэслэл журмын дагуу хүчингүйд тооцож түүнд хариуцлага хүлээлгэх үндэслэл болно” гэж заасан бол мөн хуулийн 10 дугаар зүйлд “хэнд боловч эрүү шүүлт тулгаж хүнлэг бус хэргийн хандаж нэр төрийг нь доромжилж болохгүй” гэжээ. Энэ нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн заалтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн чухал заалт юм. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьдаг

прокурор нь уг ажиллагааг анх эхэлсэн үеэс эхлэн байнга, тасралтгүй, зэрэгцсэн хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байгаа. Прокурор нь энэхүү үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй ЭБША нэг бүрт хүрч, түүнийг байнга мэдэрч хянаж чадахгүй байгаагаас болж ЭБША-нд хууль зөрчигдөх явдал түүний дотор эрүүдэн шүүх гэмт хэрэгтэй холбоотой асуудал гарч байгаад онцгой анхаарах ёстой;

2. ЭБША-ны явцад хүний эрх, эрх чөлөөг хангахад прокурорын хяналтын чанар үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай. Ялангуяа ЭБША-нд оролцогчдын эрхийг хангах, хамгаалахад прокурорын хяналт чухал ач холбогдолтой юм. Яагаад гэвэл шүүхийн өмнөх шатны байцаан шийтгэх ажиллагаанд хяналт тавих, хууль сахиулах цорын ганц чиг үүргийг прокурор хуулиар хүлээсэн байдагтай холбогдоно. Эрүүдэн шүүхтэй холбоотой ямар нэгэн зөрчил, хууль бус үйлдэл гаргуулахгүй байх, үүний тулд сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогчийн хуулиар олгогдсон эрхийг бүрэн хангуулахад прокурор хяналтаа бүрэн чиглүүлж ажиллах нь зүйтэй;

3. Эрүүдэн шүүх гэмт хэрэгт прокурор хяналт тавихдаа анхаармаар зарим онцлогуудыг авч үзэх нь зүйтэй. Энэ нь:

а) Сэжигтэн, яллагдагч мэдүүлэг өгөх эрхтэй, үүрэггүй гэсэн хуулийн заалтыг үл хайхран мэдүүлэг өгөхийг албадах, хэрэг хүлээлгэхийг урьтал болгодог оос албадан мэдүүлэг авах гэсэн чиг хандлага байдаг.

б) гэрч, хохирогч болон бусад оролцогчид зөвхөн үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй гэтэл зарим тохиолдолд гэднийг хэргийн нөхцөл байдалд (эрэгт авагдсан баримтанд нийцүүлж) тохируулж мэдүүлэг гаргуулахыг оролдох, гэднийг мэдүүлэх өөрчлөхийг шаардах, худлаа гэрчлүүлэх зэрэг оролцлогууд хүртэл хааяа гардаг.

в) Ийнхүү мэдүүлэг авахын тулд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь ямар нэгэн хууль бус арга хэрэглэж ЭБША-нд оролцогчдын эрхэнд халдаж хууль зөрчиж хууль бус ажиллагаа явуулах нь эрүүдэн шүүх гэмт хэргийн нэг илрэл болно. Эдгээр нөхцөл байдлыг тухай бүр хяналтаараа илрүүлэхийн тулд прокурор нь сэжигтэн, яллагдагч болон бусад оролцогчидтой биечлэн уулзах, тодорхой ЭБША-нд биечлэн оролцох, ЭБША-ны оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдолл туйлын хариуцлагатай хандаж тэдний эрх ашиг зөрчигдсөн эсэхийг тухай бүрт нь хянаж, шуурхай шалган тогтоож байх нь юунаас чухал юм.

4. ЭБША-ны хүрээнд эрүүдэн шүүсэн болон бусад хэлбэрээр хууль бус ажиллагаа явуулсан тохиолдолд бүрт прокурорын хяналтын эрх зүйн хэлбэрүүдийг чадмаг ашиглах/шаардлага бичих, даалгавар өгөх, хариуцлага тооцуулах, гаргасан шийдвэрийг хүчингүй болгуулах/ замаар зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хууль бус ажиллагааг таслан зогсоох, улмаар уг хэргийг тухайн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар цаашид мөрдүүлэхийг зогсоох хүртэл арга хэмжээ авч байх бүрэн эрх нь прокурорт хуулиар олгогдсон байгаа. ЭБША-ны хүрээнд эрүүдэн шүүлтэд өртсөн эрх ашиг, сонирхол нь ямар нэгэн хэмжээгээр зөрчигдсөн гэж үзвэл ЭБША-ны оролцогчид түүний төлөөлөгчид нь тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорт

хандаж гомдол, хүсэлт гаргах замаар эрх ашиг сонирхолоо хамгаалах боломж бас бий. Энэ тохиолдолд боломжтой асуудлыг прокурорын хяналтын чиглэлээр шалган шийдвэрлэж болохоос гадна эрүүдэн шүүх гэмт хэргийн шинжтэй байна гэж үзвэл УЕП-ын дэргэдэх мөрдөн байцаах албанд шилжүүлэн шалгуулах арга хэмжээг прокурорын байгууллага авдаг. Гэтэл практикт эрүүдэн шүүх гэмт хэргтэй холбоотой гомдол нэлээд гардаг боловч гомдол гаргагч нь гаргасан гомдлынхоо үндэслэлийг нотолж чаддаггүй, зарим тохиолдолд эрүүдэн шүүсэн ажиллагааг илчилхээс өөрсдөө татгалздаг зэрэг нөхцөл байдлаас болж энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт хангалтгүй байж болох юм. Эрүүгийн тоо бүртгэл статистик мэдээллээс үзэхэд эрүүдэн шүүсэн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн тохиолдол маш ховор гардаг байна. Энэ нь монголд эрүүдэн шүүхтэй холбоотой гэмт хэрэг огт байдаггүй гэсэн үг биш гагцхүү энэ гэмт хэргийг илчлэх, илрүүлэх ажиллагаа хангалтгүй, мөрдөн шалгах арга тактик, дадлага туршлага шаардлагын хэмжээнд хүрээгүй, эрүүдэн шүүх гэмт хэргийн талаар хуульчдын дунд нэгдмэл нэг мөр ойлголт хараахан бүрэлдээгүй байдагтай холбоотой байх гэсэн саналтай байна. Эрүүдэн шүүх гэмт хэргийн шинжгүй ч гэсэн ЭБША-ны явцад сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорихыг урьтал болгодог, удаан хугацаагаар хорьж байцаадаг, цагдан

хорих байрны нөхцөл шаардлагын хэмжээнд хүрээгүй, тэнд хоригдогсод бие биенээ дарамтлах, хүч хэрэглэх явдал арилаагүй, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэг хүлээлгэх арга хэрэгсэл болгох хандлага орцсоор байгаа нь эрүүдэн шүүх ажиллагааны нэг илрэл гэж үзэх үндэслэлтэй. Түүнчлэн сэжигтэн, яллагдагчийн тэр ч байтугай гэрч хохирогчийг хэрэг бүртгэх мөрдөн байцаах байгууллагын үүд сахиулж удаан хугацаагаар хүлээлгэж залхаадаг, тэдэнтэй зүй бус харьцдаг, зарим тохиолдолд тэднээр хувийнхаа ажлыг хийлгэдэг зэрэг зохисгүй байдал хандаага ч заримдаа гардаг тухай гомдол, мэдээлэл гарах тохиолдол бий.

Нөгөө талаар эрүүдэн шүүх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг ч гэсэн тодорхой болгох шаардлагатай гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл эрүү шүүлт тулгах гэмт хэрэг нь зөвхөн мэдүүлэг гаргуулахаар албасан үйлдлээр хязгаарлагдаж байгааг эргэн үзэж эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага ч гарч байна гэсэн саналтай байна.

Хүмүүнлэг энэрэнгүй ардчилсан нийгэм байгуулахыг эрхэм зорилгоо болгосон ардчилсан нийгэмд, эрх зүйт төрийн нөхцөлд амьдарч байгаа хүн бүхэн, ялангуяа төрийн албан хаагч хэн боловч төрийн хуулиа дээдлэн хүндэтгэж сахин биелүүлэх хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах явдал нь хуульч бидний эрхэм зорилт байх ёстой.

ДААТГАЛЫН ЭРХ ЗҮЙН ТУЛГУУР ОЙЛГОЛТ



**“Монгол Даатгал” ХХК-ийн
Даатгалын газрын захирал,
МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч
Б.Жавхлант**

Оршил

Хүн төрөлхтөн аль болох эрсдлээс урьдчилан сэргийлэх, нэгэнт бий болсон эрсдлийг хохирол багатайгаар даван туулах оролдлогуудыг анх үүсэн бий болсон цаг мөчөөсөө эхлэн эрэлхийлж ирсэн бөгөөд он цаг улиран одох бүрт нийгэм, эдийн засгийн хөгжил хурдацтайгаар өрнөж, ололт амжилт өөд цаг үргэлжтэмүүлж ирсэний хажуугаар гарз, хохирлыг олонтоо амссан юм. Энэхүү гарз, хохирлыг даван туулах арга замуудын нэг нь гарч болзошгүй эрсдлийг амжилттайгаар даван туулах зохистой менежмент буюу даатгал билээ.

Амгалан тайван амьдралын нэг баталгаа нь даатгал хэмээн дэлхий даяар хүлээн зөвшөөрч, үүнийг даган даатгалын зах зээл өргөжин тэлсээр байна. Иймийн тул даатгалын эрх зүйн зарим тулгуур ойлголтыг дараах хэсэгт хуваан авч үзье.

1. Даатгалын эрх зүйн тухай;
2. Даатгал үүссэн түүх;
3. Даатгалын төрлүүд;
4. Даатгалын эрх зүйн эх сурвалж;
5. Даатгалын компанийн хэлбэр;
6. Санал дүгнэлт.

Нэг. Даатгалын эрх зүйн тухай

Даатгал гэдэг нь гарч болзошгүй эрсдэл, хохирлын эсрэг хамгаалалт юм. Энгийн үгээр бол бага хэмжээний зардал гарган их гарзаас хамгаалах гэсэн ойлголт бөгөөд нэг талаас хуулийн дагуу байгуулагдсан даатгагч буюу даатгалын бүтээгдэхүүн борлуулагч, нөгөө талаас даатгуулагч буюу даатгалын бүтээгдэхүүн худалдан авагч хоорондын харилцаанаас даатгалын харилцаа үүсдэг.

Даатгалын эрх зүй гэдэг нь даатгагч болон даатгуулагч хоорондын харилцаа, даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрт төрөөс тавих хяналт, зохицуулалтын зарчмыг тодорхойлсон хэм хэмжээнүүдийн нийлбэр юм.

Даатгалын эрх зүй нь даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад хамаарах эрх зүйн зохицуулалт, даатгуулагч хохирлоо барагдуулах эрх зүйн зохицуулалт гэсэн үндсэн хоёр зохицуулалтаас бүрдэнэ.

Эрсдэл. Даатгалын тухай авч үзэхэд юун түрүүнд эрсдэл гэж юу болохыг авч үзэх шаардлагатай байдаг. Эрсдэл гэдэг нь хийсвэр ойлголт юм. Аливаа хувь хүн, байгууллага нь хэзээ, хаана эрсдэл бий болж, ямар хэмжээгээр юунд, хэрхэн хохирол учрахыг урьдчилан гааж мэдэх бололцоогүй байдаг. Эдгээр тааж мэдэх бололцоогүй хүчин зүйлийг “эрсдлийн элементүүд” гэж нэрлэдэг. Хэрэв эрсдлийн элементүүд нь тодорхой байх аваас энэ нь даатгалын харилцааны эрсдэл биш болно.¹

Нэг хариуцлагагүй үйлдлээс хэд хэдэн эрсдэл үүсч болно. Жишээ нь, жолоочийн хариуцлагагүй үйлдлийн улмаас явган зорчигч хохирол амслаа гэж үзье. Тэгвэл энд явган зорчигчийн биеийг гэмтээж, эрүүл



**Австралийн Мельбурнийн Их
сургуулийн Азийн хуулийн
судалгааны төвийн зочин
эрдэмтэн, Хууль зүйн доктор
Б.Гүнбилэг**

мэндийг хохироох эрсдэл, үүнийг дагаад эмчилгээний зардлыг хариуцах эрсдэл, ажил хийдэг бол ажил эрхлээгүй хугацаан дахь орлогыг нөхөн төлөх эрсдэл, гэр бүлтэй бол гэр бүлийн харилцаанд бүрэн оролцох боломжгүй болсныг нөхөн төлөх эрсдэл гэх мэт маш олон төрлийн эрсдэл үүсч болно.

Эрсдлийн менежментийн аргуудыг ашиглан гарч болох эрсдлийг бууруулах, үйлчлүүлэгчийн хохирлыг багасгах боломжтой аргуудыг даатгалын гэрээнд тусгаж өгөх шаардлагатай байдаг.

Нөхөн олговор. Даатгалын гэрээний нөхөн олговор нь дараах хоёр хэлбэртэй:

1. “нөхөн олговор”-ын бодлоготой;
2. “өмнөөс нь төлөх” бодлоготой.

“Нөхөн олговор”-ын бодлоготой гэдэг нь даатгуулагч гуравдагч этгээдэд төлсний дараа даатгагчаас нөхөн олговороо авна гэсэн үг. Тухайлбал, жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний хүрээнд гуравдагч этгээдийн тээврийн хэрэгсэлд гэмтэл

¹ Robert E. Keeton and Alan I. Widiss, Insurance law, A guide to fundamental principles, legal doctrines, and commercial practices., West Publishing 1988.

учруулж, тодорхой хэмжээний мөнгийг хохирол учруулсан бол уг мөнгийг даатгуулагч өөрийн халааснаас төлөөд, төлсөн мөнгөө даатгагчаас авна гэсэн үг.

Харин “өмнөөс нь төлөх” бодлоготой гэдэг нь гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг даатгуулагчийн халааснаас гаргалгүй, даатгагч шууд төлнө гэсэн үг.

Даатгаж болох ашиг сонирхол. Аливаа ашиг сонирхлыг эрсдлээс хамгаалахын тулд даатгаж болох ашиг сонирхлын тухай нэн түрүүнд авч үздэг. Даатгаж болох ашиг сонирхол гэдэг нь даатгалд хамруулж болохоор хуульд заасан буюу зүй ёсонд нийцсэн ашиг сонирхол байх ёстой юм. Энд дурдаж буй зүй ёсны гэдэг ойлголтонд хуульд заагаагүй хэдий ч амьдралын шаардлагаар урган гарч ирж болох эрсдлийн хэлбэрүүдийг багтаана. Гэхдээ эдгээр нь хуульд харшлах буюу шударга бус ашиг сонирхолд баталгаа гаргасан даатгалын хэлбэр байж болохгүй. Тухайлбал, тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ хийсэн жолооч санаатайгаар тээврийн хэрэгслээ эвдээд даатгалаас нөхөн төлбөр гаргуулахаар гэмт үйлдэл хийх нь зүй ёсны бус, хуульд харшилсан үйлдэл юм.

Нөгөө талаас аливаа ашиг сонирхлыг эрсдлээс хамгаалан даатгахдаа заавал тухайн ашиг сонирхлыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хүсэл сонирхлыг харгалзан үзэх ёстой. Энэ нь хэн нэгний ашиг сонирхлыг хамгаалах гэж бусад өөр хүн өмнөөс нь даатгалын гэрээ хийж болохгүй гэсэн үг юм. Жишээ нь, амь насны даатгалын гэрээг хэн нэгний өмнөөс хийх үйлдэл нь тухайн хүний амь насыг бүрэлгэх буюу нас барсны дараа нөхөн төлбөрийг авна гэсэн гэмт санааг шууд бусаар торүүлэх аюултай байдаг.¹

Мэдээж хүн бүр эд хөрөнгөө

даатгах сонирхолтой байдаг. Өмчлөгч, ашиглагч, эзэмшигч, хөлслөгч, хөлслүүлэгч, түрээслэгч, түрээслүүлэгч, эд хөрөнгөд засвар хийж буй засварчин, барилгачин гээд даатгуулах хүсэл сонирхолтой этгээд олон байдаг бөгөөд даатгалын нөхөн төлбөрийг хэн төлөх вэ гэдгийг хуулиар шууд заах буюу заагаагүй тохиолдолд талууд хооронд гэрээгээр тохиролцох ёстой.

Даатгаж болох ашиг сонирхол нь даатгуулагчийн хувийн ашиг сонирхлоос гадна нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс заавал даатгах шаардлагатай ашиг сонирхлуудыг багтаадаг. Үүнд эрсдлийн нийгэмд үзүүлж болох хохирол, эрсдлийн хамрах хүрээ зэргээс шалтгаалан амь насны, галын, мэргэжлийн, хариуцлагын гэх мэт бүхий л даатгалуудыг эрсдлийн элементээс шалтгаалан хамруулдаг.

Хоёр. Даатгал үүссэн түүх.

Даатгал гэдэг нь хүн төрөлхтөн бий болсонтой зэрэгцэн үүссэн үзэгдэл гэж хэлж болно. Эдийн засгийг мөнгөний (зах зээл, мөнгө, санхүүгийн хэрэгсэл, үнэт цаас гэх мэт) ба мөнгөний бүс (мөнгөөр шууд илэрхийлэгдэхгүй) хэмээн хоёр ангилдаг. Хоёрдахь буюу мөнгөний бүс эдийн засаг нь мөнгөний эдийн засгийн хэлбэрээс бүр өмнө бий болсон үзэгдэл юм. Тухайлбал, хөрш айлынх нь байшин шатлаа гэхэд хөршүүд буюу тосгоны хүмүүс хамтын хүчээр гүүнд шинэ байшин барьж өгдөг. Харин удаах тохиолдолд өөр нэг айлын байшин шатвал шатсан байшингийн эзнээс тусламж авч байшингаа барьж байсан гэр бүлийн хүмүүс болон бусад хүмүүс туслаж байшинг бариллаж өгнө. Хэрэв хөршүүдийнх нь байшин шатахад шинэ байшин барих ажилд гусладаггүй бол дараагийн удаад өөрийнх нь байшин шатсан тохиолдолд хөршүүд түүнд

туслахгүй байх тохиолдол гардаг. Энэ мэтээр ирээдүйд гарах эрсдлээс хамтын хүчээр хамгаалах заншлууд үүсэн бий болж байжээ. Эдгээр заншил өнөө үед ч үргэлжлэн үйлчилсээр байна.

Орчин үед хэрэглэгдэж буй даатгалын хэлбэрүүдийг анх МЭӨ III, II мянганы үед Вавилоны худалдаачид хэрэглэж байсан тухай баримт бий. Вавилончууд гарч болзошгүй эрсдлийн эсрэг арга хэмжээ авах өөрсдийн тогтолцоог МЭӨ 1750 оны Хаммурабийн хуульд тусгаж, уг тогтолцоог Газар дундын тэнгисээр дамжин худалдаа хийгчид хэрэглэж байсан байна. Хэрэв далайн тэвэрээр хүргэх барааны эргэлтэд зориулан зээл авсан бол хөлөг онгоц жижвэ, сураггүй алга болох эрсдэлд зориулан зээлдэгч зээлсэн мөнгөнөөс тусад нь төлбөр төлдөг байжээ.

Эртний Персэд эзэн хаандаа өргөл барьц өгөх хэлбэрээр даатгалын харилцаа үүсчээ. Эзэн хаанд өргөл барьц өгснөө бүртгүүлж, эзэн хааны албан ёсны бүртгэгчид бүртгүүлснээр цаашид гөрийн болон хувийн харилцаанд тухайн бэлэг өгөгчид гарз учирвал хаан тусламж дэмжлэг үзүүлдэг байжээ.

Грек болон Ромд МЭ 600 оны үед эрүүл мэндийн болон амь насны “сайн дурын” нийгэмлэгийн гэх даатгалын хэлбэрийг дайчдал зориулан хэрэгжүүлж эхэлсэн байна. Тэд дайн тулаанд үүргдсэн дайчдын оршуулгын зардлыг төлж, аргарт нь тусламж үзүүлдэг байжээ. Лундал зууны үед ч энэ хэлбэрийн даатгал оршиж байв. XVII зуунд Англид “нохөрсөг нийгэмлэг” нэртэй сан байгуулагдаж, хандив цуглуулан ямар нэгэн гамшиг тохиолдсон үед түүнийгээ зарцуулаг болжээ.

Гвинейд XIV зуунд газрын харилцаанд хорогто оруулалтын болон зээлийн гэрээгээс тусад нь даатгалын гэрээг хийж эхэлсэн байна.

¹ Charles Y.C.Chew, Insurance law, The Law book company limited 1994. p.15.

1680-аад оны сүүлээр Эдвард Ллойд гэдэг хүн Англид далайн тээвэрчид, наймаачдад зориулан цайны газар байгуулсан бөгөөд уг газарт далайчид, наймаачид цуглан далайн тээврийн даатгал зэрэг ажил хэргээ ярилцдаг болжээ. Улмаар энэ цайны газар нь энэ төрлийн ажил үйлчилгээ эрхлэгчдийн цуглагдах газар болон өргөжиж, өнөөдөр ч Лондонгийн Ллойдсын даатгагчид нэртэйгээр даатгал эрхлэгчдийн тэргүүлэх даатгалын зах зээл болсон хэвээр байна.

Бидний өнөөдөр хэрэглэж буй үл хөдлөх хөрөнгийн даатгал нь 1666 онд 13200 байшинг сүйтгэсэн Лондонд болсон түймрийн дараах арга хэмжээний үр дүнд бий болжээ. Энэхүү түймрийн дараа Николас Барбон гэдэг хүн байшин даатгах жижиг бизнес эхлүүлж улмаар 1680 онд Английн анхны “Галын байгууллага” нэртэй даатгалын компанийг байгуулсан байна.

АНУ-д 1732 онд Өмнөд Каролиний Чарльзтон хотод анхны даатгалын компани байгуулагдаж, Ерөнхийлөгч Бенжамин Фрэнклин 1752 онд гал түймрийн эрсдлийн эсрэг даатгалын хөдөлгөөнийг өрнүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулжээ.³

Монгол Улсад албан ёсоор даатгалын байгууллага 1934 онд Улсын Аюулаас хамгаалах газрын нэг хэсэг болон байгуулагджээ. Тухайн үеийн ЗХУ-ын Государственное Страхование нэртэй байгууллагын тогтолцоог монголчлон буулгасан нь энэ юм.

Гурав. Даатгалын төрөл, хэлбэр

Онолын хувьд гарч болзошгүй ямар ч эрсдлийг даатгаж болно гэж үздэг. Гагцхүү тухайн даатгалын компани барьж буй бодлогоос шалтгаалж, даатгалын бүтээгдэхүүний хамрах хүрээг тодорхойлдог. Жишээ нь АНУ-ын даатгалын компаниуд үл хөдлөх хөрөнгийн даатгалыг бүхлээр нь хийвэл байшин, түүн доторх хөдлөх

хөрөнгө болон гэрт нь зочилсон хүн шалан дээр нь хальтирч унаснаас үүлэн гарч болох хохирлыг хүртэл хариуцахаар даатгалын гэрээндээ тусгах явдал байдаг. Мөн бизнесийн үйл ажиллагааг ч даатгаж болно. Тухайлбал, өмгөөлөгчийн хариуцлагын даатгал, бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн ханшийн бууралтын эсрэг даатгал гэх мэт.

Даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар даатгалыг урт хугацааны даатгал, ердийн даатгал гэж ангилна. Даатгал нь сайн дурын болон заавал гэсэн төрөлтэй байдаг.

Дэлхий нийтэд хамгийн өргөн хэрэглэгдэж буй даатгалын хэлбэрүүдийг нэрлэвэл:

Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээнд эд хөрөнгө, хариуцлага, эмнэлгийн үйлчилгээний гэсэн гурван хэлбэрийн нөхөн төлбөрийг хамруулан авч үздэг;

Орон байры даатгалын гэрээнд байгалийн болон гэнэтийн ослоос шалтгаалан орон байр гал түймэр, үер, газар хөдлөлт, цасны нурулт, шуурга гэх мэтийн улмаас сүйдэх эрсдлээс үүдэн гарах нөхөн төлбөрийг хамруулан авч үздэг. Зарим оронд энэ хэлбэрийн даатгалыг заавал даатгалд хамруулахаар заасан байдаг бол зарим оронд хэрэв орон байраа бусдад түрээслэвэл заавал даатгалд хамруулахаар заасан байдаг;

Эрүүл мэндийн даатгалын гэрээ нь эрүүл мэндэд учирч болзошгүй аливаа өвчин, эмгэгийн үед эмнэлгийн үйлчилгээ авахад зориулан нөхөн олговор олгохоор тохиролцсон гэрээ юм. Дэлхий нийтэд хамгийн их түгсэн энэ хэлбэрийн даатгалд шүдний эрүүл мэндийн даатгал тооцогддог;

Гэмт хэргээс сэргийлэх даатгал гэж гуравдагч этгээд гэмт хэрэг хийсний улмаас хувь хүн, байгууллагад хохирол учирвал түүнийг нөхөн төлөх даатгалын

хэлбэр юм. Тухайлбал, ажлын байранд хулгай буюу эд хөрөнгө ашиглан шамшигдуулах гэмт хэрэг гарвал түүний уршгаас үүдэн гарсан хохирлыг нөхөн төлнө гэсэн үг;

Улс төрийн байдлын эрсдлийн даатгал гэж байгууллага, хувь хүний бизнес эрхэлж буй улсад төрийн эргэлт, хувьсгал гарсны улмаас улс төрийн тогтворгүй байдал үүсч, бизнесийн хэвийн үйл ажиллагаанд хохирол учирч болох эрсдлийг хаах даатгалын хэлбэр юм;

Амь насны даатгалд нас барагчийн ар гэрт зориулан оршуулах, чандарлах болон нас барагчийг эцсийн замд үдэхэд шаардлагатай зардлуудыг төлж, ар гэрт нь мөнгөн буюу бусад хэлбэрийн нөхөн олговор олгохоор гэрээнд заадаг. Амь насны даатгалын хүрээнд нөхөн олговрыг нэг удаа бөөнөөр буюу эсвэл жил бүрээр олгодог;

Мэргэжлийн хариуцлагын даатгал гэж бусдад зөвлөгөө өгөх буюу бусдын эрх ашиг, сонирхлыг гэрээний үндсэн дээр мэргэжлийн дагуу төлөөлөн, ажил гүйцэтгэж байгаа этгээдийн өөрийн болон үйлчлүүлэгчийн хариуцлагагүй байдлаас үүдэн бий болж болох эрсдлийг хамгаалах зорилготой даатгалын хэлбэр юм. Эмч, хуульч, зуучлагч, брокер, нягтлан бодогч гэх мэт мэргэжлүүд хамаардаг;

Ажил гүйцэтгэгчийн хариуцлагын даатгал гэж ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр ажил гүйцэтгэж буй этгээдийн хариуцлагагүй байдлаас үүдэн гарч болох эрсдлийг хамгаалах даатгалын хэлбэр юм. Тухайлбал, барилгын компани барилга, байгууламж, зам барих явдлаа алдаа гарган зохих чанарын түвшинд барьж, байгуулаагүй бол захиалагч этгээдэд хохирол учирдаг. Энэхүү хохирлыг даатгалын гэрээний дагуу нөхөн төлнө гэсэн үг. Монгол Улсад өнөөгийн байдлаар барьж дуусаагүй барилгад захиалга авч, иргэдээс төлбөр аваад, эцэст нь

³ John Lowry and Philip Rawlings., Insurance law: Doctrines and Principles., Oxford and Portland Oregon 1999. p.25.

барилга хүлээн авах үед мэргэжлийн байгууллага чанарын шаардлага хангаагүй барилга хэмээн ашиглахыг хориглох үед захиалсан иргэд хохирч үлддэг тохиолдлууд гарсаар байна. Энэ төрлийн эрсдлээс хамгаалахад ажил гүйцэтгэгчийн хариуцлагын даатгалын хэлбэр хэрэглэгдэх ёстой;

Аялал жуулчлалын даатгал гэж гадаад болон дотоодод зорчигчдын эрүүл мэнд, ачаа, амь насны гэх мэт даатгалуудыг цогцоор бүрдүүлсэн даатгалын хэлбэр юм;

Тээврийн даатгал гэж тээвэрлэгч болон тээвэрлүүлэгч нар тээврийн үйл ажиллагаа явуулах хугацаанд тээвэрлэх эд юмс, бараа, бүтээгдэхүүнийг эрсдлээс хамгаалахаар тээврийн гэрээнд тусган, уг гэрээний үндсэн дээр даатгалд хамруулж буй даатгалын хэлбэр юм. Олон улсын тээврийн даатгалыг Олон улсын арилжааны нэр томъёо (international commercial terms, товчоор INCOTERMS)-нд зааснаар талууд гэрээндээ тусгах явдал элбэг байдаг.⁴ Тээврийн даатгалд хамрагдаж буй эд юмс, тухайлбал, алт, эрдэнэс, бичиг баримт гэх мэт эд зүйлсийг тээвэрлэхэд гэрээний үнийн дүнг даатгалын гэрээний талууд харилцан тохиролцох буюу үнэлгээний мэргэжлийн байгууллагаар үнэлүүлэн даатгалд хамруулдаг;

Далайн даатгал нь далайн тээвэр, ан агнуур, аялал жуулчлал гэх мэт үйл ажиллагааг далайд эрхэлдэг орнуудын хувьд өргөн хэрэглэдэг даатгалын хэлбэр юм. Эдгээр орнуудад зөвхөн далайн даатгалыг зохицуулсан хууль тогтоомжуудыг ч гаргах явдал байдаг. Тухайлбал, Их Британийн 1909 оны Далайн Даатгалын тухай хуулийг үүнд нэрлэж болно;

Нийгмийн хариуцлагын даатгал гэж тухайн гарч болох эрсдлээс хувь хүн болон олон нийтийн эрх ашиг хохирч болохыг харгалзан хийж буй

даатгал юм. Энэ хэлбэрийн даатгалыг хуулиар зохицуулан тухайн эрсдэл учирч болох нийгмийн бүлэг хүмүүсийг бүгдийг хамруулдаг. Тухайлбал, ажил олгогч нь ажилтан бүрийн цалин, хөлснөөс даатгалын байгууллагад шимтгэл төлж, хариуцлагын даатгалд нэгдсэн журмаар хамруулах, галын эрсдэл өндөртэй шигүү байрласан сууц, барилгуудыг өмчлөгч этгээдээс хураамж аван заавал даатгах гэх мэт. Ажил олгогч, ажилтан нарын хоорондын хариуцлагын даатгалыг Монгол Улсад Нийгмийн даатгалын хуулиар зохицуулж байгаа бол нийтийг хамарсан галын болон байгалийн гамшиг тохиолдож болох газарт оршин байгаа буюу байрлаж буй хувь хүн, байгууллага, этгээдийг заавал даатгалд хамруулах зохицуулалт одоогоор байхгүй байна. Шигүү байрласан сууц, байруудад нэг айлын хариуцлагагүй байдлын улмаас гал гарахад бусад хөршүүдийн эд хөрөнгөд уг галын аюул зэрэг нүүрлэх тохиолдол элбэг тохиолдох бөгөөд үүнээс үүдэн гарсан хохирлыг тухайн гал алдсан өрх дантаараа төлөх үү, эс бөгөөс хариуцлага тооцох эзэнгүй хоцрох уу гэдэг асуудал өнөөг болтол тодорхойгүй байсаар байгаа юм. Ихэнх тохиолдолд давагдашгүй хүчин зүйл буюу форс мажор гэсэн ойлголтод хамруулан орхиж байгаа нь хохирлыг хариуцах эзэнгүй болгож, иргэд, байгууллага хохирол амсаж үлдэх зохисгүй харилцааг бий болгодог.

Дөрөв. Даатгалын эрх зүйн эх сурвалж

Даатгалын эрх зүйн эх сурвалжид дараах эх сурвалжууд багтана.

1. Хууль;
2. Захиргааны акт;
3. Шүүхийн жишиг;
4. Олон улсын гэрээ;
5. Заншил;
6. Эрдэмтэдийн бүтээл, номлол;

7. Даатгалын гэрээ.

Хууль, захиргааны акт, шүүхийн жишиг, олон улсын гэрээ, заншил, эрдэмтэдийн бүтээл зэрэг нь эрх зүйн аль ч салбарт эрх зүйн эх сурвалжид тооцогддог. Эрдэмтэдийн бүтээл, номлолын хувьд дам эх сурвалжид тооцогдох бөгөөд харин даатгалын эрх зүйн хувьд бусад салбар эрх зүйтээс ялгарах онцлог нь даатгалын эрх зүй нь хувийн эрх зүйн англо-америкаас гаралтай салбар учраас даатгалын гэрээ нь өөрөө шууд эх сурвалж болдог. Гагцхүү хууль, захиргааны акт, олон улсын гэрээ, заншилд харшилж болохгүй. Нөгөө талаас Монгол Улсын даатгалтай холбогдох хууль, захиргааны актаар эрх зүйн зохицуулалтыг нэг мөр тусгаж чадаагүй учраас даатгагч болон даатгуулагч хоорондын гэрээгээр хуулиар нарийвчлан заагаагүй зохицуулалтыг тусгаж өгдөг. Даатгалын эрх зүйн захиргааны актад ихэвчлэн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хувьд Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрүүдийг хэрэглэж байна.

Харин даатгалын эрх зүй нь хувийн эрх зүйн нэгэн салбарын хувьд Иргэний хуульд заасан ерөнхий зохицуулалтад тулгуурладаг. Иргэний хуулийн зохицуулалтаас гадна зарим тохиолдолд гадаад улсын хууль, эрх зүйн болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг хэрэглэх нөхцөл бий. Тухайлбал, Монгол Улсын 2002 оны Иргэний хуулийн 540 дүгээр зүйлд "Гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх" гэсэн хэсэгт "1. Шаардлагатай бол шүүх иргэний хэрэг, маргаан шийдвэрлэх буюу иргэний эрх зүйн бусад харилцааг зохицуулахад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд харилцаагүй гадаад улсын хууль, эрх зүйн болон олон улсын нийтээр

⁴ Инкотермсийн талар Т.Мэндсайхан. "Олон улсын хууийн эрх зүй". УБ., 2002 он. номлоос дэлгэрүүлэн уншиж болно.

хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг хэрэглэж болно” гэсэн нь шаардлагатай тохиолдолд гадаад улсын хууль, эрх зүйн болон заншлын хэм хэмжээ, шүүхийн жишгийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд харшлагагүй бол Монгол Улсын хуулийн нэгэн адил хэрэглэж болно гэсэн утга санааг илэрхийлж байна. Түүнчлэн мөн зүйлийн гуравт “Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээнд ямарваа нэгэн эрх зүйн харилцааг тодорхойлоогүй, эсхүл түүнийг өөр нэрийн дор ялгаатай агуулгаар тодорхойлсон бөгөөд Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах аргаар тодорхойлж болохооргүй бол түүний эрх зүйн ангиллыг тогтооход тухайн эрх зүйн харилцаа зохицуулсан гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг харгалзаж болно” хэмээн нарийвчлан тусгаж өгчээ.⁵

Гадаад улсын эрх зүйн хэм хэмжээ гэдэгт тухайлбал, Их Британийн эрх зүйн хэм хэмжээ, эх сурвалжийг аваад үзвэл парламентаар батласан хууль буюу статут, олон улсын гэрээ, заншил, шүүхийн жишиг, хүлээн зөвшөөрөгдсөн хуульчдын бүтээл зэргийг эх сурвалжид тооцсон байдаг. Иймээс Монгол Улсын хууль хэрэглэгч хуульд заасан энэхүү үндэслэлээр гадаад улсын хууль, заншил, шүүхийн жишгийг хэрэглэнэ гэсэн үг. Даатгалын харилцаанд олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн заншлын хэм хэмжээнд Английн Ллойдсын даатгагчдын тогтоосон заншил өндөр байр суурь эзэлдэг.

Тав. Даатгалын компанийн хэлбэр

Даатгалын компани нь үндсэн хоёр хэсэгт хуваагдана. Үүнд:

-Амь нас, эрүүл мэнд, тэтгэврийн даатгалын бүтээгдэхүүн борлуулдаг компани;

-Эд хөрөнгийн болон

хариуцлагын даатгалын бүтээгдэхүүн борлуулдаг компани гэж хуваагдана.

Олон улсад эдгээр даатгалын бүтээгдэхүүн борлуулдаг компаниудын хувьд татвар, нягтлан бодох бүртгэлийн харилцааг харилцан адилгүйгээр зохицуулдаг байна. Учир нь амь нас, эрүүл мэнд, тэтгэврийн даатгал нь олон жилийн тасралтгүй үйл ажиллагааг шаарддаг бол эд хөрөнгийн болон хариуцлагын даатгал нь ихэнхдээ хугацаа заасан буюу нэг жилийн хугацаанд хэрэгждэг.

Зарим оронд, жишээлбэл АНУ-д даатгалын компаниудыг стандарт түвшний, дээд түвшний гэж хоёр хэсэгт ангилдаг. Стандарт түвшний даатгалын компани нь тээврийн хэрэгсэл, орон сууц, бизнесийн зэрэг даатгалын бүтээгдэхүүнийг муж улсын хуульд заасан хэмжээ хязгаарт тохируулан хярилцагчидлаа шууд хэлбэрээр санал болгодог бол дээд түвшний даатгалын компани нь эрсдлийн төрөл, нөхөн олговрын хэмжээ хязгаарыг хярилцагчидтай тохиролцон тогтоох маягаар стандарт түвшний даатгалын компаниудын үзүүлж чадахгүй үйлчилгээг санал болгодог байна.

Үүсгэн байгуулах хэлбэрээр нь хязгаарлагдмал хариуцлагатай ба хувьцаат компани гэж хоёр ангилдаг. Дэлхий нийтийн хандлагаас харахад хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрийг даатгалын тогтолцоонд хярилцааг хүлээх чадварын хувьд тогтворгүй гэж үздэг учир хувьцаат компанийн хэлбэрийг илүүтэй сонгосон байдаг. Тухайлбал, хорьдугаар зууны эцсээр АНУ-д хаалттай компанийг хувьцаа эзэмшигч цөөн тооны этгээдийн ашиг сонирхлыг хамгаалдаг гэж үзэн даатгалын компаниудыг нээлттэй буюу хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх хөдөлгөөн явагджээ. Гэхдээ хувьцаагаа хөрөнгийн зах зээлд борлуулдаггүй

ч нэгэнт бие даасан, олны итгэл хүлээсэн цөөн тооны хувьцаа эзэмшигчтэй зарим даатгалын компанийг энэ ажиллагааны гадна орхиж итгэл хүлээлгэсэн юм.

Даатгалын үйл ажиллагаа явуулахдаа давхар даатгалын үйлчилгээ явуулдаг эсэхээс хамааран мөн давхар даатгалын бүтээгдэхүүн борлуулдаг, борлуулдаггүй даатгалын компани гэж хоёр ангилдаг. Даатгалын компани нь өөрийн эрсдлийг бууруулах үүднээс даатгалын гэрээнд заасан эрсдлээ хэсэгчлэн буюу дангаар бусад даатгалын компаниар хариуцуулахаар санал тавьж болно. Энэхүү даатгалын хэлбэрийг давхар даатгал гэдэг. Давхар даатгалыг дэлхийн зах зээлд санхүүгийн өндөр боломжтой цөөн тооны компани эрхлэн явуулж байна.

Даатгалын үйл ажиллагааны төрлөөр нь дагнасан буюу олон төрөлт даатгалын бүтээгдэхүүн борлуулдаг компани гэж мөн ангилж болно. Тухайлбал, зөвхөн тээврийн хэрэгслийн даатгалын харилцаанд оролцдог компани байж болно. Үүнийг дагнасан даатгалын компани гэж нэрлэдэг. Нөгөө талаас санхүүгийн томоохон бүлгийн охин компанийн хэлбэрээр байгуулагдаж, зөвхөн тухайн компанид хамаарах даатгалыг хариуцдаг компани байж болно. Жишээ нь, уул уурхайн чиглэлээр ажилладаг групп байлаа гэхэд түүний эрсдлийг хариуцах зорилгоор даатгалын нөөцийн сан бүрдүүлсэн охин компани байж болдог. Энэ төрлийн даатгалын компани нь хуульд заасан нөөцийн санг бүрдүүлж, өөрийн толгой компаниас харьцангуй бага хэмжээний төлбөр авдаг байж болох ч эдийн засгийн хувьд буруу зарцуулалтанд тооцогддог. Учир нь өөрөө өөрийнхөө эрсдлийг хүлээх нь бизнес амархан дампуурах шалтгаан болох тохиолдол олон бий.

Даатгалын үйл ажиллагаа

⁵ Б.Гүнбилэг, “Жишгийн эрх зүй”, УБ., 2008 он, 92 дэхь тал.

явуулдаггүй ч даатгалын харилцаанд оролцдог өөр нэг компанийн хэлбэр нь “даатгалын зөвлөх” компани юм. Энэ хэлбэрийн компани нь даатгалын бүтээгдэхүүн худалдан авах сонирхолтой этгээдэд мэргэжлийн тусалцаа үзүүлж, ямар компанийн даатгалын бүтээгдэхүүнийг худалдан авах талаар зөвлөгч юм.

Сүүлийн жилүүдэд байгалийн болон гэнэтийн хүчин зүйлс, дэлхийн эдийн засгийн хямрал зэргээс шалтгаалан даатгалын компаниудын эрсдэл хүлээх чадвар харьцангуй суларсан бөгөөд даатгалын бүтээгдэхүүн худалдан авах сонирхолтой этгээдүүд зөвлөх болон үнэлгээ тогтоох компаниудын үйлчилгээг өргөнөөр авч хэрэглэж байна. Энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг бие даасан, олонд танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн компаниудын тоонд Best's, Fitch, Standard & Poor's, Moody's Investors Service зэрэг компаниуд багтаж байна.⁶

Зургаа. Санал, дүгнэлт

Монгол Улсад даатгалын эрх зүй

нь бий болохдоо санхүүгийн эрх зүйн нэг хэсэг гэдэг утгаар бус харин нийгмийн халамжийн эрх зүйн салбар гэсэн утгаар хөгжиж иржээ. Энэ байдал нь үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, ажилгүйдлийн даатгал гэх мэт даатгалын төрлүүд нь уг чанартаа тэтгэвэр, тэтгэмжийн асуудалтай агуулгаараа ижил утгаар ойлгогдож даатгалын эрх зүйн асуудал бус нийгмийн халамжийн эрх зүйн асуудал болгон нийгэмд “бэлэнчлэх” сэтгэлгээг зохиомлоор бий болгож байгаагаараа сул талтай байна.

Орчин үеийн даатгалын чиг хандлага нь санхүүгийн эрх зүйн нэг хэлбэр байж, тухайн даатгалын гэрээг хийж буй даатгуулагчийн ашиг сонирхлыг бүрэн хамгаалсан байх учиртай атал манай улсад хэрэгжиж буй нийгмийн даатгалын тогтолцоо нь нийгмийн халамжийн тогтолцоотой нягт холбогдож, даатгуулагчаас зөвхөн хураамж авдаг, нэг талын ашиг сонирхлыг хамгаалсан даатгалын гэрээ байгуулахыг тулган шаарддаг,

даатгуулагч өөрийн төлсөн хураамж, төлбөрийн хэмжээ, нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн хүчин чадлыг мэдэх боломжгүй, сонголт хийх эрхгүй, хэдий хэмжээний эрсдлийн хохирлыг нөхөн төлүүлэх нь голорхойгүй, үүнийгээ дагаад даатгалын байгууллагад итгэх итгэлийг сулруулж, даатгалд мөнгө төлөх нь ашиггүй үрэлгэн зарцуулалт мэт сэтгэгдэл төрүүлж, нийгэмд үл итгэлцлийн хэв шинжийг бүрдүүлсэн тогтолцоог бий болгож байна. Иймээс нийгмийн халамжийн тогтолцоо, нийгмийн даатгалын тогтолцоог ялган салгах нь зүйтэй.

Цаашид тус улсад даатгалын эрх зүйг санхүүгийн эрх зүйн хүрээнд тууштай хөгжүүлж, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоог зах зээлийн эдийн засгийн хэв шинжтэй тогтолцоонд шилжүүлж, ил тод, даатгуулагчийн эрх ашгийг дээдэлсэн харилцаа бий болгон ажиллах шаардлагатай юм.

© © ©

ХУУЛЬЗҮЙН

1982

ЛАВЛАХ

⁶ http://en.wikipedia.org/wiki/Insurance_law . (Хамгийн сүүлд 2009-11-16-ны өдөр зочилсон)

ЗАР СУРТАЛЧИЛГАА БА ГЭМ ХОР

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн сектор*-ын судалгааны тайлан

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн сектор нь “Зар сурталчилгаа ба гэм хор” сэдэвт судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд бил энэ дугаартаа тайланг тоймлон¹ хүргэж байна.

УДИРТГАЛ ХЭСЭГ

Иргэдийн бараа, үйлчилгээг худалдан авах сэдлийг төрүүлэхэд нөлөөлөгч нэг томоохон хүчин зүйл нь зар сурталчилгаа болдогийн хувьд түүнээс үүдэлтэй гэм хор учрах нь нийгэмд нийтлэг байна. Жишээ нь, тус хүрээлэнгээс өмнө нь хийгдсэн судалгаагаар Хадагаламж зээлийн хоршоод мөнгөө өгч залилуулсан иргэдийн 70 орчим хувь нь зар сурталчилгаанд итгэн хоршоодол хандсан нь тогтоосон. Мөн зараас үүдэлтэй хохирсон иргэдийн талаарх сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээрх мэдээлэл зэргээс зар сурталчилгаа ба гэм хорын асуудлыг судлах нийгмийн бодит хэрэгцээ байна гэж судалгааны баг үзсэн болно.

Судалгааны зорилго нь зар сурталчилгааны эрх зүйн орчин, зараас үүдэлтэй гэм хорын шалтгаант холбоог шүүхийн практикаас судлан тогтоож, судалгааны үр дүнгээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, хэлэлцүүлэн хуулийн биелэлтийг хангах талаар холбогдох байгууллагад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, зөвлөмж боловсруулж хүргүүлэхэд чиглэнэ.

Хүн амын суурьшил, нягтрал ихтэй гэж үзэн Улаанбаатар хот,

Дорнод аймгийн Чойбалсан хот, Орхон аймгийн Эрдэнэт хот, Дорноговь аймгийн Замын-Үүд сумыг сонгон авч төрийн байгууллага, зар сурталчилгааны харилцаанд оролцогч субъектууд болон иргэдийн дунд судалгаа хийлээ. Судалгаанд нийт 60 орчим байгууллагын 90 орчим ажилтан, албан тушаалтан, 300 орчим иргэнийг хамруулсанаас гадна Зар сурталчилгааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, 2006-2008 онд нийслэлийн хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн 27 497 иргэний хэргийг уншиж судалсаны 111 хэргийг тэмдэглэн авч судалгаанд ашиглав.

Судалгааны тайлан нь “Удиртгал хэсэг”, “Зар сурталчилгааны эрх зүйн орчин, түүний үр нөлөө”, “Зар сурталчилгаанд тавигдах хяналтын тогтолцоо, түүний үр нөлөө”, “Эрүү, иргэний эрх зүй дэх зар сурталчилгаа ба гэм хорын асуудал”, “Дүгнэлт, санал, зөвлөмж” гэсэн бүтэцтэй.

ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ

Судалгааны баг Англи, Оросын Холбооны Улсын эрх зүйн зохицуулалтыг судлан үзэж хууль зүйн нэр томъёо, зар сурталчилгааны төрөл, хэлбэрээс шалтгаалан бий болгосон эрх зүйн зохицуулалтын онцлогуудыг судлав. Судалгааны энэ сэдвийн хүрээнд дараах асуудлыг хөндөн судалсан болно. Үүнд: Зар сурталчилгааны харилцааны эрх зүйн зохицуулалт дахь нэр

томъёоны хувьд нэг мөр болоогүй, зөрүүтэй, салаа утгыг илэрхийлсэн дутагдалтай тал байна. Эдгээрээс хамгийн чухал нь буюу тухайн харилцааны зохицуулалтын үндсэн зүйл болсон зар сурталчилгааны хувьд “зар”, “зар мэдээ”, “зарлал”, “зар сурталчилгаа”, “сурталчилгаа”, “реклам” гэх мэт нэр томъёо байгаа бөгөөд эдгээрийг хууль бүрт өөр өөрөөр хэрэглэсэн байна.

Иймд судалгааны баг нэр томъёоны талаар өөрсдийн саналыг доорх байдлаар боловсруулав.

• “Зар”, “зарлал”, “зар мэдээ” гэдэгт (цаашид зарлал гэх) аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой болон холбоогүй төрөлжүүлэн ангилсан, үгэн буюу бичмэл бүх хэлбэрээр түгээж буй мэдээллийг ойлгож болох юм. Үүнд ажилд авах, худалдах, худалдан авах, орон сууц зарах, хөлслүүлэх, тусламж хүссэн, тусламж үзүүлэх, анхааруулга, сэрэмжлүүлэг гэх мэт багтана. Эдгээр томъёолол хоорондын нарийн ялгаа, хэлбэр, зорилгыг тусгайлан гаргаж ирэх, тусад нь зохицуулах нь эрх зүйн үр дагаврын хувьд төдийлөн ач холбогдол байхгүй байна;

• “Зар сурталчилгаа”, “сурталчилгаа”, “реклам” гэдэгт (цаашид зар сурталчилгаа гэх) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа (цаашид “бүтээгдэхүүн” гэх)-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг

¹ Д.Шолмон, Д.Тамир, Р.Болормаа, Ц.Одмаа, Б.Солонго.

² Энэхүү судалгааны тийлгэн “Хууль дуулах ёс” сэтгүүлд бүхэлд нь нийтлэх боломжгүй бөгөөд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн номын сангаас бүрэн эхээр нь үзэж болно.

³ Английн зар сурталчилгааны эрх зүйн зохицуулалтын хувьд “бүтээгдэхүүн” гэдэгт бариа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, саная (idea), шалтгаан нөхцөл, боломж, шагнал урамшуулал, бэлэг гэх мэтийг хамруулж ойлгоно гэсэн байдаг. /The British Code of Advertising, Sales Promotion and Direct Marketing/

ойлгох боломжтой. Гэхдээ энд маркетингийн идвэжжүүлэлтийн бүх үйл ажиллагааг хамруулж байгаа гэж ойлгох нь зохистой гэж үзэж гэж үзэж байна.

Хоёрдугаар бүлэг: Зар сурталчилгааны эрх зүйн орчин

Зар сурталчилгаатай холбоотой нийгмийн харилцааг зохицуулах, хяналт тавих үүднээс Улсын Их Хурлаас “Зар сурталчилгааны тухай” бие даасан хуулийг 2002 онд батлан гаргасан байна.

Энэ бүлэгт Зар сурталчилгааны эрх зүйн зохицуулалт дахь нэр томъёоны тодорхойгүй байдал, хуулийн хамгийн ихээр зөрчигдөж байгаа зүйл заалтууд, хуулийн хариуцлага, Зар сурталчилгааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж хоорондын уялдаа холбоо, давхардал хийдэлд дүн шинжилгээ хийж, гадаадын зарим орны зохицуулалтын талаар товч авч үзэв.

2.1. Зар сурталчилгааны харилцаан дахь эрх зүйн нэр томъёоны асуудал

Зар сурталчилгааны харилцааны эрх зүйн зохицуулалт дахь нэр томъёоны хувьд нэг мөр болоогүй, зөрүүтэй, салаа утгыг

“зар мэдээ”, “зарлал”, “зар сурталчилгаа”, “сурталчилгаа”, “реклам” гэх мэт олон нэр томъёо байгаа бөгөөд эдгээрийг хууль бүрт өөр өөрөөр хэрэглэсэн байна. Үүнд, “сурталчилгаа” гэсэн нэр томъёо орсон 32 хууль, “Зар” гэсэн үг орсон 5 хууль, “Зар мэдээ” гэсэн нэр томъёо орсон 2 хууль, “зарлал” гэсэн заалт орсон 1 хууль, “Реклам” гэсэн нэр томъёо хэрэглэсэн 1 хууль, “зар сурталчилгаа” гэсэн нэр томъёо хэрэглэсэн 6 хууль байна.¹

Ийнхүү өөр өөр нэршил бүхий боловч бүгд Зар сурталчилгааны тухай хуулийн үйлчлэлд багтан ойлгогдож тэдгээрийн төлөө зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгч бүгд хариуцлага хүлээхээр харагдаж байна. Гэтэл хувь хүний зарыг их хэмжээгээр авч төрөлжүүлэн ангилж нийтэлдэг “Зар мэдээ”, “Шуурхай зар” сонин, зарын нэгдсэн сайтууд өөрийн хүлээн авч байгаа хэдэн мянган зарын үнэн, бодит байдлыг нягтлан шалгаж, тэдгээрийн төлөө хариуцлага хүлээх бодит боломжгүй юм.

Зарим нэр томъёог хэл зүйн талаас нь харвал “Зар-олонд зарлан нийтлэх үг буюу мэдээ”,

нэр томъёог Зар сурталчилгааны гухай хуульд “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа (цаашид “бүтээгдэхүүн” гэх)-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг” ойлгоно гэж гайлбарлан оруулсан байна. Гэгээрэх зар сурталчилгаанд эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилго бүхий зар, зарлал, мэдээлэл, сурталчилгаа бүгд хамрагдахаар байна. Өөрөөр хэлбэл, маркетинг, олон нийттэй харилцах ажлын хүрээнд хийж байгаа бүх мэдээллийг хамруулж ойлгох боломжтой юм.

Нэр томъёонуудыг шинж чанар, агуулга, эрх зүйн үр дагавраар нь ийнхүү 2 бүлэгт ангилан авч үзэх нь нэгэнт хэрэглэгдэж заншсан үг хэллэгийг хасах эсвэл, шинээр нэршил гаргаж ирснээс илүү үр дүнтэй юм. Дээрх 2 бүлэг нэр томъёоны шинж гэмдгийг нарийвчлан хүснэгтээр харуулъя. Үүнд: (Хүснэгт 1)

Хүснэгт-1

№	“Зар”, “зарлал”, “зар мэдээ” буюу <u>Зарлал</u>	“Зар сурталчилгаа”, “сурталчилгаа”, “реклам” буюу <u>Зар сурталчилгаа</u>
1.	Төрөлжүүлэн ангилсан (олон нийтэд чиглэсэн арилжааны бус нийгмийн шинжтэй мэдээ, мэдэгдэл, мэдээлэл сонордуулгын хувьд заавал төрөлжсөн байх шаардлагагүй) байна.	Заавал төрөлжүүлэн ангилсан байх шаардлагагүй.
2.	Үгэн буюу бичмэл хэлбэртэй байх.	Дуу, дүрс, үйл хөдлөлийг ашигласан байх.
3.	Аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой болон холбоогүй байж болно.	Аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой (үүнд олон нийтэд чиглэсэн арилжааны бус нийгмийн шинжтэй, сонгуулийн зар сурталчилгаанд хамаарахгүй).
4.	Бүх хэлбэрээр түгээж болно.	
5.	<u>Илт хууль бус байх</u> тохиолдолд түгээгч хариуцлага хүлээнэ.	
6.	<u>Хууль бусад тооцож болох</u> тохиолдолд түгээгч хариуцлага хүлээхгүй.	<u>Хууль бусад тооцож болох</u> тохиолдолд түгээгч /зөвхөн Телевиз, радио/ хариуцлага хүлээнэ.

илэрхийлсэн дутагдалтай тал байна. Эдгээрээс хамгийн чухал нь буюу тухайн харилцааны зохицуулалтын үндсэн зүйл болсон зар сурталчилгааны хувьд “зар”,

“сурталчилгаа- сурталчлах, сурталлахын нэр үг байн байн сургаж ягтах, ухуулах, сэхрүүлэх”⁵ гэсэн утгыг тус тус илэрхийлэх аж.

Харин “Зар сурталчилгаа” гэсэн

Дээрх хүснэгтийн 5, 6 дуугаар эгнээнд илт хууль бус зар сурталчилгаа, хууль бусад тооцож болох зар сурталчилгаа гэсэн ангилал оруулсан. Үүнийг

¹ Тайлангийн нэгдүгээр хансралтаас дэлгэрэнгүйг үзнэ үү.

⁴ Я.Цэнэл. “Монгол хэлний тогч тайлбар толь”. УБ., 1966 он. 267 дахь тал.

⁵ Я.Цэнэл. “Монгол хэлний тогч тайлбар толь”. УБ., 1966 он. 491 дэх тал.

Хүснэгт-2

Илт хууль бус	Хууль бусад тооцож болох
Тусгай зөвшөөрөл аваагүй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулах;	Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа;
Монгол Улсын хууль тогтоомжоор үйлдвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бүтээгдэхүүнийг сурталчлах;	Хуульд заасны дагуу чанар, стандарт, эрүүл ахуйн баталгаажуулалтад заавал хамруулах бүтээгдэхүүнийг ийнхүү баталгаажуулаагүй бол сурталчлах;
Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгаа;	Тарифын бус хязгаарлалт тогтоосон барааг сурталчлах;
Айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгаа;	Хуульд заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх төслийг үнэлгээ хийлгэхээс өмнө, эсхүл үнэлгээ хийгдсэн боловч төслийг хэрэгжүүлэх боломжгүй гэсэн дүгнэлт гарсан бол уг төслийг сурталчлах;
Монгол Улсын болон бусад улс орны төрийн тусгай бүрэн эрх, чиг үүрэгт хамаарах үйлчилгээ, үйл ажиллагаа, эрх олгох баримт бичгийг хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх, олгохоор сурталчлах (виз гаргах, диплом олгох, иргэний бүртгэлийн бичиг баримт гаргах, тэдгээрийг худалдах, худалдан авах гэх мэт)	Зар сурталчилгааны тухай хуульд заасан бусад түгээхийг хориглосон зар сурталчилгаа;
Хуулиар сурталчлахыг хориглосон бараа, ажил, үйлчилгээг сурталчлах (үүнд, Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйл хамаарахгүй)	
Тухайн эм, эмчилгээ, аминдэм, биологийн нэмэлт бүтээгдэхүүний үйлчлэлийн талаар урьдчилсан баталгаа гаргах;	

дэлгэрэнгүй тайлбарлан харуулъя: Дээрх нэр томъёоны тодорхойлолт, үндсэн шинжийн ангилал бий болгосноор дараах дүгнэлт гарч байна. Үүнд: (Хүснэгт2)

• Илт хууль бус зарлал ("Зар", "зарлал", "зар мэдээ"), зар сурталчилгаа ("Зар сурталчилгаа", "сурталчилгаа", "реклам") түгээсэн бол түгээгч нь хэн байхаас (телевиз, радио, сонин, сэтгүүл, веб сайт, зурагт хуудас, самбар гэх мэт олон нийтэд түгээж болох бүх хэлбэр) үл шалтгаалан хариуцлага хүлээнэ;

• Хууль бусад тооцож болох зарлалын хувьд цацагдаж байгаа хэлбэр, зорилго, шинж чанараас нь үл хамааран түгээгч хариуцлага хүлээхгүй. Оөрөөр хэлбэл, элгээрх бодит үнэнийг зарлуулсан байгууллага, хувь хүн хариуцна;

• Харин Хууль бусад тооцож болох зар сурталчилгааны хувьд түгээгч (зөвхөн телевиз, радио) хариуцлага хүлээнэ.

2.2. Зар сурталчилгааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн үндэсн холбоо

"Хууль дээдлэх ёс", 2009 он, №4

зорчил, давхардал, хийдэл

Зар сурталчилгааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг судлахын тулд ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан Иргэн, эдийн засгийн эрх зүйн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлалыг удирдлага болгон хийсэн бөгөөд хууль-41, зар сурталчилгааны харилцааг зохицуулсан хуулийг тайлбарлан Улсын дээд шүүхийн тогтоол-5, нийтээр дагаж мөрдүүлэхээр эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн акт-1-ийг харьцуулан давхардал, зөрчил, хийдлийг тогтоов (дэлгэрэнгүйг судалгааны тайлангаас харна уу).

Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл:

1. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д "Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно" гэжээ. Гэтэл Зар сурталчилгааны тухай хуульд хууль бус зар сурталчилгаа гэдэгт зүй бус,

бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгааг хамааруулахаар заагаад тус бүрийг тодорхойлжээ. Тэгэхээр Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар далд сурталчилгаа, арилжааны зар сурталчилгааг явуулахыг хязгаарласан мөртлөө зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн зар сурталчилгааг нэвтрүүлж болохоор мэт харагдаж байна;

2. Мөн Зар сурталчилгааны гухай хууль болон бусад хуулийн ишлэл авсан хэсэг алдаатай байна. Жишээ нь, Зар сурталчилгааны гухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт "Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт зааснаас гадна дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:" гэсэн ч Төрийн хяналт шалгалтын хууль (шинэчлэн найруулсан) 16 зүйлтэй байна;

3. Хийдлийн хувьд интернэт буюу шашим хэлбэрээр явуулж болох зар сурталчилгааны зохицуулалт дутагдаж байна. Интернэт,

компьютерийн хэрэглээ эрс нэмэгдэж байгаа өнөө үед хүмүүс телевиз, радио, сонин гэхээсээ илүү интернетээр хүссэн мэдээллээ авах, ажлаа хийх хандлага нэмэгдэж байгаа учраас энэ салбарт нарийвчилсан зохицуулалт шаардагдаж байна;

4. Зар сурталчилгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2-т Нутгийн өөрөө удирдах байгууллага замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын албатай тохиролцсоны үндсэн дээр тээврийн хэрэгслээр зар сурталчилгаа түгээхэд тавих аюулгүй ажиллагааны болон стандартын шаардлагыг тогтоож болно гэсний дагуу Замын цагдаагийн газар болон НЗАА-аас энэ талаарх эрх зүйн ал байдаг талаар лавлахад ийм эрх зүйн акт байхгүй гэсэн хариуг өгсөн юм. Мөн тус хуулийн 24.3.3-т зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд баримтлах зөвлөмж, гэрээний үлгэрчилсэн загварыг батлах талаар тусгасан. Энэ талаар үлгэрчилсэн дүрэм, журам

байдаггүй гэж Оюуны өмчийн газрын Хяналтын албаны дарга хэлж байлаа;

5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26.10-т заасан нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны танилцуулга, мэдээллийг олон нийтэд хүргэх, зардлыг тооцох, зар сурталчилгаа явуулах, Сангийн хувьцааны үнэлгээ, хадгаламж бүртгэл, санхүүгийн хяналт болон тэдгээрийг тайлбарлах журмыг Хороо тогтооно гэснээр Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн Журам батлах тухай 37 дугаар тогтоолыг олж давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоохоор эрх зүйн актыг тайланд тусгахыг хичээсэн ч хүчингүй болсон байв;

6. НИТХ-ын Тэргүүлэгчдийн Хурлын 2006 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан Журам шинэчлэн батлах тухай тогтоолыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хуулийн хэвтээс авсан. Зөрчил, давхардал, хийдлээс

гадна утга найруулга, үсгийн алдаа их байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.

2.3. Зар сурталчилгааны тухай хууль зөрчигдөж байгаа нийтлэг байдал, зүйл, заалт

Судалгаанаас харахад Зар сурталчилгааны тухай хуулийн дараах зүйл заалт ихээр зөрчигдөж байна гэж үзлээ. Үүнд: (Хүснэгт 3)

Зар сурталчилгааны эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг хуульд тусгахдаа бүтээгч, түгээгчийн эрх, үүргийг хольж, солин алдаатай зохицуулалт оруулсан гэж дүгнэж болохоор байна.

“Зар мэдээ”, “Шуурхай зар”, “Үнэгүй зар” сонинд гарч буй зар сурталчилгааны мэдээллийн агуулга нь: *Ажилд урьж байна, Ажил хайж байна, Төрөл бүрийн бараа, Барилга үйлчилгээ, Барилгын материал, Виз аялал жуулчлал, Мөнгө зээл санхүү, Тоног төхөөрөмж, Барилгын материал, Сургалт дамжаа, Гадаад хэл сургалт, Эмчилгээ гоо сайхан, Ажлын байрны түрээс, Ажлын*

Хүснэгт-3

Зар сурталчилгааны тухай хуулийн зүйл заалт

6.5.1. Тусгай зөвшөөрөл аваагүй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулах;
6.5.2. Монгол Улсын хууль тогтоомжоор үйлдвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бүтээгдэхүүнийг сурталчлах
6.5.4. Хуульд заасны дагуу чанар, стандарт, эрүүл ахуйн баталгаажуулалтад заавал хамруулах бүтээгдэхүүнийг ийнхүү баталгаажуулаагүй бол сурталчлах
6.5.7. айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгаа;
9.3. Гадна зар сурталчилгаа нь замын хөдөлгөөн зохицуулах дохио, тэмдэг, тэмдэглэлтэй төстэй байх, тэдгээрийг халхлах, дайлах болон бусад хэлбэрээр замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.
11.1. Уран сайхны болон баримтат кино, радио жүжгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхдээ зохиогч, эсхүл зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрлийг авсан байна.
11.3. Улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.
11.5. Үргэлжлэх хугацаа нь 20 минутаас дээшгүй нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.
13.3. Эмийг сурталчлахдаа тэдгээрийг хэрэглэх заавартай танилцахыг заавал сануулна.
13.4.3. тухайн эмийн гаж үйлчлэл, хориглох заалтыг нуун далдах зорилгоор сурталчлах;
13.4.4. тухайн эмийн үйлчлэлийн талаар урьдчилсан баталгаа гаргах;
13.7. Эмнэлгийн байгууллагын талаархи зар сурталчилгаа нь зөвхөн байршил, үйлчилгээний чиглэл, эмчийн нэр хаягаар хязгаарлагдана.
13.8. Эмнэлгийн үйлчилгээний талаар магтсан, үйлчлүүлэхийг уриалсан сурталчилгаа явуулахыг хориглоно
14.1. Нэн ховор, ховор ургамал, амьтны жигсгаалтад орсон болон тэдгээрийн үндэс, иш, мөчир, навч, бугын цусан эвэр, чив, засаа, согооны суул, сав, хүдрийн заар, баавгайн доньд зэрэг эрхтэнийг бэлтгэх, худалдах, худалдан авах тухай зар сурталчилгааг хориглоно.
16.1.4. хүүхдийг аюултай орон зай, нөхцөл байдалд дүрсэлсэн дүрс, дуу авиа, эсхүл үг хэллэгийг зар сурталчилгаанд ашиглах

байрны худалдаа, орон сууц түрээслэх (гадаад болой дотоодын иргэнд, ман хажуу өрөө), Орон сууц худалдаа, хашаа байшингийн худалдаа, Авто машины худалдаа, газар, танилцаж гэсэн төрөлтэй байна.

Судалгааны ажлын хүрээнд Ажилд урьж байна, Виз аялал жуулчлал гэсэн хэсгүүдийг онцлон авч үзсэн болно.

2.4. Зар сурталчилгааны хариуцаан дахь хариуцлагын асуудал

Зар сурталчилгааны хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын арга хэмжээ үр өгөөжгүй байгаа тухай судлаачид болон иргэд, албан тушаалтнууд санал бодлоо илэрхийлсэн байдаг. Судалгааны багийнхан ч тэдэнтэй санал нэг байна.

Зар сурталчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлд хууль зөрчигч иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулахаар заасан байна.

Энэ нь хууль дахин зөрчигдөхөө сэргийлэх, зөрчил гаргагчийг цэрлүүлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах чиг үүрэг хэрэгжүүлж чадахгүй байгаагаас гадна онгоддуулж байгаа торгуулийн хэмжээ тухайн зөрчлийг гаргаснаас олсон орлогын хэмжээний харьцаа алдагдсан учраас хууль зөрчигчид эдийн засгийн хувьд илт ашигтай байгаа юм. Эрх зүй ба эдийн засгийн онолын үүднээс хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэмжээ, хууль зөрчсөнөөс олох орлогын хэмжээнээс илүү байх нь хариуцлагын үр нөлөөг баталгаажуулах буюу эрх зүйн харилцааны оролцогч хуулийг бислүүлэх эдийн засгийн гол хөшүүрэг болдог байна.

Судалгааны явцад зохион байгуулсан уулзалт ярилцлагад оролцсон хэвлэл мэдээллийн

байгууллагын ажилтнууд “хууль бус зар сурталчилгааг захиалагч нь оногдуулж болох торгуулийн төлбөрийг зар сурталчилгаагаа түгээх гэрээ байгуулахдаа урьдчилан өгдөг” гэж ярьж байлаа. Үүнээс хууль зөрчигчид хүлээлгэж байгаа торгуулийн хэмжээ нь хууль зөрчсөнөөс олох ашгаас хамаагүй бага байгаа нь илт байна.

Иймд бид бусад улс оронд хариуцлагын ямар үр нөлөөтэй арга хэрэглэдэг талаар судлан үзсэнээс Англи Улсын туршлага дэвшилттэй бөгөөд үр өгөөжтэй байх тул дэлгэрүүлэн судалж судалгааны тайландаа тусгаар шийдлээ. Англид зар сурталчилгаа захиалагч, түгээгчид ногдуулах хариуцлагын төрөл, хэлбэр ялгамжтай байхаар зохицуулсан байх ба субьектын үйл ажиллагааны онцлогт тохирсон, өндөр үр нөлөөтэй байх тал дээр түлхүү анхаарсан байна. Үүнд:

Хууль зөрсөн зар сурталчилгаа захиалагчид:

- Зар сурталчилгаа захиалагчид гухайн зар сурталчилгаагаа өөрчлөх эсвэл явуулахыг зогсоохыг шаардах;

- *Сөрөг сурталчилгаа* буюу зөрчлийн талаар шийдвэр гаргасан байгууллагын тухайн шийдвэрийг нийтлэх (*Сөрөг сурталчилгаа нь ихтэлх зар сурталчилгаа захиалагчдад сөрөг нөлөөтэй байхын эрэгцээс олон нийтийг сэрэмжлүүлэх аж холбогдолтой*);

- Хууль бус зар сурталчилгааны талаар түгээгчдэд сэрэмжлүүлэг өгөх (зөрчил гаргасан субьектын зар сурталчилгааг цацах, нийтлэх үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг сануулах бөгөөд ингэхдээ сэрэмжлүүлэгт зөрчил гаргагчийн нэр, хаяг, утас, электрон шуудангийн хаяг, зөрчлийн талаар тодорхой мэдээлэл, шаардлагатай бол зураг бусад дүрсийг хавсаргасан байна);

- Олгосон худалдааны давуу эрх, хүлээн зөвшөөрөх баримт бичгийг

түр хугацаагаар түтгэлзүүлэх, хүчингүй болгох;

- Нийтлэхээс өмнө шаардлага хангаж байгааг шалгах буюу байнгын зөрчил гаргадаг этгээдийн бүх эсвэл зарим зар сурталчилгааг нийтлэхээс өмнө заавал эрх бүхий байгууллагаар хянуулж, шаардлага хангасан тохиолдолд нийтэлж байх шийдвэр гаргах;

- Хуулийн албадлага хэрэглэх (дээрх арга хэмжээнүүдийг авсан ч зөрчлөө арилгахгүй байгаа тохиолдолд хуулийн дагуу Шударга өрсөлдөөний газарт тухайн зөрчил гаргагчийг шилжүүлнэ. Тийнхүү шилжүүлснээр Шударга өрсөлдөөний төлөө газар хуулийн дагуу арга хэмжээ авах эрх эдэлнэ. Энэ тохиолдолд зөрчил гаргагч зөрчлөө засаагүй хэвээр байгаа тохиолдолд шүүхэд шилжүүлэх бөгөөд тэрхүү зөрчилд шүүх зохих ялыг оногдуулна).

Зар сурталчилгаа түгээгчид хүлээлгэх хариуцлага:

- Түгээгчээс тодорхой хөтөлбөр болон зар сурталчилгааг явуулахгүй байхыг шаардах;

- Түгээгчийг тодорхой төрлийн зар сурталчилгаанууд, зар сурталчилгааны аргыг ашиглахгүй байхыг шаардах;

- Залруулга (Бодитой биш зар сурталчилгааг зассан, зөв болгосон) хийх эсвэл шийдвэрийн талаар мэдээлэхийг үүрэг болгох;

- Санхүүгийн хариуцлага оногдуулах, эвсэл тусгай зөвшөөрлийн хугацаа багасгах;

- Гусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хураан авах.

- Эдгээр хариуцлагын төрлийг судлан үзэж, манай улсын эдийн засаг, эрх зүйн хөгжил, соёлын гүвшин, уламжлалд нийцүүлэн зохих байдлаар өөрчлөн үндэсний хууль тогтоомжид суулгах боломжтой юм.

ЗАР СУРТАЛЧИЛГААНД ТАВИГДАХ ХЯНАЛТЫН ТОГТООЛЦОО, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ

Зар сурталчилгааны тухай хуулийн 5 дугаар бүлгийн

* The British Code of Advertising, Sales Promotion and Direct Marketing.

* Television Advertising Standards Code.

зохицуулалтаар зар сурталчилгаанд тавих хяналтыг:

- төрийн;
- олон нийтийн;
- хамтын гэж ерөнхийлөн 3 ангилж болох юм.

Эдгээр 3 хэлбэрийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны уялдаа холбоо, үр нөлөөний талаар тус тусад нь үзье.

3.1. Төрийн хяналт

Зар сурталчилгааны тухай хуулийн 24, 25, 26 дугаар зүйлд зааснаас үзвэл төрийн хяналтыг хамрах хүрээгээр нь:

- Улсын;
- Орон нутгийн;
- Салбарын гэж хуваасан байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгаанд тавих хяналтыг **Оюуны өмчийн улсын хяналтын алба**, орон нутгийн хэмжээнд **Засаг дарга**, түүний томирсон байцаагч, салбарын хяналтыг эм, био бэлдмэл, эрүүл ахуй, байгаль орчин, чанар, стандартчлал, барилга, тээвэр, гааль, татвар, худалдаа, үйлчилгээ зэрэг чиглэлийн мэргэжлийн хяналтын алба, тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаатай холбоотой зар сурталчилгааны хувьд тухайн тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага өөрийн чиг үүргийн дагуу хяналт тавих, бүрэн эрхийнхээ хүрээнд арга хэмжээ авах үүрэгтэй байна.

Улсын хэмжээний хяналтыг Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга, 2 байцаагчийн хамт нийт 3 хүний бүрэлдүүлтэйгээр хэрэгжүүлж байна. 2.5 сая хүн амтай, зөвхөн нийслэлийн хэмжээнд 18 телевиз, 4 кабелийн телевиз, өдөр тутмын 12 сонин, ... самбар, 42001⁴ интернэтийн хэрэглэгч, олон тооны хэвлэх үйлдвэр, 4 үүрэн холбооны операторын 1 763 178⁵ үйлчлүүлэгчийн хүрээнд 2 байцаагч хяналтыг хэрэгжүүлж байгаа нь зар сурталчилгааны хуулийн биелэлт

улсын хэмжээнд ямар түвшинд байгаагийн тод илрэл болно.

Зар сурталчилгааны тухай хууль батлагдсан үеэс буюу 2002 оноос эхлэн 2008 он хүртэл Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтэс нийт 1574 удаа хяналт шалгалт хийж 132 550 000 төгрөгийн торгууль ногдуулсан байна. Мөн 6 жилийн хугацаанд 17 удаа сургалт, семинар зохион байгуулжээ.

Орон нутаг дахь төрийн хяналт

Зар сурталчилгааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "Тухайн орон нутгийн хэмжээнд мэдээлэл тараагагч мэдээлэх хэрэгслээр түгээсэн зар сурталчилгаанд аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний томирсон байцаагч хяналт тавина" гэж заажээ.

Хэдий ийм боловч орон нутагт хийсэн судалгаагаар хуулийн энэ заалт огт хэрэгжихгүй байгаа буюу орон нутаг дахь төрийн хяналт байхгүй байна гэж хэлж болохоор байна.

Улаанбаатар хотод:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хуульд заасан хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ганцхан мэргэжилтэн ажилладаг байна. Судалгааны хугацаанд судалгааны баг Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд хангах чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Захирагчийн ажлын албаны Реклам, зар сурталчилгаа хариусан мэргэжилтэнтэй хэд хэд уулзаж, ярилцлагын аргаар судалгаа авсан.

Орон нутагт хийсэн судалгаа:

Бид 2009 оны 6 дугаар сарын 17-ноос 7 дугаар сарын 3-ны хооронд Дорнод, Орхон аймаг, Дорноговь аймгийн Замын-Үүд суамд ажиллаж тухайн орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа Зар сурталчилгааны тухай хуулийн хяналт, түүний үр нөлөөнд ярилцлагын аргаар, хууль бус зар сурталчилгаанд тандалт болон

анкетын аргаар судалгаа хийсэн болно.

Судалгааны хүрээнд аймаг бүрийн Засаг даргын Тамгын газар, Шүүх, Прокурор, Тагнуул, Цагдаагийн байгууллага, Мэргэжлийн хяналтын алба, Хил хамгаалах газар, Хэвлэл мэдээллийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж ярилцсан болно. Ийнхүү хийсэн судалгааны үр дүнд тогтоогдсон нөхцөл байдлыг аймаг бүрээр авч үзвэл.

Дорнод аймагт:

Гэвч тус аймгийн ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж ярилцахад зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг хариуцагда албан тушаалтан байхгүй бөгөөд энэ талаар ямар нэгэн дүрэм журам аймгийн хэмжээнд гаргаж байгаагүй талаар хэлж байлаа. Тамгын газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас зар сурталчилгааны талаар ямар нэгэн гомдол, хүсэлт ирүүлж байгаагүй байна.

Орхон аймагт:

Тус аймгийн хэмжээнд зар сурталчилгааны хяналтыг ЗДТГ-ын Тогтоол шийдвэрийн биелэлт хариусан мэргэжилтэн хариуцагда байна. Тэрээр ярихдаа "Улиралд 2-3 зөрчил илэрдэг ... Удирдах байгууллагаас бодлогоор зохицуулдаггүй, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгдөггүй, энэ ажлыг хариуцаж хийлээ гээд ямар ч урамшуулал, цалин олгодоггүй харин жилийн эцэст ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ биелүүлээгүй гээд хариуцлага хүлээх болдог. Энэ чиглэлээр даанан хариуцдаг орон тооны мэргэжилтэнтэй болох нь үр дүнтэй. Манай аймагт согтууруулах ундаа олгох журам байдаг. 1 удаа үйл ажиллагаагаа зорчих юм бол үйл ажиллагаагаа нь хүчингүй болгоно. Манайд үйл ажиллагаагаа явуулдаг том сүлжээ дэлгүүрүүд торгуулийг нь төлөөд (80 000 төгрөг) хууль зорчдог. ..."

⁴ <http://www.ictpa.gov.mn/?p=129&lang=mn>.

⁵ <http://www.ictpa.gov.mn/?p=129&lang=mn>.

гэлээ.

Орхон аймгийн хувьл Дорнод болон Замын-Үүдтэй харьцуулахад зар сурталчилгааны тухай хуулийн биелэлтийг хариуцсан нэг албан тушаалтантай, тэр нь өөрийн ноёд бололцооны хэмжээнд хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа явуулалгаараа дэвшилтэтэй байгаа юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд суманд:

Сумын хэмжээнд Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтан байхгүй байна гэж болохоор байна. Учир нь сумын Засаг даргын Тамгын газрын дарга нь “хуулийн 1 мэргэжилтэн хариуцан ажилладаг” гэх боловч тухайн албан тушаалтантай уулзахад тэрээр “миний ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй, ийм төрлийн үйл ажиллагаа явуулж байгаагүй” гэж байлаа. Мөн сумын хэмжээнд гуламж, талбайд байрлуулах самбар, зар сурталчилгааны зурагт хуулсыг хэрхэн байрлуулах, ямар стандарт, шаардлагыг хангасан байх, хөлс төлбөрийн талаар ямар нэгэн зохицуулалт хийлдэггүй байна.

Салбарын хяналт

Зар сурталчилгааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг “Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн биелэлтэд эм, био бэлдмэл, эрүүл ахуй, байгаль орчин, чанар, стандартчилал, барилга, тээвэр, гааль, татвар, худалдаа, үйлчилгээ зэрэг мэргэжлийн хяналтын алба, нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн энэ хуулийн 6.2-т заасан тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага тус тусын чиг үүргийн дагуу хяналт тавих, бүрэн эрхийнхээ хүрээнд арга хэмжээ авах үүрэгтэй”, 24 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “... Эдгээр хяналтын алба, байгууллага нь зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн

тухай мэдээллийг тодорхой үндэслэл, саналын хамт зар сурталчилгаанд хяналт тавих эрх бүхий байгууллагад шуурхай ирүүлэх үүрэгтэй” гэж тус тус заажээ.

Хэдийгээр хуульд ийнхүү салбарын хяналт хэрэгжих үндсийг тавсан боловч энэ нь бодит байдал дээр хэрэгжихгүй байна гэж дүгнэж болохоор байна. Жишээ нь МХЕГ-ын байцаагчид ярилцлагын үеэр “Зар сурталчилгааны тухай хуульд зааснаар Оюуны өмчийн газар хяналтыг тавих ёстой, бидний ажлын чиг үүрэгт зар сурталчилгаанд хяналт тавих эрх үүрэг байхгүй” гэж байлаа. Харин НМХГ-аас 2008 онд эмийн зар сурталчилгааны байдалд шалгалт хийсэн байна. Уг шалгалтад хамрагдсан хэвлэл мэдээллийн хэрэгслээр эм, эмийн зүйлс бусад

төөрөгдөлд оруулсан сурталчилгааг, “Шуурхай зар”, “Зар мэдээ” сонингуудад жороор олгох болон эмнэлгийн нөхцөлд хэрэглэхээр заагдсан үр зулбуулах эмийг борлуулах зорилгоор тус тус сурталчилсан, радио телевизээр явуулж байгаа зар сурталчилгааны хугацаа, цагийн хэмнэл нь алдагдалтай, сургалтын болон хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур хүнсний болон хоол, эм, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зар сурталчилгааг түгээж байгаа зөрчлүүд нийтлэг байна.

Харин иргэдээс авсан анкетийн асуулгаар Зар сурталчилгаанаас үүдэн хохирч байгаа иргэд хаана хандахаа мэддэг эсэхийг судлахаар Зар сурталчилгаанаас үүдэн хохирсон бол хаана хандаж байсан бэ? гэсэн асуултад доорх байдлаар хариулсан байна. Үүнд: (Хүснэгт 4)

Хүснэгт-4

№	Тоо	Хувь
1	15	39.47
2	-	-
3	3	7.89
4	-	-
5	-	-
6	-	-
7	20	52.63
8	-	-

эрүүл мэндийн бүтээгдэхүүний улсын бүртгэлийн гэрчилгээ, чанарыг нотолсон баримт, хүнсний болон хүний эмийн салбар зөвлөлийн комиссын протокол зэргийг үндэслэлгүй сурталчилсан, сурталчилж буй бүтээгдэхүүний лагалдах бичиг баримтыг баримтжуулж хадгалаагүй, хяналт тавьдаггүй зэрэг зөрчил нийтлэг байсан байна. Мөн Монголчуудын амьдрал, Сэрүүлэг, Зар мэдээ, Шуурхай зар, Хүмүүс, Хүмүүсийн амьдрал сонины газрууд, Ай ТВ, ТВ-9, С-1, 25 дугаар суваг телевиз, 103.6 FM радио зэрэг байгууллагад бүтээгдэхүүний талаар урьдчилсан баталгаа гаргасан, мэдлэг, туршлага дутмаг, итгэмтгүй байллыг ашигласан, иргэдийг

Үүнээс дүгнэхэд зар сурталчилгааны улмаас өөрт нь хохирол учирсан гэж үзсэн иргэдийн ердөө 8 хүрэхгүй хувь нь МХГ-т хандаж байсан байна.

3.2. Олон нийтийн хяналт

Зар сурталчилгааны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн болон түүнтэй холбоотой мэдээллийг тодорхой үндэслэл, саналын хамт эрх бүхий байгууллагад тавих, шаардлагатай бол мэдээлэх хэрэгслээр нийтийг сэрэмжүүлж болно”, тус зүйлийн 2 дахь хэсэгт “Хэрэглэчийн эрх ашиг, түүнчлэн зар сурталчилгаа бүтээх, түгээх үйл

ажиллагаанд оролцогчийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага зар сурталчилгаанд хяналт тавих чиглэлээр дараахь эрх эдэлнэ:

- хэрэглэгчийн нэрийн өмнөөс зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах;

- тухайн зар сурталчилгаа хууль тогтоомжилд заасан шаардлагад нийцэх буй эсэх талаар зөвлөмж гаргах;

- зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгчид зар сурталчилгаатай холбогдох санал тавих, зөвлөмж өгөх;

- Зар сурталчилгааны хяналттай холбоотой тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн улсын төсвөөс санхүүжүүлж болно” гэж тус тус заажээ.

Хуулийн энэхүү зохицуулалтаас харахад зөвхөн төрийн бус байгууллага хэрэглэгчийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргаж болохоор байна.

Олон нийтийн энэ хяналт хэр хэрэгжиж байгааг Оюуны өмчийн газрын тайлан болон судалгааны багийн шүүхийн архивт сууж түүврийн аргаар хийсэн судалгаанаас харж болохоор байна. Судалгааны баг 2009 оны 7 дугаар сарын 20–28–ны өдөр Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн архивт сууж Баянгол, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, Сүхбаатар, Баянзүрх, Налайх дүүргийн 2006–2008 оны шүүхийн шийдвэртэй танилцсан бөгөөд зар сурталчилгаатай холбоотой байж болох хэргийн тоон үзүүлэлтийг дор хүснэгтэд харуулав. (Хүснэгт 5)

(Шүүхийн архивт суусан тэмдэглэлийг хавсралт 2-оос үзэх боломжтой.)

Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн 2006–2008 онд хийсэн хяналт шалгалтын тоотой харьцуулахад 935 харьцах нь 3 гэсэн лүнтэй гарч байна. Өөрөөр хэлбэл,

Хүснэгт-5

Нийт уншсан хэргийн тоо: 27 497		
Үүнээс зар сурталчилгаатай холбоотой хэргийн тоо: 111		
Харилцааны төрлөөр	Зар сурталчилгааны тухай хуулийг баримтлан шийдвэрлэсэн	3
	Виз гаргаж өгөх	45
	Худалдах, худалдан авах	23
	Зээл	5
	Түрээс	18
	Ажил гүйцэтгэх	3
	Хөдөлмөр	2
	Бусад	12

шүүхэд нэхэмжлэл гаргаж болох 935 (зөвхөн хяналтад өртөгдсөн зөрчил) зөрчлөөс зөвхөн 3 тохиолдолд л олон нийтийн хяналт хэрэгжиж чадсан байна. Мөн Оюуны өмчийн газрын “Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилт” тайлангаас харахад 2002–2008 оны хугацаанд 1574 удаа хийсэн хяналт шалгалтын 9 нь л өргөдөл, гомдлын үндсэн дээр хийгджээ.

Судалгааны багийн гишүүд Нийслэлийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн (НХЭАХН) дарга, ажилтнуудтай уулзаж ярилцлагын болон баримт бичгийн аргаар судалгаа хийсэн. Судалгааны явцад НХЭАХН-ийхэн зар сурталчилгаа үнэн бодитой байх хуулийн шаардлагыг хангахгүй байна, зар сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллагын талаар гомдол ирж байгаагүй гэж байв. Тус байгууллагад ирсэн 180 гомдолтой уншиж танилцахад нийт 8 гомдол зар сурталчилгааны дагуу очиж үйлчилгээ, бүтээгдэхүүн авсан гэж дурьдсан байлаа. Эдгээр гомдлын дагуу НХЭАХН тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулсан байгууллагаатай холбогдон торгох, бүтээгдэхүүнийг солих, буцаах, үйлчилгээний төлбөрийг буцаах гэж мэт арга хэмжээ авсан байна. Гэсэн хэдий боловч тухайн зар сурталчилгааг түгээсэн, бүтээсэн байгууллагаатай хариуцлага тооцох, хууль бус зар сурталчилгаа явуулсан гэсэн үндэслэлээр төрийн эрх бүхий байгууллагад хандсан тохиолдол байхгүй байна.

Нийслэл болон гурван аймгийн

хэмжээнд авсан анкетын асуулгаас харахад зар сурталчилгааны улмаас хохирсон үедээ иргэд ихэвчлэн зохих байгууллагад ханддаггүй, цөөхөн хувь нь мэргэжлийн хяналтын газар хандаж байсан байна. Өөрөөр хэлбэл, хяналт тавих гол субъект болох Оюуны өмчийн газарт хандаж байсан тохиолдол судалгаанд хамрагдсан иргэдийн дунд гарч байгаагүй байна.

3.3 Хамтын хяналт

Зар сурталчилгааны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Оюуны өмчийн улсын хяналтын алба энэ хуулийн 24.6, 25 дугаар зүйлд заасан этгээлтэй харилцан мэдээлэл солилцох, шаардлагатай хяналт, шалгалт, судалгаа хамтран явуулах зэргээр ажиллаж болно” гэж заасан байна. Өөрөөр хэлбэл, Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтэс төрийн хяналтыг хэрэгжүүлэгч дээр дурьдсан байгууллагууд болон олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэгч хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагаатай хяналтыг хамтран хэрэгжүүлж болохоор тусгасан байна.

Оюуны өмчийн газраас огссон мэдээлэлээр хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа өнгөрсөн 7 жилийн хугацаанд зар сурталчилгааны хуулийн хэрэгжилтийн асуудлаар Зар сурталчилгааны тухай хууль батлагдан гарсан жил буюу 2002 онд Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Монгол Улсын эрүүл мэндийн яам, Монгол Улсын байгаль орчны яам,

21 аймгийн Засаг даргал хуулийн шинэ зохицуулалтын талаар мэдэгдэж, холбогдох мэдээлэланах санал явуулж байжээ. Мөн 2006-2008 оны хооронд хуулийн нэмэлт, өөрчлөлтөд санал өгөх чиглэлээр 3-4 байгууллагатай харилцаж байсан байна. Үүнээс өөрөөр хуулийн хэрэгжилтийг хянах зорилгоор салбарын хяналт тавих эрх бүхий этгээд болон олон нийтийн байгууллагатай хамтарч ажиллан тодорхой үр дүнд хүрсэн мэдээлэл байхгүй байна.¹⁰ Иймд зар сурталчилгаанд тавигдах хамтын хяналт хэрэгжихгүй байна гэж дүгнэх үндэстэй байна.

ИРГЭН, ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЗАР СУРТАЛЧИЛГАА БА ГЭМ ХОРЫН АСУУДАЛ

Зар сурталчилгаа ба гэм хор сэдвийн хүрээнд асуудлыг иргэн, эрүүгийн эрх зүйд хэрхэн шийдвэрлэж болох, ямар асуудал тулгараад байгаа болон түүнийг хэрхэн сайжруулах талаар авч үзэх нь асуудлыг тал бүрээс нь бүрэн авч үзэх зарчимд нийцэж байгаа тул судалгааны баг хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох хууль тогтоомжид хийсэн судалгаа болон түүврийн аргаар хийсэн судалгааг энэ бүлэгт тусгасан болно.

4.1. Иргэний эрх зүйн дэх зар сурталчилгаа ба гэм хорын асуудал

Гэм хор гэдэг нь тодорхой этгээдийн эрх зөрчигдсөнөөс түнд бий болсон эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус сөрөг үр дагавар юм. Мөн түүнчлэн Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.3 дахь хэсэгт "Гэм хор учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд гэм хор учруулсан этгээд төдийгүй, түүнийг уруу татсан, дэмжин тусалсан, түүнчлэн гэм хор учруулсны үр дүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээнэ" гэж заасан. Үүнээс харахад үндэслэлтэй гэж үзвэл зар сурталчилгааг

захиалагч, бүтээгч, түгээгчийг зар сурталчилгаанаас үүдэлтэй гэм хорыг учруулахад хамтран оролцсон гэж үзэж нэгэн адил хариуцлага хүлээлгэж болохоор байна.

Зар сурталчилгаанаас үүсэх гэм хорыг тогтооход хялбар эсэх болон гэм хор учирсан субъектээр нь доорх байдлаар ангилж болохоор байна. Үүнд:

■ Тоогтооход хялбар буюу хувь этгээдэд учирсан гэм хор;

■ Тоогтооход хялбар биш, нийгэмд учирч буй гэм хор.

Тоогтооход хялбар буюу хувь этгээдэд учирсан гэм хор гэдэгт доорх зүйлсийг ойлгох үндэстэй. Үүнд:

• Эрүүл мэндээрээ хохирох (Арьсны өвчин судлалын үндэсний төв)/АӨСҮТ/-ийн эмч ажилтнуудтай уулзахад арьсны өвчнийг эмчилдэг "Б" гэх эмч, турах тос, гоо сайхны бүтээгдэхүүн мэтээс хүмүүс хордох, харшлах тохиолдол элбэг байгаа г.м);

• Эд хөрөнгө нь ууссан, гэмтсэн (Хөргөгч дуудлагаар засна гэсэн зарын дагуу хөргөгчөө засуулсан боловч бүр эвдэлсэн /ХЭАХН/);

• Сэтгэл ханамжгүй байдал үүссэн ("Гүшиг" их дэлгүүрээс Estee Lauder-ийн мөнгө, алтны хольцтой бүтээгдэхүүнийг үрчлээг 14 хоногийн дотор арилгана гэж рекламдсаны дагуу худалдан авч хэрэглэсэн боловч тухайн үр дүнг гарахгүй байгаа /ХЭАХН/);

• Бизнесийн нэр хүндээ алдах;

• Олох байсан ашиг, орлогоо алдах (ШӨХТГ-аас ШБӨХТХ-ын 101.1, 101.2 зөрчсөн дүгнэлтүүд);

• Бусад.

Тоогтооход хялбар биш, нийгэмд учирч буй гэм хор гэдэгт доорх гэм хорыг хамруулж үзэх боломжтой. Үүнд:

• Буруу, ташаа мэдээлэл цацах замаар төөрөгдөл бий болгох (Хадгаламж зээлийн хоршоо);

• Нийгэмд муу зуршил бий болгох (архи, тамхи, садар самууны

зар сурталчилгаа);

• Буруу үлгэр, жишээ үзүүлэх замаар буруу сэдэл төрүүлэх, хүүхдийн хүмүүжилд муугаар нөлөөлөх (буу барьсан хүүхэд, ээжийнхээ даашинзыг хайчлах);

• Бусад.

Ийнхүү гэм хорыг субъект, хамрах хүрээ, онцлог шинжээр нь ангилж авч үзэх нь гэм хорыг зөв үнэлэх, түүн дээрээ үндэслэн нэхэмжлэлийн шаардлагаа үндэслэлтэй гаргах, хууль хэрэгжүүлэх бусад тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд ач холбогдолтой байна.

Зар сурталчилгаанаас үүдэн гэм хор учирч байгаа эсэхийг тогтооход Арьсны өвчин судлалын үндэсний төв, НХЭАХН, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, НМХГ зэрэг газарт ирсэн өргөдөл гомдлууд, тэдгээрийг шийдвэрлсэн байдалтай уншиж танилцан, холбогдох ажилтан, албан тушаалтантай уулзаж ярилцлагын аргаар судалгаа хийсэн (дэлгэрэнгүй тайлнгаас харна уу).

Судалгаанаас дүгнэхэд зар сурталчилгаа нь хэрэглэгчийн тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгон хэрэглэх сэдлийг бий болгодог мөртлөө тэрхүү сонголтыг хийх болсон хүлээгдсэн үр дүнг бий болгодоггүй буюу үнэн бодитой биш зарын улмаас иргэд хохирсоор байгаа нь харагдаж байна. Харин иргэдэд Зар сурталчилгааны тухай хуулийн талаарх мэдээлэл өгөх, буруутай этгээдийг зөв олж тогтоон хуульд заасан хариуцлага хүлээлгүүлэхээр зохих байгууллагад хандуулдаг болгоход чиглэсэн шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Судалгааны баг 2009 оны 7 дугаар сарын 20-28-ны өдөр Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн архивт сууж 7 дүүргийн 2006-2008 онд шүүхээр шийдвэрлэсэн практикийг судлахдаа нийт 24497 хавтаст хэрэг

¹⁰ "Оюуны өмчийн газрын зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт таних үйл ажиллагааны чиглэлээр хийсэн ажлын талаархи мэдээлэл". Оюуны өмчийн газар. 2009 он.

уншсанаас Зар сурталчилгааны тухай хуультай шууд холбоотой 3 хэргийг шийдвэрлэсэн талаар дурдсан.

Эдгээр гурван хэргийн хувьд Зар сурталчилгааны тухай хуульд заасан олон нийтийн хяналтыг хэрэгжүүлж, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалан буруутай этгээдийг шүүхэд хариуцагчаар дуудсан нь дэвшилттэй байгаа хэдий ч иргэний эрх зүй талаасаа зар сурталчилгааны гэм хорыг тогтооход анхаарах олон асуудал байна. Үүнд:

Нэхэмжлэгчийн хувьд:

Зар сурталчилгааны тухай хуульд олон нийтийн хяналтыг хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага хэрэгжүүлж болохоор заасан байдаг. Ийнхүү заахдаа төрийн бус байгууллагад хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс шүүхэд нэхэмжлэл гаргах нэхэж гэсэн боловч энэ эрхийг хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд дурлаагүй. Гэсэн хэдий ч үндэслэлтэй гэж үзвэл хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгж шүүхэд нэхэмжлэл гаргаж болох эрх нь иргэний хуулийн дагуу нээлттэй байгаа юм. Дээрхи гурван хэргээс харахад бүх хэрэгт төрийн бус байгууллага нэхэмжлэгчээр оролцсон байна.

Хариуцагчийн хувьд:

Дээрх гурван хэрэгт нэхэмжлэгч зар сурталчилгаа түгээгчдийг хариуцагчаар татсан байдаг. Нэг зар сурталчилгааг хүлээн авагчид хүргэх явцад захиалагч, бүтээгч, түгээгч гэсэн 3 субъект оролцдог. Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "Хууль бус зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээхийг хориглоно" гэж заасан учраас гурван субъект гурвуулаа буруутайд тооцогдох боломжтой буюу гурвууланг нь хариуцагч байхаар нэхэмжлэл гаргах боломжтой. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Гэм хор

учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд гэм хор учруулсан этгээд төдийгүй, түүнийг уруу татсан, дэмжин тусалсан, түүнчлэн гэм хор учруулсны үрдүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээнэ" гэж заасан байдаг.

Нэхэмжлэлийн шаардлагын хувьд: Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "Шүүх энэ хуулийн агуулга, зарчимд нийцүүлэн энэ хуулийн 7 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр зар сурталчилгааг хууль бус гэж тооцож болно" мөн хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хэрэглэгчийн эрх ашгийг гүнчлэн зар сурталчилгаа бүтээх, түгээх үйл ажиллагаанд оролцогчийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага зар сурталчилгаанд хяналт тавих чиглэлээр дараахь эрх эдэлнэ: -хэрэглэгчийн нэрийн өмнөөс зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах" гэж заажээ. Дээрх гурван хэргийн хувьд нэхэмжлэлийн шаардлага гаргахдаа нийтлэгээр а) явуулж байгаа ил болон далд зар сурталчилгааг таслан зогсоох, б) албан тушаалтанд хуульд заасан хариуцлага ногдуулах гэсэн 2 шаардлагыг тавьсан байна. Энэ тохиолдолд тухайн зар сурталчилгааны улмаас учирсан шууд гэм хорыг тооцон гаргах, шалтгаант холбоог тогтоох нь хүндрэлтэй учраас мөнгөн хэлбэрээр гэм хорыг арилгах талаар нэхэмжлэх нь хүндрэлтэй байж болох юм. Гэхдээ нэхэмжлэлийн шаардлагыг хязгаарласан заалт Иргэний хууль, Зар сурталчилгааны тухай хууль болон бусад хуульд байхгүй учраас тухайн төрийн бус байгууллага тэрхүү зар сурталчилгааны эсрэг (жишээ нь архины хэрэглээг багасгах, хор

уршгийг тайлбарласан) зар сурталчилгаа явуулахад гарах зардлыг нэхэмжилж болох юм.

4.2. Эрүүгийн эрх зүй дэх зар сурталчилгаа ба гэм хорын асуудал

Монгол Улсын Эрүүгийн хуульд хууль бус зар сурталчилгааг эрүүгийн гэмт хэрэгт тооцох тусгайлсан зүйл, заалт байхгүй. Харин дараах үйлдлүүдийг сурталчилсан тохиолдолд нийгэмд аюултай гэж тооцон гэмт хэрэгт тооцож болохоор тусгайлан заажээ. Үүнд: Садар самууныг сурталчлах (123), Шашны харгис үзэл номлол сурталчлах, тараах (144), Терроризмыг сурталчлах (178) Дайныг сурталчлах, уриалах (298) зэргийг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Мөн зарим төрлийн хэргийн объектив талын шинжид сурталчилсан үйлдлийг гэмт хэрэгт тооцож болохоор байна. Тухайлбал: Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлд "Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны үзэл номлолоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх зорилгоор ухуулга, сурталчилгаа явуулсан... бол, " 156² дугаар зүйлд "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхэлсэн, өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийсэн..."¹², 169 дүгээр зүйлд "Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллагын ажилтан... бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэл өгөх, хуурамч зар сурталчилгаа явуулах зэргээр хэрэглэгчдийг хуурч мэхэлсэн, төөрөгдүүлсний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол тус тус эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилжээ.

2007 оноос 2009 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн Садар самууныг сурталчлах(123), Шашны харгис

¹¹ Эрүүгийн хуулийн 84 дүгээр зүйл "Үндэсний эв нэгдлийг бусниулах".

¹² Эрүүгийн хууль 156 дугаар зүйл "Хоршооны тухай хууль тогтоомж зөрчих".

үзэл номлол сурталчлах, тараах (144), "Терроризмыг сурталчлах (178) Лайныг сурталчилах, уриалах (298) гэмт хэрэг цагдаагийн байгууллагад нэг ч бүртгэгдээгүй байна.¹³

4.2.1. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зар сурталчилгааны эрх зүйн орчин

Хүн худалдаалах гэмт хэргээс (ХХГХ) урьдчилан сэргийлэхэд зар сурталчилгааны эрх зүйн орчин чухал үүрэгтэй. Учир нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх урьдах нөхцөл нь зар сурталчилгаа болдог байна. Өөрөөр хэлбэл, зар сурталчилгааны хяналтгүй байдлыг давуу талаа болгон гэмт хэргийн хохирогчид болон гэмт үйлдэлдээ ашиглах бичиг баримтыг зарын дагуу олж авдаг нь тогтоогджээ. Үүнд нэг жишээг татвал:

2004-2007 онд шийдвэрлэгдсэн нийт 17 ХХГХ-ийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоож графикт үзүүлсэн байна.¹⁴

Мөн дээрх хэргүүд үйлдэгдэхэд нөлөөлсөн зар сурталчилгааг түгээсэн байгууллагуудыг ямар нэгэн байдлаар хэрэгт хамааруулан шалгаагүй, хариуцлага хүлээлгээгүй. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд ЭБШХ-ийн 80 дугаар зүйл 80.1.6-д заасан гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг нотлох хүрээнд хууль бус зар сурталчилгааг түгээсэн байгууллагад хариуцлага тооцдог болох нь чухал ач холбогдолтой болно.

ХХГХ-ээс зар сурталчилгаа талаас нь урьдчилан сэргийлэх талаар Садар самуун явдалтай тэмцэх тухай, Зар сурталчилгааны тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Эрүүгийн хуульд хангалттай тодорхой заалт байгаа боловч хэрэгжилт нь тэр болгон үр нөлөөгүй байна (2007 оноос 2009

оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйл "Садар самууныг сурталчлах" гэмт хэрэг цагдаагийн байгууллагад нэг ч бүртгэгдээгүй байна¹⁵).

Судалгааны хамрах хүрээнээс шалтгаалан урьдчилан сэргийлэх явдлыг нийслэлд болон судалгаа хийсэн орон нутаг гэж хуваасан болно.

Нийслэлд

Нийслэлийн хэмжээнд хууль бус зар сурталчилгаа түгээх явдал нь хамгийн түгээмэл бөгөөд ингэхдээ ТВ чат, зар мэдээллийн сонинг ашиглаж байна. ХХГХ-ийн гаралтын байдлыг авч үзэхэд нийслэл хотод үйлдэгддэг бөгөөд үүнд зар сурталчилгаанд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын болон аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл олгодог байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцох, хамтран ажиллах зэрэг ажиллагаа огт хийгддэггүй нь нөлөөлдөг ажээ. ХЗҮХ-ийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн сектороос 2009 оны 8 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан "Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт" сэдэвт уулзалтад оролцогсдын хэлснээр хууль бус зар сурталчилгааны эсрэг тодорхой арга хэмжээ авдаг боловч үр дүн муутай байдагт бүгд санал нэгтгэж байсан юм. Мөн шүүгч нартай хийсэн уулзалтад оролцсон нэгэн шүүгч хэлэхдээ: "ТВ чатаар хүүгээ захиалга өгч алуулсан гэх хэрэг буюу "чагын эмээгийн" хэрэг гэж нэрлэд байгаа хэрэг дээр прокурор хяналт тавихдаа чатаар тэр зарыг нэвтрүүлсэн телевизийг хариуцлагад татах ёстой байсан. Тэгсэн бол бусад мэдээллийн хэрэгсэл тодорхой хэмжээгээр сургаж болох байсан байх гэж

бодож байна."¹⁶ гэснийг зориуд тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

Орон нутагт

Дээр дурьдсанчлан судалгаанд хамрагдсан орон нутгийн хэмжээнд хууль бус зар сурталчилгаа бага байгааг хэлэхийн сацуу Эрдэнэт хотод туршилтын аргаар хийсэн судалгааг дурдахыг хүсэж байна. Зар сурталчилгаанд тавих хяналт хэлийгээр харьцангуй сайн байгаа гэж хэлж болох боловч авч буй зарим арга хэмжээ, нийслэлд бэлтгэгдэн түгээгдэж буй мэдээллээс (зарын сонин, орон даяар цацагдаж байгаа арилжааны телевизүүд) шалтгаалан тэр болгон үр дүнд хүрэхгүй байна. ТВ чатаар дамжуулж биеэ үнэлэх явдал нарийссан, өөрөөр хэлбэл, садар самуунд уруу татсан үг хэллэгтэй бичмэл зарыг ТВ чатаар нэвтрүүлэхдээ текстийг дардаг боловч дугаарыг нь гаргаж байгаа нь учир дутагдалтай. Текстийг дарах нь "Санхүүгийн тусламж өгнө, авна" гэх мэт зүй бус зар болох сэдэл төрүүлж дугаар руу нь залгаж уулздаг байна.

4.2.2. Хүн худалдаалах гэмт хэргэ үйлдэгдэхэд зар сурталчилгаа нөлөөлж буй оноогийн нөхцөл байдал

Судалгааны явц, судалгаанд оролцсон байдлыг харахад ХХГХ хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй зар сурталчилгааны гол цөм нь "нийслэл Улаанбаатар"-т байна гэж дүгнэж болохоор байна. Мэдээ, мэдээлэл хурдацтай тархахын хэрээр хууль бус зар сурталчилгаа ч тэр хэрээр тархана. Үүнд нэг жишээ татахад орон нутагт амьдарч байгаа иргэдийн сэтгэхүйд нийслэлд ажлын байрны эрэлт их байдаг гэсэн бодлыг тэндээс бэлтгэн хүргэж байгаа "аливаа мэдээлэл" маш хүчтэй нөлөөлжээ. Энэ явдалд орон нутгийн захиргааны байгууллага хяналт

¹³ Улсын хэмжээнд бүртгэгдсэн 2007-2009 оны эхний 7 сард бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ 2009.8.5 ЦЕГ-ын мэдээлэл, судалгааны төл.

¹⁴ ХЗҮХ-ийн ЭЭЗКС-ын эрдэм шинжилгээний ажилтнуудын хийсэн судалгаа. 2009 он.

¹⁵ Улсын хэмжээнд 2007-2009 оны эхний 7 сард бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ 2009 оны 8 дугаар сарын 5-н ы өдөр. ЦЕГ-ын мэдээлэл, судалгааны төл.

¹⁶ 2009 оны 8 дугаар сарын 21-нд ХЗҮХ-ийн ИЭЗЭЗС-оос зохион байгуулсан "Зар сурталчилгаа ба гэм хор" сэдэвт уулзалт ярилцлагын тэмдэглэл.

тавих боломжгүй байгаа юм. ХХГХ үйлдэхэд нөлөөлж болох зар сурталчилгаа болон бусад сөрөг мэдээлэл дараах хэлбэрээр нийгэмд хүрч байна.

- Зар мэдээллийн сониноор;
- Телевизийн эфирээр (ТВ чат);
- Интернетээр;
- Тусгай дугаарын утас.

Дээрх хэлбэрүүдээс хамгийн өргөн хүрээтэй нь зарлал мэдээллийн сонин, телевизийн хэрэгсэл гэж үзэж байна. Энэ нь дараах энгийн үндэслэлээр тайлбарлагдана.

1. Өнөө цагт нийслэлд айл болгон телевизортой. Монгол Улс даяар цацаж буй суваг болгоныг ихэнх өрх үзэж байгаа. Судалгаа явуулах хугацаа оюутан сурагчдын зуны амралтын цаг таарсан нь онцлог байсан бөгөөд, хичээлийн шинэ жил эхлээд ТВ чатаар "үйлчлүүлэгчдийн" тоо эрс өсөх нь мэдээж юм. Олон эцэг, эхийг хэцүү байдалд оруулж байгаа зүйл бол ТВ чат. Үүнд холбогдох боломжоор хангагдсан ямар ч насны хүүхэд эцэг эх нь ч төсөөлж байгаагүй бэлгийн харьцааны ил задгай, бүдүүлэг, садар самуун явдал харуулсан үгсийг олж үзэхээр болсон байна. Үүнээс үзэхэд ТВ "чат" нь садар самууныг сурталчилж байгаа нэгэн эх сурвалж болж байгааг хэлэхийн сацуу өөрөө тухайн телевизийн санхүүгийн боломжоо зузаатгах нэг гол суваг нь болж байна гэдгийг бидний хийсэн судалгаанаас гадна НХХЯ-ны судалгаа харуулж байна.¹⁷

Түүн дотроос ТВ8 телевизийн ТВ чатыг жишээ болгон авч үзвэл: ТВ8-телевизийн "чат" нь уг сувгийн бүх мэдээллийн 38.4%-ийг эзэлж байгаа ба нэвтрүүлэг нь өдөр бүр гардаг. Өдөр, орой гэсэн байдлаар хоногт дунджаар 8 цаг орчим гардаг байна.

Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болсон өнөө үед төр

засагтаа, ард иргэддээ хандсан, цаашлаад юу хүссэнээ илэрхийлсэн, уриалсан, шаардсан, бүр сексийн хамтрагч хайсан, ивээн тэтгэхээ амласан, биеэ үнэлэхээ ичгүүр сонжуургүй илэрхийлсэн олон арван санал хүсэлт телевизийн сувгууд, ТВ "чат" хэмээх нэвтрүүлгээр цацагдах болсон. Гэтэл заримдаа манай залуучуудад үзэл бодлоо хэтэрхий чөлөөтэй илэрхийлэх боломжийг ЧАТ нэвтрүүлгүүд олгож байна.¹⁸

2. "Зар мэдээ" сониндөгсөн "20-25 насны охидыг Япон, Солонгост өндөр цалинтай ажилд яаралтай зуучилна"¹⁹ гэсэн зарын идэвхитэй үргэлжлэх хугацаа нь ТВ зарыг бодвол харьцангуй удаан, ойролцоогоор 5 хоног буюу дараагийн зар гарах хүртэл үргэлжилдэг байна. Үүнтэй зэрэгцэн гадаадад гэр бүлээр нь зуучлах, виз гаргах, визтэй гадаад паспорт зарах гэх мэт хууль бус заруудын үйлчлэх хугацаа ч уртсаж байгаа нь ойлгомжтой юм. Дээрх сонинд өгсөн зарын дагуу нийт 36 дугаараас 38 эмэгтэй холбогдсон бөгөөд зөвхөн 3 хүн ХХГХ биш биз гэж асуусан бол 2 хүн очоод биеэ үндэлхийг шууд хүлээн зөвшөөрсөн.

ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ 5.1. Дүгнэлт

Судалгаанаас харахад хууль бус зар сурталчилгаа нь нийслэлд хамгийн хүчтэй байна гэж дүгнэж болохоор байна. Нийслэл дэх хэт төвлөрөл, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа муу байгаагаас зар сурталчилгаанд тавих хяналт сул байна. Мөн телевиз, сонин, хэвлэл гэх мэт нийслэлд үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагад тавих зар сурталчилгааны хяналт муу байснаас эдгээр нь орон даяар цацагдах боломжийг бүрдүүлж

байна. Жишээ нь, Орхон аймагт (Эрдэнэт хотод) зар сурталчилгаанд тавих хяналт Дорнод, Дорноговь аймагтай харьцуулахад сайн байгаа боловч гэдний хяналтын хүрээ орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар хязгаарлагдаж байгаа учраас нийслэлд үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагын хууль бус зар сурталчилгаа хяналтгүй цацагдаж байна.

ЗСТХ-д хууль бус зар сурталчилгаа бүтээх, түгээх, захиалахыг хориглосон байдаг. Хуулийн энэ хориглосон хэм хэмжээ "Зар сурталчилгааны үнэн бодит байдлыг зарлуулсан байгууллага, хувь хүн бүрэн ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагын хууль бус зар сурталчилгаа хяналтгүй цацагдаж байна.

"Зар сурталчилгаа ба гэм хор" сэдвийн хүрээнд хийсэн судалгаанаас харахад зар сурталчилгааны эрх зүйн орчинг цаашид боловсронгуй болгох шаардлага байгаа нь харагдаж байна. Үүнд:

- Зар сурталчилгааны хууль дотроо болон бусад хуультай давхардсан, зөрчилдсөн, хийдэлтэй байгаа;

- Зар сурталчилгааны нэр томъёо хуулиудад өөр өөрөөр тусгагдсан;

- Хууль зөрчигчид хүлээлгэж байгаа хариуцлага нь хууль зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, буруутай этгээлийг цээрлүүлэх үүргээ гүйцэтгэж чадахгүй, хангалтгүй байгаа;

- Зар сурталчилгааны хяналт хангалттай биш, хяналт тавих албан тушаалтны тоо бага, байгууллага хоорондын уялдаа холбоо муу;

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус

¹⁷ Хүүхдийн хүмүүжилд үзүүлэх хэлэл мэдээллийн сөрөг нөлөөлөлд хийх судалгааны тайлан НХХЯ. ИҮБ-ын Хүүхдийн сан. Улианбаатар хот. 2008 он. 18 дахь тал.

¹⁸ Дурдсан судалгаа 17 дахь тал.

¹⁹ "Зар мэдээ" сонин 2009.8.28 №63(1238) дугаар 10 дахь тал. Зарын дугаар 358.

байгууллагын мэдлэг, идэвх сул байгаа зэрэг нь харагдаж байна.

Гэхдээ судалгааны явцад зар сурталчилгааны тухай хууль зохицуулах шаардлагатай харилцаагаа хамруулж чадсан, харилцаанд оролцогчдыг зөв ангилан эрх, үүргийг нь ялгамжтай тогтоосон зэрэг сайн тал харагдаж байна. Үүний зэрэгцээгээр хууль хэрэгжүүлэх явцад цагдаагийн байгууллага ТВ чаттай эрчимтэй тэмцлийн дүнд бодитой ахиц гарсан, зарим нэг төрийн бус байгууллагаас хэрэглэгчийн нэрийн өмнөөс буруутай этгээдийг шүүхэд өгөх замаар олон нийтийн хяналтыг тодорхой түвшинд хэрэгжүүлсэн сайн талууд байна.

5.2. Санал, зөвлөмж

Судалгааны явцад тогтоогдсон байдлыг үндэслэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлт, хуулийн бислэлтийг хангах арга хэмжээ гэсэн 2 дэд хэсгээр санал зөвлөмжийг бичлээ.

САНАЛ

Хууль тогтоомжийн хүрээнд:

Зар сурталчилгааны тухай хуульд:

21 дүгээр зүйл. Зар сурталчилгаанд хамаарах мэдээллийг шаардах

21.1. Зар сурталчилгаа бүтээгч, түгээгч тухайн зар сурталчилгаа үнэн зөв болохыг нотлох баримтыг зар сурталчилгаа захиалагчаас шаардах эрхтэй.

21.3. Зар сурталчилгаа бүтээгч, түгээгч нь энэ хуулийн 21.2-т заасан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ буюу зохих ёсоор баталгаажсан баримт үзүүлэхийг шаардах эрхтэй.

21.6. Энэ хуулийн 21.1-д заасны дагуу шаардсан нотлох баримтыг гаргаж өгөөгүй бол зар сурталчилгаа бүтээгч, түгээгч холбогдох гэрээг цуцалж, өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэхийг захиалагчаас шаардах эрхтэй.

Үндэслэл: Зар сурталчилгааны эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг хуульд тусгахдаа бүтээгч, түгээгчийн эрх, үүргийг

хольж, солин алдаатай зохицуулалт оруулсан байна. Хуулийн дээрх заалтуудад эрхтэй биш үүрэгтэй гэж оруулах нь илүү зохимжтой байсан гэж судлаачид үзэж байна. Аливаа хуулиар олгогдсон эрхийг тухайн этгээд эдлэх болон эдлэхгүй байх эрхтэй. Өөрөөр хэлбэл эрхээ эдлээгүйн төлөө хариуцлага хүлээдэггүй. Харин хуулиар ногдуулсан үүргээ гүйцэтгээгүйн төлөө хариуцлага хүлээдэг. Гэтэл дээрх заалтуудын хувьд үүрэгтэй биш харин эрхтэй гэж тодорхойлсноор зар сурталчилгаа бүтээгч, түгээгч тухайн зар сурталчилгаа үнэн зөв болохыг нотлох баримт болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ буюу зохих ёсоор баталгаажсан баримтыг зар сурталчилгаа захиалагчаас шаардахгүй байж болно. Тийнхүү шаардаагүйнхээ төлөө хуулийн хариуцлага хүлээхгүй. Харин шаардсан тохиолдолд тухайн баримтыг захиалагч гаргаж өгөөгүй бол зар сурталчилгаа бүтээгч, түгээгч холбогдох гэрээг цуцлах эсэх нь мөн л эрхийн асуудал. Тэгэхээр дээрх заалтуудын эрхтэй гэдэг үгийг үүрэгтэй гэж сольсноор хуулийн хэрэгжилт илүү сайжрах, хариуцлагыг тодорхой болгох ач холбогдолтой байна.

22 дугаар зүйл. Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчиж болох нөхцөл байдлын талаар урьдчилан мэдэгдэх

22.1. Зар сурталчилгаа бүтээгч, түгээгч нь зар сурталчилгаа захиалагчаас өгсөн захиалга, даалгаврыг зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчиж байгааг түүнд урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

22.2. Энэ хуулийн 22.1-д заасны дагуу урьдчилан мэдээлсэн боловч зар сурталчилгаа захиалагч өөрийн захиалга, даалгаврыг өөрчлөөгүй тохиолдолд зар сурталчилгаа бүтээгч, түгээгч нь зар сурталчилгаа бэлтгэх, түгээхээс татгалзах үүрэгтэй.

Үндэслэл: ЗСТХ-ийн уг заалтыг

өөрчлөлт ороогүй байдлаар нь хэрэглээл зар сурталчилгаа захиалагч нь өөрөө зар сурталчилгаагаа бүтээхчлээл түгээгч нь урьдчилан сануулах үүрэг хүлээхгүй шууд түгээж болохоор байна. Мөн ХЗҮХ-ийн ИЭЗЭЗС-ын 2009 оны 6 дугаар сарын 28-нд зохион байгуулсан зар сурталчилгаа бүтээгчидтэй хийсэн уулзалтад оролцсон зар сурталчилгаа бүтээгч (Рекламын ассоциацийн захирал асан): “Реклам бүтээх нь тийм ч хортой зүйл биш. Харин түгээгээд нийтэд мэдээлэл болж очих нь хамгийн чухал байдаг. Хичнээн бүтээсэн ч түгээхгүй бол үр дагавар үүсэхгүй. Тэгээд ч энгийн бичгэн зар нийтлүүлэхэд бүтээх гэсэн ойлголт байхгүй”²⁰ гэсэн байна.

24 дүгээр зүйл. Төрөөс зар сурталчилгаанд тавих хяналт

24.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгаанд тавих хяналтыг Оюуны өмчийн улсын хяналтын аяба хэрэгжүүлнэ.

Судалгааны баг төрөөс зар сурталчилгаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг худалдаа, аж үйлдвэрийн салбарын төрийн захиргааны байгууллагын бүтэцд оруулан хуульчлах нь илүү нийцтэй гэж үзэж байна. Учир нь зар сурталчилгаа нь дийлэнхдээ худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн чиглэлээр явагддагаас гадна энэ чиглэлийн төрийн байгууллага хяналтыг илүү бодитой, өргөн хүрээг хамарсан байдлаар хийх боломжтой гэж үзлээ.

24.3.4. Зар сурталчилгааны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 14 хүртэлх хоногоор түдгэлзүүлэх, ажуул-цуцлах саналыг уг зөвшөөрлийг олгоосон эрх бүхий байгууллагад тавих;

Үндэслэл: Нэгэнт ЗСТХ-иар Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагч хяналт тавина гэж заасан учраас тэрхүү хяналтаа бүрэн утгаар нь тавих хэрэгтэй. Үз

²⁰ ХЗҮХ-ийн ИЭЗЭЗС-ийн зохион байгуулсан “Зар сурталчилгаа бүтээгч” уулзалт ирилцлагын тэмдэглэл, 2009.6.28

хуулийн хариуцлагын хамгийн дээд хэмжээ болох үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл цуцлах саналыг уг зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллагад тавих гэсэн заалт хууль батлагдсанаас хойш биелэж байгаагүй. Жишээ нь: “Хүн худалдаалах гэмт хэрэгт зар сурталчилгаа нөлөөлж буй байдал” сэдэвт ХЗҮХ-ийн ИЭЗЭЭС-ээс зохион байгуулсан уулзалт, ярилцлагад (2009.8.26) оролцсон ОӨГ-ын Хяналт шалгалтын хэлтсийн дарга “Санкц нь торгуулийн арга хэмжээ, давтвал үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх саналыг гаргана гэсэн заалт байдаг. ХХЗХ (Харилцаа холбооны зохицуулах хороо) тусгай зөвшөөрөл олгодог. Бид 2009.2.16-ны өдөр ХХЗХ-роонд албан тоот явуулсан. 9 телевизийн үйл ажиллагааг цуцлах санал тавихад 6 сар болоход хариу ирээгүй л байна.”²¹ гэжээ. Энэ мэт байдлууд нь хууль хэрэгждэггүй, үр нөлөөгүй байдлуудыг бий болгож байгаа ба нэмж өөрчилсөн хувилбар нь хариуцлагын арга хэмжээг үр нөлөөтэй болгоно гэж судалгааны баг үзсэн болно.

24.4. Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагч нь Төрийн хяналт-шалгалтын тухай хуулийн 21-дүгээр зүйлийн 9-дэх хэсэгт-зөвшөөрөгчид дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

Үндэслэл: Төрийн хяналт шалгалтын тухай хууль²² нь анх 1995 оны 3 дугаар сарын 27-ны өдөр анх батлагдахдаа 7 бүлэг 27 зүйлтэй УИХ-аар батлагдсан байдаг. Харин 2003 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар хүчингүй болсон бөгөөд шинээр батлагдсан Төрийн хяналт шалгалтын тухай²³ хууль нь 4 бүлэг 16 зүйлтэй батлагдсан байна. Тийм учраас одоогийн уг хуульд 21 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг гэсэн заалт байхгүй.

29 дүгээр зүйл. Захиргааны хариуцлага

29.1.2. Энэ хуулийн 6.1, 6.3, 6.4 дэх хэсэгт, 6.5-1-6.5-8-дахь заалт, 7 дугаар зүйл, 9.3 дахь хэсэг, 10-14, 14, 16, 17 дугаар зүйл, 19.3, 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчсөн бол гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж хуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох.

Үндэслэл: Дээрх хасахаар санал болгож байгаа заалтууд нь хууль бус зар сурталчилгааг захиалах, бүтээх, түгээх харилцааг зохицуулж байгаа учир тусад нь авч үзэх хэрэгтэй гэж үзэж байна. Хуулийн хариуцлага буюу торгууль оногдуулахдаа харилцааны энэ хэсгийн онцлогийг харгалзан ялгамжтай зохицуулах шаардлагатай гэж судалгааны баг үзлээ. Жишээ нь, Сонинд өгсөн хууль бус зартай холбоотой маргааныг шийдвэрлэхдээ зөвхөн 250000 төгрөгөөр торгоод өндөрхөх бус зарыг хэдэн төгрөгөөр нийтэлсэн, сонин хэдэн хувь хэвлэгдсэн зэргийг харгалзан торгуулийн хэмжээг тогтоох нь хууль бус зар сурталчилгааг түгээхээс урьдчилан сэргийлэхэд томоохон хүчин зүйл болно.

29.1.3. Энэ хуулийн 6.5.1-6.5.8 дахь заалт, 7 дугаар зүйл, 9.3 дахь хэсэг, 10-14, 14, 17 дугаар зүйлд заасныг зөрчсөн бол тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хурааж, гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох.

Үндэслэл: ЗСТХ нь 2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан ба 2009 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өөрчлөлт оржээ. Инхүү өөрчлөлт оруулахдаа хууль тогтоомж

зөрчигчид хүлээлгэх хариуцлага бүлэг дэх торгуулийн хэмжээг огт “хөндөөгүй” байна. ЗСТХ батлагдахад Засгийн газрын 2000 оны 108 дугаар тогтоолд нэг цагийн хөдөлмөрийн холсний хэмжээ 146 төгрөг 45 мөнгө байжээ. Үүнийг ажлын 8 цагт үржүүлвэл одоот 1171 төгрөг 60 мөнгө болно. Нэг сард дунджаар ажлын 21 өдөр байдаг гэж тооцвол сарын хөдөлмөрийн холсний доод хэмжээг 24603 төгрөг 60 мөнгө байхаар байна. Энэ нь одоогийн мөрдөж буй хөдөлмөрийн холсний доод хэмжээ болох 108000 төгрөгтэй харьцуулбал 4,3 дахин бага юм. Эдийн засгийн өсөлт бууралт, мөнгөний ханш, инфляци зэргийг харгалзахгүйгээр торгуулийг ингэж тодорхой тогтоох нь буруу юм. Харин судлаачдын зүгээс санал болгож байгаа “үйл ажиллагаанаас олсон орлого” гэдэг үг нь эдийн засгийн өсөлттэй тохирно гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, зар сурталчилгааны үнэ тариф өсвөл хууль бус зар сурталчилгааны торгуулийн хэмжээ дагаж өснө гэсэн үг. Үүнд жишээ татвал: ХЗҮХ-ийн ИЭЗЭЭС-ийн 2009 оны 5 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан “Зар сурталчилгаа түгээгч”-тэй хийсэн уулзалт ярилцлага дээр нэгэн телевизийн Бизнес төлөвлөлт, Маркетингийн албаны дарга: “Архи согтууруулах ундаа үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүд рекламьг нь гараахгүй гэхээр торгуулийг нь бас огно гэдэг. Бас нэг хэцүү зүйл нь MCS компани нь олон охин компанитай. Тэдний нэг болох “Спирт бал бурам” компаних нь архийг сурталчлахгүй гэхээр бусад охин компаниудынхаа зар сурталчилгааг бидэнд өвөлгүй зогсоочихдог. Тийм учраас 250 000 төгрөгийн торгууль хэт бага байна. Чангатах хэрэгтэй.”²⁴ гэсэн бол 2009 оны 5 дугаар сарын 14-нд зохион байгуулсан их, дээд сургуулийн багш судлаачидтай хийсэн уулзалт дээр

²¹ ХЗҮХ-ийн ИЭЗЭЭС-ийн зохион байгуулсан “Хүн худалдаалах гэмт хэрэгт зар сурталчилгаа нөлөөлж буй байдал” сэдэвт уулзалт, ярилцлагын тэмдэглэл. 2009 оны 8 дугаар сарын 26-ны өдөр.

²² “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 1995 он. №4.

²³ “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2003 он. №3.

²⁴ ХЗҮХ-ийн ИЭЗЭЭС-ийн зохион байгуулсан “Зар сурталчилгаа түгээгч” сэдэвт уулзалт, ярилцлагын тэмдэглэл 2009.5.21

МУИС-ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш Д.Энхзүл “Зар сурталчилгааны эрх зүйн орчин тухайн харилцааныхаа бодит хошжлийг гүйцэхгүй байна. Олон жилийн олно баталсан хуулийн 250 000 тогрогийн торгууль оногдуулах тухай заалт одоо ямар ч нолоогүй болсон байна. Тиймээс тухайн байгууллагын тодорхой хугацааны орлогын тодорхой хувиар оногдуулах гэх мэт заалтыг оруулах хэрэгтэй байна.”²⁵ гэжээ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль:

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл

15.7. Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр:

15.7.7. Гадаад улсын еронхий боловсролын сургууль, их сургууль, дээд сургууль, коллеж, хэлний курс, мэргэжлийн курс, зуучлан суралцуулж

Үндэслэл: Сүүлийн үед гадаадад явж суралцах сонирхолтой хүний тоо эрх нэмэгджээ. Зар мэдээллийн сонинд ч энэ төрлийн зарын эзлэх хувь өссөөр байна. Суралцахын хажуугаар ажиллах боломжтой гэсэн нь анхаарал татаж байгаа юм. Ийнхүү суралцуулах нь тодорхой гэрээний үндсэн дээр хийгдэх нь мэдээж юм. Үүнийг мөн л бүртгэлжүүлэх шаардлагатай байна.

15.9. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

15.9.2. Гэр бүл, зуучлалын үйлчилгээ эрхлэх

Үндэслэл: Судалгаагаар тогтоосон зүйлийн нэг нь гэр бүл зуучлалын үйл ажиллагааг ямар нэгэн байдлаар зохицуулсан хэм хэмжээ одоогоор байхгүй байна. Гэр бүл зуучлал болон танилцуулах үйл ажиллагааг хариуцсан торийн ямар нэг байгууллага байдаггүй бөгөөд иргэд хувийн шугамаар, танил талаараа энэ “ажиллагааг”

явуулдаг байна. Мөн “Гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучилла. Гадаадын иргэнтэй гэр бүл болно” гэсэн зар нь хувь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудал учир шууд хориглох боломжгүй юм. Харин түүнд нь хяналт тавьж бүртгэлжүүлэх нь энэ төрлийн зар сурталчилгааг хяналттай болгоно. Гэхдээ үүнийг Иргэний эрх бүлийн бүртгэлээс ялгаж үзэх хэрэгтэй. Гэр бүл бол нийгмийн анхан шатны нэгж бөгөөд харьцангуй удаан тогтвортой үргэлжлэх харилцаа байдаг. Үүнийг ХХГХ-т ашиглаж байгаа нь ажиглагддаг. Одоогоор яг энэ зараас болж шийдвэрлэгдсэн хэрэг байхгүй байна. Цаашид гарч болохыг үгүйсгэхгүй юм. Гэр бүлийн асуудал нь нийгмийн хамгааллын салбарт хамаардаг учир тухайн чиглэлийн яамны хариуцах асуудлын хүрээнд багтах нь зүйтэй болов уу. Одоо мөрдөгдөж буй “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай”²⁶ хуульд нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зөвшөөрөл олгодог нэг харилцаа (үйл ажиллагаа) байна.

Гэр бүлийн тухай хууль:

5 дугаар зүйл. Гэр бүлийн эрхийг хамгаалах

5.3. Төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр гэр бүл зуучлалын үйл ажиллагаа эрхлэх, зар сурталчилгаа явуулахыг хориглоно.

Үндэслэл: Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах саналтай холбогдуулан гэр бүлийн харилцааг тусгайлан зохицуулсан хууль “Гэр бүлийн тухай”²⁷ хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай болж байна. Ингэж өөрчлөлт оруулах нь тухайн харилцааг зохицуулж буй хэм хэмжээний уялдаа холбоог сайжруулах ач холбогдолтой юм.

Бусад:

• Гадаадад бүтээгдсэн зар сурталчилгаанд тодорхой

хязгаарлалт тогтоох;

• Телсвиз, радиогийн зар сурталчилгааны хугацаанд тухайн өдрийн нийт нэвтрүүлгийн тодорхой хувиас илүүгүй байна гэсэн хязгаарлалт тогтоох;

• Тухайн төрлийн зар сурталчилгаатай холбоотой зөрчил илэрсэн болон шүүхэд нэхэмжлэл гарсан тохиолдолд бүтээгч, түгээгч, захиалагчдыг хамтран хариуцагчаар оруулах;

• Тодорхой төрлийн зар сурталчилгаанд тавигдах шалгуур үзүүлэлтийг албан ёсоор баталж мөрдүүлэх.

ЗӨВЛӨМЖ

Төрийн байгууллагуудын хүрээнд

Зар сурталчилгааны харилцаанд хяналт тавих үүрэг бүхий төрийн байгууллагууд нь харилцан мэдээлэл солилцох, хуулиар олгогдсон эрхийн хүрээнд арга хэмжээг авч хэвших нь хамтын ажиллагааны эхлэл болох юм. Үүнд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгосон байгууллагууд тусгай зөвшөөрлийн тухай иргэдэд дэлгэрэнгүй мэдээлэх, улмаар зар сурталчилгаа түгээдэг аж ахуйн нэгжид хүргүүлэх зэрэг ажлыг хийж болно. Жишээ нь: НХХЯ-аас гадаадад ажиллах хүч илгээх чиглэлээр хичнээн аж ахуйн нэгж зөвшөөрөл авсан. Одоо ямар аж ахуйн нэгж хичнээн ажлах хүч гаргах гэж байгаа зэргийг хэвлэл мэдээллийн байгууллагад тогтмол өгөх нь хууль бусаар (тусгай зөвшөөрөлгүй) гадаадад ажилл зуучлах, ХХГХ-т өртөхөөс урьгчилан сэргийлэх ажлын нэгэн хэлбэр болно.

Хэрвээ гэмт хэрэг гарахад хууль бус зар сурталчилгаа нөлөөлсөн бол ЭБШХ-ийн 80 дугаар зүйл, 190 дүгээр зүйлд тус тус заасан хэм хэмжээ баримтлан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуророос тодорхой арга хэмжээ авдаг болох

²⁵ ХЗҮХ-ийн ИЭЗЭЗС-ийн зохион байгуулсан “Зар сурталчилгаа ба гэм хор” сэлэнг уулзалт, ирилцлагын гэмдэгчид 2009.5.14

²⁶ “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2001 он. №6

²⁷ Гэр бүлийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 1999 он. №30.

нь чухал ач холбогдолтой болно. Учир нь ийм төрлийн арга хэмжээг авч шийдвэрлэж байсан тохиолдол байдаггүй байна.

Мөн хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнуудын зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн мэдлэгийг сайжруулах, хууль бус зар сурталчилгааг "өргөн хүрээнд" ойлгуулах шаардлагатай байна.

Төрийн бус байгууллага, иргэдийн хувьд:

Судалгааны явцад ажиглагдсан зүйл нь Зар сурталчилгааны тухай хууль, холбогдох бусад хуулийн хүрээнд ХХГХ гэж юу болох, хэрхэн зүйлчилж шийдвэрлэх зэргээр хууль хяналтын байгууллагуудын

ажилтнуудад сургалт сурталчилгаа явуулж байгаа нь сайшаалтай боловч нөгөө талаар учир дутагдалтай байна. Учир нь ХХГХ үйлдэгдсний дараа хэрэгжүүлэх алхмын тухай ойлголт өгч байгаа болохоос бус хууль бус зар сурталчилгаа ХХГХ үйлдэгдэхэд хэрхэн нөлөөлж байгаа, түүнд хэрхэн хандах ёстой талаас нь сурталчлах, иргэдийн дунд сургалт явуулах нь илүү үрдүнтэй болно.

ХХГХ-ээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай иргэдийн дунд сургалт сурталчилгаа явуулах.

Бусад

Судалгааны явцад тогтоогдсон авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг дурдвал:

- "Зар сурталчилгаа" гэсэн ойлголтыг нэг мөр ойлгох үүднээс УДШ-ээс тайлбар гаргуулах;


- "Зар сурталчилгааны бодит үнэнийг зарлуулсан байгууллага, хувь хүн бүрэн хариуцна" гэдэг нь хууль бус гэдгийг нийтэд мэдээлэх;

- ТВ чатаар явуулах зүйлийн шалгуурыг хууль тогтоомжийн дагуу хяналт тавих байгууллагууд хамтарсан зөвлөмж хэлбэрээр гаргах;

- Холбогдох байгууллагуудтай хамтран зар сурталчилгаанд гавигдах шалгуур үзүүлэлтийг зөвлөмж маягаар боловсруулах;

- Судалгааны үр дүнгээр сургалт зохион байгуулах.

☞ ☞ ☞



БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХУУЛЬ ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ


Оршил оролд

Ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийн харилцаанд тулгуурласан эрх зүйн тогтолцоо бүхий эрх зүйн орчин үүсээд дариу 20 жилийн пүүр үзэж байна. Энэ хугацаанд салбар эрх зүйн хөгжил төлөвшиж, нөгөө талаар эрх зүйн тогтолцоонд судалбал зохих онолын болоод практикийн маргаантай эрх зүйнүүд орших явдал нь судлаачдаас судалгааны байгуй эрэл хайгуулыг шаардаж байгаа бөгөөд тэрхүү судалгааны объектуудын нэг хэсэгт бизнесийн эрх зүй зүй ёсоор орно.

Судалгааны ажлын зорилго, судалгааны арга, хэрэгцээ, шаардлага

Судалгааны ажлын зорилгыг тодорхойлбол бизнесийн эрх зүйн харилцаа түүний төрлийг бизнесийн эрх зүйн үнэт зүйлсэд тулгуурлан тодорхойлох замаар, уг харилцаанд дахь хууль зүйн болон хууль зүйн бус хариуцлагын ойлголт, онол практикийн ач холбогдолыг судалгааны харьцуулалтын, логикийн аргаар судлан дүгнэлт өгөх.

Эрх зүйн тогтоолцоонд шинэлэг гэгдэх бизнесийн эрх зүйн харилцаа түүний онцлог, шинж, харилцааны элемент, харилцааны зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын асуудал, түүний онол, практикийн ач холбогдолыг иргэний эрх зүй болон бизнесийн эрх зүйгээр мэргэшиж буй судлаачдаас судалгааны дорвитой бүтээл гарахгүй байгаа цаашлаад онолын түвшинд бизнесийн эрх зүйн үнэт зүйл, зарчимд тулгуурлан бизнесийн эрх зүй дэх хууль зүйн хариуцлагыг үнэлдэггүй нь уг эрх



Шихихутуг хууль зүйн дээд сургуулийн Салбар эрх зүйн тэнхимийн багш С.Батбуяа

зүйн зүй мөн чанар өөрийн зүй тогтолыг үгүйсгэж, практикт бизнес эрхлэгчийн эрх ашиг, сонирхолыг зөрчихөд хүргэж байгаа зэрэг нь туссэдлийг суллах хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна.

1. Бизнесийн эрх зүй дэх хууль зүйн хариуцлага

Бизнесийн эрх зүйд үнэлэлт өгөх нь: Эдийн засгийн харилцаа, эрх зүйн харилцааны огтолголд дээр орших бизнесийн эрх зүйн талаар эрдэмтэд олон янзийн байр суурь, үзэл бодлыг дэвшүүлсэн байдаг. Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид "Бизнесийн эрх зүй бол хуульд заасан үндэслэлийн дагуу ашгийн төлөө барааны үйлдвэрлэл-борлуулалт, ажил үйлчилгээг тогтвортой эрхлэх, зохион байгуулах, засаг төрөөс оролцон зохицуулах явцад бизнес эрхлэгчдийн хооронд, түүнчлэн бизнес эрхлэгч ба бусад этгээдийн хооронд үүссэн харилцааг зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц юм"¹ гээд бизнесийн эрх зүй захиргааныхаас зарим, иргэнийхээс зарим дэд

салбар хэсгийг "авч" ихэвчлэн "бизнес" гэх тусгай зохицуулалтыг баримтлан тогтолцоожуулах учир "холимог" шинжтэй эрх зүй гэж үзсэн бол Д.Дүгэржав "Бизнесийн эрх зүй бол янз бүрийн салбар эрх зүй, институтийг багтаасан цогцолбор эрх зүй юм"² дээрх эрдэмтэдийн ингэж тодорхойлох шалгуур нь бизнесийн эрх зүйн зохицуулах зүйл, зохицуулалтын аргыг удирдлага болгосонтой холбогдоно.

Харин судлаачийн зүгээс дээрх эрдэмтэдийн үзэл бодлыг харгалзан, хүндэтгэхийн зэрэгцээгээр "Бизнесийн эрх зүй гэж харьцангуй бие даасан шинжтэй холимог эрх зүй"³ гэж тодорхойлоно.

Бизнесийн эрх зүйн харилцааг тодорхойлох нь: Бизнесийн эрх зүйн харьцангуй бие даасан өсоор ашгийн төлөөх үйл ажиллагаатай холбоотой нийгмийн тодорхой харилцаа байх бөгөөд энэ харилцааг судлаачийн хувьд аль салбар эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж байгаа эсхүл аль ч салбар эрх зүйд үл хамааралтайгаар орших байдлыг харгалзан дараах төрлийн харилцаанд төрөлжүүлэх боломжтой гэж үзэж байна.

- Захиргааны эрх зүйд хамаарах бизнесийн эрх зүйн харилцаа;

- Иргэний эрх зүйд хамаарах бизнесийн эрх зүйн харилцаа;

- Цэвэр бизнесийн эрх зүйн харилцаа.

Захиргааны эрх зүйд хамаарах бизнесийн эрх зүйн харилцаанд ашгийн төлөөх бизнесийн үйл ажиллагааг хуулиар зөвшөөрсөн арга, хэлбэрээр тогтвортой явуулж байгаа эсхүл явуулах зорилго бүхий бизнесийн эрх зүйн субъект

¹ Т.Мөнхжаргал. "Эдийн засгийн харилцааны эрх зүйн зохицуулалт". УБ., 2004 он. 76 дахь тал.

² Т.Мөнхжаргал, Ц.Полмон. "Бизнесийн эрх зүй". 2000 он. УБ., 18 дахь тал.

³ "Тодорхойлолтод орсон "харьцангуй бие даасан шинжтэй байх" ойлголт нь бизнесийн эрх зүйн цэвэр харилцааг бизнесийн эрх зүйн зохицуулалтын арга, зарчим хийгээд үнэт зүйлсэд тулгуурлан үнэлэхтэй холбоотой санаа юм".

(бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээд) нөгөө талд бизнесийн хууль тогтоомжид заасан чиг үүрэг (хянах, шалгах, бүртгэх, зөвшөөрөл олгох) бүхий захиргааны эрх зүйн субъект болох төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан оролцоно. Энэ харилцааны объект нь бизнесийн үйл ажиллагаа эрхлэх ашиг сонирхол, хуулиар зөвшөөрсөн ашгийн төлөөх үйл ажиллагаа, мөн энэ ажиллагааны үр дүн байна. Харилцааны агуулга нь харилцаанд оролцогч субъектуудын хуульд заасан эрх үүргээр илрэнэ.

Иргэний эрх зүйд хамаарах бизнесийн эрх зүйн харилцаанд нэг талд бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээд нөгөө талд бизнес эрхлэдэггүй, бизнесийн харилцаанд нэг удаагийн болон тохиолдлын шинжтэй оролцдог бизнест оролцогч иргэн, хуулийн этгээд гэх субъектууд оролцдог бол харилцааны объектод ашгийн төлөөх, тогтвортой шинж бүхий бизнесийн бүх төрлийн ажил үйлчилгээ, эдийн болон эдийн бус хөрөнгө, оюуны үнэт зүйлс хамаарах ба нөгөө талаараа зарим нь иргэний эрх зүйн харилцааны объектод давхцаж. Харилцаанд оролцогч субъектуудийн хуульд заасан эрх үүргээр агуулга нь тодорхойлогддог.

Цэвэр бизнесийн эрх зүйн харилцаанд оролцогч субъектуудын аль аль нь бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээд буюу бизнесийн эрх зүйн субъект байна⁴. Нийгмийн хэрэгцээ шаардлага хангасан ашгийн төлөөх, тогтвортой, бизнесийн үйл ажиллагаа цэвэр бизнесийн эрх зүйн харилцааны объект болно. Нийгмийн шаардлага хангасан ашгийн төлөөх үйл ажиллагаа гэж хуулиар

хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууний хэм хэмжээнд үл харшлах, нэг хэсэг болоод нийтийн хэрэгцээг хангахад чиглэгдсэн идэвхитэй үйлдэл. Харилцааны агуулга нь бизнесийн эрх зүйн хууль, тогтоомжид заасан бизнесийн эрх зүйн субъектуудын эдлэх эрх, хүлээх хууль зүйн үүргээр илэрнэ.

Бизнесийн эрх зүйд хамаарах хариуцлагын хувьд: Судлаачийн зүгээс бизнесийн эрх зүйн харилцааг тодорхойлсон нь дээрх харилцаануудыг зөрчсөн тохиолдолд хууль зүйн ямар төрлийн хариуцлага хүлээлгэх талаар ярих вэ гэдэгт хариулт олох гарцыг хайсан болно. Эрхийн онол ёсоор хууль зүйн 4 төрлийн хариуцлага зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэнэ⁵. Үүнд:

- Эрүүгийн эрх зүйн хариуцлага;
- Иргэний эрх зүйн хариуцлага;
- Захиргааны эрх зүйн хариуцлага;
- Сахилгын хариуцлага.

Хууль зүйн хариуцлагын онцлог шинжийг "Эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн этгээдэд нөлөөлөх төрийн албадлага бүхий нөлөөллийн арга хэрэгслийн нэг хэлбэр, гагцхүү төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас эрх зөрчигчдөд хэргэлдэг арга хэрэгсэл, хууль зүйн хариуцлагын арга хэмжээ болж хуульд заасан санкцыг хэрэглэнээр илэрдэг"⁶ зэргээр тооцож болохыг дурьджээ.

Судлан буй бизнесийн эрх зүйд иргэний эрх зүй, захиргааны эрх зүйн хариуцлага хүлээлгэх нь гарцаагүй бөгөөд шалтгаан нь дээрх харилцааг баримжаалж, харилцааг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хууль зүйн оновчтой, гарцаагүй хариуцлага гэвэл тус хоёр

хариуцлагаас өөрийг нэрлэх боломжгүй гэж үзэх нь бизнесийн эрх зүйн цэвэр харилцаа түүнийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх бизнесийн эрх зүйн бие даасан хариуцлагыг үгүйсгээд байгаа юм. гийм учраас бизнесийн эрх зүйн хариуцлагыг үнэлэх шаардлагатай.

Захиргааны эрх зүйд хамаарах бизнесийн эрх зүйн харилцаанд оролцогч бизнесийн эрх зүйн субъект хуульд заасан үндэслэл журмын дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх явцшаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль зөрчсөн бол тус хуулийн 27 дугаар зүйлд заасан захиргааны хариуцлага хүлээх байдлаар захиргааны эрх зүйд хамаарах хууль тогтоомж, болон бизнесийн эрх зүйн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд оногдуулах хариуцлага.

Иргэний эрх зүйд хамаарах бизнесийн эрх зүйн харилцааны хувьд: бизнес эрхлэгч, хуулийн этгээд бизнесийн үйл ажиллагаа явуулах явцдаа бусдад гэм хор, учруулах, гэрээний үүргээ зөрчих зэргээс үүсэх үр дагаварт иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэнэ.

Цэвэр бизнесийн эрх зүйн харилцааны хувьд: Бизнес эрхлэгчид цэвэр бизнесийн эрх зүйн харилцааг зөрчсөн тохиолдолд онол ёсоор бизнесийн эрх зүйн хариуцлага хүлээхээс өөр гарцгүй гэвч бизнесийн эрх зүйн хариуцлага гэх бие даасан хууль зүйн хариуцлагын тухай ярих нь бусад хууль зүйн хариуцлагын шинжийг үгүйсгэх хандлага бий болох хэдий ч судлаачийн хувьд бизнесийн эрх зүйн цэвэр харилцааг тогтоосон зорилго нь бизнесийн эрх зүйн харилцааг хууль зүйн хариуцлагад үнэлэх шаардлагатай холбоотой

⁴ "Бизнесийн эрх зүйн субъект гэж ашгийн төлөөх бизнесийн үйл ажиллагааг тогтморт, хуулийн хэрэгцээгээ хангах бус илүү хэрэгцээ хангаж ашиг олох зорилготой этгээдийг, энэ субъектэд монголын хувьд бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээд хамаарч байгаа бөгөөд бизнес эрхлэгч иргэнийг тогтоох онолын шалгуур нь хуулийн хэрэгцээгээ хангаад зогсохгүй хурамтлал бий болгодог, орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй хувь хүний орлогын албан татвар төлдөг, тогтморт бизнес эрхлэдэг байх. Харин хуулийн этгээдэд иргэний хууль, ах ахуй нэгжийн орлогын албан татварын хуульд заасан ашгийн төлөө хуулийн этгээд болох компани, нөхөрлөлийг ойлгоно.

⁵ А.Ф. Вишневский, Н.А. Горбаток, Н.А. Кучинский. "Общая теория государства и права". 2004.

⁶ Д.Наранчимэг. "Иргэний эрх зүйн үндсэн асуудал". УБ., 1999 он. 84 дэх тал.

юм. Бизнесийн эрх зүйн хариуцлага хууль зүйн хариуцлага мөн гэж үзэх оролдлогыг судлаачын зүгээс зориг шалдан хийж байна. Учир нь бизнесийн эрх зүйн хариуцлагын зорилго нь бизнес эрхлэгчийн эрх, ашиг сонирхолд нөлөөлж байдаг бусад хууль зүйн хариуцлагад ийм шинж огт байдаггүй. Мөн түүнчлэн бизнесийн эрх зүйн зарим хууль тогтоомжид хууль зүйн аль ч хариуцлагад оруулах боломжгүй гэхдээ хууль зүйн хариуцлагын шинж, зорилгыг хангах хариуцлага ажиглагддаг. Тухайлбал: Компанийн хууль, Нөхөрлөлийн хууль (хобогдох зүйл заалтыг ишлэлээр харуулав). Компаний тухай хуулиар энэ мэтчилэн үүргийг тогтоосон хэм хэмжээ цөөн бус байгаа.⁷

2. Бизнесийн эрх зүй дэх хууль зүйн бус хариуцлага

Бизнесийн эрх зүйн харилцааны зөрчилд хууль зүйн хариуцлагын шинжийг хадгалсан биш ч хариуцлагад тооцогдох, хууль зүйн хариуцлага хүлээлгэхэд үнэлж үзэх хариуцлага бол хууль зүйн бус хариуцлага. Тухайлбал: бизнесийн ёс зүйн хариуцлага байна. Бизнес ёс зүйн хэм хэмжээнд тулгуурлан ихэнх ашгийн төлөөх бизнесийн үйл ажиллагаа явагддаг. Түүнчлэн

бизнесийн ёс зүйн хариуцлагын зорилго нь бизнесийн нэр хүнд, ашиг орлогод нөлөөлөхөд чиглэгддэг. Ашгийн төлөөх бизнесийн харилцаанд оролдогчын үйл ажиллагаа нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэхийн тулд ёс зүйн хэм хэмжээнд нийцсэн байх ёстой.⁸ Ёс зүйн хэм хэмжээ нь хууль зүйн тодорхой хэлбэрт орж баримт бичиг болохоороо дүрэм хууль гэж нэрлэгддэг.⁹ Бизнесийн ёс зүй гэдэг нь угтаа бизнес эрхлэгчид өөр хоорондоо болон төртэй, хэрэглэгчидтэй харилцах талаар тогтоосон дэг, ёс горим юм¹⁰ гэж зарим судлаач үзжээ. Гэхдээ бизнесийн харилцааг ёс зүйн хэм хэмжээгээр зохицуулах үед бизнесийн ёс зүйн тухай ярихад хүргэдэг. Мөн тогтсон бизнесийн ёс, дадал, хуульчлагдаагүй бизнесийн харилцаанд өргөн хэрэглэгддэг нь бизнесийн ёс зүйн бас нэг онцлог юм.

Онол, практикийн ач холбогдолыг дурьдан дүгнэх нь

Бизнесийн эрх зүй дэх хууль зүйн хариуцлагыг судалсны эцэст онолын болон практикийн дараах ач холбогдол өгч байна.

- Онолын хувьд бизнесийн эрх зүй дэх хууль зүйн хариуцлагыг тодорхой нэг мөр ойлогх;

- Бизнесийн эрх зүйн хариуцлагад хамаарах бие даасан шинжийг үнэлэж цаашлаад хууль зүйн бие даасан хариуцлагад тооцох;

- Бизнесийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бий болгоход урьдчилсан онолын судалгаа болох, харгалзан үзэх санаа болно;

- Бизнесийн эрх зүйн хариуцлагыг бизнесийн эрх зүйн үнэт зүйлсэд багтаан цаашид бие даасан бизнесийн эрх зүйн харилцаа, бие даасан бизнесийн хууль тогтоомж, бие даасан бизнесийн процессын ажилгаа, түүний эрх зүйн орчныг бий болгох үнэлж тооцдог байх;

- Бизнесийн ёс зүйн хариуцлагыг үнэлэх эрх зүйн ухамсарыг зохих этгээдэд төлөвшүүлэх.

Эцэст нь дүгнэхэд, бизнесийн эрх зүйн хариуцлага бол бусад хариуцлагаар орлуулж болохгүй бие даасан зорилго, шинж бүхий хариуцлага бөгөөд энэ хариуцлагын зорилго нь бизнес эрхлэгчийн ашиг сонирхолд нөлөөлөх байдлаар хангагддаг гэж үзэж байна.

СЭ СЭ СЭ

⁷ Компанийн тухай хуулийн 7.2, 7.5, 7.7, 19.3, 19.4, 21.2, 23.1, 25.3, 33.4, 35.3, 60, 62, 63 гэх мэт үүрэг хүлээлгэсэн заалтууд, 24, 25.6, 35.1 гэх мэт эрх олгосон заалтууд цөөн бус байна.

⁸ М.Бундэлгэр. "Бизнесийн ёс зүй". УБ., 2002 он.17 дахь тал.

⁹ "Бизнесийн эрх зүй" (Хуульчдад зориулсан гарын авлага) УБ., 2003 он. 179 дэх тал.

¹⁰ Мөн тэмд "Бизнесийн ёс зүйг ёс зүйн үзэл баримтлалд тулгуурлан тодорхойлсон энэ ойлдолттой судлаач санал нийлж байна".

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ХҮРЭЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЗӨРЧИЛДӨӨН

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Олон улсын эрх зүйн секторын судалгааны тайлан*

Монгол Улсын шүүх эрх мэдлийн хүрээний хууль тогтоомж, олон улсын гэрээний зөрчилдөөн сэдэвт судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний секторууд хамтран хийсэн бөгөөд тодорхой үр дүнтэй судалгаа болж чадсан гэж үзэж байна.

Аливаа улс үндэсний хэмжээнд хууль тогтоомжоо Олон улсын гэрээнд нийцүүлэхгүйгээр тус гэрээг соёрхон батлах ажиллагаа явуулж болох боловч дараагийн шатанд нь нийцүүлэх ажлыг зохион байгуулах нь зохимжтой. Учир нь тэгээгүйгээс практикт асуудалтай тулгарч олон улсын гэрээг зөрчих магадлалтай. Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байдлаа үндэсний хууль тогтоомжоор зөвтгөхийг олон улсын эрх зүйгээр хориглосон байдаг¹. Харин энэ заалтыг үл тоон Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй гэж үзсэн нь хоорондоо олон улсын эрх зүйн давамгайлах зарчмыг зөрчсөн явдал болсон.

Судалгааны зорилго нь:

Монгол Улсын шүүх эрх мэдлийн хүрээний хууль тогтоомж ба олон улсын гэрээний нийцэл зөрчилдөөнийг нэгтгэн дүгнэж олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх арга

замыг тодорхойлсон санал зөвлөмж батлахад оршино.

Судалгааг хийхдээ Монгол Улсын хуулиуд болон олон улсын гэрээг хооронд нь харьцуулан судлах судалгааны аргаар хийж гүйцэтгэсэн.

Судалгаанд дараахь Монгол Улсын хуулиуд ба олон улсын гэрээнүүд хамрагдсан болно. Үүнд:

- Эрүүгийн хууль;
- Эрүүгийн байцаан шийтгэх хууль;
- Иргэний хууль;
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль;
- Шүүхийн тухай хууль;
- Прокурорын байгууллагын тухай хууль;
- Тэмдэгтийн хураамжийн хууль;
- Монгол Улсын Дээд шүүхийн 2008 оны “Монгол улсын олон улсын гэрээ болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 09 дүгээр тогтоол;
- Хүний эрхтэй холбоотой 34 гэрээ, гэмт хэргийн эсрэг тэмцэх салбарын 30 гэрээ;
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал;
- Боловсролын талаар алагчлах явдалтай тэмцэх тухай конвенц;
- Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц;
- Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм хэрэг

үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай конвенц;

• Аж үйлдвэрт хүүхдийг ажил авах насны доод хязгаарын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 59 дүгээр конвенц;

• Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 87-р конвенц;

• Зохион байгуулах эрх ба хамтын хэлэлцээний тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 98 дугаар конвенц;

• Ижил хөдөлмөрт адил хөлс олгох тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц, зөвлөмж;

• Эхчүүдийг хамгаалах тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 103 дугаар конвенц;

• Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц, зөвлөмж;

• Арьс өнгөөр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц;

• Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт;

• Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт;

• Апартейдын гэмт хэргийг таслан зогсоох, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай олон улсын конвенц;

• Хөдөлмөр эрхлэх бодлогын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 122 дугаар

* Энэхүү судалгааны дэлгэрэнгүй тайланг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн номын сангаас үзнэ үү.

¹ 1969 оны Олон улсын гэрээний эрх зүйн Вений конвенцийн 27 дугаар зүйл. (Монгол Улс 1988 оны 4 дүгээр сарын 11-нд нэгдэн орсон)

конвенц, зөвлөмж;

- Газар дор буюу уурхайд ажиллагсдын насны доод хязгаарыг тогтоох тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 123 дугаар конвенц, 124 дүгээр зөвлөмж;

- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц;

- Спортод апартейд бодлого явуулахын эсрэг олон улсын конвенц;

- Ажилчдын төлөөлөгчдийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 135 дугаар конвенц, 143 дугаар зөвлөмж;

- Хүүхдийн эрхийн тухай конвенц;

- Сайн дурын үндсэн дээр гэрлэх болон гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай конвенц;

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт протокол;

- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн 20 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэг дэх нэмэлт өөрчлөлт;

- Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 43 дугаар зүйлийн (2) нэмэлт өөрчлөлт;

- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох болон нэн даруй устгах тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 конвенц;

- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн нэмэлт протокол;

- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц;

- Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц;

- Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахаас хамгаалах тухай Хүүхдийн эрхийн тухай конвенцийн

нэмэлт протокол;

- Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самуунд татагдахаас тухай Хүүхдийн эрхийн конвенцийн нэмэлт протокол;

- Ажилд авах насны доод хязгаарын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенц, 146 дугаар зөвлөмж;

- Гурван талт зөвлөлдөөний тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 144 дүгээр конвенц, 152 дугаар зөвлөмж;

- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенц, 164 дүгээр зөвлөмж;

- Мэргэжлийн нөхөн сэргээлтийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенц, 168 дугаар зөвлөмж;

- Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц;

- Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр үйлдсэн конвенцийн олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай нэмэлт протокол;

- Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенц;

- Олон улсын хамгаалалтад орох хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенц;

- Терроризмын зорилгоор бөмбөг хэрэглэхтэй тэмцэх тухай олон улсын конвенц;

- Т е р р о р и з м ы г санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц;

- Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай олон улсын конвенц;

- Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц далайн навигацын аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц;

- Эх газрын хормойд байрлуулсан суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай протокол;

- Авилгалын эсрэг НҮБ-ын конвенц;

- Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц;

- Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц;

- Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц;

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц;

- Олон улсын эрүүгийн шүүхийн ромын дүрэм гэх мэт

Эдгээр судалсан хууль тогтоомжуудаас Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Тэмдэгтийн хураамжийн хуулиуд нь холбогдох олон улсын гэрээнүүдтэй зөрчилдсөн үйлгүйг байна гэсэн дүгнэлтэд тус хуулиудыг олон улсын гэрээнүүдтэй харьцуулан судалсан судалгааны багийнхан хүрсэн байна.

Харин Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиуд нь холбогдох Олон Улсын гэрээнүүдтэй зарим талаар нийцэхгүй байна гэсэн

дүгнэлтийг эдгээр хууль тогтоомж болон олон улсын гэрээг судалсан эрдэм шинжилгээний багийнхан өгсөн.

Тухайлбал, “Төрийн мэдээлэл” сэтгүүлд албан ёсоор хэвлэгдэн гарсан 30 гэрээг судлан 308 хэм хэмжээг түүвэрлэн, тэдгээрт Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох хэм хэмжээг харьцуулан тайлбарлан дүгнэж, зохих саналыг боловсруулсан байна.

Судалгаанд хамрагдсан 30 гэрээний харьцуулан судлагдсан 308 хэм хэмжээний:

- 209 буюу 67.8% нь үндэсний хууль тогтоомжид бүрэн тусгагдсан;
- 29 буюу 9.4% нь бүрэн бус тусгагдсан;
- 41 буюу 13.3% нь огт тусгаадаггүй байна.

Энэ нь Монгол Улс Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх” үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байгааг илэрхийлсэн үзүүлэлт юм.

Ийм учраас дээрх үүргээ бүрэн хэрэгжүүлэх зорилгын дор Монгол Улсын Эрүүгийн хууль, ЭБШХ-д бүрэн тусгаадаггүй, эсвэл огт тусгаадаггүй байгаа олон улсын гэрээний хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид хэрхэн, ямар байдлаар тусгаж, нийцүүлэх талаар тайлбарлан дүгнэж, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах талаар 76, ЭБШХ-д өөрчлөлт оруулах талаар 23 санал, нийт 99 санал боловсруулсан.

Мөн 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх

тухай” Улсын Дээд шүүхийн 9 дүгээр тогтоолыг судалж олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх эрх зүйн орчин бүрдсэн байдалд зохих судалгаа хийж дүгнэлт өгөв.

1. Энэхүү тогтоолыг олон улсын гэрээний заалтыг дотоодод хэрэгжүүлэхтэй холбоотой шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор гаргасан байх хэдий ч Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх асуудлаас зөвхөн олон улсын гэрээг хэрэглэх асуудлыг тусгаж өгсөн байна. Өөрөөр хэлбэл, тогтоолын нэрд агуулагдаж буй олон улсын гэрээнээс гадна олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрхэн хэрэглэх нь огт тайлбаргүй үлдсэн байна;

1.1. Тогтоолын 2 дугаар хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 3-д заасныг үндэслэн олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг болно гэсэн нь оновчтой бус байна. Тухайлбал, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ болгон олон улсын гэрээний хэлбэртэй байдаггүй бөгөөд тэдгээрийн хувьд соёрхон батлах, түүнд хэглэн орох асуудал байдаггүй.

2. Олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх арга зүйн асуудал нь хэт ерөнхий болсон байх боловч 4 тогтоолын 13 дугаар хэсэгт энэ асуудлыг сургалт, арга зүйн материал, гарын авлага төлөвлөснөөр шийдэж болохоор зохицуулсан байна;

2.1. Арга зүйн асуудал хэт ерөнхий, тухайлбал, шүүх олон улсын гэрээг хэрэглэх дараалсан алхам, хэрхэн хэрэглэх аргачлал, шүүхийн шийдвэрийн хаана нь хэрхэн тусгах гэх зэрэг асуудал тодорхой биш байна. Энэ тогтоол гарснаас хойш 2 жил өнгөрсөн боловч тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээ хийгдээгүй байна. Олон улсын гэрээг хэрэглэх аргачлал, сургалт, сургалтын гарын авлага одоо болтол боловсруулаагүй байна.

3. Тогтоолын 2-т Олон улсын гэрээг тодорхойлохдоо 1993 оны Олон улсын гэрээний тухай хуулийн өөр хоорондоо зөрчилтэй заалтыг үндэс болгосон нь Улын Дээд шүүх албан ёсоор энэ зохицуулалтыг хүлээн зөвшөөрч байна.

Олон улсын гэрээний тодорхойлолтыг Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулиас авахдаа болгоомжтой хандах ёстой байсан. Учир нь онолын хувьд Парламентын байгуулсан гэрээг олон улсын гэрээнд багтаан тооцдоггүй ба Парламент улсын нэрийн өмнөөс гэрээ байгуулах эрхгүй байдаг. Мөн үүний адилаар агентлаг, түсгий газрын байгуулж буй гэрээг ялган авч үзэх шаардлатай.

Үүнтэй холбогдуулж олон улсын гэрээг Монгол Улсын Үндсэн хуульд болон Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуульд тус тус ялгаатай байдлаар тодорхойлсоныг анхаарах. Тухайлбал, Үндсэн хуульд Монгол Улсын олон улсын гэрээ гэхийг зөвхөн соёрхон баталсан, эсхүл соёрхон батлах замаар нэгдэн орсон олон улсын гэрээг ойлгохоор бол Олон улсын гэрээний тухай хуульд олон улсын гэрээг өргөн хүрээгээр томъёолсон байна. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3-т хоёрдмол санаа агуулалгүй зөвхөн соёрхон баталсан, эсхүл соёрхон

батлах замаар нэгдэн орсон олон улсын гэрээ холбогдох хууль гармагц дотоодын хуулийн адил хүчинтэй болхоор заажээ. Иймд шүүх зөвхөн Үндсэн хуулийн тодорхойлсон Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэх нь зохистой;

4. Монгол Улсын Дээд шүүх анх удаа шүүхэд хэрэглэх олон улсын гэрээний шинжийг тодорхойлжээ. Тухайлбал, Монгол Улсын олон улсын гэрээ нь дараахь шинжийг агуулсан бол шүүх хэрэглэнэ.

- Үндсэн хуульд харшлаагүй;
- хүчин төгөлдөр болсноор заавал даган мөрдөх шинжийг агуулсан;
- албан ёсоор нийтлэгдсэн;
- дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардсан заалтгүй;
- үндэсний эрх зүйн харилцааны оролцогч этгээдүүдэд шууд эрх, үүрэг үүсгэх чадалтай.

Энэхүү шинж онол, практикийн үндэсэл бүхий бөгөөд эрдэмтэдийн анхаарал татсан тулгамдсан асуудлыг нэг болоод байна. Тухайлбал, НҮБ-ын Олон улсын шүүхийн 2001 оны La Grand-ийн (ХБНГУ vs. АНУ)² хэргийн шийдвэрт өөрөө биелэгдэх олон улсын гэрээний шинжийг тодорхойлсон байна. Олон улсын гэрээний заалт үндэсний эрх зүйн субъект

хэрэглэхэд чиглэгдсэн агуулгатай байх, дотоодын хуульчилсан акт шаардахгүйгээр тухайн улсын нутаг дэвсгэр дээр шууд үйлчлэх чадвартай байх ёстой.³

Харин зарим олон улсын гэрээ оролцогч улсад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх тодорхой арга хэмжээ авахыг үүрэг болгодог хэдий ч зарим гэрээ нь “шаардлагатай бол” тийм арга хэмжээ авна гэж уян томъёолсон байдаг. Иймд 27 дугаар зүйлийн дагуу “шаардлагатай талаар заасан” бол шууд хэрэглэх боломжгүй гэж ойлгох нь дутагдалтай. Тухайлбал, Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай 1997 оны конвенцийн 18 дугаар зүйлд “шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлт оруулах” гэх заалтыг оролцогч улс өөрийн үндэслэлээр шаардлагатай эсхээ тогтооно.

5. Тогтоолд “Олон улсын гэрээ хүчинтэй болсон хэдий ч албан ёсоор нийтлэгдээгүй бол шүүх түүнийг хэрэглэхгүй” гэсэн байна. Энэ асуудалд маш болгоомжтой хандмаар байна. Учир нь өнөөдөр санхүүгийн бэрхшээлээс болж төдийлөн олон улсын гэрээг нийтэлж чадахгүй байгаа. Хоёр талт олон улсын гэрээ огт нийтлэгдээгүй байгаа. Дээрхи байдлаар шүүх нь нийтлэгдээгүй хуулийг хэрэглэж болохгүй боловч нөхцөл байдлыг

дүгнэж энэ асуудалд болгоомжтой хандахгүй бол хүний эрхийг ноцтой зөрчсөн хэрэгт унах өндөр магадлалтай.

Тогтоолын талаархи нэгдсэн дүгнэлт

1. 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн хандлагыг хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” Улсын Дээд шүүхийн 9 дүгээр тогтоолыг сайжруулах замаар, эсхүл түүний хэрэгжилтийг хангах үүднээс зохих арга хэмжээ авч олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх аргачлал боловсруулах шаардлагатай байна.

2. Шүүгчийн сургалтын сэдэв, төлөвлөгөөг эргэн хараж олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх аргачлалтай уялдуулж чанарыг сайжруулах шаадлагатай байна.

3. Нийтлэгдээгүй Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэхгүй байх асуудлыг түр заалт, эсхүл түр хугацааны арга хэмжээгээр шийдэх бололцоог судлах шаадлагатай байна.

4. Шүүх эрх мэдлийн хүрээнд олон улсын гэрээг хэрэглэх талаар зөвхөн Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний зөрчилдөөнийг арилгах, зохицолдуулах ажлыг гайлбар гаргах замаар бус хууль батлан шийдвэрлэдэг болох шаардлагатай байна.



² La Grand case. (2001) 40 ILM 1069.

³ Консулын харилцааны тухай 1963 оны Венений конвенцийн 36 дугаар зүйл өөрөө биелэгдэх шинжийг агуулсан. Үүний дагуу АНУ-д тухайн улсын хуулиар эрүүгийн хариуцлага хүлээсэн ХБНГУ-ийн иргэн Карл Лагранд нь конвенцийн зүйлстэй эрхээ хамгаалуулах бүрэн эрхтэй байсан гэж үзсэн байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ СИНГАПУРЫН ТУРШЛАГА

Авлига нь нийгмийн үнэлэмж, хөдөлмөрийн үнэ цэнэ, хувь хүний хичээл зүтгэлийг үнэгүйдүүлж, нийгмийн тогтвортой байдал, шударга ёсыг алдагдуулдаг хорт тахал гэдгийг ХХ зууны дунд үеэс эхлэн хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрч, авлигын эсрэг бодит тэмцэл өрнүүлж эхэлсэн юм.

Авлигатай тэмцэх нь авлигаа улс орны хувьд шударга өрсөлдөөнийг хангах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, сайн засаглалыг бэхжүүлэх, эрх зүйт төрийг төлөвшүүлэх зэрэг стратегийн чухал ач холбогдолтой байдаг.

Өнөөдрийн байдлаар дэлхийн улс орнууд гүйцэтгэх засаглалынхаа өмнө хариуцлага хүлээж ажилладаг Хонгконгийн универсал загвар, Сингапурын буюу мөрдөн байцаах үйл ажиллагааны чиглэл нь давамгайлсан цомхон, бие даасан загвар болон парламентынхаа өмнө хариуцлага хүлээдэг Уэльсийн авлигатай тэмцэх газар, мөн Америкийн Нэгдсэн Улсын авлигатай тэмцэх олон талт тогтолцоо гэсэн үндсэн дөрвөн хэлбэрээр авлигатай тэмцэж байна.

2009 оны 11 дүгээр сард Трансперенси Интернэшнлээс гаргасан авлигын судалгаагаар Монгол Улсын индекс 0.3 функтээр бууран 18 байр ухарчээ. Дээрх жагсаалтад манай улс 2007 онд 99, 2008 онд 102 дугаар байрт жагсаж байсан бол энэ жил 120 дугаар байр руу огцом ухралт хийлээ. Энэ нь Монгол Улсад авлигын цар хүрээ нэмэгдэж, нийгмийн бүхий л салбарт авлига хүчтэй тархаж буйг илэрхийлж байна гэсэн үг.

Сонирхолтой нь сүүлийн жилүүдэд энэхүү жагсаалтын эхний аравт Сингапур, Хонгконг, Дани, Швед, Голланд, Швейцари, Финланд зэрэг улс орон тогтмол орж байгаа бол Сомали, Афганистан, Мянмар, Судан, Ирак, Иран, Туркменстан, Узбекистан зэрэг улс төр, эдийн засгийн хувьд тогтворгүй, ядуу буурай улс орон байнга сүүл мушгиж явна.



Хууль зүйн доктор Ж.Батзандан

Харин бидэнтэй адил хэдхэн жилийн өмнө социалист лагерыг хамрагдаж байсан Болгар, Румын, Унгар, Польш, Чех, Словак зэрэг улс орон бидний өмнө буюу энэ жилийн жагсаалтын 40-70 дугаар байрт багтлаа. Мөн манай хойд хөршийн авлигын индекс огцом нэмэгдэж 146 дугаар байрт орсон бол урд хөршид авлига буурч 79 дугаар байрт жагсчээ.

Авлигыг багасгах зорилгоор манай улс гадаад улс орнуудын туршлагаас судалж, шинэ стретги, тактик боловсруулж ажиллах зайлшгүй шаардлага байгааг сүүлийн жилүүдэд хийсэн судалгаануудын үр дүн тодорхой харуулж байна. Иймээс судлаачийн хувьд авлига, хээл хахуулийг бууруулж чадсан Сингапурын туршлагын талаар санал хуваалцаж.

Английн колончлолын үед Сингапурт авлига ердийн үзэгдэл болж нийгмийн бүхий л хүрээг хамарч байв. Иймд 1937 онд Сингапурын засгийн газраас "Авлигаас Урьдчилан Сэргийлэх" тогтоолыг батлан гаргаж, цагдаагийн байгууллагын дэргэд "Авлигатай Тэмцэх Хэлтэс" байгуулсан.

Харамсалтай нь Сингапурын цагдаагийн дэргэдэх "Авлигатай Тэмцэх Хэлтэс"-ийн үйл ажиллагаа нь мэргэшсэн боловсон хүчний дутагдал, цагдаагийн байгууллагад

нүүрлэсэн авлигын сүлжээ, цагдаагийн удирдах ажилтнуудад авлигатай тэмцэх бодит хүсэл зориг дутмаг байсны улмаас тодорхой үр дүнд хүрээгүй. Тухайлбал, 1951 онд Сингапурын цагдаагийн байгууллагын удирдлагууд 400 мянган ам.долларын үнэ бүхий хар тамхины хэрэгт орооцолдсон нь авлигад идэгдсэн цагдаагийн байгууллага авлигын эсрэг зоригтой, шийдвэртэй тэмцэл явуулах ямарч чадваргүй болохыг нотлон харуулсан байдаг.

Иймээс олон түмний шахалтаар 1952 онд авлигатай тэмцэх хуучин тогтолцоог халж оронд нь цагдаагийн байгууллагаас гусдаа бие даасан "Авлигын Хэргийг Мөрдөн Шалгах Хороо"-г (цаашид АХМШХ гэх) шинээр байгуулсан юм.

Хэдийгээр Сингапур Улс нь авлигатай тэмцэх шинэ тогтолцоог сонгож авлигын эсрэг тэмцэх бие даасан байгууллагыг бий болгосон хэдий ч хуучны хандлага, хуулийн бүрхэг зохицуулалтаас болж олгийтой үр дүнд хүрэхгүй байлаа. Үүнийг судлаачид АХМШХ-ны ажилтнуудад хангалттай эрх олгогдоогүй, авлигын хэрэгт холбогдох нотлох баримт цуглуулах эрхийн асуудал нарийн зохицуулагдаагүй, мөн гэрчийн эрх хамгаалагдаагүй байсантай шууд холбоотой гэж үздэг.

Мөн иргэдийн эрхийн боловсрол нимгэн, төрийн албан гушаалтнуудын цалин хөлс бага, түүнчлэн АХМШХ-ны ажилтнуудын дийлэнх олонх нь цагдаагийн байгууллагаас түр томилогдон ажиллаж байсан зэрэг нь авлигын хэргийг мөрдөн шалгахад хүндрэл учруулж байжээ.

1959 онд Сингапурт Ардын Хөдөлгөөний Нам засгийн эрх авсны дараа нэн түрүүнд авлигыг бууруулах, авлигын талаарх нийгмийн сэтгэл зүйн хандлагыг өөрчлөхийн тулд урт хугацааны стратеги боловсруулан гаргаж АХМШХ-ны эрх хэмжээг нэмэгдүүлж, "Авлигаас урьдчилан сэргийлэх хууль"-ийг шинээр батлан гаргасан юм.

Тодруулж хэлбэл 1960 онд батлан гаргасан Авлигаас урьдчилан сэргийлэх хууль нь 1937 оны Авлигаас урьдчилан сэргийлэх тогтоолын олон сул тал, дуутууг нөхсөнөөрөө түүхэн ач холбогдолтой болсон. Мөн авлигын хэрэгт ногдуулах хорих ялын хэмжээг 5 жил, мөнгөн торгуулийн хэмжээг 10,000 доллар (сүүлд 1989 онд 100,000 доллар) хүртэл нэмэгдүүлсэн ба АХМШХ-ны боловсон хүчний хэмжээг 16 дахин нэмэгдүүлж 82 ажилтантай болгосон. Хэрэв авлигын хэрэг нь захиргааны гэрээ хэлцэлтэй холбоотой, парламентын гишүүн болон төрийн өндөр албан тушаалтнууд холбогдсон бол шүүхээс ногдуулах хорих ялын хэмжээг 7 жил хүртэл нэмэгдүүлэх болсон юм. Түүнчлэн торгуулийн болон хорих ялаас гадна, авлигаар авсан мөнгө, эд зүйлээ буцааж төлөхийг шаардах, авлигын хэрэг үйлдсэн этгээдийн өмч хөрөнгийг хураах шийдвэрийг ч шүүхээс гаргах эрхтэй болсон.

Мөн Сингапур улс төрчид олон түмний итгэл, дэмжлэгийг олж авахын тулд өөрсдөөсөө эхэлж бодит үлгэр дуурайл үзүүлсэн байдаг.

Авлигыг бууруулах зорилгоор Сингапурын улс төрчид доорх шинэчлэлтүүдийг хийсэн юм. Үүнд: - АХМШХ-нд цагдаагийн байгууллагаас томилогдон ажиллаж байсан мөрдөн байцаагч нарыг аажмаар сольж тэдний оронд хүний эрхийн өндөр мэдлэгтэй, иргэний баримжаатай хуульчдыг сонгон шалгаруулж, шинээр мэргэшүүлэх замаар боловсон хүчний шинэчлэлт хийсэн;

- Төрийн албан тушаалтнуудын цалин хөлсний хувь хэмжээг нэмж хувийн секторт ажиллаж буй иргэдийн авч буй дундаж цалингүйн жишигт хүргэсэн;

- Бүх төрлийн захиргааны гэрээ, хэлцэл байгуулах явцад авлига авч, огсон нь тогтоогдвол тухайн гэрээ хэлцэлийг түдгэлзүүлэх тухай заалтыг гэрээнд заавал тусгаж огөх тухай нөхцлийг хуульчилсан;

- Захиргааны гэрээ байгуулах явцад авлига өгсөн талыг 5 жилийн хугацаагаар дахин ямар нэгэн захиргааны гэрээ, хэлцэл байгуулах

эрхийг нь хасах болсон байна.

Түүнчлэн Сингапурын Засгийн газраас төрийн албан тушаалтнуудад хандаж авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг гаргасан байдаг. Зарим заалтыг нь товч дурдвал;

- Төрийн ямарч албан тушаалтан ажил үүргийн харилцаанд байгаа хувь хүн, хуулийн этгээдээс мөнгө зээлэх, эсвэл түүний өмнө ямар нэгэн санхүүгийн хариуцлага хүлээхийг хориглох;

- Төрийн албан тушаалтан албаны мэдээллийг хувийн ашиг сонирхлооо хангах зорилгоор ашиглаж үл болох;

- Төрийн албан тушаалтан зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх болон давхар ажил хийхийг хориглох;

- Төрийн албан тушаалтан ямар нэгэн зугаа цэнгэл, үзвэр үйлчилгээний урилга иргэдээс хүлээж авч үл болох;

- Төрийн албан тушаалтан зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн аж ахуйн нэгжээс санал болгосон хувьцааг худалдан авч болохгүй;

- Төрийн албан тушаалтан жил бүр орлого, зарлагаа тогтмол мэдүүлэх үүрэгтэй гэх зэргээр заасан байдаг.

Хууль тогтоох болон захиргааны аргаар авлигын эсрэг тэмцэхээс гадна АХМШХ-ны ажилтнууд нь хууль хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтнуудтай тогтмол уулзаж авлигын хор аюул, түүнээс сэргийлэх аргачлалын талаар сургалт, семинар зохион байгуулдаг. Мөн авлигын хэрэгт холбогдсон албан тушаалтнуудыг захиргааны хариуцлагын хүрээнд ажил, албан тушаалаас нь халах, зэрэг, дэвийг нь бууруулах, албан тушаал дэвших эрхийг нь хасах, цалин хөлсний нэмэгдлийг нь зогсоох, торгох эсхүл сануулга өгөх, тэтгэвэрт гарах болсон албан тушаалтан авлигын хэрэгт холбогдсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг нь хасах зэрэг олон шийтгэл ногдуулдаг байна.

Сингапур Улсын авлигатай хийх тэмцэлд АХМШХ-ны үйл ажиллагаанаас гадна төрийн байгууллага, яам, тамгын газрын

албан тушаалтнуудын идэвх чармайлт чухал нөлөө үзүүлсэн байдаг.

АХМШХ нь авлигын хэргийг мөрдөн шалгах чиглэлд гол анхаарлаа хандуулдаг бол авлигын хэргээс урьдчилан сэргийлэх гол ажлыг төрийн захиргааны салбарын яамд нь хариуцдаг. Тодруулж хэлбэл яамны төрийн нарийн бичгийн дарга нар авлигаас урьдчилан сэргийлэх аргачлалуудыг боловсруулан гаргаж, засгийн газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилладаг.

Мөн энэ хүрээнд захиргааны ажлын арга барил, процессийг боловсронгуй болгох, зөвшөөрөл лиценз олгохтой хөнгөвчлөх, хүндрэлгүй болгох арга замыг олох, авлигыг үүсгэж буй захиргааны процессийг байнга хянаж, засч залруулах, захиргааны шинэ, залуу албан тушаалтнуудын шийдвэр гаргах процессийг хянах, эрх мэдлээ хэтрүүлэх болон урвуулан хэрэглэх явдлаас урьдчилан сэргийлэх, захиргааны сонгон шалгаруулалтыг тогтмол явуулах, ахмад, гуршлагатай ажилтнаар байнгын болон гэнэтийн хяналт шалгалтыг тогтмол хийлгэх, авлигын эсрэг тэмцэх аргачлалуудыг тогтмол хянан шалгах, боловсронгуй болгох зэрэг ажлыг гүйцэтгэдэг байна.

Энэт нь хэлэхэд авлигаас бүрэн ангижирсан нэг ч улс дэлхий дээр байхгүй боловч авлига буюу энэхүү нийгмийн хорт өвчнийг хяналтдаа авч, амжилттай тэмцэж байгаа улс орны нэг бол яах аргагүй Сингапур гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрдөг болжээ.

Сингапур Улсад авлигын эсрэг тэмцэл амжилтад хүрэхэд олон хүчин зүйл нөлөөлсөн гэдэгтэй хэн ч маргахгүй. Гэхдээ авлигын эсрэг хатуу зогсож, тэмцэж чаддаг Сингапурын улс төрчдийн хүсэл зориг хамгийн чухал хүчин зүйл болсон гэж би хувьдаа ойлгодог ба авлигын хор хөнөөлийг нийтээрээ ухамсарлаж нийгмийн бүх түвшинд авлигыг үл тэвчих хандлагыг дэмжиж, зоригтой, туштай тэмцэж чадвал түүнийг устгах боломж байгааг Сингапурын туршлага бидэнд харуулж байна.

АШИГТ МАЛТМАЛЫН ЛИЦЕНЗ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Удиртгал

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш эдийн засгийн бүхий л салбарт эрчимтэйгээр өөрчлөлт шинэчлэл хийж, газрын баялагыг дэлхийн эдийн засгийн эргэлтэнд оруулах таатай боломж гадаад ертөнцөд нээгдэж өгсөн.

Тэр дундаа уул уурхайн салбарын өсөлт нь бусад аль ч салбар, үйлдвэрлэлээс голлох байр суурийг эзэлж, энэ хандлага нь цаашид хадгалагдах төлөвтэй боллоо. Тус салбар 2006 онд 950 тэрбум гаруй төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь дотоодын нийт бүтээгдэхүүний 30%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 70%, экспортын бүтээгдэхүүний 76%-ийг тус тус эзэлжээ. Ийнхүү тус салбарын манай улсын эдийн засгийн өсөлт, хөгжилд оруулж буй хувь нэмэр сүүлийн жилүүдэд өссөөр байгаа бөгөөд аж үйлдвэр, экспортын тэргүүлэх салбарын түвшинд хүрчээ.¹

Мөн онд дэлхий даяар геологи хайгуулын ажилд зарцуулсан нийт хөрөнгийн 4% буюу 413.33 сая ам.долларыг Монгол улсын нутаг дэвсгэр дээр хийгдсэн геологи хайгуулын ажилд зарцуулж энэ үзүүлэлтээрээ манай улс геологи хайгуулын ажилд гадаадын хөрөнгө оруулалтыг хамгийн ихээр татаж байгаа дэлхийн топ 10 улсын 9 дүгээрт ороод байна.



ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, магистр Ц. Ундрах

Уг салбарын эрх зүйн үндсийг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль болон эдгээр хуулиудад нийцүүлэн гаргасан бусад тогтоол, дүрэм, журмууд бүрдүүлдэг. Мөн түүнчлэн Компаний тухай хууль, Иргэний тухай хууль, Газрын тухай хууль, Байгаль орчны тухай хуулиуд, Татварын тухай багц хуулиуд, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль зэрэг бусад хуулиудаар зохицуулдаг байна.

Миний илтгэлийн зорилго нь уул уурхайн салбар дахь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаар МУ, БНСУ болон БНХАУ-ын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалснаар ямар этгээд тусгай зөвшөөрлийг эзэмших эрхтэй мөн түүнд ямар шаардлага тавигддаг тухай судлан дүгнэлт хийхийг зорилго.

Монгол Улс дахь эрх зүйн зохицуулалт

Манай улсын уул уурхайн салбарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч² хуулийн этгээдийг³ үндсэнд нь хоёр ангилдаг. Үүнд:

- Хуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх эрх олж авсан хайгуулын үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд

- Хуулийн дагуу ашигт малтмал ашиглах эрх олж авсан хайгуулын үйл ажиллагаа нь дуусаж цаашид олборлолтын үйл ажиллагаанд ороход бэлэн болсон хуулийн этгээд

2007 оны байдлаар ашигт малтмалын хайгуулын 3387 тусгай зөвшөөрөл олгогдсон 41 484 294 гектар талбай, ашигт малтал ашиглалтын 1024 тусгай зөвшөөрөлөөр олгогдсон 391 722 гектар талбай нь аж ахуй нэгж, хуулийн этгээдийн эзэмшилд байна.⁴ Эдгээр тусгай зөвшөөрлийг эзэмшигчдээр нь харуулбал дараах байдалтай. (Хүснэгт 1, хуудас 70-д)

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаас хойш өнөөг хүртэл уул уурхайн салбарт дагаж мөрдөж ирсэн Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль нь 3-н удаа шинэчлэгдсэнээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх эрх зүйн зохицуулалт мөн адил үүний

¹ Монгол Улсын Эдийн засгийн эрх чөлөөний тойм судалгаа-2007 (МУИС-ЭЭС).

² 2006 оны Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20-т "тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрх авсан, эсхүл түүнийг энэ хуульд заасан нөхцөл журмын дагуу шилжүүлэн авсан хуулийн этгээдийг;

³ 2002 оны Монгол Улсын Иргэний тухай хууль. Тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д "ашигийн төлөө хуулийн этгээд нөхөрлөл, компани хэлбэрээр байгуулна."

⁴ Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын 2007 оны үйл ажиллагааны тайлан.

Хүснэгт 1

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэлбэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоо	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбай /%-иар/
1	Дотоодын аж ахуй нэгж	445	Ашиглалт	700	0.41
2		935	Хайгуул	2127	31.1
3	Гадаадын 100% хөрөнгө	99	Ашиглалт	182	0.44
4	оруулалттай аж ахуй нэгж	168	Хайгуул	936	46.7
5	Хамтарсан аж ахуй нэгж	68	Хайгуул	142	0.08
6		76	Ашиглалт	275	8.7
7	Геологийн газар	1	Хайгуул	56	12.5
	Нийт дүн	1792		4418	

даган өөрчлөлт орсон.

Эхнийх нь 1994 оны Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль бөгөөд энэ хуульд ашигт малтмалыг хайгуулдах, олборлож ашиглах эрхийг төрийн захиргааны эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэж олгох, хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааг түрээсийн гэрээгээр гүйцэтгүүлэхээр тусгасан байна. Улмаар Ашигт малтмалын тухай хуулийг 1997 онд шинэчлэн баталж, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын онцгой эрхийг зөвхөн лиценз эзэмших журмаар зохицуулсан. Ашигт малтмалын тухай хуулийг 2006 онд дахин шинэчлэн найруулж, ашигт малтмалын хайгуулын болон ашиглах эрхийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох журмаар явуулж эхэлсэн.

1997 оны Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулиар³ ашигт малтмалын хайгуулын лицензийг Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, хуулийн этгээд

эзэмших эрхтэй байсан. Харин ашигт малтмал ашиглах лицензийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байгаа хуулийн этгээд эзэмших эрхтэй гэж тусгасан бөгөөд нэг лицензийг зөвхөн нэг этгээдийн нэр дээр олгож байсан байна.

2006 оны Монгол Улсын Ашигт малтмалын шинэчилсэн хуулиар⁴ хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгохоор болж, зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх бүх хугацаанд дээрх нөхцөлийг хангах ёстой. Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглахыг хориглон нэг тусгай зөвшөөрөл зөвхөн нэг хуулийн этгээдийн нэр дээр олгохоор болсон.

1997 оны Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашигт малтмалын лиценз

эзэмшиж байсан иргэдийн лиценз эзэмших эрхийг 2006 онд батлагдан гарсан Монгол Улсын Ашигт малтмалын хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулиар⁵ зохицуулж өгсөн юм. Шинэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнөх тусгай зөвшөөрөл эзэмших эрхтэй иргэн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу компани⁶, нөхөрлөл⁷ байгуулан

үргэлжлүүлэн эзэмшиж болно гэж тусгасан.

Дэлхий улс орнуудын хувьд өөр өөрийн улсын онцлогт тохируулан бий болгосон уул уурхай болон ашигт малтмалын гухай хуулиар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх зүйн байдал, түүнд тавигдах шаардлагыг тодорхой хэмжээгээр тусгаж өгсөн байдаг.

БНСУ дахь эрх зүйн зохицуулалт

БНСУ нь 1981 онд Уул уурхайн тухай хуулийг баталж гүүнээс хойш 5-н удаа нэмэлт, өөрчлөлт орсон байдаг. Тус хуулиар “ашигт малтмал ашиглах” гэдэг нь ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, хүдэр баяжуулах, агуулгыг нэмэгдүүлэх, бусад дагалдах үйл ажиллагаа⁸ гэнэ.

Мөн ашигт малтмал ашиглах эрх, түрээслэх эрхийн талаар тусгахдаа “ашигт малтмал ашиглах эрх” гэдэг нь тус хуульд бүртгэлтэй ашигт малтмал, бүртгэлтэй газарт байгаа ашигт малтмал хэлбэрээр ашигт

³ Тус хуулийн 10 дугаар зүйл. Лиценз эзэмших эрх бүхий этгээд

⁴ Тус хуулийн 7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглахад танигдах ерөнхий шаардлага.

⁵ Тус хуулийн 2 дугаар зүйл.

⁶ 1999 Монгол Улсын Компанийн тухай хууль. Тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т “хуульд заасны дагуу зөвшөөрөл шаардгдах үйл ажиллагаа эрхлэх компани нь холбогдох эрх бүхий байгууллагаас бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр энэ үйл ажиллагааг эрхлэн явуулна.”

⁷ 1995 оны Монгол Улсын Нөхөрлөлийн тухай хууль. Тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “тусгай зөвшөөрөл шаардлагатай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нөхөрлөл хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авна.”

⁸ Mining act of Korea 1981. Article 4.(Mining).

малтмалын орд газарт байгаагаас бусад ашигт малтмалыг ашиглах эсвэл эзэмших эрх харин “ашигт малтмалын концессын эрх”-ийг бусад этгээдийн ашигт малтмалын талбайд ашигт малтмалын аль ч эрх хамаарах эрдэс баялгийг ашиглах эсвэл эзэмших хуулиар олгогдсон эрх⁷ гэж тусгасан байна.

Ашигт малтмалын эрх эзэгшигчид тавигдах шаардлага нь 2 анз байна:

- Ашиглах лиценз эзэмшигчид тавигдах шаардлага;
- Уул уурхайн олборлолтын концессын гэрээний эрх эзэмшигчид тавигдах шаардлага.

Ашиглах лиценз эзэмшигчид тавигдах шаардлага⁸ нь дараах этгээдэд ашигт малтмал ашиглах эрх олгодоггүй. Үүнд: гадаадын иргэн болон гадаадын хуулийн этгээд, БНСУ-ын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хөрөнгийн тал буюу түүнээс дээш эсвэл санал өгөх эрхийн дийлэнх нь гадаадын иргэн эсвэл гадаадын хуулийн этгээдэд хамаарах хуулийн этгээдүүд ордог. Хэрэв Худалдаа, Аж Үйлдвэр, Эрдэс Баялгийн Яам нь үндэсний аж үйлдвэрийн бодлогод чухал шаардлагатай гэж үзвэл тус яам нь ашиглалтын эрхийг эзэмших хугацаа, зөвшөөрөлд тавигдах бусад нөхцөлийг зааж мөн дээр нь Үндэсний Ассемблейгаас урьдчилсан зөвшөөрлийг авснаар ямар ч этгээдэд ашигт малтмалын ашиглах эрх эзэмших зөвшөөрөл

олгодог байна.

Уул уурхайн олборлолтын концессын гэрээний эрх эзэмшигч⁹ нь уул уурхайн олборлолтын концессын гэрээний эрхийг зөвхөн Солонгос Улсын иргэн, тус улсын хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд мөн Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу тодорхой чадамж бүхий этгээд эдэлнэ. Хэрэв тус улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд нь гадаадын хөрөнгө оруулалт нь хагас болон дийлэнх хэсгийг эзэлж байвал Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу тодорхой төрлийн эрдэс баялгийн уул уурхайн концессын гэрээний эрхийг эзэмших эрхгүй байдаг.

БНХАУ дахь эрх зүйн зохицуулалт

БНХАУ-ын уул уурхайн салбарт хэрэглэгдэх уул уурхайн гол хуулиас гадна түүн дээр үндэслэж, дагалдан гарсан олон хууль тогтоомж үйлчилдэг. Гол хууль болох БНХАУ-ын Ашигт малтмалын нөөцийн тухай хууль 1986 онд батлагдан 1996 онд нэмэлт өөрчлөлт орж байжээ. Тус хуульд “ашигт малтмал нь төрийн өмч юм. Газрын дээрх болон доорх ашигт малтмалын төрийн эзэмших эрхийг өөрчлөхгүй..... Хайгуул, ашиглалтын эрх эзэмших өргөдөл гаргаж, тодорхой хэсэгт бүтээгдэхүүн олборлох эрх авсан уул уурхайн аж ахуйн нэгжээс бусад ашигт малтмал хайх,

олборлохыг хүссэн аль ч этгээд хуулийн дагуу өргөдөл гаргана. Хуульд зааснаар уурхайн аж ахуйн нэгж нь өргөдөл гарган, хайгуул, олборлолтын эрхийг авсны дараагаар бүртгүүлнэ. Ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа явуулах этгээдэд тодорхой шаардлага тавигдана”¹⁰ гэжээ.

Хятад Улс нь ашигт малтмалын эрхэд тавигдах шаардлагыг стандарчлах, геологийн ашиглалтын зах зээлийг зохицуулах, геологийн ашиглалтын хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор геологийн хайгуул явуулахад тавигдах шаардлагыг хуульчлах тогтолцоог хэрэгжүүлэх, геологийн хайгуулын компанид тавигдах шаардлагын тогтолцоог гаргасан.¹¹ Хятад Улсын газар нутаг дээр геологийн хайгуул явуулахад хуулийн дагуу бүртгүүлж, геологийн хайгуул явуулахад тавигдах шаардлагыг хангасан тухай гэрчилгээг авах шаардлагатай. Энэ гэрчилгээ нь зөвхөн тодорхой нэг засаг захиргааны хэмжээнд бус Хятад Улсад хүчинтэй үйлчилнэ.

Геологийн хайгуул явуулахад гаргаж шаардлага өргөдөл гаргагч нь хайгуул явуулах шаардлагад нийцэх геологийн хайгуултай шууд холбоотой аж ахуйн нэгж¹² эсвэл байгууллага байна. Мөн хуулийн этгээдийн шаардлагыг “хангасан байна.

Жишээ нь: Ашигт малтмал ашиглах эрх авахад Хятад Улсад

⁷ Mining act of Korea 1981. Article 5. (Mining Rights and lease Rights).

⁸ Mining act of Korea 1981. Article 6. (Qualification Eligible for Mining Right Holder).

⁹ Mining act of Korea 1981. Article 53. (Qualification for Mining Concession Right Holder).

¹⁰ Mineral Resources Law of the People's Republic of China 1986. Article 3.

¹¹ Administration of geological exploration qualifications 2003.

¹² БНХАУ-ын Иргэний хуулийн 3 дугаар бүлэг. (Хуулийн этгээд)-ийн 2-р хэсэг. (Аж ахуйн нэгж хуулийн этгээд болох нь)-ийн 41 дүгээр зүйлд “Төрөөс тогтоосон тодорхой хэмжээний сантай, зохион байгуулалт, өмчтэй бие даан хуулийн хариуцлага хүлээх чадвартай, эрх бүхий байгууллагад бүртгэлтэй хэсэг хүмүүс эсвэл хамтаар эзэмших аж ахуйн нэгж нь хуулийн этгээд болно. БНХАУ-ын газар нутагт байгуулагдсан Хятадын хамтарсан хувьцаат, хятадын хамтарсан гэрээт, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь хуулийн этгээдэд тавигдах шаардлагад нийцэж, хуулийн дагуу аж үйлдвэр худалдааны захиргааны байгууллагад бүртгэлтэй бол хуулийн этгээд гэнэ.” Мөн хуулийн 42 дугаар зүйлд “Аж ахуйн нэгж нь бүртгэлтэй, зөвшөөрөгдсөн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

” Тус хуулийн 3 дугаар бүлэг. (Хуулийн этгээд)-ийн 1 дүгээр хэсгийн 36 дугаар зүйлд “Хуулийн этгээд нь иргэний эрх, иргэний үйл ажиллагааг явуулах хүчин чадалтай, хуулийн дагуу иргэний эрхийг бие даан эдэлж, үүрэг хүлээх этгээд

уул уурхайн үйл ажиллагаа явуулах хүсэлтэй гадаадын хөрөнгө оруулагчид нь уул уурхайн аж ахуйн нэгж байгуулах ёстой. Аж ахуйн нэгж байгуулах өргөдөлд худалдааны захиргааны байгууллагаас зөвшөөрөл олгоно. Зөвшөөрөл авсны дараагаар аж ахуйн нэгж нь худалдаа аж үйлдвэрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ. Түүний дараагаар ашигт малтмалын ашиглалтын эрх эзэмших өргөдлийг төрийн захиргааны газар, эрдэс баялгийн газарт гаргаж зөвшөөрөл авна.

Дүгнэлт

Аливаа уул уурхай болон ашигт малтмалын тухай хууль тогтоомжид уул уурхайн ашигт малтмалын лиценз эзэмшихээр өргөдөл гарган авах эрхтэй этгээдийг тодорхойлсон байдаг. Хайгуул нь эрдэс бодисыг илрүүлэхийг харин уул уурхайн ашиглалт нь бодитой газар ашиглалт, орлого олох үйл ажиллагааг хэлдэг. Уул уурхайн ашиглалтын шатанд илүү хатуу шаардлага тавигдаж болох юм. Тиймээс хайгуулын зөвшөөрөл эзэмшигч нь уул уурхайн ашиглалтын зөвшөөрөл эзэмших өргөдөл гаргахдаа бизнесийн аж ахуйн нэгжийн хэлбэрээ өөрчлөх хэрэгтэй болдог. Ихэнх улсын хувьд уул уурхай болон ашигт малтмалын хуулийн дагуу уул уурхайн ашиглах эрхийг зөвхөн чадамж бүхий иргэн (насанд хүрээгүй болон сэтгэцийн өвчтэй

хүн байж болохгүй) эсвэл хуулийн этгээдэд олгоно. Зарим тохиолдолд зөвхөн тухайн улсын иргэн эсвэл хуулийн этгээд байх шаардлага тавьдаг байна.

Манай улсын 2006 оны Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулиар хайгуулийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхийг зөвхөн хуулийн этгээдэд олгохоор болсон. Хуучин 1997 оны Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль нь манай улсын эдийн засгийн хөгжлийн нэг гол хүчин зүйл болох гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилготой байсан боловч нөгөө талаар уг хууль ашигт малтмалын хайгуулын лицензийг гадаад, дотоодын иргэн ялгахгүй хамгийн түрүүнд өргөдлөө өгсөн дарааллаар хайгуул хийх онцгой эрхийг олгож байсан нь дэндүү либераль шинжтэй байсан бөгөөд эндээс гарах сөрөг үр дагавар нь монгол орны экологийн сүйрэлд хүргэх, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах үндсийг бүрдүүлж байсан. 2006 оны энэ хуулийн өөрчлөлт нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг чангатгаж, төрийн хяналтыг нэмэгдүүлж өгсөн талтай.

Мөн ашигт малтмалын лиценз эзэмшигчдэд тавигдах шаардлагад анхаарах зүйлс байна. Үүнд:

- Лицензийг хуулийн этгээдэд олгохдоо эдийн засгийн чадамжтай (хайгуул болон

олборлосон газрыг нөхөх сэргээх, гатвараа төлөх гэх мэт) нэгжид олгох;

- Хайгуулын лицензийн нэрийн доор зарим хуулийн этгээд олборлолтын үйл ажиллагаа явуулахыг зогсоох;

- Кадастрын албанаас лицензийг олгох, тухайн жилийн гатвараа авахаас өөр дорвитой ажил хийгдэхгүй байгаа бөгөөд гус нэгжээс олгосон лицензийн ашиглалт, байгалийн нөхөн сэргээлт зэрэг ажлыг эрх зүйн хувьд боловсронгуй болгох.

Нэгэнт уул уурхайн салбар нь манай улсын хувьд эдийн засгийн голлох салбар болж байгаа учир уг салбарт хөрөнгө оруулах сонирхолтой гадаад болон дотоодын хуулийн этгээдийн хувьд тулгамдаж байгаа асуудал нь ашигт малтмалын салбарын эрх зүйн орчин түүний тогтвортой байдал юм.

Мөн энэ салбарыг тойрсон олон асуудал нь зөвхөн хөрөнгө оруулалт, татвар гэсэн сэдвийг хамарч байдаг бөгөөд эдгээрээс бусад асуудалд эрдэмтэн судлаачид анхаарлаа хандуулан дэлхийн бусад улсын хууль тогтоомжтой харьцуулан уул уурхай ашигт малтмалын салбарын эрх зүйг маш нарийн судлаж, гаргах үр дүнг тооцсоны үндсэн дээр боловсруулан, тогтвортой байдлыг хангаж ажиллах эрх зүйг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.



болно. Хуулийн этгээд байгуулагдсанаар түүний иргэний эрх, иргэний үйл ажиллаганы хүчин чадал эхэлж, хуулийн этгээд цуглагдсанаар дуусгавар болно." Мөн хуулийн 37 дугаар зүйлд "Хуулийн этгээдэд тавигдах шаардлага: (1) Хууль дагуу байгуулагдсан байх; (2) Шаардгдах өмч, санг эзэмшсэн байх; (3) Өөрийн нэр, бүтэц зохион байгуулалт, өмчтэй байх; (4) Иргэний хариуцлагыг бие даан хүлээх чадвартай байх.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ ТҮҮНИЙ КРИМИНОЛОГИ ШИНЖ

Дэлхий дахинд “Мөнгө угаах” гэмт хэргийн талаархи ойлголт, нэгдсэн нэр томъёо, бүрэлхүүний шинжийг тогтоосон боловч энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зам боловсронгуй болоогүй байна. Энэ гэмт хэргийн талаархи ойлголтыг зөвхөн хуулийн байгууллагын албан хаагчид мэдэж байх ёстой гэсэн явцуу ойлголтоос бид салах хэрэгтэй. Банк санхүүгийн салбарт их хэмжээний хохирол учруулдаг энэ гэмт хэргийн нийгмийн хор аюул тодорхойлогддог.

Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн алба нь мөнгө угаах гэмт хэргийг ерөнхийд нь хянах үүрэгтэй байдаг. Саяхнаас дампуурсан, банктай холбоотойгоор мөнгө угаах гэмт хэрэг тэрхүү банкинд үйлдэгдэж байсан юм биш биз гэсэн хардлага бүхий нийтлэлүүд одор тутмын хэвлэлүүдэд гарч эхэллээ.¹

Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт түүний үүсэл хөгжил, төрөл, арга хэлбэрүүдийн талаар хуульч судлаачид хангалттай томъёолж, эрүүгийн эрх зүйн үндэс нь тайлбарласан байдаг. Гэхдүү **Монгол Улсад мөнгө угаах буюу шинэ төрлийн гэгдэх энэ хэрэг үйлдэгдэж байгаа эсэх, ямар хэлбэрээр үйлдэгдэж болох, түүнээс урьдчилан сэргийлэх ямар арга зам**ууд байна вэ гэдэгт хариулт олохыг зорилоо.

Манай улсад хар тамхи, галт зэвсэг зарж борлуулдаг зохион байгуулалттай гэмт бүлэглэл, картел, синдикатууд байх



*Хууль зүйн үндэсний
хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн секторын эрдэм
шинжилгээний ажилтан
Г.Оюунболд*

боломжгүй. Тийм болохоор гэмт бүлэглэлүүдийн мөнгө угаах гэмт хэрэг манай улсад үйлдэгдэхгүй боловч харин гадаад улсуудын ийм байгууллагууд мөнгө угаах аятай цөхцөлтэй орны тоонд багтдаг. Дээрээс нь эдгээр бүлэглэлүүдийн гар хөл болох, эсвэл тэдэнд болгоомжгүй байдлаар хууртах зэргээр мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх боломжтой юм. Эдгээрээс дурьдвал:

Сан байгуулах: Сүүлийн үед сан байгуулах үзэгдэл нэлээд түгээмэл болоод байна. Сангийн шугамаар оруулж ирж байгаа хууль бус мөнгө хэний ч нүдэнд буцалтгүй тусламж хэлбэрээр харагддаг. Мон татвараас зайлсхийх тун энгийн, хялбар арга бөгөөд эрсдэл багатайд тооцогддог. Дээрээс нь хүмүүнлэгийн сайн үйлсийн аян хуульдаг мэтээр ард иргэдийн нүдэнд тусдаг боловч мөнгө угаах

гэмт хэрэг санг тойрч байгаагүй юм.

Банкинд хувь нийлүүлэх: Практикт тохиолдоол байгаа банкны лампуурал, хараа хяналтгүй байдал, хувь нийлүүлсэн хоронго гэх мэт үйлдэлд мөнгө угаах гэмт хэргийн энгийн элементүүд ажиглагдаж байна. Зарим нь гадаадын нэгэн банкинд мөнгөө хадгалуулаад алдсан гэдэг. Чухамдаа ОХУ-д мөнгө угаах зорилгоор сарл хэлэн банк нээгдэж, хаагдаж, дампуурч байдаг нь нэн түгээмэл.² Тийм ч учраас Оросын Холбооны Улсын Хууль Зүй, Дотоод явдлын яам, Санхүүгийн албал хамтран ийм банкуудын тоог цөөлөх, мөнгө угаах хэлбэрээр байршуулдаг байдлыг бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Шашны урсгал, хандив: Шашны нэлээд гуйвуулагдсан урсгал сектүүд олноор орж ирснээр монголчуудын уламжлалт сэтгэлгээ, үнэлэмж, амьдарлын хэв маяг, нийгмийн ёс суртахуун гэдэг ойлголт өөрчлөгдөхөд хүрч, нийгмийг илүү задгай байлгах чиглэлд түлхүү үйлчилж байгаа нь ажиглагдаж, зарим төрлийн шашны хориотой хэлбэрүүд гэмт хэргийн сэдлийг “шүтэгч этгээдэд”, төрүүлдэг, тархийг нь угаадаг байдлууд байсаар байна. Энэ нь эл хоронгөгүй байхыг шаардах, орлогынхоо 10 хувийг өгөх зэргээр илэрдэг. Зарим тохиолдолд ямар нь мэдэгдэхгүй санхүүгийн эх үүсвэр шашны байгууллагуулаар дамжин орж ирдэг бөгөөд үүнийг хянах боломж манай улсад байхгүй байна.³ Оороор хэлбэл шашны байгууллагын үйл ажиллагаанд

¹ Энэ тухай Өнөөдөр сонин 2009 оны 10 дугаар сарын 12-ны дугаарт “Тэрбум тэрбумын бэлэ буюу Ангол банкны сэжигтэй түүх” нэртэй нийтлэл гарчээ.

² Dirty dealing .. Untold truth about Global money laundering .. Peter Lilley 2002 у., British

³ “Хууль дээдлэх ёс” нэвтүүл. Г.Оюунболд. “Орчин үеийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл” эрдэм шинжилгээний огууд, 2009 оны №2.

мөнгө угаах гэмт хэрэг агуулагдаж байж болно гэдгийг хууль хяналтын байгууллага анхаарлаа хандуулж, шалгахгүй байна.

Барилга байгуулах, зарах, хорлог оруулах, хорниих хэлбэрүүд байна. Зарим төрлийн аж ахуйн нэгж, гадны мөнгөн тусламж, эсвэл хувь нийлүүлсэн хөрөнгө гэлэг утгаар хууль бусаар олсон орлогыг оруулж улмаар баригдсан барилгаа заран хууль ёсны орлого болгох явдал хамгийн далл хэлбэрт байдаг төдийгүй ийм барилга байшин бариулж байгаа эх үүсвэрийг шалгахгүй орхигдуулж байгаа нь гэмт хэрэг үйлдэгчдийг өөгүүлэх байдалд хүргэж мэдэхээр байна.

Сүүлийн үед манай нэр нөлөө бүхий албан тушаалтнууд, банкны удирдагчид, УИХ-ын зарим гишүүн өөрийн гэсэн фракцтай болсон зэрэг баримт байдаг.⁴ Шар хэвлэлд өнгөлж байгаа (хэдий нотолгоотой биш ч) банкетай холбоотой нийтлэлүүдээс ачаад үзэхэд ийм бүлэглэл банк болгоны ард байдаг тухай дурджээ.

Судалгааны ажил болон мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх талаар гаргасан бүтээлүүд, материалыг нэгтгэн авч үзвэл энэ гэмт хэрэг манай улсад үйлдэгдэх боломж, нөхцөлийн талаар судалсан нь үгүй байна. SAR (suspicious activities report) буюу сэжигтэй гүйцлээний талаар идэвхтэй шалгах үйлдэл нь энэ төрлийн гэмт хэргийг хянах хамгийн том хэрэгсэл байдаг байна.

Банк хадгалж буй мөнгө нь гэмт хэргийн шинжтэй эсэхийг шалгадаг байгууллага биш бусдын мөнгийн хадгалах үүрэгтэй. Цагдаагийн байгууллага үүнийг шалгаж, нотлох ёстой⁵ гэдэг боловч мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх туршлага

байхгүй нь өнөөгийн нөхцөлл илэрхий байна. Өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэрэг гарч, бүртгэгдсэн тохиолдол байхгүй байгаа нь нуугдмал байдалд байгааг харуулж байгаа төдийгүй криминологи шинж нь цагаан болон цэнхэр захтнуудын хүрээнд үйлдэгдэж байдаг онцлогтой хэрэг гэдгийг анхаарвал зохиотой.

Татвар төлөлтийг сайжруулах тухай нийтлэл гаргадгаараа ОХУ-ын тэргүүлэх хэвлэл болох "OFF SHORE NEWS" нь Монгол Улсыг Банк бус санхүүгийн байгууллага байгуулахад хамгийн таатай орны жагсаалтад оруулсан байна. Монгол Улс 2001 оны 9 дүгээр сарын 11-нээс хойш дэлхийн санхүүчдийн сонирхол татахуйц орон болсныг дурджээ.⁶

Америкт болсон 9 дүгээр сарын 11-ний гэгдэх террорист халдлагын дараагаар батлагдсан АНУ-ын "Эх оронч акт"-д офшор банкуудыг олон улсын төлбөр тооцоонд оролцуулахтай холбоотойгоор олон тооны хязгаарлалтыг бий болгосон байна. Энэхүү арга хэмжээ нь уг чанартаа банкны төлбөр тооцоо, үйл ажиллагааг нээлттэй болгож террористуудын мөнгөний урсгалыг хянах улмаар хэт даврагчдын санхүүгийн үйл ажиллагааг зогсооход чиглэгджээ.

Дэлхийн санхүүгийн урсгал нь олон тооны офшор банкуудаар⁷ дамждаг гэдгийг хэлэх хэрэгтэй. Энэ нь зөвхөн террорист халдлага биш янз бүрийн гэмт хэргээс олсон хууль бус орлого байж болдог. Өөрийнхөө нутаг дэвсгэр дээр офшор банк байгуулсан орнууд дэлхий нийтийн капиталд арай илүү либералчилсан харьцаатай оролцдогтоос гадна тэдэнд татвар бага хэмжээтэй ногддог. (татварын

хөнгөлөлт) Гэвч өнөөдөр офшор гэдэг үг нь хараалын үг мэт болж сайн үйл ажиллагаатай банк гэдгээртэй холбоотой байж болохгүй гэнэ. Офшор нэгжид ямар нэг хамааралгүй, АНУ-ын "Эх оронч акт"-д нийцсэн банк бус санхүүгийн байгууллагууд нь олон нийтийн анхаарлыг ихээхэн татаж байна. Жишээлбэл, иймэрхүү төрлийн банк бус санхүүгийн компанийг Монголд бүртгүүлэх бүрэн боломжтой юм. Өнөөдөр банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй үндсэн эрх зүйн бичиг баримт нь Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан журмууд юм. Санхүүгийн эдгээр компаниудыг олон улсын мөнгөн гуйвуулга явуулах зорилгоор ашиглах асуудал олны анхаарлыг ихээхэн татаж байна гэж бичжээ.⁸

Монгол Улсын хууль тогтоомжоор эдгээр компаниуд нь олон улсын мөнгөн гуйвуулгыг үндсэн үйл ажиллагаагаа болгох талаар ямар нэгэн эрх зүйн хязгаарлалт заагаагүй боловч гатвар төлөлтийг маш чөлөөтэй тусгажээ. Тиймээс эхлээд Монголд бүртгэлтэй санхүүгийн компанийн дансанд хууль бусаар орсон орлогыг оруулж улмаар цаашид төрөл бүрийн олон улсын банкууд шилжүүлж болох юм байна.

Одоо ажиллаж байгаа банкууд бүгд гадаадын хөрөнгө оруулалттай, Монгол Улсад үндэсний гэх банк үлдсэнгүй. Одоогоор "Хаан", "Голомт", "Худалдаа хөгжлийн банк", "Улаанбаатар банк", "Капитал", "Хадгаламж", "Чингэс хаан", "Үндэсний хөрөнгө оруулалтын банк", "Монгол шуудан банк", "Эрэл", "Зоос" (одоо Төрийн банк

⁴ Д.Адьянбазар, З.Төрмөдөн. "Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэс". 2005 он, 20 дахь тал.

⁵ Зууны мэдээ сонин 2000 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн №261. "Гонь", МИАТ, АПУ-г барьцаалж болно шүү дээ". гухайн үсгийг Монголбанкны ерөнхийлөгч О.Чулуунбатын өгсөн ирилдлагаас.

⁶ Мировые финансы перемещаются в Монголию., Оросын олон нийтийн хэлэлт Номер один соининоос орчуулсан материал

⁷ Офшор банк гэдэг нь татварын хөнгөлөлттэй, өөрийн үйл ажиллагаагаа гадаадад явуулдаг банк юм.

⁸ "Өдрийн сонин". 2002 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн №252. "Дэлхийн мөнгөний урсгал Монгол руу шилжиж байна"

гэсэн нийтлэлд энэ тухай тодорхой дурджээ.

болсон), АНОД (дампуурсан) гэвч 16 банк байна. Эдгээрийн дийлэнхи нь улс төр, бизнесийн томоохон бүлэглэлийн ард байдаг гэсэн нотлогдоогүй баримтууд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсаар байна. Уг нь аливаа улс орон арилжааны банкуудаа гадаадын мэдэлд өгдөггүй жишиг бий. Хэрэв Арилжааны банкууд олонхи нь гадаадынханд очвол Монголбанк мөнгөний бодлогоо хянаж чадахаа болих төдийгүй цаашлаад мөнгө угаах суурь ч болж болзошгүй.⁹ Тодорхой жишээ дурдахад “Анод” банкны дүрмийн санд мөнгө оруулсан хувь хүн болон байгууллага аж ахуйн нэгжүүдийн хувьцааны эх үүсвэрт эргэлзэхээр асуудлууд олон байгаа нь Монголбанкнаас томилсон шинжээчийн дүгнэлтээр тогтоогдоод байна.

Зарим банкны нэгдлийн арталд Оросууд байгаа гэсэн мэдээлийг баталж чадаагүй¹⁰ ч үндэсний аюулгүй байдлын үүднээс ч тэр жижиг банкыг 100 хувь гадныханд өгнө гэдэг эрсдэлтэй алхам. Гадаадын зарим оронд 15–25 хувиас дээшхгүй гадныханд өгдөггүй. Хэрэв өгөх бол Засгийн газар нь шийддэг гэнэ.¹¹ Үүнтэй холбоотойгоор холбогдох мэргэжилтнүүд Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага буюу ФАТФ-аас гаргасан зөвлөмжийн дагуу галаадын зарим байгууллагатай хамтран ажиллах зайлшгүй

шаардлагатай байна. ФАТФ олон улсын стандартыг үл тоосон, хэрэгжүүлээгүй орнуудыг тусгай хар жагсаалтад оруулдаг. Жагсаалтад орсон улстай санхүү эдийн засгийн ямар нэг харилцаа тогтоохгүй байхыг уриалдаг юм байна. Энэ жагсаалтад нэр бүхий 25 орон багтаж байсан бөгөөд тэд тодорхой арга хэмжээ авсны дүнд бүгд жагсаалтаас хасагджээ.¹² Магадгүй энэ байдлаараа манай улс дээрхи хар дансанд орж мэдэхээр байна.

Судлаачын дүгнэлт

Энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал байна. Дурдсан тохиолдлуудад мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх аятай нөхцөл “хөрс, суурь” манай улсад байна. Зарим тохиолдолд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгааг ч үгүйсгэх аргагүй.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй олон галт хамтын ажиллагаагаар тэмцэж байж үр дүнд хүрдэг. Өнөөдөр янз бүрийн салбарт үйлдэгдэж байж болохоор энэ гэмт хэргийг илрүүлэхэд банкир, сайн эдийн засагчийн туслалцаа хэрэгтэй байна. Хэрэв банк болон банк бус санхүүгийн байгууллагаас цагдаагийн байгууллагыг дан ганц үүнийг хэрэгжүүлнэ, харилцагчдын дансыг шалгадаг, “төвөг учруулдаг” гэсэн өрөөсгөл хандлага байсаар байх юм бол энэ төрлийн гэмт хэрэг илрэхгүй юм. Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн алба нь цагдаагийн байгууллагатай үйл ажиллагаагаа

нягт уялдуулах хэрэгтэй байна. Зүй нь мэргэшсэн алба хаагчдыг өөр салбараас авч ажиллуулах талаар цагдаагийн байгууллага санаачлагатай ажиллах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл банкны салбарт ажиллаж байсан мэргэжилтэнг цагдаагийн байгууллагад авч ажиллуулдаг олон улсын туршлага байдгийг хэрэгжүүлэх цаг болжээ.

Өнөөдөр криминологич, судалгааны ажилтан бэлтгэгдээгүй, орон тоо байхгүйгээс (цагдаагийн байгууллагад гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалдаг судлаач байхгүй харин мэдээлэл дүн шинжилгээний албатай) гэмт хэргийн тоон шинж чанарт хэт анхаарч, үйлдэгдсэн гэмт хэргийн тухайд л урьдчилан сэргийлэх асуудал ярьдаг хэвээрээ байна. Өөрөөр хэлбэл криминологи судалгааг үр ашигтай явуулдаг мэргэжилтэн бэлдэх, тоон мэдээллийг “шүтдэг” байдлаас ангижрах хэрэгтэй байна.

Шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьчилан сэргийлэхэд “шинэ төрлийн арга” хэрэгтэй байдаг. Нэн ялангуяа хуулийн байгууллагын алба хаагчдыг чадавхижуулахдаа үүнийг анхаармаар. Хуулийн байгууллагын алба хаагчдын мэргэжил дээшлүүлэх сургалтын арга барил, тэдэнд хүргэх мэдээлэл зэргийг байнга шинэчилж байж амжилтад хүрдэг олон улсын сайн туршлагыг үр өгөөжтэй явуулах цаг иржээ.



⁹ “Өдрийн сонин”. 2009 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн №248 “Монгол Улс үндэсний гэх банкгүй боллоо” нийтлэлээс.

¹⁰ “Өдрийн сонин”. 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн №276 “Банкуудын нэгдлийн цаахад хуйналдан” нийтлэлээс.

¹¹ “Өдрийн сонин”. “Оросуудын олигархуудын түрэмгийлэл буюу үндэсний аюулгүй байдал”. Монголын банкнуудын холбооны ерөнхийлөгч, Худалдаа хөгжлийн банкны захирал Б.Мэдрээгээс авсан тодруулгаас.

¹² 10-th Review of the Suspicious Activity Reporting System., Financial Crimes Enforcement Network., april. 2008.

ИНТЕРПОЛ БА ШҮҮХ-ДНХ ШИНЖИЛГЭЭ ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

*Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн
лабораторийн тасгийн дарга, биологийн ухааны доктор С.Ганболд*

Олон улсын эрүүгийн цагдаагийн газар (International Criminal Police Organization) Интерпол нь тухайн улс орны үндэстний болон олон улс дамжсан гэмт хэргийг илрүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлдэг дэлхийн 187 улсыг эгнээндээ нэгтгэсэн хүчирхэг байгууллага юм.

Олон улсын эрүүгийн цагдаагийн газар Интерпол нь өөрийн бүтэцдээ Интерполын ДНХ-ийн мониторингийн шинжээчийн групп (Interpol DNA Monitoring Expert Group) гэсэн салбар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ салбар нь Интерполын үндсэн үйл ажиллагааны нэг бүрэлдэхүүн хэсэг болох гэмт хэргийн холбогдогчдын генетик мэдээллийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу хийгдсэн ДНХ-ийн шинжилгээний үр дүнг гарган авахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг байна.

Хүний ДНХ-ийн тодорхой хэсэг нь нэг эцэг эхийн хүүхдүүд ч гэсэн (нэг өндгөн эсийн ихрүүд л биш бол) хоорондоо ялгаатай байдаг бөгөөд энэхүү өвөрмөц шинж чанарыг шүүхийн шинжилгээний байгууллагад гэмт хэргийн газраас олдсон биологийн материалын ДНХ нь уг хэрэгт сэжиглэгдэх буй хүнийг мөн эсэхийг тогтоох шүүхийн ДНХ-ийн шинжилгээний практикт өргөнөөр хэрэглэж байна. Нөгөө талаас олныг хамарсан байгалийн гамшиг, онгоцны сүйрэл болон сураггүй алга бологсдыг эрэн сурвалжилан хайж, олж тогтооход хамгийн найдвартай шинжилгээний арга гэж үзэж байна.

Сүүлийн 20 гаруй жил ДНХ-ийн хэв шинжийг тодорхойлох аргыг шүүх-криминалистикийн

шинжилгээний практикт өргөнөөр хэрэглэж ирсэн ба өнөө үед гэмт хэргийг мөрдөх үйл ажиллагааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үзсээр байгаа юм.

ДНХ-ийн шинжилгээний технологийн дэвшлийн ачаар ДНХ-ийн хэв шинжээр хүмүүсийг адилтган харьцуулах шинжилгээ хурдацтай, өндөр нарийвчлалтайгаар тоо, чанарын өндөр төвшинд шүүх эмнэлгийн лабораториудад өдөр тутамд хэрэглэгдэж байна.

Эрүүгийн эрэн сурвалжлах зорилгоор ДНХ-ийн хэв шинжийг тодорхойлсон дээжний тоо байнга өсөн нэмэгдэж, улмаар ДНХ-ийн хэв шинжийн суурь өгөгдөхүүний цахим-мэдээллийн санг бий болгон хадгалах зайлшгүй шаардлага урган гарч байгаа ба түүнд хадгалагдсан мэдээллийг ашиглан гэмт хэрэгтэнг хайх, сэжигтний генетик мэдээлэлтэй харьцуулан дүн шинжилгээ хийх ажил цаг хугацаа, зардал ихээхэн хэмнэсэн, хамгийн үр дүнтэй арга болох нь нэгэнт нотлогдсон билээ.

Дээрхи зорилгын үүднээс Интерполын гишүүн улс орнууд гэмт хэрэгтэй холбоотой биологийн дээжинд шүүх-ДНХ-ийн шинжилгээ хийж, хурдацтай өсөн нэмэгдэж байгаа энэхүү дээжний ДНХ-ийн мэдээллийг боловсруулах, харьцуулахын тулд өөрийн улс орнуудын ДНХ-ийн лабораторийн тоног төхөөрөмж, боловсон хүчнийг бэхжүүлэхэд түлхүү хөрөнгө оруулалтыг хийж байна. Интерпол нь олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллагын хувьд Интерполын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог болон оролцох сонирхолтой гишүүн орнуудынхаа шүүх-ДНХ-ийн шинжилгээний чиглэлд гол

үүрэг гүйцэтгэдэг. Эрүүгийн цагдаагийн газрын улс хоорондын ДНХ-ийн хэв шинжийн мэдээллийг гишүүн орнуудад солилцох үйл ажиллагааны зорилгоор Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын газар ДНХ-ийн хэв шинжийн суурь өгөгдөхүүн буюу олон улсын анхны "Генетик мэдээллийн сан"-г бий болгон ажиллаж байна.

"Интерполын ДНХ-ийн мониторингийн шинжээчийн групп" салбар нэгж нь үйл ажиллагаа 2 үе шаттайгаар явуулдаг байна.

1 дүгээр шат нь Интерполын стандартын шаардлагын дагуу ДНХ-ийн хэв шинжийг тодорхойлох ДНХ-ийн шинжилгээг тухайн орны шүүхийн шинжилгээний практикт нэвтрүүлэх;

2 дугаар шат нь гишүүн орнуудын үндэсний хууль тогтоомжийн дагуу ДНХ-ийн хэв суурь өгөгдөхүүн буюу "Генетик мэдээллийн сан"-гийн бүртгэлийг бий болгох, улмаар сүлжээний дэглэмд шилжин ажиллах явдал байдаг.

Тухайн мэдээллийн систем ба "Генетик мэдээллийн сан" нь оролцогч бүх гишүүн улсад нээлттэй байх ба хүсэлтийнх нь дагуу эрэн сурвалжилж буй хүний мэдээллийг илгээх явдал юм.

Интерпол нь гишүүн орнуудаас эрүүгийн гэмт хэргийг илрүүлэх ДНХ-ийн шинжилгээг ямар төвшинд хэрэглэж байгаа нөхцөл байдлыг мэдэх, цаашдын хэтийн бодлогын талаархи мэдээллийг мэдэхийн тулд тодорхой асуудлаар судалгаа авч нэгтгэн гаргадаг бөгөөд 2002 онд гаргасан судалгааны зарим үр дүнг толилуулж байна. (Хүснэгт 1).

Хувиат 1

Бүс нутаг	Интерполим газраас явуулсан санал өсүүлэгд оролцсон улс орнуудын оролцооны хувь	Зүүргийн мөрдөн байцаах үйл ажиллагаанд ДНХ-ийн шинжилгээ хэрэглэх байгаа улсууд	ДНХ-ийн өгөгдлийн санг CODIS системээр бүрдүүлсэн орнууд	ДНХ-ийн өгөгдлийн санг CODIS системээр бий болгохоор төлөвлөж буй улсууд	Албан ёсны итгэмжлэгдсэн ДНХ-ийн лабораторитай, суурь өгөгдэхүүний санг бий болгосон улсууд	ДНХ-ийн шинжилгээний хэрэглээний онцлог
Африк	48 улсаас /63%	8	2	5	Байхгүй	1. 7-с 2 улс ДНХ-ийн мэдээллийн санг өөрийн улсын шүүхийн шинжилгээний байгууллагад нэвтрүүлэхээр төлөвлөж, улмаар олон улсын хэмжээнд харилцан ДНХ-ийн мэдээлэлээ солилцохоор ажиллаж байна. 2. Ихэнх улс нь хэргийн газраас хураан авсан биологийн дээжний ДНХ-ийн мэдээллийг бүртгэж бэлтгэх өгөгдөхүүнд оруулах чиглэлийг баримтлан ажиллахын зэрэгцээ хохирогч, сэжигтний мэдээллийг бэлтгэх өгөгдөхүүний санд оруулдаг байна.
Америк	37 улс, 7 Үндэсний товчоодоос /51%	13	9	9	10	1. 10-с 7 улс ДНХ-ийн мэдээллийн санг өөрийн улсын шүүхийн шинжилгээний байгууллагад нэвтрүүлэхээр төлөвлөж, улмаар олон улсын хэмжээнд харилцан ДНХ-ийн мэдээлэлээ солилцохоор ажиллаж байна. 2. Ихэнх улс нь хэргийн газраас хураан авсан биологийн дээжний ДНХ-ийн мэдээллийг бүртгэж бэлтгэх өгөгдөхүүнд оруулах чиглэлийг баримтлан ажиллахын зэрэгцээ шүүхээр шийтгүүлсэн хүмүүсийн мэдээллийг бэлтгэх өгөгдөхүүний санд оруулах бодлого барин ажиллаж байна.
Ази ба өмнөд Номхон далайн улсууд	30 улс, 3 Үндэсний товчоодоос /71%	11	4 улс ДНХ-ийн өгөгдлийн санг бүрдүүлэн ажиллаж байгаа боловч нэг ч улс нь CODIS систем хэрэглэхгүй байгаа	4 улс ДНХ-ийн өгөгдлийн санг бүрдүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа боловч CODIS системийг сонгоогүй болно.	3	1. 8-с 5 улс ДНХ-ийн мэдээллийн санг өөрийн улсын шүүхийн шинжилгээний байгууллагад нэвтрүүлэхээр төлөвлөж, улмаар олон улсын хэмжээнд харилцан ДНХ-ийн мэдээлэлээ солилцохоор ажиллаж байна. 2. Ихэнх улс нь хэргийн газраас хураан авсан биологийн дээжний ДНХ-ийн мэдээллийг бүртгэж бэлтгэх өгөгдөхүүнд оруулах чиглэлийг баримтлан ажиллахын зэрэгцээ шүүхээр шийтгүүлсэн хүмүүсийн мэдээллийг бэлтгэх өгөгдөхүүний санд оруулах бодлого барин ажиллаж байна.
Европ	46 улс, 1 Үндэсний товчоодоос /91%	36 улс ДНХ-ийн шинжилгээг мөрдөн ажиллаж байгаагийн 9 улс нь CODIS системийг хэрэглэн ажиллаж байна.	26	5 улс ДНХ-ийн өгөгдлийн санг бүрдүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаагаас 4 улс нь CODIS системийг сонгосон.	28	1. 35-с 24 улс ДНХ-ийн мэдээллийн санг өөрийн улсын шүүхийн шинжилгээний байгууллагад нэвтрүүлэхээр төлөвлөж, улмаар олон улсын хэмжээнд харилцан ДНХ-ийн мэдээлэлээ солилцохоор ажиллаж байна. 2. Ихэнх улс нь хэргийн газраас хураан авсан биологийн дээжний ДНХ-ийн мэдээллийг бүртгэж бэлтгэх өгөгдөхүүнд оруулах чиглэлийг баримтлан ажиллахын зэрэгцээ шүүхээр шийтгүүлсэн хүмүүсийн мэдээллийг бэлтгэх өгөгдөхүүний санд оруулах бодлого барин ажиллаж байна.

Хойд Африк ба Ойрох Дорнод	18 улс /72%	9	4	4 улс ДНХ-ийн өгөгдлийн санг бүрдүү- лэхээр төлөв- лөн ажиллаж байгаа ба 1 улс нь CODIS сис- темийг сонго- хоор төлөв- лөөд байна	Байхгүй	1. 8-с 3 улс ДНХ-ийн мэдээллийн санг өврийн улсын шүргийн шинжилгээний байгууллагад нявтруулхээр төлөвлөж, улмаар олон улсын хэмжээнд харилцан ДНХ-ийн мэдээллээ солилцохоор ажиллаж байна. 2. Ихэнх улс нь хэргийн газраас хураан авсан биологийн дээжний ДНХ-ийн мэдээллийг бүртгэж баз өгөгдхүүнд оруулах чиглэлийг баримтлан ажиллахын зэрэгцээ шүүхээр шигтгүүлсэн хүмүүсийн мэдээллийг баз өгөгдхүүний санд оруулах бодлого барин ажиллаж байна.
----------------------------------	-------------	---	---	--	---------	---

Судалгааны дүнгээс үзэхэд 127 гишүүн улс буюу гишүүн орнуудын 71% нь судалгаанд хамрагдсан үзүүлэлт гарсан байна.

Судалгааны дүнгээс шүүхийн шинжилгээний зорилгоор ДНХ-ийн шинжилгээг хамгийн өргөнөөр хэрэглэж байгаа бүс нутаг Европ болох нь харагдаж байна.

Гэмт хэрэгт холбоотой ДНХ-ийн мэдээллийн суурь өгөгдхүүний 54% нь Европын улсуудад байгаагийн 20% нь генетик мэдээллийн "CODIS" нэгдсэн системийг хэрэглэж байгаа ба зарим улс Identifier, PowerPlex16, GenePrint, PolyMarker, Profiler, Profiler+, SGM+, Cofiler зэрэг генетик маркерыг хэрэглэн гэмт хэрэгт холбоотой дээжний генетик мэдээллийг тодорхойлж улмаар "Генетик мэдээллийн сан"-г бий болгож гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагаагаа явуулж байна.¹

АНУ-ын Холбооны мөрдөх товчоо CODIS (Combined DNA Index System) гэсэн систем буюу аутосомын хромосом дээр байрлах микросателлитын 13 локусаар (D3S1358, TH01, D21S11, D18S51, D5S818, D13S317, D7S820, D16S539, CSF1PO, vWA, D8S1179, TPOX, FGA), Европын холбооны улсууд

Европын холбоо European DNA Profiling Group (EDNAG) буюу микросателлитын 9 локус (D3S1358, TH01, D21S11, D18S51, vWA, D8S1179, FGA, D19S433, D2S1338)-аар, Олон улсын эрүүгийн цагдаагийн газар Интерпол "Интерполын стандарт локусын цомог" Interpol Standart Set of Loci (ISSOL) буюу микросателлитын 7 локус (D3S1358, TH01, D21S11, D18S51, vWA, D8S1179, FGA)-аар хүнийг адилтган харьцуулах ДНХ-ийн шинжилгээ хийж, улмаар "Генетик мэдээллийн сан"-г бий болгоод гэмт хэрэгтэнг эрэн сурвалжилж байна.²

Монгол Улсын ЦЕГ-ын Интерполын үндэсний товчоо нь олон улсын Интерполын гишүүн орон, шүүх-ДНХ-ийн шинжилгээг эрүүгийн гэмт хэргийг илрүүлэхэд ашиглаж байгаагийн хувьд Олон улсын Интерполын байгууллагатай хамтын ажиллагааг улам өргөжүүлэх, дэмжлэг туслалцаа авах боломж нь нээлттэй байгаа гэж үзэж байна.

Монгол Улсын Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь эрүүгийн болон иргэний холбогдолтой хэргийг шийдвэрлэхэд GenePrint ДНХ-кит хэрэглэн шүүх-ДНХ-ийн

шинжилгээ хийж, үр дүнгээр нь шинжээчийн нотлох баримт гаргаж өгөх болоод даруй 6 жил болж байна.

Шүүхийн шинжилгээний ДНХ-ийн лаборатори нь 2008 оны сүүлчээс эхлэн Монгол Улсын хууль хяналтын байгууллагын тогтоол, захирамжийн дагуу ДНХ-ээр хүнийг адилтган харьцуулах шинжилгээг олон улсын төвшинд хэрэглэж байгаа тоног төхөөрмж, урвалж бодис, Identifier, PowerPlex16, GenePrint зэрэг ДНХ-кит, оношлуур хэрэглэн ДНХ-ийн шинжилгээний үр дүнг гарган авч байна.

АНУ-ын Холбооны мөрдөх товчоонд хэрэглэж байгаа CODIS систем-ийн 13 локус, Европын холбооны улсуудад хэрэглэж байгаа 9 локус, Интерполын гишүүн орнууд хэрэглэж байгаа 7 локусаар хүнийг адилтган харьцуулах ДНХ-ийн шинжилгээг ШШҮХ-ийн ДНХ-ийн лабораторид хийгдэж байгаа бөгөөд энэ шинжилгээг олон улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа стандартын шаардлагын төвшинд тогтмол хийхийн тулд ШШҮХ, ЦЕГ-ын нягт хамтын ажиллагаа туйлын чухал байгаа юм.

CR CR CR

¹ С.Ганболд. "Гэмт хэрэг илрүүлэхэд "Генетик мэдээллийн сан"-г бий болгож ашиглах асуудалд". "Хууль дээдлэх ёс" сэтгүүл. 2009 он. №(24) 68 дахь тал.

² Werner Schuller, Lyn Fereday, Richard Scheithauer, "Interpol Handbook on DNA data Exchange and Practice" Recommendation from the Interpol DNA Monitoring Expert Group. First edition, Lyon -2001, www.interpol.int

ГАРЫН МӨРНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хүн төрөлхтөн үүссэн үеэс эхлэн хөгжиж дэвшихийн хэрээр сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг мөн адил хурдацтайгаар өсөж, гэмт этгээдүүдийн арга заль, үйлдэл улам нарийсч байна. Иргэдийнхээ эрх, эрх чөлөөг хамгаалж, гэмт хэрэг үйлсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх, гэм буруугүй хүнд хариуцлага хүлээлгэхээс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхийн тулд хөдлөшгүй нотлох баримтад тулгуурлан тогтоох зайлшгүй шаардлага бидний өмнө тулгарч байна. Гарын мөр нь криминалистикийн бусад салбар шинжлэх ухаан дотор мөр үүсэх механизмаараа эзэн холбогдогчоо шууд тодорхойлон заадагчаа илүү ач холбогдолтой билээ. Өөрөөр хэлбэл гарын мөр нь харьцангуй тогтвортой, нөхөн сэргээгдэх чадвартай, дахин давтагдашгүй, эд зүйлс дээр дүрслэгдэн үлддэг, тэдгээрийг ангилан хувааж болдогчоороо криминалистикийн чухал ач холбогдолтой юм. Энэ нь гэмт хэрэг үйлдэгчийн гарын үйл ажиллагааны шууд үр дүн, түүнд тослог хөлсний бодис байдгаар тайлбарлагдана. Иймээс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд илүү өргөн ашиглагддаг. Тиймээс гарын мөрийн шинжилгээгээр гэмт хэргийг илрүүлж, нотолж байгаа өнөөгийн байдал, тулгарч байгаа болон цаашид анхаарвал зохих асуудлуудыг дэлгэж тавихыг зорьсон болно.

Энэ талаар манай эрдэмтэн багш нар "Хийсвэр аман нотолгоог чухалчилах бус харин болит мөр ашиглан шийднэр гаргах нь хэргийг шуурхай, бүрэн бодитой, тал бүрээс нь тогтоох гэсэн эрүүгийн



ШШҮХ-ийн Гарын хээний шинжилгээний хэлтсийн шинжээч, Цагдаагийн дэслэгч Б.Номин

байцаан шийтгэх ажиллагааны зорилт, зарчмыг илүүтэйгээр хангана!" гэж үздэг байна. Монгол Улсад анх 1939 онд гарын хээг ашиглаж Цагдан сэргийлэх байгууллагад гарын хээний шинжээчийн орон тоог бий болгож гэмт этгээдийг гарын хээгээр нь бүртгэж эхэлсэн байна. 1995 он хүртэл ийнхүү гар ажиллагаатай гарын хээний санг ашиглан шинжилгээ явуулж дүгнэлт гаргадаг байсан бол 1995 онд ОХУ-ын Папилон⁵ Автомат харьцуулалтын системийг авч хэрэглэн 2008 он хүртэл нийт 3 удаа шинэчлэлт хийжээ. 2008 оноос Шүүх шинжилгээний байгууллагын техник тоног төхөөрөмжид хийсэн шинэтгэлийн хүрээнд Папилон-7.7.4 системийг Монгол Улсын 21 аймаг, Замын-Үүд, ШШБЕГ-ын харьяа 401, 461 дүгээр хорих ангиуд, АСБТөв, Нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны 9 криминалистикийн лаборатори (8 дүүрэг, 3ЦГ)-д тус тус суурилуулан ажиллуулж эхэлдэг байна.

2009 онд Нийслэлийн төвийн 6 дүүргийн Криминалистикийн лабораторид ажиллаж буй ажлын станцуудыг нэгдсэн сүлжээнд холбох ажил шийдвэрлэгдэх шатандаа явагдаж байна. Ингэснээр нэгдсэн сангийн мэдээллийг цаг алдалгүй түргэн шуурхай ашиглан нэгж дээр шинжилгээ хийх, хэрэгтний галаарх лавлагаа мэдээллийг гаргах боломж бүрдэж байна. Одоогоор Папилон системийн нэгдсэн санд нийт 189432 хүний гарын хээний дардас, хэргийн газраас олдсон 15469 гарын мөр бүртгэлтэй байна.

2008 оны байдлаар "Папилон" системийг ашиглан нийт 1995 гарын мөрийн шинжилгээ хийснээс 148 тооны гэмт хэргийг нотлон тогтоож өгсөн сайн үр дүн харагдаж байгаа боловч нийт хийсэн шинжилгээний 11 орчим хувь болох 184 шинжилгээний гарын мөр нь бүхэлдээ шинжилгээнд тэнцээгүй тул татгалзсан дүгнэлт гаргасан байгаагаас гадна объект дээрээс гарын мөр илрүүлэхээр ирүүлсэн 66 шинжилгээний дөнгөж 16 орчим хувь болох 10 шинжилгээний 13 объектоос 16 ширхэг гарын мөр илэрсэн бол 2009 онд одоогийн байдлаар нийт 1898 шинжилгээ хийгдсэнээс 136 гаруй эрүүгийн хэргийн үйлдсэн этгээдийг тогтоож өгсөн боловч нийт хийсэн шинжилгээний 10.9 орчим хувь болох 208 ширхэг шинжилгээний гарын мөр нь бүхэлдээ тэнцээгүй тул татгалзсан дүгнэлт гаргасан байна.

Мөн энэ онд объектон дээрээс гарын мөр илрүүлэх 102 шинжилгээний 316 ширхэг объект ирүүлсний 12.2 хувь болох 12

¹ Б.Лхагвасүрэн. "Гэмт үйлдлийн мөр". УБ., 2008 он. 68 дахь тал.

² Папилон систем-Энэ систем нь ОХУ-ын мэргэжилтнүүдийн болонсруулсан Гарын мөр, гарын хээний дардаснуудыг өөр хооронд нь автоматаар харьцуулдаг компьютерийн систем (AFIS)

шинжилгээний 15 объект дээрээс 37 ширхэг гарын мөр илэрсэн байна. Шинжилгээнд тэнцэх 37 ширхэг гарын мөрнөөс ердөө 1 ширхэг хохирогчийнхтой, 1 ширхэг гарын мөр сэжигтний гарын хээний дардастай тохирчээ. Дээрх тоо

ирж байгаа нь хангалттай тоо биш юмаа. Эдгээрээс гарын мөр нь харьцуулах шинжилгээнд тэнцэхгүйн улмаас 13 шинжилгээг татгалзан буцаасан байна. Үүнийг доорх хүснэгтээр харуулав. (Хүснэгт 3)

стандартын дагуу сав, хайрцганд битүүмжлэн шинжилгээнд ирүүлсэн бол гялгар уутанд сул хийж ирүүлсэн 38, задгай байдалтайгаар 20, бусад объектуудыг цаас, сонин, гялгар уут болон сконоор битүү боож ирүүлсэн нь харьцуулах шинжилгээний шаардлага хангах гарын мөр илрэх боломжгүй болгож байгаа юм;

• Гарын мөрний үр дүн нь гүүнийг хэрхэн илрүүлэх, бэхжүүлэх, хураан авахаас ихээхэн шалтгаална. Гарын мөр илрүүлж, бэхжүүлэхэд нунтаг, урвалж бодис, багс тэр дундаа нунтагийн төрөл, чанар, хадгалалт, хугацаа маш чухал. Гэтэл нунтагийн хангалт тогтмол хийгдэхгүй байгаагаас шинжээчдийн гарын мөр илрүүлэлт сул байгаа юм. Тухайлбал ШШҮХүрээлэнгийн гарын хээний шинжилгээний хэлтсийн 8 шинжээч нарын дунд 2009 оны байдлаар ердөө 50 грамм нунтагийн хангалт хийсэн байна;

• Объект дээрхи гарын мөр илрүүлэлт нь тухайн мөр хэдийд ямар байдлаар үүссэн, объектын гадаргуугийн шинж чанар, орчин, цаг улирал зэрэг олон хүчин зүйлүүдээс шалтгаалан янз бүр байж болно. Дээрх бүгдийг зөв готорхойлж сурснаар гарын мөр илрүүлэх үйл ажиллагаанд ахиц байна. Өөрөөр хэлбэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шинжээч, мэргэжилтнүүд

Хүснэгт 3

А/А	Завхан	Сэлэнгэ	Орхон	Налайх	Өвөрхангай	Баянзүр	Өвөрхангай	Дорноговь	Дархан-Уул	Төв	Баянхонгор	Хөвсгөл	Говь-Алтай	Архангай	Дорнод	Хэнтий	Нийт
2009 онд хийгдсэн нийт шинжилгээний тоо	5	14	5	19	3	5	2	4	6	12	1	2	1	3	1	1	84

баримтаас харахад гарын мөр илрүүлж, гэмт хэрэгтний үйлдлийг нотлоход тодорхой хэмжээний үр дүнд хүрч байгаа боловч нэгдсэн сан ашиглан хийгдэж буй нийт шинжилгээний 10,9 орчим хувийн гарын мөр нь шинжилгээнд тэнцэхгүй байгаа нь нийт криминалистикийн шинжээчид эсвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын ажилдаа шүүмжлэлтэй хандах үндэс болж байна. Дээрх тоо баримтыг дараах хүснэгтээр үзүүлэв. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Он	Гарын мөрний нийт хийгдсэн шинжилгээний тоо	Гарын мөрний шинжилгээгээр нотолсон хэргийн тоо	Гарын мөр нь шинжилгээнд тэнцэхгүйн улмаас татгалзсан шинжилгээний тоо	Татгалзсан шинжилгээний тоог хувиар харуулав
2008 он	1995	148	184	11%
2009 он	1898	136	208	10.9%

Гарын мөрний шинжилгээ
Объектон дээрээс гарын мөр илрүүлэхээр төрөл бүрийн объект ирүүлсэн шинжилгээ (Хүснэгт 2)

хэргийн газар дээрээс хэрэгт ач холбогдол өгч болох объектыг хуульд заасан үндэслэл журмын дагуу сав баглаа боодолд

мэргэжилтнүүд объектын битүүмжлсэн гохидлолд шинжилгээнд яаралтай хүргүүлэх, эсвэл хэрэг болсон

Хүснэгт 2

Он	Объектон дээрээс гарын мөр илрүүлэх шинжилгээний тоо	Шинжилгээнд ирүүлсэн нийт объектын тоо	Гарын мөр илэрсэн шинжилгээний тоо	Гарын мөр илэрсэн объектын тоо	Гарын мөр илэрсэн шинжилгээний тоог хувиар харуулав	Объектон дээрээс илэрсэн гарын мөрний тоо
2008 он	66	195	10	13	16%	16ш
2009 он	102	316	12	15	12.2%	37ш

Нэг жилийн хугацаанд нэгдсэн сан ашиглан хийгдэж буй нийт гарын мөрний шинжилгээний 5 орчим хувь нь хөдөө орон нутгаас

битүүмжлэн авах ёстой. Гэтэл дээр дурдсанчлан 2009 онд объектон дээрээс гарын мөр илрүүлэх 102 шинжилгээний ердөө 6 объектыг

газраасаа тэр даруй гарын мөрөө илрүүлж үзэх шаардлагатай юм. Үүнээс гадна "Гарын мөрний харьцуулах шинжилгээнд загвар

загвар, материал дээр гарын хээг нь буулгаж явуулах нь чухал үр дүн өгдөг" гэж үздэг ба үүнийг практикт ашиглаж чадвал чухал ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл зарим тохиолдолд гэмт хэрэг үйлдэх үеийн нөхцөл байдал, даралдсан байдлаасаа шалтгаалан гарын мөр нь хээний ерөнхий шинжээрээ өөр өөр үүсгэгдэн гарах талтай байдаг;

- Гэмт хэргийн механизм болон мөр үүсэх зүй тогтлуудыг шинжээч, мэргэжилтэн нар зөв тодорхойлж сурах хэрэгтэй. Гэмт хэрэг гарч, гэмт этгээдийн үйлдлийн аргаас шалтгаалан 2 биет хоорондоо харилцан хүрэлцсэний улмаас ямар нэгэн ул мөр үлдэнэ. Үүнийг гархай зөв харж, зөв тодорхойлж сурснаар гэмт этгээдийн мөрийг олж тогтоож чадна. Үүнд шинжээч, мэргэжилтний ур чадвар, мэдрэмж, туршлага маш чухал;

- Монгол Улсад гарын мөрний оношлогооны шинжилгээний арга, аргачлал, практик байхгүйн улмаас шинжилгээнд тэнцэхгүй буцааж буй гарын мөрүүдийг ашиглах, мэдээлэл авах боломжгүй болдог, ингэснээр гэмт хэргийг түргэн, шуурхай, бодитойгоор илрүүлж, нотлоход хүндрэл учрах ба цаашлаад гэмт этгээдүүд хэрэг завших явдлыг өөгшүүлэх үндэс болно. Өөрөөр хэлбэл гарын мөрний хээн дээр харьцуулалт хийгээд зогсохгүй гарын мөрний өчүүхэн жоохон хэсэг үлдсэн байсан ч түүн дээр эд эсийн түвшинд шинжилгээ хийх шинэ арга, аргачлалыг нэвтрүүлэх хэрэгтэй байна.

Дээрх асуудлуудыг ямар нэг

байдлаар нааштай шийдвэрлэвэл хэргийн газар, төрөл бүрийн объектууд дээрээс хэрэгт ач холбогдол өгөх гарын мөрүүдийг илрүүлж, бэхжүүлэн, битүүмжилж чадсанаар Папилон системийг ашиглан гэмт хэрэг, гэмт этгээдийн үйлдлийг нотлох ажлын үрдүн улам сайжирна. Ингэхийн тулд ажлын байрны сургалт, судалгаа, давтан сургалтуудыг зохион байгуулж, тулгамдаж буй асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, зөвлөмж гарын авлага гарган, материаллаг баазын хангалтыг сайжруулах шаардлагатай байна. Ингэснээр тухайн ул мөр, эд мөрийн баримт нь нотлох баримтын үнэ цэнээ алдалгүйгээр гэмт этгээдийг бүрэн нотолж чадна. Тиймээс дараах асуудлыг санал болгон дэвшүүлж байна. Үүнд:

- Шинжээч мэргэжилтнүүдийг бэлтгэж буй өөрийн орны болон гадаад орны сургуулийн сургалт, судалгаа, дадлага ажлыг улам боловсронгуй болгож сайжруулах. Өөрөөр хэлбэл тулгамдаж буй асуудал, хэргийн газар дээр гарах алдаа дутагдал зэргийг тайлан эсвэл бусад хэлбэрээр тухайн сургуульд хүргүүлэн анхаарч ажиллах. Мөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ангид суралцаж буй оюутан сонсогч нарын криминалистикийн хичээл тэр дундаа хэргийн газрын үзлэгт оролцох, ул мөр, эд мөрийн баримтыг бэхжүүлж, битүүмжлэх талаархи техникийн болон тактикийн онолын сургалт даллагыг сайжруулах.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шинжээч, мэргэжилтэн

зэрэг бусад байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч нарт хэргийн газрын үзлэг, ул мөр эд мөрийн баримт олж бэхжүүлэх, битүүмжлэх тал дээр анхан шатны мэдлэг олгох сургалт, давтан сургалтуудыг тогтмол зохион байгуулах;

- Тулгамдаж буй асуудлын талаар сэдэв бүрээр онол практикийн бага хурал зохион байгуулах, зөвлөмж, гарын авлага бичиж боловсруулах;

- Гарын мөр илрүүлэх нунтаг, урвалж бодис, багс зэрэг материаллаг баазаар хангах асуудлыг системтэйгээр шийдвэрлэж, хангалтыг тогтмолжуулах;

- Гэмт хэрэг илрүүлэх хамтын багийн ажиллагааг сайжруулах, чадварлаг боловсон хүчнийг сонгон шалгаруулж, ажиллуулж чадаж байгаа эсэхэд анхаарах;

- Бусад орны гарын мөрний харьцуулалтын шинэ арга, аргачлал болон оношлогоо шинжилгээний талаар судалж, боломжит хувилбарыг өөрийн оронд нэвтрүүлэх, уламжлалт аргуудтай хошуулан ажиллах.

Дээрх дэвшүүлж буй саналыг хэрэгжүүлснээр одоогоор тулгамдаж буй асуудлыг нааштай шийдвэрлэх бүрэн боломжтой бөгөөд ингэснээр Папилон системийн одоо ажиллаж буй нөөц бололцоог бүрэн ашиглах, гэмт хэргийг нотлох, гэмт этгээдийг илрүүлэх, өөрийн байгууллагын алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлээд зогсохгүй гэмт этгээдүүдийн ял завших байдлыг таслан зогсооход ихээхэн ач холбогдолтой юм.

© © ©

¹ Д.Мөрөн. Ч.Алтанхшиг. "Шүүх-шинжилгээ". УБ., 2004 он. 8 дахь тал.

ТОРГОХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ БА ТОРГОХ ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

Энэхүү сэдвийн хүрээнд торгох ялыг Ардын Засгийн газраас өнөөг хүртэлх хугацаанд хэрхэн хуульчилж ирсэн, торгуулийн ялын ойлголт, хэмжээ, торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаар та бүхэнд хүргэхийг зорисон юм.

1921 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн Ардын Засгийн газрын хурлын 9 дүгээр тогтоолын 5 дугаар зүйлд пүнлүү хасах, золио авах ялыг анх удаагаа торгуулийн ял болгож ял шийтгэл ногдуулахдаа тайж, ард гэж ялгаварлан үзэхийг зогсоожээ.

Монгол Улсын анхны Эрүүгийн хууль нь "Шүүх цаазны бичиг" бөгөөд ерөнхий ангийг нь Засгийн Газрын 1926 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1 дүгээр хурлаар, тусгай ангийг нь 1926 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Улсын 3 дугаар их хурлаар баталсан.

"Шүүх цаазын бичиг" нь (1926 он) ерөнхий товчоо, тусгай ангийн товчоо гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд энэ нь 31 бүлэг, 227 зүйлтэй.

Ерөнхий ангийн товчоонд:

2 дугаар бүлгийн 5 дугаар зүйлд. Ял ба засан сайжруулах арга хийгээд ард олныг арчлан хамгаалах аргууд нь: 5 дугаар зүйлийн 5-д мөнгөн ял торгох гэж зааж өгсөн байна.

11 дүгээр зүйлд. Ял торгууль дор төгрөг ба мөнгөөр тогтооно. Хэрэв цааз хуулийн дотор ялын дээд хэмжээ нь нэгэн зуун төгрөгнөөс дээш бус болвоос ял торгохыг даган 10 төгрөгнөөс дорош (доош) торгож үл болно. Ял тушаах хугацааг Шүүх таслах газрын тогтоон шийтгэсэн өдрөөс хошой нэгэн жил хүртэл сунгаж болно. Хэрэв ялыг тушаах чиггүй бөгөөс нэгэн төгрөгт нэгэн өдөр бодож түүний биеийг хорихгүйгээр үйлдвэр хийлгэнэ.



**ШШГЕГ-ын Хяналт
шалгалтын тасгийн ахлах
байцаагч, докторант Б.Байаев**

Үүнд дор тайлбарлах нь: Ялыг шударгаар тушаахгүй ялаас зайлсхийсэн болвоос түүний хувийн хөрөнгө хогшлыг албан газраас данс тэмдэг үйлдэж худалдах буюу банкны зэрэг газарт хадгалуулсан мөнгө, зоос, жич: бусдаас авах зүйл байваас тэдгээрийг битүүмжлэх зэргээр тушаалгаваас зохино.

Тусгай ангийн товчооны 80 дугаар зүйлд торгох ял оногдуулахаар заасан байна. Үүнд 25 төгрөг хүртэл буюу 25-1800 төгрөгөөр торгох хэмжээ заасан байна. Нийт оногдуулах ялын 35 хувьд торгуулийн ялыг үндсэн буюу нэмэгдэл ялын шинжтэй хэрэглэж байжээ.

Шинэчлэн найруулсан "Шүүх цаазны бичиг"-ийг 1929 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 30 дугаар хурал, Улсын 14 дүгээр бага хурлаар баталсан.

Энэ хууль нь өмнөх хуульд үндсэн өөрчлөлт оруулаагүй боловч хэм хэмжээг ойлгож хялбар болгож сайжруулсан нь хуулийг бүхэлд нь шинээр батлах шалтгаан болсон байна. "Шүүх цаазын бичиг" нь (1929) Ерөнхий ангийн

говчоо, тусгай ангийн товчоо гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд энэ нь 30 бүлэг, 227 зүйлтэй.

Ерөнхий ангийн товчоонд:

5 дугаар зүйл. Ард улсыг арчлан хамгаалж засан сайжруулах арга зүйлүүд нь 5 дугаар зүйлийн 6-д мөнгөн торгох гэж зааж өгсөн байна.

11 дүгээр зүйлд. Торгуулийг төгрөгөөр тогтоож улсын ба орон нутгийн сан дор хурааваас зохимой. Үнэхээрийн ядуу хоосон этгээдийг 100 төгрөгөөс хэтрүүлэлгүйгээр торгох бөгөөд хэрвээ уул зүйлийг төлөх хөрөнгө чинээ үгүй ахуй бол даруй хорихгүйгээр албадан ажил үйлдвэр хийлгэвээс зохих, үүн дор 1 өдрийн ажлыг 1 төгрөгөөр бодож гүйцэтгэхээс гадна торгуулийн зүйлийг хувиарах буюу тогтоосон хугацааг тогтоол гарсан өдрөөс нэг жил хүртэл сунгаж болмой.

Үүнд дор тайлбарлах нь: хөрөнгө бүхий этгээд ялыг шударгаар тушаахгүй зайлах болвоос түүний хувийн хөрөнгө хогшлыг албаны газраас данс тэмдэг үйлдэж худалдах буюу банкны зэрэг газар хадгалуулан мөнгө зоос, жич: бусдаас авах зүйл буй аваас тэдгээрийг битүүмжлэх зэргээр төлүүлээс зохимой.

Тусгай ангийн товчоонд 93 зүйл ангид торгох ял оногдуулахаар заасан байна. Мөн 25 төгрөг хүртэл буюу 25-1800 төгрөгөөр торгох хэмжээг заасан байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1934 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 13 дугаар хурал, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 17 дугаар хурлаар 1929 оны Эрүүгийн хуулийн ерөнхий анги, нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгож БНМАУ-ын "Шүүх цаазын бичиг" (1934 он)-ийг шинэчлэн баталсан.

Тусгай анги нь хэвээр мөрдөгдөж 1935-1939 онд нийт 8

удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

БНМАУ-ын шүүх цаазын бичиг нь ерөнхий анги 6 бүлэг, тусгай анги 9 бүлэг хэсгээс бүрдэж 174 зүйлтэй байна.

Ерөнхий ангид шийтгэх ялын тухай 4 дүгээр бүлгийн 14 дүгээр зүйлийн 9-т торгуулийн ялыг мөнгөөр торгох гэж заах өгсөн байна.

18 дугаар зүйлд. Энэхүү цааз бичиг нь тусгай зүйлүүдэд заасан хэмжээний дотор шүүн таслах газраас мөнгөөр хэмжээ тогтоон шийтгэхийг торгууль хэмээмэй.

Торгууль ногдуулан шийтгэхэд уул шийтгэгдсэн этгээд нь ямар байдлаар суудаг ба хөрөнгө чинээний байдлаар харгалзан тогтоох бөгөөд хураасан торгуулийг улсын санд оруулна. Хэрвээ ногдуулсан торгуулийг эс төлбөөс шүүх таслах газраас хорихгүйгээр албадан ажил хийлгэхийг тогтоогоод 50 төгрөг бүрийн төлөхийг 1 сар албадан ажил хийлгэх болгон гүйцэтгэж болно. Торгуулийн оронд хорих, хорихын оронд торгож үл болно. Торгуулийн оронд хөрөнгө хураахад үл оролцох юмнуудыг мөн торгууль болгон хурааж үл болно.

Тайлбарлах нь: Биеийн хүчин үнэлж амьдрах хүмүүст торгууль ногдуулахдаа 2 сарын хөлснөөс хэтрүүлэн тогтоож үл болно.

Тусгай ангийн 54 зүйл ангид торгох ялаар шийтгэхээр заасан.

20 төгрөг хүртэл буюу 50-3600 төгрөгөөр торгох хэмжээг заасан байна.

Шинэ Үндсэн хуулийн дагуу 1942 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Улсын 25 дугаар бага хурлаар "БНМАУ-ын Эрүүгийн хууль"-г батлагдсан. Уг хууль нь ерөнхий анги, тусгай анги гэсэн 11 бүлэг, 225 зүйлээс бүрдэнэ.

Ерөнхий ангид гэмт хэрэг үйлдэгчдэд эрүүгийн хуулийн ёсоор оногдуулах тухай дөрөвдүгээр бүлгийн 19-т Шүүн таслахын засан сайжруулах чанар бүхий арга хэмжээнүүд гэж заахыг 19 дүгээр

зүйлийн 8-д мөнгөн торгууль гэсэн байна.

Мөн хуулийн 41 дүгээр зүйлд. Энэхүү хуулийн зохих зүйлүүдэд заасан хэмжээний дотор шүүх таслах газраас оногдуулсан мөнгөн шийтгэлийг торгууль гэнэ.

Мөнхүү шүүх таслах газраас мөнгө торгож шийтгэх этгээдийн хөрөнгө чинээний байдлыг харгалзан тогтоовол зохино.

Хэрэв оногдсон торгуулийг эс төлбөл шүүх таслах газраас хорихгүйгээр засан сайжруулах хөдөлмөр хийлгэх шийтгэвээр солж болох бөгөөд үүнд торгуулийн 120 төгрөгт нэгэн сарын хугацааны засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэхээр бодвол зохино.

Торгуулийн оронд хорих, засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх буюу мөн хорихын оронд торгож үл болно.

Хөрөнгө хураахад хурааж үл болох зүйлүүдийг торгуульд авч үл болно мөн биеийн хүчнийг үнэлж амьдрах хүмүүст торгуулийг оногдуулахдаа түүний 2 сарын шалингийн хэмжээнээс хэтрүүлэн тогтоож үл болно.

Эрүүгийн хуульд хэд хэдэн үндсэн өөрчлөлт хийх шаардлагатай болсон тул 1961 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр БНМАУ-ын Ардын их хурлын 2 дугаар чуулганаар шинэ эрүүгийн хууль баталж 1942 оны Эрүүгийн хуулийг хүчингүй болгож шинээр баталсан хуулийг 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсэн. Уг хууль нь ерөнхий анги, тусгай анги гэсэн хэсэг 11 бүлэг, 221 зүйлээс бүрдэнэ.

Ерөнхий ангид ял шийтгэлийн 7 төрлийг заасан байх бөгөөд 17 дугаар зүйлийн 6-д торгох гэж оруулсан байна.

Хуульд заасан хэрэгт, хуульд заасан хэмжээгээр зохих тооны мөнгө гаргуулан авахыг торгууль гэнэ.

Торгуулийн хэмжээг гэмт этгээдийн хөрөнгийн байдал, хэргийн хүнд хөнгөнийг харгалзан тогтооно. Торгууль төлөх хугацааг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр

болсон өдрөөс хой дээшгүйгээр тогтооно.

Тогтоосон хугацаанд торгуулийг төлөхгүй бол шүүх торгуулийн 75 төгрөг бүрийг 1 сарын засан хүмүүжүүлэх ажилтай тэнцүүлэн бодож уг торгох ялыг засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялаар солж болох боловч 1 жил 6 сараас хэтрүүлж болохгүй.

Торгуулийг хорих ялаар солж болох буюу хорих ялыг торгуулиар солж болохгүй.

1986 оны 12 дугаар сарын 5-ны өдөр шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль батлагдсан. Уг хууль нь ерөнхий анги, тусгай анги 13 бүлэг 301 зүйлээс бүрдэнэ.

Ерөнхий ангид ялын 6 төрлийг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэглэж болохоор заасан бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 20 дугаар зүйлийн 1-ийн а-д торгох, 20 дугаар зүйлийн 2-т зөвхөн үндсэн ялын чанартай хэрэглэхээр заасан байна

Хуульд заасан тохиолдолд, тогтоосон хэмжээгээр шүүхээс мөнгөн шийтгэл оногдуулахыг торгох гэнэ.

Торгуулийн хэмжээг тогтоохдоо үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөн, буруутай этгээдийн эд хөрөнгийн байдлыг харгалзан 2000-250.000 төгрөг хүртэл, тусгай ангид заасан тохиолдолд 500.000 хүртэл төгрөгөөр торгохоор заасан.

Мөн торгох ялаас ноцтойгоор зайлсхийсэн тохиолдолд 1-6 сар хүртэл хорих ялаар солж болох хорих ялыг торгуулиар солж болохгүй талаар тусгаж өгсөн. Торгох ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлж дууссанаас хойш хоёр жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй тохиолдолд ял шийтгэлгүй болохыг тусгасан.

2002 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр одоо мөрдөж буй Монгол Улсын Эрүүгийн хууль батлагдсан 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөгдсөн.

Уг хууль нь ерөнхий анги, тусгай анги 12 хэсэг, 31 бүлэг 305 зүйлээс бүрдэнэ.

Ерөнхий ангид Эрүүгийн хариуцлагын зорилго, төрлийн 9 дүгээр бүлгийн 46 дугаар зүйлд ялын 7 төрлийг зааж өгсөн бөгөөд үүнд 46.1.1-д торгох гэж заасан байна.

Мөн энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ гэж тодорхойлсон байна.

Торгох ялын хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтоон өгч уг ялаас ноцтойгоор зайлсхийвэл торгох ялыг гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болох талаар заасан. Тэгэхдээ торгуулийн ялыг зөвхөн үндсэн ялын чанартай хэрэглэхээр заасан.

Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа

Торгох ялын хэрэгжилт, түүнд тавих хяналтын хүрээнд торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар иргэний хэргийн талаархи шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгуурлан явуулна. Тухайлбал, гүйцэтгэх бичиг баримт, агуулга, түүнд тавигдах шаардлага, үр дагавар, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх, харьяалал, явуулах хугацаа, төлбөр төлөгч болон түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах, ажиллагааны тэмдэглэл, мэдэгдэх хуудас өгөх зэргийг тусгаж өгснөөр харагдаж байна.

Торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг ялтан 7

Торгох ялын нэгдсэн үзүүлэлт

№	он	Биелүүлбэл зохих		Бодитой биелүүлсэн		Үлдэгдэл		Биелэлтийн хувь	
		г/х	м/д	г/х	м/д	г/х	м/д	г/м	м/д
1	2002	2281	215434.1	1423	117724.9	858	97709.2	62.4	54.6
2	2003	726	266498.5	572	224552.8	154	41945.7	78.8	84.3
3	2004	503	409658.4	360	323915.4	143	85743.0	71.6	79.1
4	2005	557	894285.9	398	710732.0	159	183553.9	71.5	79.5
5	2006	179	321251.0	158	287540.0	21	33711.0	88.3	89.5
6	2007	329	759658.8	181	381278.7	148	378380.1	55.0	50.2

хоногийн дотор биелүүлэх үүрэгтэй ба торгуулийн мөнгийг бүрэн тушааснаар ялыг бодитой биелүүлсэнд тооцно. Дээрхи хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй тохиолдолд шүүгч шийтгэх тогтоолыг шийдвэр гүйцэтгэх албанд 3 хоногийн дотор хүргүүлнэ. Хүлээн авсан шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэлийн дансанд 14 хоногийн дотор тушаан төлөөгүй тохиолдолд албадан биелүүлэх тухай мэдэгдэл явуулах төлөөгүй тохиолдолд торгуулийн мөнгийг ялтын эд хөрөнгөөс албадан гаргуулна.

Ялтан торгуулийн мөнгийг 7 хоногийн дотор төлөх бололцоогүй байвал түүний өргөдлийг үндэслэн шийдвэр гүйцэтгэгч 6 сар хүртэл хугацаагаар хойшлуулах ба мөн хугацаанд хэсэгчилэн төлүүлэх тухай санал прокурорт гаргах ба прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэхээр заасан.

Ялтан торгуулийн ялаас санаатайгаар зайлсхийсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч шалгалт явуулан торгох ялыг баривчлах, хорих ялаар солих саналаа прокурорт гарган прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх баривчлах, хорих ялаар солихоор заасан байдаг. Тэгэхдээ ялтан торгуулийн ялаас санаатайгаар зайлсхийсэн гэдэгт:

• эд хөрөнгө, хөдөлмөрийн хөлс, шалин орлогоо нуух, бусдад хууль бусаар шилжүүлэх, үрэгдүүлэх;

• шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүйгээр байнга оршин суугаа газраа өөрчлөх зэрэг багтана.

Дээрх тоон үзүүлэлтээс дүгнэлт хийж үзэхэд торгуулийн ял шийтгэлийн биелэлтийн улсын дундаж гүйцэтгэх хуудасны 71.2 хувь, мөнгөн дүнгийн 72.8 хувьтай байгаа нь төдийлөн хангалттай үзүүлэлт болж чадахгүй байна.

Ихэвчлэн Эрүүгийн хуулийн 89, 99, 145, 146, 148, 150, 151, 152, 155, 175, 181, 215, 216, 230, 233 дугаар зүйл хэсгүүдэд заасан гэмт хэрэгт торгуулийн ял оногдуулж байгаа бөгөөд ялангуяа Эрүүгийн хуулийн 99, 175, 145, 151, 155, 215 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэгсдэд торгуулийн ялыг түгээмэл оногдуулжээ.

Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх хэсэгт хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч гурван жилийн хугацаа өнгөрсөн бол ялтын үндсэн ба нэмэгдэл ялыг эдлүүлж болохгүй гэж заасан.

Тэгэхээр Эрүүгийн шинэ хуульд торгуулийн ял шийтгүүлэн уг ялаас биелүүлээгүй ял шийтгүүлэгчдийн дийлэнхи ноцтойгоор энэ ялаас зайлхийж, оргон зайлаагүй, торгуулийн ялыг биелүүлэх төлбөрийн чадваргүй байдлаас болж уг ялаас биелүүлж чадахгүй тохиолдолд дээрхи хуулийн үйлчлэлд ихэнх тохиолдолд хамрагдаж байна.

“ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” СЭТГҮҮЛ НИЙТЛЭЛИЙН ЖАГСААЛТ (2009 он)			
№	Сэдвийн нэр	Зохиогчийн нэр, эрхэлсэн ажил	Нийтлэгдсэн дугаар
Хууль зүйн албаны 100 жилийн ойд			
1.	Монгол Улсын төрийн таван яамны анхны сайдууд		2009 ОН №1 (24)
2.	Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн тухайд өгүүлэх нь	ШУА-н Олон улс судлалын хүрээлэн, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор О.Батсайхан	2009 ОН №2 (25)
3.	1911 оны Монголын үндэсний хувьсгалын оргил буюу 12 дугаар сарын 29-ний өдөр VIII богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн хаанаар өргөмжилсөн нь	ШУА-н Олон улс судлалын хүрээлэн, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор О.Батсайхан	2009 ОН №3 (26)
4.	1911 оны Монголын үндэсний хувьсгалын тухай гадаадын түүх судлалд өгүүлэх нь	ШУА-н Олон улс судлалын хүрээлэн, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор О.Батсайхан	2009 ОН №4 (27)
Төрийн байгуулалтын хууль тогтоомж			
1.	Үндсэн хуулийг эрх зүйт ёсны үүднээс авч үзэх нь	МУИС-ийн ХЗС-ийн Төрийн онол-түүхийн тэнхимийн багш М.Батсуурь, Ч.Өнөрбаяр	2009 ОН №1 (24)

2.	Үндсэн хуулийн үзэл баримтлал дахь хууль дээдлэх ёс, учир холбогдол	Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгч, магистр Н.Мөнхөө	2009 ОН №1 (24)
3.	Ашиг сонирхолын зөрчил, танил талаа харж үзэх асуудал	Авлигтай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч, комиссар, докторант Д.Золжаргал	2009 ОН №1 (24)
4.	Хуулиудын амин сүнс буюу бид хөгжмөөр л байна... Гэхдээ саад байна	Хуульч, магистр Ш.Үнэнтөгс	2009 ОН №1 (24)
5.	Онцгой байдал зарласан үе дэх мэдэх эрхийн тухай	ИЗИС-ийн багш Ц.Мөнхбат	2009 ОН №1 (24)
6.	Германы сонгодог философич Гегелийн эрх зүйн үзэл санаа	МУИС-ийн ХЗС-ийн багш, хууль зүйн доктор Х.Сэлэнгэ	2009 ОН №2 (25)
7.	Эрх зүй нийгмийн үзэгдэл мөн	МУИС-ийн ХЗС-ийн багш, хууль зүйн доктор Р.Уранбилэг	2009 ОН №2 (25)
8.	Эрх зүйт ёсыг төгөлдөржүүлэх нь хөгжлийн тулгуур багана мөн. (Эрх зүйн шинэтгэлийн зорилт)	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрхлэгч, докторант Р.Мухийт	2009 ОН №2 (25)
9.	Монгол Улсын хөрөнгө, орлогын мэдүүлгийн тогтолцоо, тулгамдсан асуудал	Голомт банкны хууль зүйн зөвлөх П.Өнөрмаа	2009 ОН №2 (25)
10.	Иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбогдох зарим асуудал	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан магистр Б.Одонгэрэл	2009 ОН №2 (25)

11.	Бараа импротлох гаалийн тариф түүний хөнгөлөлт	МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант В.Оюумаа	2009 ОН №2 (25), 2009 ОН №3 (26)
12.	Монгол Улс дахь эрх зүйн боловсролын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал	МУИС-ийн ХЗС-ийн захирал, Академич С.Нарангэрэл	2009 ОН №3 (26)
13.	Үндсэн хуулийн эдийн засгийн тогтолцоон дахь төр	Хууль зүйн шинжлэх ухааны доктор, МУИС-ийн тэргүүлэх профессор Н.Лүндэндорж	2009 ОН №3 (26)
14.	Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийг анх баталсан ээдрээтэй түүх	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор, дэд профессор С.Сүхбаатар	2009 ОН №3 (26)
15.	Иргэний албан татвар төлөх үүрэг: Үндсэн хуулийн зохицуулалт, хэрэгжилт	МУИС-ийн Хууль зүйн сургуулийн төр захиргааны эрх зүйн тэнхимийн багш, докторант Ж.Жавзандулам	2009 ОН №3 (26)
16.	Монгол Улсад хууль тогтоомжийг хэвлэн нийтэлж ирсэн түүхэн тойм	МУИС-ийн ХЗС-ийн Монголын төр, эрх зүйн түүхийн сударгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант Б.Батбаяр, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, хүмүүнлэгийн секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр А.Түвшинтулга	2009 ОН №4 (27)

17.	Хууль нийтлэх талаарх зарим асуудал	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Р.Болормаа	2009 ОН №4 (27)
18.	Авлига ба нийгэм	Авлигтай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч, комиссар, докторант Д.Золжаргал	2009 ОН №4 (27)
Шүүх эрх мэдэл			
1.	Шүүгч үү байцаагч уу? Байцаагч уу?	МУИС-ийн ХЗС-ийн Эрх зүйн V анги, Ө.Жамбалсүрэн	2009 ОН №1 (24)
2.	Үндсэн хуулийн цэцийн шийдвэр жишиг болох нь	МУИС-ийн ХЗС-ийн Эрх зүйн III анги, Т.Мөнхсүлд, М.Мөнхжаргал	2009 ОН №1 (24)
3.	Хууль хэрэглэх онол практикийн асуудал	МУИС-ийн ХЗС-ийн Эрх зүйн III анги, О.Алтантуяа	2009 ОН №1 (24)
4.	Иргэний хэрэг үүсгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт	ИЗИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн эрхлэгч, Дэд профессор З.Мөнхжаргал	2009 ОН №1 (24)
5.	Иргэний хэргийн шүүхийн шийдвэр, түүнд тавигдах шаардлага	МУИС-ийн ХЗС-ийн ахлах багш, докторант Д.Хуяг	2009 ОН №2 (25)
6.	Мэтгэлцээн ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа	МУИС-ийн ХЗС-ийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш, докторант Ж.Эрхэсхулан	2009 ОН №2 (25)

7.	Хэн дор эрх байна, түүн дор хилэнц бий	Өвөрхангай аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч П.Соёл-Эрдэнэ	2009 ОН №2 (25)
8.	Хууль дээдлэх ёсыг хангахад шударга шүүхийн үүрэг	Монгол Улсын Ардын багш, гавьяат хуульч, доктор профессор Б.Чимид	2009 ОН №3 (26)
9.	Шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулагчийн оролцоог чухалчлах нь	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Энх-Амгалан	2009 ОН №4 (27)
10.	Хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах асуудал	МӨХ-ийн гишүүн, өмгөөлөгч, магистр Б.Ганболд	2009 ОН №4 (27)

Прокурорын хяналт

Монгол Улсын Прокурорын байгууллагын 80 жилийн ойд

1.	Эрүүдэн шүүх гэмт хэрэгт тавих прокурорын хяналт	Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор, Хууль цаазын ахлах зөвлөх Е.Сарсай	2009 ОН №4 (27)
----	--	--	--------------------

Иргэний хууль тогтоомж

1.	Үндсэн хуулийн “зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үзэл санаа” ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль дахь “Урамшуулалын гэрээ”	Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн туслах С.Өмирбек	2009 ОН №1 (24)
2.	Монгол Улсын Шудрага бус	МУИС-ийн Хууль зүйн	2009 ОН

	өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй зарим асуудал	сургуулийн багш М.Уянга	№1 (24)
3.	Өмчлөх эрх ба өмчийн мөн чанарын асуудалд	"Законы России" сэтгүүлээс орчуулсан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Олон Улсын эрх зүйн секторын эрхлэгч, докторант М.Мөнхбат, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Тамир	2009 ОН №2 (25)
4.	Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаанд шүүмжлэлтэй хандах нь	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн профессор, хууль зүйн доктор Б.Уранцэцэг	2009 ОН №2 (25)
5.	Хөдөлмөрийн эрх зүй дэх хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдлын зохицуулалт	МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхэмийн багш, докторант С.Болормаа	2009 ОН №2 (25)
6.	Хучин төгөлдөр бус гэрээнээс үүсэх үр дагавар	МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхэмийн багш, докторант Ц.Давхарбаяр	2009 ОН №2 (25)
7.	Хөдөлмөрийн харилцаа ба түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	ОТИС-ийн ХЗС-ийн Иргэн, бизнесийн эрх зүйн тэнхэмийн багш Г.Жаргал	2009 ОН №2 (25)
8.	Мэдээллийн эрх чөлөө	Хууль зүйн хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм	2009 ОН №2 (25)

		шинжилгээний ажилтан Б.Солонго	
9.	Монгол Улсын нотариатын хөгжил, цаашдын чиг хандлага	Сүхбаатар дүүргийн нотариатч Р.Онончимэг	2009 ОН №2 (25)
10.	Хүүхэд хөдөлмөрлөх ёстой юу?	Хуульч Д.Солонго	2009 ОН №2 (25)
11.	Үнэт цаасны зах зээлийн хуулийн хэрэгжилтийн асуудал	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны баг	2009 ОН №3 (26)
12.	Даатгалын эрх зүйн тулгуур ойлголт	"Монгол Даатгал" ХХК-ын Даатгалын газрын захирал, МӨХ-ын гишүүн, өмгөөлөгч Б.Жавхлант, Австралийн Мельбурнийн их сургуулийн Азийн хуулийн судалгааны төвийн зочин эрдэмтэн хууль зүйн доктор Б.Гүнбилэг	2009 ОН №4 (27)
13.	Зар сурталчилгаа ба гэм хор	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын судалгааны тайлан	2009 ОН №4 (27)
14.	Бизнесийн эрх зүй дэх хууль зүйн хариуцлагын онол, практикийн асуудал	Шихихутуг хууль зүйн дээд сургуулийн Салбар эрх зүйн тэнхимийн багш С.Батбуян	2009 ОН №4 (27)
Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй			
1.	АНУ-ын эрүүгийн процесс дахь хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	СБД-ийн шүүхийн шүүгч, докторант Ч.Хосбаяр	2009 ОН №1 (24) 2009 ОН №2 (25)
2.	Нийтийн эрх зүйн бүлийн	Хууль зүйн үндэсний	2009 ОН

	зарим улс дахь эдийн бус гэм хорыг арилгах	хүрээлэнгийн Иргэний хууль тогтоомжийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистрант Ц.Одмаа	№1 (24)
3.	Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд хийсэн харьцуулсан зарим судалгаа	Цагдаагийн академийн ТЗЭЗТ-ийн багш, Цагдаагийн дэслэгч Д.Булган	2009 ОН №1 (24)
4.	ХБНГУ дахь концернийн эрх зүйн зохицуулалт, онцлог	МУИС-ийн ХЗС-ийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш, докторант Э.Байгаль	2009 ОН №2 (25)
5.	Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт: төлөв байдал, шийдвэрлэх асуудал	Академич Ж.Амарсанаа, Гадаад харилцааны яамны гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын зөвлөх Ж.Шишмишиг	2009 ОН №3 (26)
6.	Солонгосын "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хуулийн бэрхшээл, тулгамдсан асуудал	Сөүл хотын их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор Ким Дэ Вон	2009 ОН №3 (26)
7.	Гадаадын хөрөнгө оруулалт ба эдийн засгийн чөлөөт бүс	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Олон Улсын эрх зүйн секторын эрхлэгч, докторант М.Мөнхбат	2009 ОН №3 (26)
8.	Солонгосын эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хуулийн бэрхшээл, тулгамдсан асуудал	Жэжү их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор Ким Ёо Сон	2009 ОН №3 (26)
9.	Монгол Улсын шүүх эрх мэдлийн хүрээний хууль тогтоомж, олон улсын гэрээний зөрчилдөөн	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Олон улсын эрх зүйн секторын судалгааны тайлан	2009 ОН №4 (27)

10.	Авлигатай тэмцэх Сингапурын туршлага	Хууль зүйн доктор Ж.Батзандан	2009 ОН №4 (27)
11.	Ашигт малтмалын лиценз эзэмшигчийн эрх зүйн байдлыг харьцуулсан судалгаа	ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, магистр Ц.Ундрах	2009 ОН №4 (27)
Криминологи			
1.	Кримналистикийн шинжилгээний аргачлалын асуудал өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Нийслэлийн Шүүхийн шинжилгээний албаны Чингэлтэй дүүргийн шинжээч, Цагдаагийн ахлах дэслэгч Х.Баярмаа	2009 ОН №1 (24)
2.	Гэмт хэргийг илрүүлэхэд "Генетик мэдээллийн сан" бий болгож, ашиглах асуудалд	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн лабораторийн тасгийн дарга, Биологийн ухааны доктор С.Ганболд	2009 ОН №1 (24)
3.	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг Монгол Улсын шүүхийн шинжилгээний байгууллагын бодлого, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхийн ач холбогдол	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн лабораторийн тасгийн дарга, Биологийн ухааны доктор С.Ганболд	2009 ОН №2 (25)
4.	Орчин үеийн зарим төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан,	2009 ОН №2 (25)

		магистр I .Оюунболд	
5.	Мал хулгайлах гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, хийх дүгнэлт, тулгамдсан асуудал	Төв аймгийн шүүхийн шүүгч Д.Гансүх	2009 ОН №2 (25)
6.	Компьютерийн гэмт хэрэг	МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант Ц.Хүрэл-Очир	2009 ОН №2 (25)
7.	Хэргийн газраас илрүүлсэн биологийн үл мөрийн ДНХ-ийг "Генетик мэдээллийн сан"-д оруулах асуудалд	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн лабораторийн тасгийн дарга, Биологийн ухааны доктор С.Ганболд, магистрант Р.Баярмаа	2009 ОН №3 (26)
8.	Гүтгэлэг ба кибер орчин, эрх зүйн зохицуулалт	Голомт банкны хууль зүйн зөвлөх П.Өнөрмаа	2009 ОН №3 (26)
9.	Өршөөлийн хуулийн үр нөлөө	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Г.Оюунболд	2009 ОН №3 (26)
10.	Цаазаар авах ял ба эрүү шүүлт	Хүний эрхий үндэсний комиссийн гишүүн, докторант Ю.Оюунчимэг	2009 ОН №3 (26)
11.	Хууль бус донор ба хүний наймаа	Цагдаагийн академийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, магистр, цагдаагийн дэслэгч С.Гантулга	2009 ОН №3 (26)
12.	Мөнгө угаах гэмт хэрэг түүний криминологи шинж	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Криминологийн судалгааны секторын эрдэм	2009 ОН №4 (27)

		шинжилгээний ажилтан, магистр Г.Оюунболд	
13.	Интерпол ба шүүх- ДНХ шинжилгээ түүний хэрэглээ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн лабораторийн тасгийн дарга, Биологийн ухааны доктор С.Ганболд	2009 ОН №4 (27)
14.	Гарын мөрний шинжилгээний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Гарын хээний шинжилгээний хэлтсийн шинжээч, цагдаагийн дэслэгч Б.Номин	2009 ОН №4 (27)
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл			
1.	Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ятнуудаас бусдад учруулсан хохирол нөхөн төлүүлэлтийн асуудал	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Б.Одонгэрэл	2009 ОН №1 (24)
2.	Насанд хүрээгүй хүмүүсийн цагдан хорих байр, хорих ангийн нөхцөл	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Г.Оюунболд	2009 ОН №1 (24)
3.	Төлбөр авагчийн эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл	ХЗХТБАА-ны Албадан дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч, дэслэгч Ц.Буянзаяа	2009 ОН №1 (24)
4.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд (2002) шинээр тусгагдсан үзэл баримтлал,	Цаглаагийн академийн магистрант Ю.Оюунаа	2009 ОН №1 (24)

	хэрэгжилтийн чиг хандлага		
5.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн түүхэн хөгжил, цаашдын чиг хандлага	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тогтоол гүйцэтгэх газрын судалгааны ажилтан, докторант, хошууч Б.Алтангэрэл	2009 ОН №3 (26)
6.	Торгох ялын эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал ба торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт шалгалтын тасгийн ахлах байцаагч, ахмад, докторант Б.Байгал	2009 ОН №4 (27)
Эрх зүйн үйлчилгээ			
1.	Монгол Улсад нотариат үүсч хөгжсөн нь	ОТИС-ийн ХЗС-ийн багш Х.Цогзолмаа	2009 ОН №1 (24)
Хөрөг нийтлэл			
1.	Ажлын фронтын дайчин		2009 ОН №1 (24)



Монгол Улсын хууль 4 боть эмхтгэлд 2009 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд орсон хуулийн бүх нэмэлт, өөрчлөлтийг тусган шинэчлэн эмхтгэтгэж гарлаа.

Монгол Улсын хууль 4 боть эмхтгэлийг хэрэглэхэд хялбар, цаашид нэмэлт, өөрчлөлтийг оруулан сольж болохуйц сугалбар хуудас, төмөр цоожлогч бүхий хатуу хавтастайгаар хэвлэсэн. Эдгээр 4 ботид цаашид орох өөрчлөлтийг жилд хоёр удаа нэг багц болгон хэвлэж захиалгын дагуу түгээх юм.


Монгол Улсын хууль 4 боть эмхтгэлийн 2009 оны нэмэлт, өөрчлөлтийн багцыг бэлтгэн хэвлэж Та бүхэнд хүргэхэд бэлэн болоод байгаа тул тус 4 боть эмхтгэлээс худалдан авсан, байгууллага, иргэд манайд хандан өөрчлөлтийн багцыг авах захиалгаа өгнө үү.

Та бүхэн дээрх 4 боть эмхтгэл болон, эдгээр ботиудын нэмэлт, өөрчлөлтийн багцыг захиалан авахыг хүсвэл доорхи хаяг, утсаар хандана уу.

**Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Сүхбаатарын талбай 7, Хууль зүйн үндэсний хүрээлэн**
Утас: 315736, 315735, 1982, 8800-7557
Факс: 315735




Монгол Улсын хууль тогтоомжийн үндсэн эх сурвалж болох Үндсэн хуулийг (1992 он) уйгаржин монгол бичиг-кирилл үсгээр бичиж судар хэлбэрээр хэвлүүлэн, баринтаглан бүтээжээ. Эртний Энэтхэг, Төвдөөс дамжин Монголд орж ирсэн гэх судрын загварыг ашиглан эх нутгийнхаа хөх тэнгэрийг бэлэгдэн баринтагны гадрыг хөх торгоор, газар нутгаа дүрслэн дотрыг ногоон торгоор хийн, баринтагны оосорт шинээр зоос үйлдэн бүтээжээ.



Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их сургууль, Шинжлэх ухааны академиас эрхлэн хэвлүүлсэн Монголчуудын хэрэглэж ирсэн үсэг бичгээр бүтээсэн Монгол Улсын Үндсэн хуулийг танд толилуулж байна. “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн эхийг Монголчуудын хэрэглэж ирсэн зургаан гол зүйл бичиг үсэг, арван зүйл тиг хэлбэрээр бүтээжээ. Энэхүү номд хэрэглэж ирсэн бичиг үсгийн дараахь дарааллаар оруулсан байна.

- Их Монгол Улсын үеийн монгол бичгийн тиг;
- Монгол бичгийн модон барын тиг;
- Монгол бичгийн бийрийн тиг;
- Монгол бичгийн эвхмэл тиг;
- Монгол бичгийн төмөр барын тиг;
- Монгол дөрвөрлжин бичиг;
- Тод бичиг;
- Соёмбо бичиг;
- Латин бичиг;
- Монгол кирилл бичиг.



1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хууль тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг эмхтгэн Англи хэлээр орчуулан хэвлүүлжээ. Уг бүтээлд 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулийн жинхэнэ анхаагч эхийг хуулбар хувь, тухайн цаг үед хэвлэгдэн гарч байсан анхны хэвлэлийн хуулбарыг багтаасан байна.